



ХУУЛЬ САХИУЛАХЫН
ИХ СУРГУУЛЬ



МОНГОЛЫН КРИМИНОЛОГИЧДЫН
ХОЛБОО

ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ

ОНОЛ, АРГА ЗҮЙН
УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

2017 №1 (59) 15 дахь жилдээ



СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

ЭРХЛЭГЧ

Д.ЗҮМБЭРЭЛЛХАМ

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Б.БАТ-ЭРДЭНЭ

Монгол Улсын Дээд Шүүхийн шүүгч, доктор (Ph.D),
профессор

Б.БАТЗОРИГ

Доктор (Ph.D), дэд профессор

Б.БОЛДБААТАР

Монголын Криминологичдын холбооны гүйцэтгэх
зөвлөлийн гишүүн, доктор (Ph.D), профессор

Н.ГАНБАДРАЛ

Доктор (Ph.D), дэд профессор

Ж.ДОЛГОРСҮРЭН

Доктор (Sc.D), профессор

Н.ЖАНЦАН

Монгол Улсын гавъяат хуульч, доктор (Ph.D),
профессор

О.ЗОРИГТ

Доктор (Ph.D)

А.ЛХАГВА

Монгол Улсын гавъяат хуульч, доктор (Ph.D),
профессор

Г.ЭРДЭНЭБАТ

Улсын Ерөнхий Прокурорын орлогч, Төрийн хууль
цаазын шадар зөвлөх

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.ГАНТУЛГА

Доктор (Ph.D)

Б.ЭНХБОЛД

Доктор (Ph.D)

ДУГААРЫГ ЭРХЛЭН ГАРГАСАН

С.ГАНТУЛГА

Доктор (Ph.D)

ЭХ БЭЛТГЭГЧ ДИЗАЙНЕР

Х.БАДНААЖОНОН



Гарчиг

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

• Монгол Улс дахь кибер гэмт хэргийн нөхцөл байдал, үйлдлийн арга, урьдчилан сэргийлэх асуудал Д.Сумьяацэрэн	4
• Насанд хүрээгүй хүн гэмт хэрэг үйлдсэн, гэмт хэргийн халдлагад өртсөн шалтгаан нөхцөл, анхаарах зарим асуудал Т.Мөнхзүл	9
• Монгол Улсын алтны салбарын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал Ц.Эхбаатар	14
• Зэвсгийн хууль бус эргэлтийн өнөөгийн байдал, анхаарах асуудал Ц.Очгэрэл	18
• Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ Д.Гомбосүрэнжав, Э.Энхболд	22
• Гэмт хэргийн статистикийн ойлголт, хөгжил, чиг хандлага М.Хатанзориг	26
• Шүүхийн байгууллага дахь гэмт хэргийн статистикийг боловсронгуй болгох нь Г.Уянга	30

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

• Хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гадаадын орнуудын Эрүүгийн хуульд хуульчилсан байдал, түүнд хийсэн харьцуулсан судалгаа Г.Гантөмөр, О.Амарсайхан	32
• Монгол Улсын ялын бодлогын өөрчлөлт (2012-2016) С.Гантулга, Б.Энхболд	39
• Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах гэмт хэргийг Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжид хуульчилсан байдал Э.Золбоо	46
• Иргэдийн улс төрийн (сонгуулийн эсрэг) эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэргийг зүйлчлэхэд анхаарах асуудал Д.Ганзориг	50

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

• Гэмт хэрэг мөрдөн шалгах үйл ажиллагаанд орчны нөхцөлийг үнэлэх онол, загварыг ашиглах нь Г.Бямбадорж	53
• Шүүхийн ажиглалт, хэргийн хөдөлгөөний менежмент ба анхан шатны шүүх хуралдааны тов С.Эрдэнэболор, М.Ариунаа	57
• Хэргийн газрын үзлэгийн удирдлага, зохион байгуулалт, хамтын ажиллагаанд тулгамдаж буй асуудлууд Х.Бат-Эрдэнэ	60

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

• Дотоод аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллага: Монгол Улс ба гадаадын зарим орны жишээн дээр Б.Энхболд, М.Баярсайхан	67
• Монгол Улс дахь нийтийг хамарсан арга хэмжээний нөхцөл байдал, гадаадын зарим улс оронтой харьцуулан авч үзэх нь М.Батбаяр	72
• Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд инновацийг нэвтрүүлэх хэрэгцээ, шаардлага Б.Наргулан	77

КРИМИНАЛИСТИКИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

• Монголын криминалистикийн түүхийн хуудаснаа нэмэрлэхүй: мөр мөшгин хохирол нэхэмжилж байсан тухай нэгэн баримт Б.Жаргалсайхан	80
----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	----

ТӨР, ЗАХИРГАА, ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

• Төрийн албан хаагчид хүлээлгэх сахилгын шийтгэл ба хууль зүйн хугацаа /зарим хууль тогтоомжинд хийсэн дүн шинжилгээ/ С.Эрдэнэболор, Н.Эрдэнэбаяр	83
-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	----



КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ



МОНГОЛ УЛС ДАХЬ КИБЕР ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ҮЙЛДЛИЙН АРГА, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АСУУДАЛ

Д.Сумъяацэрэн
ХСИС-ийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн Цагдаа судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан, цагдаагийн ахмад

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооноос гаргасан судалгаагаар Монгол Улсад 2016 оны эхний хагас жилийн байдлаар давхардсан тоогоор 2,512,100 интернет хэрэглэгч байгаагаас 30 сүлжээний хэрэглэгч 90,79 хувийг эзэлж, нийт хэрэглэгчдийн хамрах хүрээ 86,7 хувь нь Улаанбаатар хотод, 10,3 хувь нь аймагт, 2,9 хувь нь сумдад, интернет үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 59 аж ахуй нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байна.^[1] Интернетийн хэрэглээ эрс нэмэгдэж, зөвхөн компьютер төдийгүй төрөл бүрийн ухаалаг төхөөрөмж ашиглан сүлжээнд холбогддог болсон, өдөр тутмын амьдралын олон хэрэглээг ухаалаг төхөөрөмж, сүлжээ ашиглан эрхлэн явуулдаг болсонтой зэрэгцэн технологийн ололт амжилтыг гэмт хэрэг үйлдэх зорилгоор ашиглах төрөл, арга хэлбэр, технологи хөгжиж байна.

Дэлхийн улс, орнууд үндэсний бодлого, стратеги гаргах, хүний нөөцөө бэлтгэх, хамгаалалтын дэд бүтэц бий болгох, байгууллага бүр бодлого, журам батлан мөрдөж, эрсдлийн үнэлгээ, аудит дээр суурилсан хамгаалалтын шийдлүүд хэрэгжүүлэх, цахим гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоогоо бий болгох, эрх зүйн орчин, хамгаалалтыг бий болгох, бүх нийтийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх замаар энэ төрлийн гэмт явдалтай тэмцэж байна.


Манай улсын хувьд “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ыг шинэчлэн

баталж “Мэдээллийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр” гаргасан ч хэрэгжилт нь хангалтгүй, ялангуяа хуулийн салбарын ажилтнууд цахим гэмт хэрэгтэй тэмцэх туршлага, мэдлэггүй, техникийн хангалт, шинжлэн судлах чадвар бүрэлдээгүй, эрх зүйн зохицуулалт, орчин хоцрогдсон, хууль, хяналтын байгууллагууд өөрсдөө кибер халдлага, гэмт хэргийн хохирогч болсоор байгаа нь нууц биш.

Цахим гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалт хангалтгүй, тооцоолох төөхөөрөмжөөс нотлох баримтуудыг гарган авах, баталгаажуулах техник хэрэгсэл, мэргэжилтэн дутмаг байна. Цахим файл, өгөгдлийг нотлох баримт гэж тооцохгүй учир ихэнх цахим гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа мухардалд орох магадлалтай. Тооцоолох хэрэгслийн бүртгэл, аудитын файлуудыг гаргаж авах, шинжлэх, түүнээс нотлох баримтууд олох, бэхжүүлэх талын ямар ч чадвар, тогтолцоо, дэд бүтэц, хүний нөөц байхгүй учир цахим гэмт хэргийг илрүүлэх чадвар маш доогуур түвшинд байна гэж үзэж байна. Олон улсын хамтын ажиллагаа хөгжөөгүй учир хил дамнан үйлдэгддэг цахим гэмт хэргийг илрүүлэх боломжийг үгүй болгож байгаа юм.

Сүүлийн жилүүдэд цахим орчинд үйлдэгдэх гэмт хэргийн төрөл нэмэгдэж түүнийг дагаад гэмт хэргийн гаралт мөн адил ихсэж байна. Иргэд цахим орчинд бусдыг доромжлох, гүтгэх, бусдын захидал харилцааны нууцад халдах, зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг зөрчих, залилан мэхлэх, далайлан сүрдүүлэх, компьютер, мэдээллийн сүлжээ ашиглан үйлдэж буй гэмт хэргүүд ихээр бүртгэгдэх болжээ.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 25 дугаар бүлэг. Компьютер, мэдээллийн аюулгүй байдлын эсрэг бүртгэгдсэн гэмт хэрэг /2006 – 2016/^[2]




Сүүлийн арван жилийн байдлаар ЭХТА-

¹ ЦЕГ-ын ЭЦГ-ын “Цахим орчинд хуурамч шуудангийн хаяг ашиглан үйлдэж буй гэмт хэрэг, тулгарч буй хүндрэл бэрхшээл, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал”-д дурдсанаар.

² “Гэмт хэргийн мэдээ” /2006-2011 он/, ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны төв, Эрүүгийн цагдаагийн газрын тоо мэдээ /2017/-ээс.



ийн 226-229 дүгээр зүйл ангид хамаарах бүртгэгдсэн гэмт хэргийн тоо баримтаас харахад, сүүлийн гурван жилийн хугацаанд 4-5 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Манай улсын хэмжээнд 2014 оноос 2017 оны эхний сарын байдлаар цахим орчинд гэмт хэргийн хохирогч болсон тухай нийт 476 өргөдөл, гомдол бүртгэгдсэнээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 110 дугаар зүйл, 111, 123, 135, 140, 148, 149, 226-229 дүгээр зүйл ангид хамаарах 202 гэмт үйлдэлд эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан байна.^[3]




Дээрх 202 эрүүгийн хэргийн 16 нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд, 39 эрүүгийн хэрэг буюу 19,3% нь яллах дүгнэлт үйлдүүлэхээр прокурорт санал хүргүүлж, яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй үндэслэлээр 29 эрүүгийн хэрэг буюу 14,3%-ийг түдгэлзүүлж, 20 эрүүгийн хэрэг буюу 9,9%-ийг өөр эрүүгийн хэрэгт нэгтгэж, 98 эрүүгийн хэрэг буюу нийт үүссэн эрүүгийн хэргийн 46,5% нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна. Дор графикт үзүүлбэл,



Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн
³ ЦЕГ-ын Эрүүгийн Цагдаагийн газрын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс ирүүлсэн мэдээллээс.

хохирогч болсон хүүхэд одоогоор байхгүй бөгөөд дээрх 202 эрүүгийн хэрэгт эрэгтэй 103, эмэгтэй 35, насанд хүрээгүй хүн 1, нийт 138 хүн холбогдон шалгагдсан ба яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй үндэслэлээр 29 эрүүгийн хэрэг түдгэлзүүлжээ.

Түүнчлэн, гадаад улс орнуудаас манай улсыг чиглэсэн олон зуун халдлага өдөр бүр бүртгэгдэж байдаг. ТЕГ-ын Кибер аюулгүй байдлын газраас манай улсад интернетийн үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгжийн 0.02% интернетийн урсгал дээр бодит, тухайн цаг мөчид (Real time) интернетээр хийгдэж буй хандалтын 2016 оны 4 дүгээр сарын халдлагын шинж бүхий хандалтын үзүүлэлт^[4]-ийг авч үзвэл,



Зөвхөн өнгөрсөн оны 4 дүгээр сард л гэхэд урд хөрш улсаас 22613 халдлагын шинж бүхий хандалт манай улсруу чиглэжээ. АНУ-аас 4034 хандалт бүртгэгдсэн бол Орос, Солонгос, Франц улсаас хандалтууд удаалж байна. Дээрх графикаас манай улс ямар эрсдэлд байгаа нь харагдаж байна.

Цахим орчинд бусдыг залилан мэхлэх, цахим шуудангийн залилан, бусдыг гүтгэх, доромжлох, мөн манай улсын хувьд уг гэмт хэргийн шинэ төрөлд тооцогдох скимминг зэрэг хэргүүд түгээмэл үйлдэгдэх болсон. Эдгээр гэмт хэргүүдийн үйлдэх арга хэлбэрийн тухайд товч байдлаар авч үзвэл,

Манай улсын томоохон худалдааны компаниуд цахим шуудангийн залилан мэхлэх гэмт хэрэгт өртөж их хэмжээний мөнгийг гэмт этгээдүүдийн гадаад улсын банкинд байрлах хуурамч дансанд шилжүүлэх байдлаар залилуулах явдал сүүлийн 3 жилд эрс нэмэгдсэн байна. Энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж буй этгээдүүд харилцагч байгууллагуудын /импортын худалдааны байгууллага/ цахим шууданд хууль бусаар нэвтэрч 2 байгууллагын хоорондын нууц мэдээллийг олж аван өөрт ашигтай нөхцөл байдал бүхий цахим шууданг нөгөө талд илгээх байдлаар төлбөрийг өөрсдийн дансанд шилжүүлэн авах гэмт хэрэг хэрэг юм. Энэ гэмт хэрэг нь ихэвчлэн харилцагч байгууллагын цахим хаягтай

⁴ <http://ncsc.gov.mn/?id=134>



тун төстэй /нэг үсэг, тэмдэгт илүү, дутуу, өөрчилж бичсэн/ өөр цахим хаягнаас тус байгууллагын дансны мэдээлэл өөрчлөгдсөн тухай үнэмшилтэй шалтгаан бүхий захидал илгээж уг захидалд дурьдагдсан дансанд мөнгөө шилжүүлснээр дээрх гэмт үйлдэл төгсдөг байна.

Сүүлийн 3 жилд Монгол Улсад цахим шуудангийн залилан мэхлэх 51 тохиолдол бүртгэгдсэнээс 21-д нь эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан байдаг бол дээрх 51 тохиолдлоор 23 иргэнд 860,572,311 төгрөгийн, 28 аж ахуй нэгж байгууллагад 1,733,475,014 төгрөгийн буюу нийт **2,597,047,325** төгрөгийн хохирол учирсан байна.^[5]

Цахим орчинд үйлдэгдэж буй залилан мэхлэх гэмт хэрэг нь онлайн худалдан авалт хийх, мессеж, цахим шуудан хэлбэрээр их хэмжээний мөнгө хожсон, өв залгамжлагч болсон, хэн нэгэнд туслах шаардлагатай байгаа зэрэг захидал ирэх, цахим болзоо тогтоох, гадаад төслийн зээлийн санал ирэх зэрэг төрлүүдээр үйлдэгдэж байна. Цахим шуудангийн залилан мэхлэх гэмт хэрэгт өртөхгүй байх үүднээс албаны цахим шууданг олон хүн дундаа ашиглахгүй байх, нэг компьютерээр тухайн хаягт нэвтэрдэг байх, цахим хаягаа гар утастай холбосон байх, харилцагч байгууллагын цахим шуудангийн хаягийг нягталж байх, дансны мэдээлэл өөрчлөгдсөн тохиолдолд заавал утсаар тодруулж байх, интернет орчинд худалдан авалт хийх, татвар шимтгэл төлөх, тусламж үзүүлэх зэрэг үйлдэл хийхдээ эх сурвалжийг нягтлан шалгаж мөнгөн шилжүүлэг хийснээр энэ гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх боломжтой юм.

Фэйсбүүк компаний Ази номхон далайн хариуцсан төлөөлөгчийн 2016 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Монгол Улсад зохион байгуулсан уулзалт семинарын үеэр тавьсан илтгэл дээр дурьдсанаар Монгол Улсад сард нэгээс доошгүй удаа тус сайтад ханддаг 1,600,00 хэрэглэгч, өдөр бүр тогтмол ханддаг 950 хэрэглэгч идэвхитэй фэйсбүүк ашиглаж байна. Тус компаниас гаргасан судалгаагаар фэйсбүүк хэрэглэгчдийн 5-10 хувь буюу ойролцоогоор 140 сая хуурамч хаяг, Твиттер хэрэглэгчдийн 4 хувь буюу ойролцоогоор 20 сая нь хуурамч хаяг байгааг тогтоосон байдаг. Сүүлийн жилүүдэд Филиппин, Сингапур, Малайз зэрэг Азийн улс орнуудын харьяалалттай гэмт этгээдүүд хуурамч Фэйсбүүк хаяг ашиглан манай улсын иргэдтэй харилцаа холбоо тогтоох,

⁵ ЦЕГ-ын Эрүүгийн Цагдаагийн газрын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс ирүүлсэн мэдээллээс.

харилцан мэдээлэл солилцох, видео чат хийх зэргээр иргэдийн хувийн мэдээллийг цуглуулах, мэдээллийг хууль бус үйл ажиллагаанд ашиглах гэмт хэрэг ихээр гарах болсон. Гэмт этгээдүүд нь ямар нэг байдлаар иргэдтэй харьцаа тогтоож улмаар видео чат хийх хүсэлтийг илгээдэг, үүний дараа чат хийж байгаа бичлэгийг хуулбарлан цахим хуудсанд байршуулж танил найз нөхөд, гэр бүлийнхэнд нь мэдээллийг тараана гэх зэргээр дарамталж бэлэн мөнгө өгөхийг шаарддаг.



Шинэ төрлийн цахим гэмт хэрэгт тооцогдох скимминг /skimming/-ийн тухайд АТМ буюу бэлэн мөнгөний автомат машинд суурилуулсан иргэдэд үл мэдэгдэх тусгайлан бэлтгэсэн төхөөрөмжийн туслалцаатай хэрэглэгчийн банкны гүйлгээний картын мэдээллийг хуулбарлан авах, гүйлгээнийпин код оруулах хэсэгт бичил камер байрлуулах замаар бусдын дансанд хууль бусаар нэвтрэх гэмт үйлдэл гэж тодорхойлж болох юм.^[6] Энэхүү гэмт үйлдэл нь дэлхийн өндөр хөгжилтэй улс орнуудад ихээр үйлдэгдэж байгаа бөгөөд манай улсад хоёр ч тохиолдол бүртгэгдсэн байдаг. Иймд Хууль сахиулах салбарын болон, банк санхүүгийн байгууллагуудын ажилтан, алба хаагчдыг мэдээллээр хангах, урьдчилан сэргийлэх асуудал зүй ёсоор тавигдаж байгаа юм. Саяхны жишээ дурдвал, өнгөрсөн оны 08 дугаар сард БНХАУ-ын 4 иргэн гэрээт ажилчнаар манай улсад ирсэн бөгөөд манай улсын арилжааны банкнуудын АТМ буюу бэлэн мөнгөний машинд скимминг төхөөрөмжийг 3 хоногийн хугацаатай байрлуулж харилцагчдын мэдээллийг хууль бусаар хуулж авч өөрийн улсдаа гүйлгээ хийж 126,0 сая төгрөгийн хохирол учруулсан хэрэг гарсан байна.

2012 оноос манай улсад Украин, Малайз улсын иргэд хуурамч виза карт ашиглан арилжааны банкуудын АТМ буюу бэлэн мөнгөний машинаас их хэмжээний мөнгө авсан, авахыг завдсан хэргүүд удаа дараалан гарсан. Тухайлбал, Малайз улсын иргэд хуурамч төлбөрийн карт ашиглаж томоохон

⁶ Л.Цогтбаяр нар. "Цахим мэдээллийн орчинд үйлдэгдэх гэмт хэргийг мөрдөн шинжлэхүйн онол, арга зүйн үндэс". УБ., 2015, 294 дэх тал.



худалдааны төвүүдээс бараа бүтээгдэхүүн худалдаж авсан нь илэрсэн. Гэмт этгээдүүд ойролцоогоор 45 сая орчим төгрөгийн гүйлгээ хийсэн болохыг илрүүлсэн байдаг. Тэд Монгол төдийгүй бусад орны банкны картыг дуурайн хийдэг болох нь тодорхой болсон. Жишээлбэл, АНУ-ын “Чейз”, “Ай Ти Эс” гэх мэт банкны харилцагчдийн картны хар туузан дахь мэдээллийг хулгайлж Малайзад бэлтгэсэн картны бэлдэц дээр суулгадаг аж. Ингэснээр тухайн карт эзэмшигчийн мэдээлэл гэмт этгээдүүдийн гарт ордог байна.

Энэ төрлийн гэмт хэрэг буюу хуурамч карт ашиглаж арилжааны банкнуудаас бэлэн мөнгө хүүлэх гэмт хэрэгт гаршсан нилээдгүй гэмт бүлэглэл байдаг талаар дэлхийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээллэдэг. Тиймээс ч олон улсын банкууд хяналтын системээ сайжруулж луйвар хийх боломжгүй болгосон. Гэтэл сүүлийн үед манай улсруу тус луйвраа, мөнгө хүүлэх гэмт хэргээ үйлдэхээр олноор ирж байгаа нь манай улсын банкны хяналтын систем муу байгааг бэлхэн харуулж байгаа юм. Тиймээс арилжааны банкууд хамгаалалт, хяналтын системээ сайжруулах арга хэмжээ авах шаардлагатай юм.

ДҮГНЭЛТ

Цахим гэмт хэрэг нь тооцоолох төхөөрөмж болон сүлжээний арга хэрэгслийг ашигласан гэмт хэрэг үйлдсэн үйл ажиллагааг хэлж болох ч нарийн тодорхойлох шаардлагатай болон маргаантай асуудлуудыг ихээхэн дагуулдаг. Гэмт хэргийг үйлдэхдээ техник хангамж, програм хангамжийг ашиглах болсон нь уламжлалт гэмт хэргийг цахим гэмт хэрэг болон өөрчлөхөд хүргэж байна. Монгол улсын эрүүгийн хуулийн 25 дугаар бүлэг, 226-229 дүгээр зүйлд компьютер, мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт 4 төрлийн гэмт хэргийг хамааруулж хуульчилсан нь цахим гэмт хэрэг гэсэн тодорхойлолтыг бүрэн илэрхийлж чадахгүй байна.

Монгол Улсын өнөөгийн байдлыг хууль эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй, мэдээллийн аюулгүй байдлын мэргэжилтэн цөөн, иргэдийн мэдээллийн аюулгүй байдлын талаарх мэдлэг муу, төрийн мэдээллийн нэгдсэн дотоод сүлжээ байхгүй, интернэтэд олон гарцаар замбараагүй холбогддог, албан ёсны эрхтэй үйлдлийн систем, хэрэглээний програм хангамж хэрэглэдэггүй зэргээр тодорхойлж болох юм. Манай улс үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалдаа мэдээллийн аюулгүй байдлыг үндэсний аюулгүй байдлын бие даасан нэг

төрөл гэж тусгайлан тодорхойлолт өгсөн хэдий ч өнөөг хүртэл мэдээллийн аюулгүй байдлын суурь хууль батлагдаагүй байна.

Өсвөр үеийг мэдээллийн технологийн хэрэглээнд сургадаг аюулгүй, зүй зохистой хэрэглээнд сургах, цахим орчинд учирч болох төрөл бүрийн аюул, заналхийллээс сэргийлэх мэдлэг, ойлголт хангалттай хэмжээнд өгдөггүйн улмаас тухайн гэмт хэргийн хохирогч болох магадлалыг нэмэгдүүлсээр байна. Тиймээс нийгэм даяараа аюулгүй, зохистой хэрэглээний туршлага, ойлголт сул, цахим гэмт хэргийн хохирогч болсон ч тийм зүйл байх л мэтээр хүлээн авдаг байдал төлөвшиж байна. Их дээд сургуулиудад энэ талын мэргэжилтэн бэлтгэх тал дээр сул анхаардаг, бэлтгэж буй мэргэжилтнүүд нь ерөнхий чиглэлийн, орчин үеийн шаардлагаас хоцорсон байдалтай байна. Мэргэжилтнүүдийг цаашид мэргэшүүлэн бэлтгэх үндэсний бололцоо нөөцөө огт ашигладаггүй, хөрөнгө мөнгө хуваарилдаггүй, удирдлага дэмждэггүй зэрэг сул талуудыг нэрлэж болохоор байна.

Цагдаагийн алба хаагчдын цахим гэмт хэргийн талаарх, уг гэмт хэргийн шинжүүдийн талаарх мэдлэг ойлголт, цахим гэмт хэргийг илрүүлэх, бүртгэх, мөрдөн шалгах, зүйлчлэх, хянан шалгах, хариуцлага оногдуулах талаар мэдлэг, чадвар маш хангалтгүй түвшинд байна. Цахим гэмт хэргийг илрүүлэхэд онцгой чухал ач холбогдолтой ажиллагаа болох хэргийн газрын үзлэг хийх, ул мөрийг илрүүлэх, бэхжүүлэх, тэдгээрийг задлан шинжлэх, нотлох баримт гаргаж авах чадварыг бий болгох нь онцгой чухал асуудал болоод байна.

САНАЛ

1. Орчин үеийн шинээр үүсч буй технологийн гэмт хэргүүд, түүний дотор цахим гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх эрх зүйн зохицуулалт, чадамжийг Монгол Улсад бий болгохын тулд юуны өмнө Эрүүгийн хуульд гэмт хэргийн шинэ шинж, бүрэлдэхүүнийг нэмэх, “Мэдээллийн технологи, харилцаа холбооны тухай”, “Мэдээллийн аюулгүй байдлын тухай”, “Өгөгдөл хамгаалах тухай”, “Төрийн өгөгдөл, мэдээлэлд хандах тухай”, “Цахим засгийн тухай” хууль, “Төрийн өгөгдөл мэдээлэл, сүлжээ, системийг хамгаалах тухай” хуулийг шинээр батлан гаргах, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, “Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай”, “Мэдээллийн эрх



чөлөөний тухай”, “Оюуны өмчийн тухай” хууль гэх зэрэг 40 орчим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж орчин үеийн цахим гэмт хэргийн шинжүүд, санкцийг нэмэх, орчин үеийн мэдээллийн технологийн харилцааны зөв зохистой зохицуулалтыг бий болгох, хамгаалах харилцаануудыг тодорхой болгон зохицуулах, цахим нотлох баримт, түүнийг үнэлэх асуудлыг нэмэх, нийгэмд цахим гэмт явдалтай тэмцэх сэтгэхүйг төлөвшүүлэх, мэдээллийн технологийг зөв зохистой хэрэглэх соёлыг төлөвшүүлэх, өгөгдөл, мэдээллийн үнэ цэнийг бий болгох, хамгаалах сэтгэхүй болон мэдээллийн аюулгүй байдлын үнэ цэнэ, ач холбогдол, түүний тухай ойлголтыг нийгэмд төлөвшүүлэх, цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, шалтгаан, нөхцлийг судлах, тэмцэх зохицуулалтыг бий болгох нь шийдвэрлэх арга замуудын нэг юм.

2. Манай улсын хувьд үндэсний мэдээллийн аюулгүй байдлаа бүрэн хангах, мэдээллийн технологи ашигласан шинэ төрлийн зөрчил, гэмт хэрэгтэй шуурхай, үр бүтээлтэй тэмцэхийн тулд Кибер гэмт хэргийн тухай конвенцид заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнийг Эрүүгийн хуульд авч хэрэглэх ч шаардлага бий. Тодуулбал, Кибер гэмт хэргийн тухай конвенцид нэгдэн орох, соёрхон батлах, эсхүл түүний агуулгыг Эрүүгийн хуульд нэг бүрчлэн хуульчилж одоогийн эрх зүйн зохицуулалтаа сайжруулж, шинэ төрлийн цахим гэмт хэргийн нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх, энэ зорилгоор олон улсын болон бүс нутгийн, хоёр талт харилцаатай байх боломж бүрдэнэ. Мөн дараах ойлголтыг хуульчлах нь эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхээс урьдчилан сэргийлэх, гэмт этгээд ял завших явдлыг таслан зогсооход чухал үр нөлөөтэй. Үүнд: компьютерийн сүлжээ, компьютерийн систем, компьютерийн мэдээлэл, интернэтийн үйлчилгээ үзүүлэгч, мэдээллийн урсгал, компьютерийн мэдээлэл, сүлжээний нууцлал, бүрэн бүтэн байдал, ашиглалт гэх мэт байдлаар гэмт хэрэг, зөрчлийн төрөл, онцлогоор нь хуульчлах шаардлагатай.

3. Мэдээлэлтэй холбоотой эрх зүйн актууд, төрийн бодлогын баримт бичгүүдэд энэ төрлийн гэмт үйлдэл, зөрчлөөс сэргийлэх, хүүхэд залуус, нийгмийн гишүүдийг зөв, соёлтой, аюулгүй зан үйлд сургах, төлөвшүүлэх талаар тусгаж өгөх шаардлагатай нь харагдаж байна. Цэцэрлэг, дунд сургуулиас нь эхлэн хүүхэд, өсвөр үеийнхэнд аюулгүй зохистой хэрэглээ, соёлтой зөв зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалтын агуулга, хөтөлбөрийг бий болгох, мэдээлэл зүйн хичээлийн агуулгад нэмж оруулах шаардлага харагдаж байна. Их дээд сургуулийн оюутнуудад “Цахим орчинд ажиллах ёс зүй, соёл” хичээлийг ордог болгох

хэрэгтэй байна.

4. Төрийн байгууллагуудаас гадна Компьютерийн халдлагатай тэмцэх баг, мэдээллийн аюулгүй байдал, цахим гэмт хэргийн чиглэлд ажилладаг, судалдаг, шийдэл боловсруулдаг хувь хүн болон төрийн бус байгууллагуудыг бодлогоор дэмжих, тусламж, дэмжлэг үзүүлэх, олон улсын хамтын ажиллагаа хөгжүүлэхэд нь туслах нь олон талын ач холбогдолтой гэж үзэж байна.

5. Цахим гэмт хэрэг нь хил хязгааргүй үйлдэгддэг онцлогтой, иймд цахим гэмт хэргийг илрүүлэхэд олон улсын хамтын ажиллагаа маш чухал. Тиймээс ч манай улсын хувьд цахим гэмт хэрэгтэй тэмцэх 2001 оны Будапештийн конвенцид нэгдэн орох шаардлагатай байна. Тус конвенцид нэгдэн орсноор компьютерийн сүлжээ, мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал, ашиглалтын эсрэг шууд чиглэсэн халдлагыг таслан зогсоох, тус халдлагыг гэмт хэрэг болгон хуульчлах, түүнийг дотоодын болон олон улсын түвшинд илрүүлэх, мөрдөх, яллах, тус гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй хууль тогтоомж батлах, холбогдох олон улсын итгэмжлэгдсэн, шуурхай хамтын ажиллагааг сайтар зохион байгуулахад чухал үр нөлөөтэй юм. Мөн цахим гэмт хэргийн талаар хамтран ажиллах, харилцан туслалцах гэрээг бүс нутгийн болон халдлагын эх үүсвэр болж буй улсуудтай байгуулах нь олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх нэг арга зам мөн.

6. Олон улсад энэ чиглэлээр тэргүүлдэг гадаад улсын шилдэг туршлагаас судлах, нутагшуулах, цахим гэмт хэрэгтэй тэмцэх асуудлыг судлах талаар төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх мэргэшсэн алба хаагчид буюу кибер-мөрдөгчдийг бэлтгэхэд анхаарах, тоон ул мөр бэхжүүлэх, илрүүлэх, шинжилгээ хийх, техник хэрэгсэл бүхий лабораторийг байгуулах, цахим нотлох баримттай ажиллаж сургах, гаргасан өгөгдлийг тайлан унших чадварт сургах хэрэгцээ нэгэнт бий болжээ. Энэ чадварыг бий болгосноор зөвхөн цахим гэмт хэрэг төдийгүй тооцоолох хэрэгсэл ашигласан аливаа гэмт хэргийн нотлох баримтуудыг гарган авах, ашиглах, гэмт хэргийг мөрдөхөд орчин үеийн технологийн ололт, чадамжийг ашиглах боломж нээгдэнэ.



НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮН ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН, ГЭМТ ХЭРГИЙН ХАЛДЛАГАД ӨРТСӨН ШАЛТГААН НӨХЦӨЛ, АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ



Т.Мөнхзул

Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтсийн Нийтийн хэв журам хамгаалах тасгийн ахлах байцаагч, магистрант, цагдаагийн ахмад

Товч агуулга: Насанд хүрээгүй хүн гэмт хэрэг, зөрчилд холбогдох, эрх ашиг нь зөрчигдөж, амь нас, эрүүл мэнд, сэтгэл санаагаараа хохирч байгаа тул энэ илтгэлээрээ гэмт хэрэг үйлдээд, гэмт хэргийн халдлагад өртөөд буй асуудлыг судалж, цаашид анхаарах асуудлын талаар дурдсан болно.

Түлхүүр үг: Хүүхэд, хүүхдэд учирч болзошгүй эрсдэл, гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга хэмжээ

ОРШИЛ

Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүүхдийн эрхийн тухай конвенцид “18 насанд хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэнэ”, Монгол Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд “Хүүхдийн эрхийг төрсөн цагаас нь эхлэн 18 насанд хүртэл хамгаалахад энэ хууль үйлчилнэ” гэж тодорхойлсон.

Хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдэд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сүүлийн үед төр засаг, цагдаа, олон улсын байгууллага, төрийн бус байгууллагуудаас тодорхой ажлуудыг санаачлан хийж байгаа боловч насанд хүрээгүй хүн гэмт хэрэг үйлдэж, гэмт хэргийн халдлагад өртөж амь нас, эрүүл мэндээрээ хохирсоор байна.

Энэхүү илтгэлээр насанд хүрээгүй хүн гэмт хэрэг үйлдсэн, гэмт хэргийн халдлагад өртсөн нөхцөл байдал, хандлагыг тодорхойлох, гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг нийгэм, эдийн засаг, боловсрол, гэр бүлийн орчны хүрээнд ангилан авч үзэж, түүнд үнэлэлт дүгнэлт өгөх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төр засаг, цагдаа, боловсрол, хүүхдийн байгууллагуудаас


авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, санаачлага гаргах нь чухал ач холбогдолтой юм.

ҮНДСЭН ХЭСЭГ

Техник, технологийн дэвшилтэт нөхцөл нь өөрөө өсвөр үе, залуучуудын гэмт хэрэг үйлдэх нэг шалтгаан болж байна. Тухайлбал: Цахим тоглоомын газар хонон өнжин тоглож байгаа өсвөр насны хүүхдүүд “тоглоомонд донтох сэтгэцийн эмгэг”-ийн улмаас жилд дунджаар 20 гарсан тоогоор хүргэгддэг. “Шар хадны эмнэлэг”-т тусгай тасаг нээх хүртлээ тийм хэмжээнд хүрч, РС тоглоом тоглох нэг цагийн мөнгө эцэг эхээсээ нэхдэг байсан хүүхдүүд яваандаа нэгнээсээ мөнгө, гар утас зэрэг эд зүйл дээрэмдэх /өөрсдийнх нь хэлдгээр “бариа хийх”/, хулгайлах, булаах, айлган сүрдүүлэх замаар мөнгө нэхэх зэрэг нуугдмал гэмт хэрэг, зөрчил үйлдэх болсон.

Монгол Улсын хэмжээнд насанд хүрээгүй хүмүүсээс үйлдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлт, ерөнхий хандлагыг авч үзэхэд 2007-2016 он буюу сүүлийн 10 жилийн хугацаанд 13625 хүүхэд, 8742 гэмт хэрэгт холбогджээ. Өөрөөр хэлбэл, жилд дунджаар 1362 хүүхэд, 874 гэмт хэрэг үйлдсэн байна.

1990 оноос манай улсад шилжилтийн үе эхэлж, ард иргэд нийгэмд дасан зохицож, төлөвшиж амжаагүй байдлаас хүүхэд гэмт хэрэг үйлдэх нь 2000 он хүртэл өссөн байх⁷ба мөн оноос 2010 он хүртэлх хугацаанд хүүхэд үйлдсэн гэмт хэрэг нь нийт гэмт хэргийн 4.4 хувийг эзэлж, жилд дунджаар 77 хэргээр буурсан байна. 2011-2015 онуудад өссөн, буурсан хэлбэлзэлтэй байсан ба 2016 оноос хүүхэд гэмт хэрэгт үйлдэх явдал буурах хандлагатай болжээ.



Сүүлийн арван жилийн байдлаас үзэхэд хүүхэд үйлдсэн гэмт хэргийн гаралт буурсан, цаашид ч буурах хандлага байна. Харин сүүлийн 3 жилд (2014-2016 онд) 3656 хүүхэд, 3173 гэмт хэрэг үйлдэж, 4393 хүүхэд⁸ гэмт


⁷ 1990-2000 онд хүүхдээс үйлдсэн гэмт хэргийн нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин 5-6 хувьтай байсан.

⁸ Цагдаагийн байгууллага 2007 оноос эхлэн гэмт хэргийн халдлагад өртөж хохирсон иргэн, байгууллагын талаарх

хэргийн халдлагад өртөж хохирсоны 303 буюу 6.8 хувь нь нас барж, 2316 буюу 52.7 хувь нь гэмтсэн^{9]} байна.

Өөрөөр хэлбэл, жилд дунджаар 977 хүүхэд 1057 гэмт хэрэг үйлдэж, 1464 хүүхэд гэмт хэргийн халдлагад өртөж, 101 хүүхэд нас барж, 772 хүүхэд гэмтжээ.

Насанд хүрээгүй хүн гэмт хэрэг үйлдэх нь багассан. Харин гэмт хэргийн халдлагад өртөх явдал тогтвортой буурахгүй байдал доорх судалгаанаас ажиглагдаж байна.



Гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэмт хэргийн халдлагад өртөж хохирсон 28 хүүхэд байна. Үүний 12 нь төрсөн хүүхэд, 1 нь үрчилж авсан хүүхэд, 15 нь дагавар хүүхэд байгаа юм. Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн судалгаагаанаас үзвэл, манай улсад хоёр хүүхэд тутмын нэг нь ямар нэгэн хүчирхийлэлд өртдөг гэжээ. Энэ тухай хүүхдүүдийн өөрсдийн ойлголт, үзэл бодол, хандлагыг судалсан судалгааны дүнгээс харахад уг судалгаанд оролцсон хүүхдүүдийн 20 гаруй хувь нь төрсөн болон хойд эцэг эх, бусад төрөл садангийн хүний дарамт, хүчирхийлэлд өртдөг гэжээ.

Мөн гэр бүлийн хүрэнээс гадуур үе тэнгийнхэн, насанд хүрэгчдийн дарамтад өртөх явдал (тус бүр 16 орчим хувь) цөөнгүй тохиолддог байна. Нийт хүүхдүүдийн 55% нь бусдын дарамт хүчирхийллийг ямар нэг хэмжээгээр амсдаг гэж хариулсан байгаа нь насанд хүрэгчидтэй харьцуулахад бараг 2 дахин өндөр бөгөөд үүнээс хойш хийгдсэн бусад судалгаагаар үүнтэй ойролцоо үр дүн (58.2%) гарсан нь эдгээр судалгаанууд хүүхдийн эсрэг хүчирхийллийн дүр зургийг харьцангуй бодитойгоор харуулж байна.

Гэмт хэрэг үйлдсэн, холбогдсон насанд хүрээгүй хүмүүсийн хувийн байдлыг аваад үзэхэд дийлэнх нь урьд өмнө өөрөө гэмт хэргийн улмаас хохирч байсан нь ихээхэн сонирхол татаж байгаа төдийгүй насанд хүрээгүй хүмүүсийн дунд зохиох урьдчилан сэргийлэх ажлыг нийгмийн бусад салбарын үйл ажиллагаатай хослуулах хэрэгцээтэй

мэдээллийн сан бүрдүүлж, статистик мэдээлэл гаргаж эхэлсэн.

^{9]} Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сан

байгааг харуулж байна.

Нийтлэг байдлаар авч үзэхэд эцэг, эхийн хайр халамж дутах, амьдралын түвшин доогуур, ядуурал, ажилгүйдэл, гуйланчлал, тэнүүчлэл, бусад хүмүүсийн сөрөг нөлөө, гэр бүлийн хүчирхийлэл, насанд хүрсэн хүмүүс болон ахмад насны хүүхдүүдийн зүгээс гэмт хэрэг үйлдэх эсвэл гуйлга гуйхыг шаардан дарамтлах, сониуч, гэнэн зан, амархан автдаг байдал, багш нар, эцэг эхчүүдийн таагүй харьцаа, сургууль завсардалт зэрэг олон нийгмийн сөрөг үзэгдэл нь энэ төрлийн гэмт хэргийн үндсэн шалтгаан нөхцөл болдог.^[10] Өөрөөр хэлбэл: Нийгэм, эдийн засаг, сургууль боловсрол, гэр бүлийн орчин, хүүхдээс шалтгаалах дараах шалтгаан нөхцөл байна. Үүнд:

а. Нийгэм, эдийн засгийн:

Ядуурал

Ажилгүйдэл

Нийгэмд архиан согтуурах явдал ихэссэнтэй холбоотойгоор худалдаа, үйлчилгээний газрууд хүүхдэд согтууруулах ундааг хууль зөрчин худалдаалж, үйлчилж байгаа байдал

Ломбард, гар утасны ченж нар хүүхдээс гар утас, үнэ хүрэх эд зүйлсийг хямд үнээр худалдаж авдаг байдал

РС тоглоомын газрын цагийн хуваарь хэтрүүлэн ажилладаг байдал

Хэвлэл мэдээллийн хэт задгай, интернэтийн хяналтгүй байдал

Өсвөр насны охидууд биеэ үнэлэх нь нэмэгдсэн. Үүний улмаас бэлгийн хүчирхийлэлд өртөх, хүчиндэх гэмт хэргийн хохирогч болох эрсдэл нэмэгдэж байна.

Хорихоос суллагдсан болон хорихоос өөр төрлийн ял шийтгэлтэй хүүхдүүдийг нийгэмшүүлэх асуудал орхигдсон.

б. Сургууль, боловсролын:

Багш сурган хүмүүжүүлэгч нар хүүхэд бүрт хүрч ажиллахгүй

Хүүхдийн хүмүүжлийн чиглэлээр зохиогдох ажил хангалтгүй

Сургуулийн хүрээнд бүлэг бөөгнөрөл үүсгэх, нэгнийгээ уруу татах, бусдыг дарамтлах явдал гардаг

Сурагчдын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчин байхгүй (*дугуйлан, секц, сонгон судлах хичээлүүд дутмаг, байсан ч төлбөртэй байдаг*)

Хүүхдийг хүмүүжүүлэх, хүүхдийн сэтгэл зүй, сэтгэлгээг өөрчлөх, ёс зүйн төлөвшил олгох ажил дутагдалтай

в. Гэр бүлийн:

Гэр бүл дэх хүчирхийлэл

^{10]} Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал. Гэр бүлийн хүчирхийлэл, насанд хүрээгүйчүүдийн гэмт хэрэг дэх оролцоо, нөлөөлөл, цаашдын чиг хандлага. УБ., 2014.т.69



Эцэг, эхчүүдийн хэрүүл маргаан, таагүй харьцаа

Гэр бүл салалт

Эцэг, эхийн хараа хяналт сул, халамж анхаарал төдийлөн сайн тавьдаггүй

Гэр бүлийн орчинд эцэг, эхчүүдийн архидалт

Хүүхдийн нас, бие бялдар, хөгжлийн онцлогийг мэддэггүй, анзаардаггүй

Хүүхэдтэй зөв харьцах, тэднийг хүмүүжүүлэх арга барил дутмаг

г.Хүүхдээс шалтгаалах:

Хүүхдийн ухамсар, хүмүүжлийн доголдолтой байдал

Амар хялбар аргаар мөнгө олох сэтгэлгээтэй болсон

Амьдралын үнэ цэнийг мөнгөтэй холбон үзэх үзэл бодол бий болсон

Сэтгэл зүйн хатуужил, эр зоригийн хүмүүжил, бие даасан байдал төлөвшөөгүй

Хүүхдийн өөрийнх нь эмзэг байдал, ганцаардал

Найз нөхдийн сөрөг нөлөө, бусдыгаа уруу татах (тамхи татах, архи уух) нөлөөлөл

Хүүхдийн сонууч гэнэн зан, дэмий сэлгүүцэх, атаман байхыг хүсдэг байдал

Насанд хүрэгчдийн гар хөл болох, гэмт хэрэг үйлдэхэд нь оролцох, хамтрах

Мөн хүүхэд гэмт хэрэг үйлдэж байгаа шалтгаан нөхцөл нь давхар хүүхэд гэмт хэргийн халдлагад өртөх эрсдэл болж байна.

Хамгийн гол нь эцэг, эхийн хараа хяналт сул, аливаа дарамт, хүчирхийлэл, иргэдийн эрх зүйн мэдлэг дутмаг, сургууль боловсролын байгууллагаас урьдчилан сэргийлж сургалт, зөвлөмжийг тэр бүр хүргэдэггүй, эцэг эх, ар гэрийнхэнтэй нь энэ талаар хамтарч ажиллахгүй байгаагаас гэмт хэрэгт өртөх тохиолдол таслан зогсоогдохгүй^[1] байна.

Хүүхдийн амь нас, эрүүл мэнд хохирч байгаа нэг шалтгаан нөхцөл бол зам тээврийн осол, хэрэг юм. Энэ нь замын нөхцөл байдал, жолоочийн ур чадвар, хөдөлгөөнд оролцох соёл, анхаарал болгоомжгүйгээс хамаарч байна. Жолооч нар замын хөдөлгөөнд оролцохдоо хүүхдэд хамгаалалтын бүс зүүлгэдэггүй, хүүхдийг зорчигчийн өвөр дээр суулгасан, хурд хэтрүүлдэг, замын хөдөлгөөнд оролцох соёл, дадал дутмаг, санамсар болгоомжгүй байдлаас хүүхэд зам тээврийн осолд ихээр өртөж байна.

Насанд хүрээгүй хүн гэмт хэрэгт холбогдоод байгаагийн шалтгаан нөхцөлийг тодруулах судалгааг /Судлаач Д.Эрдэнэбаатар/ гэмт хэрэгт холбогдсон 40 хүүхэд, тэдний ар гэр асран хамгаалагчид болох 40 хүн, нийт 80 хүмүүст хийсэн судалгааны үр дүнгээс

харахад гэмт хэрэгт холбогдоод байгаа хүүхдүүдийн ихэнх хувь нь 16-18 насны хүүхдүүд байсан.

Судалгаанд хүүхдүүдийн асран хамгаалагчдаас эцгүүдийг хамруулахыг зорьсон боловч судалгаанд оролцсон хүмүүсийн 72.5% нь эмэгтэйчүүд байсан бөгөөд үүний 57,5 % нь хүүхдүүдийн эхчүүд байсан. Үүнээс харахад эрх толгойлсон эхчүүдийн хүүхдүүд гэмт хэрэгт холбогдож байгаа нь илүү их харагдаж байсан.

Гэр бүлийн орлого бага байх нь хүүхэд гэмт хэрэг үйлдэж байгаагийн нэг шалтгаан болж байна. Үүнийг нэг тод жишээ нь, судалгаанд хамрагдсан өрхийн 65% нь сард дунджаар 0-710000 төгрөгний орлоготой, 82% нь гэр хороололд амьдардаг. Мөн хүүхдүүдийн үйлдсэн гэмт хэргийн 65% нь хулгай, дээрмийн хэрэг байна.

Хүүхдүүдийн хүмүүжилд бас нэг шалтгаан болдог нь хэрэгт холбогдсон хүүхдүүдийн 77% нь амьдрал боломжтой байгаагаас харагдаж байна. Гэмт хэрэгт холбогдсон хүүхдүүдийн 62,5% цахим тоглоом тоглодог бөгөөд энэ нь гэмт хэрэг үйлдэх шалтгаан болдог бөгөөд цахим тоглоом тоглох мөнгө олох үүднээс хулгай дээрэм хийж байна.

Хүүхдүүдийн зүгээс эцэг эхийнхээ ойр дотно харилцааны байдлыг үнэлсэн үнэлгээнээс харахад эцэг эхчүүд хүүхдээ хэт хамгаалдаг буюу дээд түвшин нь 87.5% байна. Үүний нэг жишээ нь, “танай хүүхэд энэ хэргийг санаачилсан уу” гэсэн асуултад 77% нь үгүй гэсэн хариулт өгсөнөөс харагдаж байна. Харин асрамж халамжийн түвшин нь дунд буюу дундаас доош нь 85% байгаа нь асрамж халамж муугаас хүүхдүүд гэмт хэрэгт холбогдох нэг шалтгаан гэж үзэж болно.

ДҮГНЭЛТ

Насанд хүрээгүй хүмүүсээс гэмт хэрэг үйлдсэн, гэмт хэргийн халдлагад өртөж хохирсон талаарх нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тоймлон үзсэнээр дараах дүгнэлтэнд хүрч байна.

1. Манай улсын хувьд насанд хүрээгүй хүний үйлдсэн гэмт хэргийн ихэнх хувийг хулгайлах гэмт хэрэг эзэлж байна. Хулгайлах гэмт хэрэг бол үндсэндээ хүн амын ядуурал, ажилгүйдэл, амжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой холбоотой юм. Гэр бүлээ тэжээх, амьдралын аргагүй эрхэнд хулгай хийж байгаа хүүхэд тоотой хэдхэн байгаа төдийгүй харин хүүхдүүд амар хялбар аргаар мөнгөтэй болох, мөнгө олж тоглох, баяр ёслол тэмдэглэх, зугаацах, цэнгэх гэсэн хүсэл сонирхлоор хулгайн гэмт хэрэг үйлдэж байна. Үйлдэж буй арга барилаас нь үзэхэд халааснаас

¹¹ Гаравсүрэн Н. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил ба цагдаагийн байгууллага. УБ., 2013.т.14



мөнгө, гар утас, эд зүйл суйлах, гэр, орон сууц, албан байгууллага, аж ахуйн нэгж байгууллагын байр, дэлгүүр, түүц, бөөний төв, ломбард зэрэгт түлхүүр тааруулах, цонх тагтаар нэвтрэх, хаалга үүдийг эвдэх аргаар хулгайлах гэмт хэрэг үйлдэж, хулгайлсан эд зүйлээ хямд үнээр борлуулдаг, барьцаалан зээлдүүлэх газарт тавьдаг байна.

2. Сүүлийн үед хүүхдийн хүмүүжил, ёс суртахууны төлөвшлөөс шалтгаалаад бусдын бие махбодид гэмтэл учруулах буюу нэгнийхээ биед хөнгөн, хүнд, хүндэвтэр гэмтэл санаатай болон болгоомжгүйгээр учруулах гэмт хэрэг үйлдэгдэж байна. Архидан согтуурах, шөнө оройн цагаар гадуур сэлгүүцэх, сургуулийн орчинд тавих хяналт сул, бүлэг бөөгнөрөлд чиглэсэн сурган хүмүүжүүлэгч, багш нарын хяналт сул, урьдчилан сэргийлсэн, сэрэмжлүүлсэн сургалт, сурталчилгаа хангалтгүй байгаатай холбон үзэх үндэстэй юм.

3. Хүүхэд бусдын эд зүйлийг дээрэмдэх, мөн булаах гэмт хэрэг тодорхой хэмжээгээр үйлдэж байна. Өсвөр насны, ахлах ангийн хүүхдүүд бүлгээр хүүхдүүдийн гар утас, хувцас, дэвтэр, карманы мөнгийг авах нь сургуулийн орчин, ялангуяа гудамж талбайд, гэртээ харих, сургуульд ирэх замд нь булааж, дээрэмддэг байдал ажиглагдаж байна.

4. Хүүхдүүдээс хүчиндэх гэмт хэрэг багагүй үйлдэгдэж байгаа нь сэтгэл түгшээсэн асуудал. Эцэг, эхийн хараа хяналт сул, иргэдийн өөрсдийн эрх зүйн мэдлэг дутмаг, өсвөр насны хүүхдүүд согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулах, их, дээд, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны орчинд тавих хяналт сул зэрэгтэй голлон холбоотой.

5. Хүүхэд согтууруулах ундаа хэрэглэж үзэх, хэрэглэх зуршил бий болох эх сурвалж нь гэр бүлийн хүрэн дэх архидалт, баяр ёслол тэмдэглэлт өдрүүдээр согтууруулах ундаа хэт хавтгайруулан хэрэглэдэг явдалтай холбоотой.

6. РС тоглоомын газрууд орлого, ашгийн төлөө хүүхдийг хоногоор тоглуулдаг. Энэ байдлаас болж хүүхдүүд тоглоомонд донтож, дахин тоглохын тулд бусдын эд зүйл, мөнгийг хулгайлах, булаах, дээрэмдэх гэмт хэрэг үйлддэг байна.

7. Манай улсын иргэдээс сүүлийн үед мансууруулах бодис хэрэглэх явдал сэтгэл түгшээсэн асуудал болж байна. Хүүхдүүд цавуу, газ, хий үнэртэх, монголд ургадаг өвс ургамал түүх, татах зэргээр уруу татагдаж

болзошгүй байна.

8. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, интернэт, телевизээр төрөл бүрийн эротик кино, бичлэг үзэх, хүүхдийн хүмүүжилд сөргөөр нөлөөлөхүйц мэдээллийг шууд авах боломжтой болсон нь нийгэмд биеэ үнэлэх сөрөг үзэгдэл гарах, улмаар гэмт хэрэг үйлдэгдэх нөхцөл бүрдүүлж байна.

9. Хүүхдийн эрхийг хамгаалах төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа нэгдмэл бус, зарим төрийн бус байгууллагууд гагцхүү ашиг, орлогын төлөө ажиллаж буй хандлага байна. Хүүхдийн төлөө ажилладаг байгууллагууд хүүхдийн гэмт явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд дутмаг оролцох, зөвхөн тайлан мэдээ авах хэлбэрээр оролцож байна.

10. Хороо хариуцсан хэсгийн байцаагч нарын ажил үүргийн хуваарьт хэт их олон ажлыг давхардуулан хийж гүйцэтгэдэг учраас хүүхдийн асуудалд төдийлөн сайн анхаарал хандуулдаггүй дутмаг байна.

САНАЛ

Насанд хүрээгүй хүний гэмт хэрэг үйлдэх, гэмт хэргийн халдлагад өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах асуудалд анхаарал хандуулах нь зүйтэй байна. Үүнд:

1. Цагдаагийн байгууллагад “Хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх алба” байгуулах асуудлыг судалж шийдвэрлэх, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төрөл, мэргэжлийн албадын үүрэг оролцоог нэмэгдүүлж, мэргэшсэн боловсон хүчнээр хангах, чадавхжуулах;

2. Сэтгэл зүйн байдлаас хамаарч гэмт хэрэг үйлддэг, үйлдэж болзошгүй хүүхэдтэй ажиллахдаа мэргэшсэн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч ажиллуулах. (сэтгэл зүйчид ажилтан, алба хаагч руу хандах бус сурагчид, хэргийн оролцогчид руу хандаж үйлчилгээ үзүүлдэг байх);

3. Ерөнхий боловсролын сургуулиуд дээр байгуулсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл”-ийн үйл ажиллагааг идэвхижүүлэн “Цагдаа оюутны холбоо”, “Өсвөрийн цагдаагийн бүлэг”-ийн үйл ажиллагааг өргөжүүлж, сургуулийн захиргааны оролцоог нэмэгдүүлэх;

4. Нутгийн төр захиргааны байгууллагуудтай хамтран хүүхдийн дуу хоолойг сонсох “Хүүхдэд нээлттэй өдөр”-ийг сар тутамд явуулж хэвших, хүүхдийн санал хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэдэг. Мөн урьдчилан сэргийлэх санамж сэрэмжлүүлэг өгөх зэргээр шинэлэг ажлыг зохион байгуулах;



5. РС тоглоомын газрыг цагийн хуваарийн дагуу эрүүл ахуйн шаардлага хангасан орчин нөхцөлд ажиллуулах, зөрчил гаргасан тохиолдолд хариуцлага тооцох. РС тоглоомын газар, интернет кафегийн үйл ажиллагаа явуулах эрхийг зөвхөн Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр өгч байгааг өөрчилж, хүүхдийн эрхийг хамгаалах эрх бүхий байгууллага, орон нутгийн төрийн захиргааны байгууллагын саналыг харгалзан үздэг болгох;

6. Цагдаагийн алба хаагч бүр сөрөг санаа бодлоо эерэгээр сольж сурах хэрэгтэй. Тархи биеэ удирдаж, бие тушаал биелүүлдэг. Ид, уу, нарги, цэнгэ, маргаашийн тухай бүү бод гэсэн хуумгай үзэл бодлоор биеэ удирдаж хэрхэвч болохгүй. Өөрийн муу зуршил биеэ үргэлж шийтгэдэг. Айдас, зовиур бусад сөрөг бодол нь сэтгэхүйг эмх замбараагүй байдалд оруулдаг. Эерэг сэтгэлгээ л амжилтад хүргэнэ. Харин сөрөг сэтгэлгээ сүйрэл бүтэлгүйдэл авчирна. Ийм болохоор хүн бүрт өөдрөг сэтгэл, эерэг санаа бодлыг төлөвшүүлэх хэрэгтэй. Биеийн эд эсэд нөлөөлдөг сөрөг сүйрүүлэгч олон санаа бодол байдаг ч үүнийг тэвчээр, уйгагүй чармайлтын үрээр хэрэгжүүлж болдог.

Ном зүй

1. Гаравсүрэн Н. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил ба цагдаагийн байгууллага. УБ., 2013
2. Мөнхбаатар Ч., Даваасамбуу Б. Эрүүл зөв амьдрал энгийн зүйлээс эхлэнэ. УБ., 2014
3. Минжин Ц., Жалбажав Н. Шинжлэх ухааны судалгааны арга зүй. УБ., 2016
4. Мэдээлэл судалгааны төв. товхимол. Монгол Улс дахь 2010 оны гэмт хэргийн байдал, шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам. УБ., 2011
5. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал. Гэр бүлийн хүчирхийлэл, насанд хүрээгүйчүүдийн гэмт хэрэг дэх оролцоо, нөлөөлөл, цаашдын чиг хандлага. УБ., 2014
6. Отгонбаяр А. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд олон нийтийн оролцоо. УБ., 2011
7. Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сан

МОНГОЛ УЛСЫН АЛТНЫ САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ



Ц.Эхбаатар

ХСИС-ийн магистрант, цагдаагийн ахмад

Хураангуй: Алтны салбар нь аль ч улсын санхүү, эдийн засгийн хувьд баталгаа болж байдаг зүйл төдийгүй дээрх салбарын тогтворгүй байдал нь тухайн улсын үндэсний аюулгүй байдалд ч нөлөөлж байсан жишээ олон бий. Тиймээс манай улсын дээрх салбарын өнөөгийн байдал тулгамдаж байгаа асуудлын талаар харуулахыг зорьсон болно.

Түлхүүр үг: Алт, тусгай зөвшөөрөл, хайгуул, олборлолт, нөөц, шороон орд

Алт гэж хувилахуйн ухааны нэгэн язгуур махбодь, улбар шар өнгөтэй давтагдан сунахдаа сайн 2.5-3.0 хувийн хатуулагтай, 19.3 хувийн жинтэй зэвэрдэггүй төмөрлөг, эрдэнийн зүйл, үнэ цэнийн зүйл ^[12]Алтны хууль бус эргэлт нь олон улсын түвшинд зохион байгуулалттай гэмт хэрэг түүний дотор хар тамхи, мансууруулах бодисын хууль бус наймаа, зэвсгийн хууль бус наймаа зэрэг үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргүүдийн дараа орох, улс орны нийгэм эдийн засагт ихээхэн хохирол учруулдаг гэмт хэрэг бөгөөд манай улсын хэмжээнд дээрх гэмт хэргийн гаралт хэдийгээр сүүлийн жилүүдэд гаралт нь багассан дүр зураг харагдаж байгаа хэдий ч далд хэлбэрт шилжиж зохион байгуулалтад орсон болох нь илэрсэн хэргүүдээс тодорхой харагдаж байна.

Ашигт малтмалын газраас авсан судалгаагаар Монгол Улсын хэмжээнд нийт ашигт малтмал олборлох 1240 тусгай зөвшөөрөл байгаагаас 425 буюу 34.2 хувь нь алтны тусгай зөвшөөрөл эзэлж байна. 2014 онд 12 аймгийн нутаг дэвсгэрт 92 тусгай зөвшөөрлөөр 89 аж ахуйн нэгж аль олборлох үйл ажиллагаа явуулж, Стандартчилал хэмжил зүйн газраар 5119.9 кг алт сорьцлуулан 2682.4 кг-ийг Монгол

банкны эрдэнэсийн санд тушаасан байна.^[13]


Стандартчилал хэмжилзүйн газраар 2016 оны 10 дугаар сарын байдлаар нийт 5603.9 кг алт сорьц тогтоолгосноос 3039.6 кг буюу 55.5 хувь нь Монголбанкинд тушаагдсан. Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй боловч 2015 онд олборлолтын үйл ажиллагаа явуулаагүй гэх 19-н аж ахуйн нэгж 597.9 кг аптыг СХЗГ-аар сорьцуулан Монгол банкинд тушаасан байна.

Судалгаагаар хайгуулын болон ашиглалтын ямар ч зөвшөөрөлгүй 12 аж ахуйн нэгж 112.1 кг аптыг СХЗГ-аар сорьцлуулан Монгол банкинд тушаасан. Монгол улсын хэмжээнд хувиараа алт худалдан авах, борлуулах хэлбэрээр тогтмол идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг 201 алтны ченж, нинжа буюу гар аргаар алт олборлодог 10.768 иргэн байна гэсэн судалгааг ЭЦГ-ын эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс гаргажээ. Үүнд, Улаанбаатар хотын иргэд ороогүй байна. Дээрх статистик тоо баримтаас харахад төрөөс алт олборлолт, ашигт малтмалын салбарт тавих хяналтаа алдсан гэж үзэж болохоор байна. Үүнд, хяналт тавьж ажиллах төрийн байгуулагуудын ажлын уялдаа холбоо муу, хууль, эрх зүйн боловсронгуй бус байдлаас их хэмжээний эрдэнэс баялгийг гадагшаа алдахад хүргэж байна.

Алтны салбарын өнөөгийн байдал 1.Алтны тусгай зөвшөөрөл

Ашигт малтмалын газрын 2015 оны 10 дугаар сарын мэдээгээр Монгол улсад 3174 тусгай зөвшөөрөл /ТЗ/ хүчин төгөлдөр үйлчилж байна. Эдгээрийн дотор ашиглалтын тусгай зөвшөөрөл 1462, хайгуулын тусгай зөвшөөрөл 1712 байна.

Зураг 3. Алтны ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо



Одоогоор алтны 670 ашиглалтын тусгай зөвшөөрлийн лиценз байгаа бөгөөд энэ нь нийт ашиглалтын зөвшөөрлийн 49.4 хувийг эзэлж байна. Харин алтны 322 хайгуулын тусгай зөвшөөрөл байгаа нь нийт хайгуулын зөвшөөрлийн 23.1 хувийг эзэлж байна. Монгол улсын нийт нутаг дэвсгэрт ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 13.3

¹² “Шинжлэх ухааны академийн сэтгүүл” 2012 он. УБ

¹³ Буянтөр. Б. Мөнгө угаах гэмт хэргийг илрүүлэхэд анхаарах зарим асуудал. 2014 он



сая га талбай байгаагаас 22.2 хувь буюу 2.9 сая га талбайг алтны ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай эзэлж байна^[14].

Хүснэгт 1. Алтны ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо

Он	Алтны ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо	Алтны тусгай зөвшөөрлийн нийт тусгай зөвшөөрөлд эзлэх хувь
2009	513	59.5
2010	492	52.8
2011	437	41.9
2012	416	36.8
2013	397	32.9
2014	443	34.1
2015	444	31.9
2016	670	49.4

Алтны эрэл хайгуул

Уул уурхайн салбарт 2008-2013 онуудад хууль, эрх зүй болон татварын орчин тогтворгүй байсан нь алтны эрэл хайгуулын ажилд гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтыг татахад сөргөөр нөлөөлжээ. Бэлтгэгдсэн шороон ордын нөөц дуусч, цаашид шинээр томоохон нөөцтэй шороон ордууд нээгдэх магадлал бага байна. Дээрх хугацаанд олон мянган тусгай зөвшөөрөл цуцлагдаж, урт нэртэй хуульд орсон хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд ажил хийх боломжгүй болсон. Нийт тусгай зөвшөөрөлтэй талбайн хэмжээ Монголын нутаг дэвсгэрийн 40 хувийг эзэлж байснаа одоо 9.5 хувь болж, бараг 4 дахин буурсан^[15].

Алтны өнөөгийн байгаа нөөцийг нэмэгдүүлэх, шинээр илрүүлсэн орд газруудыг аж ахуйн эргэлтэд оруулах, үр ашигтай ашиглах шаардлагатай байна. Монгол улсын төсвөөс геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил гүйцэтгэхэд 2014 онд 10 тэрбум төгрөг буюу 5 сая ам.доллар хуваарилан хэрэгжүүлж байна.

2015-2016 онд Ашигт малтмалын газар нь өргөдөл болон дуудлага худалдааны журмаар 600 гаруй хайгуулын тусгай зөвшөөрлийг дотоодын болон гадаадын аж ахуйн нэгжүүдэд олгоод байгаа ба энэ нь хууль хяналтын байгууллагын анхаарлыг татсан асуудал болж байна.

Алтны нөөц

2015 онд шороон ордын 27.6 тонн, үндсэн ордын 224.2 тонн, алт агуулсан бусад металлын ордын 1101.3 тонн, нийт 2000 гаруй тонны алтны нөөц бүртгэгдсэн байна.

Хүснэгт 2. Алтны бүртгэгдсэн нөөц

Алтны ордын төрөл	2001		2009		2016	
	Ордын тоо	Нөөц, тн	Ордын тоо	Нөөц, тн	Ордын тоо	Нөөц, тн
Шороон орд	156	90.3	498	206.25	608	27.6
Үндсэн орд	15	50.2	31	127.8	74	224.2
Алт агуулсан бусад металлын орд	-	-	-	-	17	1101.3
Нийт	171	140.5	529.0	334.05	699	1353.1

Одоогоор Бороогийн алтны үндсэн ордын нөөцийг ашиглаж дууссан. Алтан Дорнод Монгол, Монголросцветмет ХХК-ийн Шижир-Алт, Монполимет зэрэг уурхайнуудын олборлолтын нөөц дуусч байгаа нь алтны олборлолтын хэмжээнд шууд нөлөөлж байна. Бэлтгэгдсэн нөөцөд шороон ордын нөөцийн эзлэх хувийн жин нилээд бага байгаа бөгөөд цаашид эрэл хайгуул хийх боломжтой нутаг дэвсгэр нь "Урт нэртэй хууль"-ийн хязгаарлалтын бүсэд орсон тул энэ чиглэлээр нөөц өсөх боломж бага, ирэх 7-8 жилд шороон ордуудын олборлолтын ажил багасч зогсох төлөв ажиглагдаж байна.

¹⁴ "Алтны суурь судалгаа 2025" Ашигт малтмалын хэрэг эрхлэх газраас гаргасан судалгаа.

¹⁵ Б.Буянтер" Мөнгө угаах гэмт хэргийг шалгаж баримтжуулах арга зүй" 2015 он. Эрдэм шинжилгээний илтгэл



3.1. Алтны шороон ордууд

Монгол улсад алтны 608 шороон орд илэрч, нөөц нь бүртгэгджээ^[16]. Эдгээрийн 169 шороон орд газруудад алтны олборлолтын үйл ажиллагаа явагдаж, ихэнх нөөц нь дуусч, зарим алтны ордуудын уул геологийн нөхцөл хүнд, олборлолтын өртөг, зардал өндөр зэргээс шалтгаалан олборлолт одоогоор явагдахгүй байна.

Одоогоор олборлолт хийгдэж байгаа шороон ордуудад 27.6 тонн алт байгаа гэсэн тооцоо гарч байна. Эндээс харахад алтны шороон ордуудын нөөц ихээхэн хэмжээгээр багасч, алтны холимог металлын ордуудад дагалдах байдлаар байгаа алт болон алтны үндсэн ордуудын нөөц нэмэгдэх хандлагатай байна.^[17] Цаашид алтны олборлолтын хэмжээг үндсэн болон алт агуулсан бусад металлын ордуудыг ашиглах замаар нэмэгдүүлэх боломж өндөр байна.

Хүснэгт 3. Алтны шороон ордуудын нөөц, аймгаар

№	Аймаг	Шороон ордын тоо	Ашиглаж байгаа уурхайн тоо	Нийт алтны нөөц, тонн
1.	Төв	179	50	12.9
2.	Сэлэнгэ	114	29	4.4
3.	Баянхонгор	99	29	4.8
4.	Дархан-Уул	46	15	2.2
5.	Булган	26	8	2.8
6.	Дорнод	20	8	1.5
7.	Өвөрхангай	26	8	1.3
8.	Увс	24	8	0.4
9.	Хэнтий	22	8	3.6
10.	Архангай	20	4	1.7
11.	Говь-Алтай	8	2	0.3
12.	Баян-Өлгий	4	-	-
13.	Өмнөговь	2	-	-
14.	Хөвсгөл	1	-	-
15.	Сүхбаатар	1	-	-
	Дүн	608	169	34.3

Төв, Сэлэнгэ болон Баянхонгор аймгуудад 392 алтны шороон орд бүртгэгджээ. Эдгээрээс 108 алтны шороон ордод олборлолт хийж байна. Эдгээр аймгуудад нийт шороон ордын 64.5 хувь, олборлолт хийж байгаа ордын 63.9 хувь, нийт нөөцийн 64.4 хувь нь хамарч байна.

3.2. Алтны үндсэн ордуудын нөөц

Монгол улсад байгаа алтны 74 үндсэн ордуудад 224.2 тонн алтны нөөц байна. Сэлэнгэ аймгийн Гацууртын алтны үндсэн ордын 50 тонн алтыг бүрэн ашиглаад байна. Эдгээрээс гадна Цагаанчулуут, Олон Овоот,

¹⁶ Алтны суурь судалгаа 2025” Ашигт малтмалын хэрэг эрхлэх газраас гаргасан судалгаа

¹⁷ “Алтны суурь судалгаа 2025” Ашигт малтмалын хэрэг эрхлэх газраас гаргасан судалгаа

Нарантолгой, Тавт болон Цагаан цахирын зэрэг ордууд үндсэн ордод хамаарч байна.

Хүснэгт 4. Алтны үндсэн ордууд, аймгаар

№	Аймаг	Үндсэн ордын тоо
1.	Сэлэнгэ	18
2.	Төв	13
3.	Өмнөговь	10
4.	Дорнод	6
5.	Ховд	5
6.	Өвөрхангай	3
7.	Баянхонгор	3
8.	Завхан	3
9.	Говь-Алтай	2
10.	Сүхбаатар	2
11.	Дорноговь	2
12.	Хэнтий	2
13.	Баян-Өлгий	2
14.	Дархан-Уул	1
15.	Дундговь	1
	Нийт	74

Гар аргаар алт олборлодог иргэд буюу “нинжа” нарын талаар

Монгол Улсад ашигт малтмалыг гар аргаар хувиараа олборлох үйл ажиллагаа нь зах зээлийн харилцаанд шилжсэн үеэс эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар улсын хэмжээнд 20 аймгийн 78 сум, 1 дүүргийн 214 газарт хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явагдаж байна. Иргэд олноороо албан бусаар ашигт малтмал олборлох болсноор тэдний үйл ажиллагаа болон байгаль орчин, нийгэмд үзүүлэх үр дагавар нь хяналтнаас гарсан гэж үзэж болохоор байна.

Гар аргаар алт олборлогч иргэдийг “нинжа” хэмээн нэрлэж хэвшсэн.

Үндэсний статистикийн хороо, Мянганы сорилтын сангаас гаргасан судалгаагаар Монгол улсын хэмжээнд 60.0 мянга орчим иргэн гар аргаар ашигт малтмал олборлож байгаа талаар тоо баримт байгаа ба дээрх иргэдийг дотор нь тогтмол үйл ажиллагаа явуулдаг, улирлын чанартай гэж хоёр хуваасан байна.

Тогтмол үйл ажиллагаатай 38.0-39.0 мянган иргэд байдаг ба тэдгээр нь цаг агаарын таатай байдал сайжирч, мал өсөх зэргээс шалтгаалж буурах хандлагатай байна. Улирлын чанартай гарч ажилладаг иргэд үлдсэн хувийг нь бүрдүүлдэг. Ихэвчлэн эмч, багш, цөөн малтай иргэд, сурагч, оюутнууд хамрагддаг байна.

Дээрх иргэд жилийн 180 хоног ажиллан нэг хоногт 20.000 төгрөгийн орлого олдог. Хамгийн багаар тооцвол 216 тэрбум төгрөг алтны далд наймааны эргэлтэд орж, 3 тонн орчим алт “нинжа” гэх иргэдийн гараар олборлогдож байна.



ДҮГНЭЛТ

“Нинжа” иргэдийн олборлосон алт нь ченж гэх иргэдийн гараар эргэлтэд орж, харин тэдгээр ченжүүд нь худалдан авсан алтаа Монгол банкинд тушаадаггүй дамжуулан борлуулдаг болох нь тусгай албадын шугамаар авагдсан мэдээнээс харахад тодорхой байна. Мөн 2012 оны СХЗГ, Монгол банкны алтны мэдээнээс харагдаж байна. Тухайлбал, 2012 онд иргэд гэсэн нэрээр 16.1 кг алт сорьцлуулан 12.5 кг-ийг Монгол банкинд тушаасан байна. Эрх бүхий этгээдээс гэнэтийн ашгийн 68 хувийн ашгийн албан татвар авч эхэлснээс үүдэн “далд” эдийн засаг үүсэх нөхцөл байдлыг бүрдүүлсэн бөгөөд “урт нэртэй” хууль нь татвар төлөгч аж ахуйн нэгжүүдийг далд эдийн засагт татагдан ороход “хувь нэмэр” болсон гэж үзэж байна.

Дээрх нөхцөл байдлаас дүгнэхэд Монгол Улсын нэг жилд олборлож байгаа алтны хэмжээ, алтны далд наймаанд эргэлдэж байгаа мөнгөний хэмжээг бодитоор тодорхойлох боломжгүй байгаа учраас хууль тогтоогчоос энэ төрлийн харилцааг зохицуулсан хууль тогтоомж, эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тулгарч байна.

САНАЛ

Монгол улсын олборлон баяжуулж байгаа алт нь дунджаар 90.0 хувийн агуулгатай бөгөөд түүнийг олон улсын зах зээлд борлуулахын тулд 99.99 хувийн цэвэр алт болгох шаардлагатай юм. Манай улс ОХУ, Их Британи, Япон зэрэг улсад алтаа цэвэршүүлж ирсэн билээ. Одоо манай улс жилд 10 тонноос дээш хэмжээний алт олборлодог болсон. Цаашид алтны үндсэн болон бусад металлын ордуудыг ашигласнаар алт олборлолтын хэмжээг 1.5-2.0 дахин нэмэгдүүлэх боломжтой нь судалгаагаар харагдаж байна^[18].

Иймээс Монгол Улс өөрийн алт цэвэршүүлэх үйлдвэртэй болох шаардлагатай бөгөөд уг үйлдвэрийг 2017-2018 онд байгуулахаар засгийн газраас төлөвлөн шат дараатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Алт цэвэршүүлэх үйлдвэрт зэс хайлуулах явцад гарах алтыг мөн цэвэршүүлэх, алтаар эцсийн бүтээгдэхүүн, тухайлбал алтан зоос, алтан эдлэлийг үйлдвэрлэх олон улсын зах зээлд гарах нь зүйтэй юм.

Нөгөө талаар гадаадад цэвэршүүлж байгаа алтны тээвэр, даатгал, хамгаалалтын зардал

18 Алтны суурь судалгаа 2025” Ашигт малтмалын хэрэг эрхлэх газраас гаргасан судалгаа

өндөр, цаг хугацаа, зохион байгуулалтын хувьд төвөгтэй байдаг.

Мөн гадаадад алт цэвэршүүлэх явцад нийт алтны 2 хувь нь алдагдал болон хаягдах ба алтанд агуулагдах мөнгө, цагаан алт зэрэг бусад металлуудыг тооцох асуудал төвөгтэй байдаг. Иймд өөрийн оронд олборлосон бохир алтны боловсруулалтын түвшинг гүнзгийрүүлж, аль ч зах зээлийн хэрэгцээг хангах, дагалдах элементүүдийг ялгаж авах, зардал хэмнэх /тээвэр, хадгалалт, даатгал/ үүднээс Монголд алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах асуудлыг шийдвэрлэх цаг нэгэнт болжээ.

Алт цэвэршүүлэх технологи улс бүрт харилцан адилгүй боловч алтыг химийн, цахилгааны болон пиро, гидрометаллургийн аргуудыг хослуулан хэрэглэж сорьцыг 99.99-д хүргэдэг. Пирометаллургийн арга нь алтанд байгаа хольц элементүүдийн хлорт нэгдлийг харьцангуй өндөр температурт дэгдээх замаар цэвэршүүлдэг бол гидрометаллурги нь электролизийн аргаар цэвэршүүлэх технологид тулгуурладаг.

Алт цэвэршүүлэх үйлдвэрүүдийн технологи дотроос хамгийн дэвшилттэй, хамгийн өндөр үр ашигтай, технологийг Өмнөд Африкийн Минатавру-технологи гэж үздэг.

Цөөн хүн ажиллуулж, жилд 24.0 тн алт цэвэршүүлдэг, хаягдал хамгийн багатай, орчныг бохирдуулдаггүй. Энэ технологийг 1996 онд Хармонид нэвтрүүлж их амжилт олсон. Минтекийн ерөнхийлөгч, доктор Айдан Эдвардын судалгаагаар энэ технологи бол алт цэвэршүүлэх аж үйлдвэрийн ирээдүй бөгөөд Өмнөд Африк зэрэг олон орны алтны үйлдвэрүүдэд энэ технологийг ашиглаж байна.

Цэвэр алтны дэлхийн стандартын шаардлага хангаагүй буюу Лондонгийн алт, мөнгөний биржийн баталгаа аваагүй үйлдвэрт цэвэршүүлсэн алтыг дэлхийн зах зээлд гаргах, барьцаалан хадгалуулах болон арилжаалах боломжгүй юм.

Шинээр баригдах алт цэвэршүүлэх үйлдвэрт дараах 3 шалгуур тавигдах шаардлагатай байна. Үүнд:

Лондонгийн алт, мөнгөний зах зээлийн холбооны “Сайн боловсруулагч” гэсэн итгэмжлэлтэй байх;

Дэлхийн зах зээлд баталгаатай, хямдралгүй борлогдох чанарын стандарт нөхцөлийг хангасан байх;

Байгаль орчинд хоргүй гэсэн баталгаатай байх;

Цэвэршүүлэх зардал нь өрсөлдөх чадвартай, татвар төлөх боломжтой байх зэрэг болно.

Алт цэвэршүүлэх үйлдвэрийн асуудлыг шийдвэрлэхдээ дараах зарчим, нөхцөлийг харгалзан үзэх нь зүйтэй юм. Үүнд:

Дэлхийн алтны зах зээлд бүрэн баталгаатай, олон улсын жишигт тохирсон технологи, тоног төхөөрөмжийг хэрэглэх;

Үйлдвэрийн үндсэн дамжлагад ажиллах хүмүүсийг уг үйлдвэрийн технологи, "ноу-хау"-г нийлүүлэгч байгууллага өөрийн үйлдвэр, лабораториудад тодорхой хугацаагаар сургаж бэлтгэх;

Үйлдвэрийн технологийн тоног төхөөрөмжийн угсралт, тохируулгын ажлыг нийлүүлэгч байгууллага иж бүрэн хийж, бүтээгдэхүүний чанарын олон улсын стандартын баталгаа гаргаж өгөх;

Хөрөнгө оруулалтад үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, иж бүрэн багаж хэрэгслээс гадна технологийн лиценз буюу "ноу-хау"-г тусгасан байх;

Үйлдвэрлэл нь байгаль орчин болон хүний эрүүл ахуйд хор нөлөөгүй байхаас гадна

хорт бодисыг саармагжуулах, хоргүйжүүлэх хамгийн сүүлийн арга технологийг хэрэглэх; Алт цэвэршүүлэх, судлах, туршихтай холбогдсон шинжилгээний иж бүрэн багаж, тоног төхөөрөмж бүхий орчин үеийн лабораторитай байх зэрэг саналуудыг дэвшүүлж байгаа болно.

НОМ ЗҮЙ

Байгаль орчныг хамгаалах тухай хууль

Ашигт малтмалын тухай хууль

Эрдэнэсийн сангийн тухай хууль

Буянтөр. Б. Мөнгө угаах гэмт хэргийг илрүүлэхэд анхаарах зарим асуудал. 2014 он. УБ

"Алтны суурь судалгаа 2025" Ашигт малтмалын хэрэг эрхлэх газраас гаргасан судалгаа. 2016. УБ

Буянтөр. Б. Мөнгө угаах гэмт хэргийг илрүүлэхэд анхаарах зарим асуудал. 2014 он. УБ

"Алтны суурь судалгаа 2025" Ашигт малтмалын хэрэг эрхлэх газраас гаргасан судалгаа. 2015. УБ

ЗЭВСГИЙН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, АНХААРАХ АСУУДАЛ



Ц.Очгэрэл
ХСИС-ийн докторант,
цагдаагийн хурандаа

Товч агуулга: Зэвсгийн хууль бус худалдаа, /наймаа/-ны мөн чанар, олон улсын хэмжээн дэх хууль бус мөнгөний эргэлтийн хэмжээ, улс төрийн шалтгаан нөхцөл, эдгээр худалдаа, наймаагаар арилжигдаж байгаа ердийн зэвсэг, зэвсэглэлүүд нь хүн төрөлхтний эсрэг болон цэргийн гэмт хэрэг, үндэстнийг аймаглан устгах, террорист халдлагад ашиглагдаж байгаа байдал.

Бүс нутгийн маргаан, шашин хоорондын мөргөлдөөн, гэмт хэргийн бүлгүүд хоорондын тэмцэлд зориулсан зэвсэг худалдан авах явдал нь зэвсгийн хууль бус эргэлт явагдах гол хөрс суурь болох тухай.

Түлхүүр үг: Зэвсгийн худалдааны хууль бус эргэлт, гинжин хэлхээ, Эрх зүйн хязгаарлалт, хоригийг даван гарах хяналт, зохицуулалтгүй байдал, улс төр, геополитикийн нөлөөлөл .

2015 оны байдлаар дэлхий дахинаа хууль бусаар наймаалж байгаа галт зэвсгийн худалдааны хэмжээ ойролцоогоор 3,5 тэрбум долларт хүрч байна гэж мэргэжилтнүүд үзэж байна. Энд галт зэвсэг, сум хэрэгсэл, тэсрэх бодис орж байгаа юм гэж ОХУ-ын Аюулгүйн зөвлөлийн нарийн бичгийн дарга Николай Патрушев мэдэгдэлдээ дурдсан байна. Хамгийн гол нь хууль бусаар худалдаалж байгаа зэвсгийг ихэвчлэн гэмт хэргийн зориулалтаар, террорист алан хядах ажиллагаанд ашиглаж байгаа гэж тэрээр онцолсон байна. Хууль бусаар зэвсэг үйлдвэрлэгчид, наймаалагчид бүтээгдэхүүнээрээ бүс нутгийн зэвсэгт мөргөлдөөн, цэргийн бүлэглэлүүдийг дэмжиж тэтгэж байна гэж онцолжээ.^[19]

Зэвсгийн хууль бус эргэлттэй холбоотой тоо мэдээ янз бүрийн эх сурвалжуудад харилцан адилгүй байдаг. Энэ нь төрийн оролцоо ба төрийн оролцоогүй хийгдэж байгаа зэвсгийн худалдаа (наймаа), тэдгээрийн хэлбэрээс ихээхэн хамааралтай хэмээн судлаачийн хувьд үзэж байна.

¹⁹ <http://www.assa.mn/content/13959>.



Цэргийн зэвсэг, техник хэрэгсэл захиалгаар үйлдвэрлэж байгаа компаниудын бизнесийн үйл ажиллагаа нь тухай улсын улс төр, эдийн засгийн бодлоготой нягт уялдаж байдаг ч өөрсдийн байгуулсан гэрээний үндсэн дээр төрийн оролцоогүй зэвсгийн худалдаагаа явуулсаар байдаг бөгөөд зэвсгийн худалдааны данс ихэнх тохиолдолд шилэн байдаггүй.

Ихэнх компани ашиг орлого олж байвал тэдний үйлдвэрлэсэн зэр зэвсгийн худалдан авагч хэн байх нь төдийлэн ач холбогдолтой биш хэмээн үздэг. Зэвсэг үйлдвэрлэгч улс орнуудаас хөгжиж байгаа орнуудын арми, зэвсэгт бүлэглэлүүд өөрсдийн шаардлагатай зэвсэг хэрэгсэл, техникээ худалдан авдаг. Тэдгээр орнууд худалдан авсан зэвсэг, техник хэрэгслээ гадаад, дотоодын гэмт бүлэглэлүүдэд өндөр үнээр хууль бусаар дамлан худалдаалж, ашиг олж байна. Ийм гинжин хэлхээгээр зэвсгийн худалдааны эргэлт хууль бусаар явагдаж хязгаарлалт, хориогийг даван гарч, хяналт, зохицуулалтгүй болж байна.

Улс төрийн тогтворгүй байдал, газар нутаг, шашин хоорондын маргаан бүхий бүс нутгууд нь зэвсгийн худалдааны хууль бус эргэлтийг бий болгох, тархах нөхцөлийг бүрдүүлж байдаг.

Хойд африкийн Ливи улсад шинэ засгийн газар байгуулагдаж, өөрчлөлтүүд гарч байгаа хэдий ч хурандаа М. Каддафийн үед хуримтлагдсан асар олон тооны зэр зэвсэг хаачсан нь тодорхойгүй байна. Алсын тусгалтай сөнөөгч пуужин алан хядагчдын гарт орвол ямар аюул тарьж болохыг төсөөлөхөд хүнд бөгөөд НҮБ-ийн Аюулгүйн зөвлөл байр сууриа илэрхийлсэн.

2013 онд Хойд Солонгос улсын усан онгоцонд пуужин барих төхөөрөмж хоёр, есөн пуужин, байлдааны "МИГ 21" онгоц хоёр, онгоцны хөдөлгүүр 15 ширхэгийг Кубээс нууцаар тээвэрлэж явсныг Панамд илрүүлсэн байдаг.

Жижиг зэвсэг гэж нэрлэгддэг гар буу, төрөл бүрийн автомат буунуудыг 100 гаруй орны 1000 гаруй компани үйлдвэрлэдэг бөгөөд тэдний худалдан авах гүйлгээний мөнгө нь 875 сая ам доллар бэлнээр эргэлдэж байна гэж олон улсын SIPRI-гийн шинжээчид үзэж байна.

Зэвсгийн худалдааны хууль бус эргэлтийн золиос болж, жил бүр 500.0 мянган хүн амь насаа алдаж, олон сая хүн өртөн гэмтэж, тахир дутуу болж байна.

Аливаа улс өөрийн цэргийн зэвсэглэлтэй холбоотой тоог нууцалдаг. Зэвсгийн худалдааны гэрээ хэлцлийн үнэ өртөг ч бас нууцны зэрэглэлд хаммаарна.

Бидэнд байгаа хамгийн ойрын жишээ бол

2002 онд Франц-Испанийн "Армарис" гэх компани Малайзын засгийн газарт "Scorpene" загварын шумбагч хөлөг гурвыг нийлүүлэхээр нэг тэрбум еврогийн үнэтэй гэрээ байгуулахаар хэлэлцээр хийсэн байдаг.

2009 онд дээрх компани Малайзын засгийн газарт хоёр "Scorpene", нэг "Agosta" загварын шумбагч хөлөг худалдсан байдаг. Гэтэл Малайзын Батлан хамгаалах яам хоёр "Scorpene" шумбагч хөлгийн ложистик болон техник сургалтын зардалд нэг тэрбум евро зарцуулсан тухай парламентдаа мэдэгдсэн байна.

Гэрээ хэлцэлд тусгагдсан тоо өөрчлөгдсөн, асар их өртөгтэй, учир битүүлэг энэ зэвсгийн худалдаа өнөөдрийг хүртэл асуудал дагуулсан хэвээр бөгөөд золиосонд Монгол Улсын иргэн өртөж, харамсалтайгаар амь насаа алдсан байдаг.

"Agosta" загварын шумбагч хөлгийг өөр улсад нууцаар дамжуулан худалдсан байж болох таамаглал эндээс гарч байгаа юм.

Аж үйлдвэржсэн орнууд нь дотооддоо цэргийн олон үйлдвэр, цэргийн техник хэрэгслийн хүчин чадлыг нэмэгдүүлэх технологийн компаниудтай байдаг. Зарим орон иргэдийнхээ хэрэгцээнд зориулж их хэмжээний зэвсгийг үйлдвэрлэн борлуулж байна. Энэ нь хуулийн дагуу явуулж буй зөвшөөрөгдсөн бизнесийн үйл ажиллагаа боловч зэвсгийн ашиглалт, борлуулалтад хяналт тавих, иргэдийнхээ аюулгүй байдлыг хангахад хүндрэл учруулж, дотоодын зэвсгийн хууль бус эргэлтийн сүлжээг бий болгож байна.

Иргэдийн гар дээр байгаа галт зэвсгийн тоогоор АНУ тэргүүлдэг бөгөөд 100 хүн тутмын 89 нь галт зэвсэг (урт, богино буунууд болон автомат буу) эзэмшдэг. Өөрөөр хэлбэл, 10 хүний 9 нь буутай гэсэн статистик үзүүлэлт байдаг.

АНУ-д хүмүүсийг олноор нь хөнөөсөн гэмт хэрэг гарах тохиолдол бүрийн дараа өөрийгөө хамгаалах зорилгоор буудлагын зэвсэг худалдан авах явдал нэмэгдэж, олон зуун галт зэвсэг иргэдийнх нь гар дээр очиж байна. Үүнтэй холбоотойгоор, галт зэвсэгтэй холбоотой гэмт хэргийн гаралт тус улсад байнга нэмэгдэж байна. Гэвч АНУ-ын Сенатын гишүүд буу худалдаалахыг хязгаарлах тухай дөрвөн хуулийн төслийг батлахаас татгалзжээ.

Тус улсад байдаг "Буу эзэмшигчдийн үндэсний холбоо" нь нөлөө бүхий лобби бүлгээр дэмжигддэг. Бүгд найрамдах нам буу эзэмших явдлыг дэмжиж, буу худалдаалахыг хязгаарлахыг эсэргүүцсээр байна.

АНУ-ын мэдээллийн хэрэгслээр гарч байгаа мэргэжилтнүүдийн судалгаа, илтгэлд



зарим зүй бус гэмээр дүгнэлтүүд гарч байна. Хөрөнгө оруулагчдын сонирхлыг зэвсгийн үйлдвэрлэлийн салбар татаж буй нэг шалтгаан нь АНУ-д олон хүнийг хөнөөсөн хэргийн дараа иргэдийн галт зэвсэг худалдан авах явдал нэмэгдэнэ гэсэн таамаглал байдаг тухай бичсэн байна.

Зэвсгийн худалдаагаар арилжигдаж байгаа ердийн зэвсэг, зэвсэглэлүүд нь хүн төрөлхтөний эсрэг болон цэргийн гэмт хэрэг, үндэстнийг аймаглан устгах, террорист халдлагад ашиглагдаж байна. Түүнчлэн, бүс нутгийн маргаан, шашин хоорондын мөргөлдөөн, гэмт хэргийн бүлгүүд хоорондын тэмцэлд зориулсан зэвсэг худалдан авах явдал нь зэвсгийн хууль бус эргэлт явагдах гол бааз суурь болж байгаа нь Олон улсын судалгааны байгууллагын тайлангаас харагдаж байна.

Зэвсгийн хууль бус эргэлтийн дийлэнх хувийг хөнгөн зэрэглэлийн буудлагын зэвсгүүдээс (гар буу, автомат, пулемёт) гадна бага оврын нисэх болон усан онгоц, өөрөө явагч, техник устгагч гранат харвагч, лазерын гэрлийн, алсын тусгалтай газар-агаар ангиллын пуужин, тэдгээрийн хөөрөг хөөрөмж эзэлдэг байна.

Эдгээр зэвсгийн хууль бус эргэлтийн арилжааны үнийн дүн хэдэн зуун мянган доллараас давах бөгөөд томоохон хэлцлүүдийн мөнгөн дүн хэдэн арван сая доллараар хэмжигдэж байдаг байна.

Зэвсгийн хууль бус эргэлтэд Азид алтан гурвалжин орчмын хар тамхины зэвсэгт бүлэглэлүүд, Зүүн Өмнөд азийн салан тусгаарлах бүлэглэлүүд, Афганистаны Талибан зэвсэгт бүлэглэл, Арабын зарим орны алан хядах байгууллагууд, Ойрхи Дорнодын зарим улс орнууд, Африк тивийн омог хоорондын дайсагнагч зэвсэгт бүлэглэлүүд, Латин Америкийн Колумба, Мексикийн хар тамхины синдикат, картелууд, Хятад, Япон, Солонгосын гэмт хэргийн триадуудууд идэвхтэй оролцож, гол худалдан авагч, нийлүүлэгч болдог байна.

Зарим том гүрний цэргийн томоохон удирдлагуудын оролцоотой зэвсгийн хууль бус наймаагүйгээр Хойд Африк, Ойрхи Дорнод, Өвөр кавказ болон бусад дэлхийн халуун цэг дэх зэвсэгт мөргөлдөөн удаан үргэлжлэх боломжгүй бөгөөд алан хядах, салан тусгаарлах үзэлтнүүдийн зэвсэгт бүлэглэлүүд зэвсгээр хангагдах боломжгүй талаар дэлхийн мэдээллийн хэрэгслээр байнга мэдээлэгдэж байдгийг үгүйсгэх аргагүй юм.

Улс орнуудын дотоодын тэмцэл, зөрчилдөөн гарч, үргэлжилж байх нь зэвсэг үйлдвэрлэгч, зэвсгийн худалдаачдын хувьд

зах зээл нь хадгалагдах, хэрэгцээ тасралтгүй, байнга байх нөхцөл юм.

2010 он хүртэл дэлхийн улс төрийн гадаад байдал харьцангуй тогтвортой, цөөн хэдэн улсын хооронд бүс нутгийн хэмжээнд гарч байсан байлдаан, зэвсэгт мөргөлдөөнийг эс тооцвол энх тайвнаар зэрэгцэн орших чиг хандлага давамгайлж байв.

“Хэн хамгийн хүчтэй зэвсэг эзэмшинэ, тэр эрх мэдлийг атгана” гэсэн хандлага сүүлийн жилүүдэд дахин сэргэж, дэлхий дахины гадаад улс төрийн бодлогын салшгүй хэсэг болсон нь олон улсын байдлаас харагдаж байна.

Сүүлийн нэг жилийн хугацаанд улс орнуудын хооронд цэргийн хамтын ажиллагаа өргөжиж, хамтарсан хээрийн сургууль байнга хийх болсон, зэвсгийн эрэлт хэрэгцээ нэмэгдэж, зэвсэг худалдан авалт, борлуулалт ил, далд байдлаар явагдаж, эрэлт нийлүүлэлт өргөжиж байна.

Зарим шинжээчийн таамаглаж байгаагаар дэлхий нийтийг хамарсан эдийн засгийн хямралаас шалтгаалж, зэвсгийн худалдаа, эргэлтийн өртөг буурах хандлага байна гэж үзэж байна. Гэвч АНУ, Япон, Бразил зэрэг орнууд цэргийн зардлаа бууруулсантай холбоотой ч байж болох юм. Харин Өмнөд Солонгос, Их Британи, БНХАУ зэрэг орнууд цэргийн зардлаа нэмсэн нь дэлхийн гадаад улс төрийн бодлогод эдийн засгийн хямрал нэг их нөлөөлөхгүй гэдгийг харуулж байна.

Дэлхийн хэмжээгээр энэ жилийн цэргийн зардалд 1.4 их наяд ам доллар зарцуулахаар төлөвлөөд байгааг олон улсын судалгааны байгууллагын судлаачид тооцоолсон байна.

Хэдийгээр зардлын нэг хэсэг нь цэргийн үйлдвэрлэлийн техникийн хангамж, үйлчилгээний зардалд төлөвлөгдсөн байгаа ч зэр зэвсгийн тоог нэмэгдүүлэх, сайжруулахад ихэнхийг нь зарцуулах болно.

Цэргийн зардал түүн дотор зэвсгийн үйлдвэрлэл, худалдааны эргэлтэд зарцуулах зардал мөнгөнөөс хамаарч захиалга, худалдааны гэрээний өртөг ч жил бүр янз бүр байдаг. Зэвсэглэлийн ангиллаас шалтгаалан нэг жилээс дээш үе шаттай хэрэгжих хугацаа ч бас өөр өөр байна.

ОХУ-ын “Рособоронэкспорт” компанийн 2015 оны захиалгын портфель 48.0 тэрбум ам доллар болсон байна^[20]. АНУ-ын цэрэг, аж үйлдвэрийн “Northrop Grumman” компани 2015 онд шинэ үеийн стратегийн бөмбөгдөгч онгоц бүтээх гэрээний захиалга авсан байна^[21]. Уг нууцалсан гэрээний өртөг 80.0 тэрбум ам доллар болсон бөгөөд тус захиалгыг гүйцэтгэгч нь 2010 оноос цэрэг

²⁰ Холбооны цэрэг-техникийн хамтын ажиллагааны албаны захирал А.Фомин мэдэгдлээс 2015 он

²¹ АНУ-ын Нисэх хүчний сайд Дебора Ли-гийн мэдэгдэл



дайны үйлдвэрлэлийн ажил гүйцэтгэлээр дэлхийд тэргүүлэгч, цэргийн нисэх онгоцны техникийн үйлчилгээ хариуцдаг, төрийн батлан хамгаалах захиалгын гүйцэтгэгчээр голлон ажилладаг компани юм.

Сүүлийн үед шинээр болон шинэчлэн сайжруулсан нисэх онгоц, усан онгоц, танк, довтолгооны болон хамгаалалтын системийн пуужингууд, бусад цэргийн техникийн үзэсгэлэн худалдаа, яармагаар танилцуулж, сурталчлах нэмэгдсэн байна.

Улс орон болгон батлан хамгаалах хүчин чадлаа бууруулахгүйн төлөө өөрсдийн зэвсэглэлийн хүчин чадлаа улам сайжруулж, хөнөөх чадварыг улам найдвартай болгох чиглэлээр ажиллаж, олон тэрбум хөрөнгө мөнгийг зарцуулах болно.

Монгол Улс тусгаар тогтносон орны хувьд өөрийн батлан хамгаалах бодлогыг зөв тодорхойлж, бусад улсын зэвсэглэлээ хоцрохгүй байх нь зайлшгүй хэрэгжүүлэх цэргийн бодлого, үзэл баримтлалын нэг байх ёстой юм. Үүний тулд гадаад орнуудын цэргийн зэр зэвсгийн тусламжийг авах, боловсон хүчнээ сургах, техник хангамж, үйлчилгээний бааз сууриа бэхжүүлэх, шинэ технологи нэвтрүүлэхэд зардал гаргах нь ойлгомжтой.

Олон улсын цэргийн зэвсгийн үйлдвэрлэл, худалдааны эргэлт, гэрээ хэлцлийг дэлхий нийтийн улс төр, эдийн засгийн хямралтай холбож ярих зайлшгүй улс төрийн шалтгаан бий болсон байна.

Нэг талаас Европын Аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллагын гишүүн улс орнуудын улс төр, батлан хамгаалах, аюулгүй байдлын талаас тавих хандлага, нөгөө талаас ОХУ-аас өөрийн геополитикийн бодлого, зорилгоо хамгаалах, барууны орнуудын авсан хоригийн эсрэг, мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх зэрэг улс төрийн гадаад бодлого, үйл ажиллагаатай холбогдож байна.

Сири, Ирак улсын нутаг дэвсгэрт байгаа Исламын улс бүлэглэлийн эсрэг цэргийн хамтарсан болон дангаар явуулж байгаа ажиллагаануудын хүрээнд цэргийн зардал нэмэгдэх, зэвсгийн үйлдвэрлэл, худалдааны эргэлт, гэрээ хэлцэл, авах зэвсгийн тоо, төрөл, үнэ өртөг өсөж байна.

Украин дахь мөргөлдөөн даамжран үргэлжлэх нь Европын болон бүс нутгийн аюулгүй байдлын олон асуудал шийдэхэд сөрөг нөлөө үзүүлэх бөгөөд сөргөлдөгч талууд цэргийн тусламжаа нэмэгдүүлэхээ мэдэгдэж байгаа нь зэвсгийн үйлдвэрлэл, худалдааны эргэлт болон хууль бус эргэлтийн хэмжээ, үнэ өртөг хяналтаас гарч, хязгаарийг давах магадлалыг улам

нэмэгдүүлж байна.

Орчин үед хөгжингүй улс гүрнүүдийн цэргийн номлол өөрчлөгдөж, батлан хамгаалах салбар дахь цэрэг армийн тоо хэмжээ, зэр зэвсгийн нөөц хангамж нь тухайн улсын цэрэг зэвсгийн бодит үзүүлэлт, байлдааны хүчин чадлыг харуулахад хангалтгүй гэж цэргийн шинжээчид дүгнэх болсон.

Цэргийн уламжлалт техник болох танк, хуягт машин, байлдааны нисэх болон усан онгоц бүтээхэд зарцуулах зардал нэмэгдэж, улс орнуудын ДНБ-ны тодорхой хувийг эзэлж, улам нэмэгдсээр байна.

Батлан хамгаалах салбарт дрон буюу нисэгчгүй онгоц бүтээгдэх эрин үе эхэлж, ийм төрлийн зэвсэг, төхөөрөмж зохион бүтээхээр олон орны эрдэмтэн, мэргэжилтнүүд ажиллаж, хэдийн байлдааны ажиллагаанд ашиглаад эхэлснийг Сири улс дахь байлдааны ажиллагаанаас харж болно.

Түүнчлэн дараагийн шинэ төрлийн зэвсгийн ангиллыг "дигитал зэвсэг" болон "дроне" зэрэг бие даасан зэвсгийн системээр (autonomous weapon system) тодорхойлно гэж цэрэг, зэвсгийн мэргэжилтнүүд үзэж байна.

Бие даасан зэвсгийн систем (autonomous weapon system) нь бүхэл бүтэн улс орны эрчим хүчний салбар, харилцаа холбоо, тээвэр ложистикийн сүлжээ, санхүүгийн системийг "дигитал зэвсэг" ашиглан устгаж чадах хэмжээнд хүрсэн.

Шинэ төрлийн зэвсэг болох дигитал зэвсэг болох компьютерийн вирусыг олноор нь зохион бүтээж, худалдах явдал түгээмэл болж байна. Энэ вирусыг дигитал зэвсэг гэж нэрлэж, энэ зэвсгийн худалдаа аль хэдийн өөрийн зах зээлтэй болж, худалдан авалт хийгдэж эхэлсэн байна.

Ийм төрлийн халдлагыг хэн ч үйлдэж болохоор болсон ба хийх аргыг нь "EPIC-BANANA", "Ex-Trabacoon" зэрэг нэрээр аль хэдийн олон нийтэд ил болгосон байна. Дигитал зэвсгийг хэдхэн 7 хоногийн дотор хийх бүхий л арга хэрэгслийг зааж байгаа ба Оросын зарим цахим хуудсуудаар ердөө 25 доллараар, ил борлуулж байна^[22].

АНУ-ын Үндэсний Аюулгүй байдлын агентлаг (NSA) өөрөө кибер дайны оролцогч бөгөөд тэдэнд "Shadow Brokers" гэх мэт групп интернетийн дайны "зэвсэг" нийлүүлдэг нь тодорхой болсон^[23].

Цөмийн зэвсэгтэй хэдхэн тооны орон дэлхийн улс төрийн системийг тодорхойлж байсан бол орчин үед гэмт хэргийн бүлэглэл, эсвэл Исламын алан хядагч, бие даасан хакарууд гээд хэн ч гэсэн дэлхийн улс төрийн систем, хүчний харьцаанд нөлөөлж

²² "Кибер дайн" news.mn 2016.11.24. Б.Тэмүүжин

²³ Мөн тэнд.

чадахаар болсон байна^[24].

Эрдэмтэн, судлаачид, олон улсын байгууллагууд “кибертерроризм”-ийн тодорхойлолт, “кибертерроризм” ба “кибер гэмт хэрэг” гэсэн ойлголтын ялгааг янз бүрээр тайлбарлаж байна.

Сүүлийн 5 жилд хөгжингүй болон хөгжиж буй орнуудын нийгмийн амьдралд компьютер улам бүр хурдацтай нэвтэрч, кибер орон зайд бүх үйлчилгээ, хангамж, хэрэглээ явагдах болж, нийгмийн бүхий л салбарууд бие биенээсээ хамааралтай болж байна.

Компьютерийн програм хангамж ашиглаагүй бүхэн нийгмийн харилцаанд оролцож чадахаа больж, хүн төрөлхтөний соёлт ертөнцийн нэг хэсэг болох эсхүл амьдрах орчны гадна хаягдах гэсэн сонголтын өмнө ойрхон ирээд байгааг мэргэжилтнүүд онцолж байна.

Компьютерийн програм хангамж улам боловсронгуй болохын зэрэгцээ гарах зардал багассаар байгаа нь хэрэглээг нэмэгдүүлж, хүний нийгэм нэг талаас улам шахаанд орж байгаа нь эргэлзээгүй юм.

Кибер халдлага зохион байгуулах, “дигитал зэвсэг”-ийг идэвхтэй ашиглаж, харилцан бие биедээ эдийн засаг, санхүүгийн хохирол учруулах, батлан хамгаалах хүчин чадлыг сулруулах туршилтууд, хорлон сүйтгэх ажиллагаа явуулах тусгай хүчин, байгууллагаа улс гүрнүүд хэдийн байгуулж, зэвсэгт хүчиндээ ажиллуулж байна. Нөгөө талд хакерын бүлэглэлүүд кибер орон зай,

сүлжээнд нэвтэрч, элдэв төрлийн мэдээлэл хулгайлах, нууцад нэвтрэх, үйл ажиллагааны хэвийн байдлыг алдагдуулах оролдлогоо үргэлжүүлсээр байна.

Ийм зэвсгийн халдлагад дэлхийн ямарч улс өртөж болохыг Балтийн тэнгис эрэг орчмын улсуудад гарсан хэрэг явдал бодит жишээ болж байна.

Дээрх асуудлын талаар дэлгэрэнгүй бичих болсон нь одоогоор зэвсгийн үйлдвэрлэл, худалдаа, эргэлтээс хол мэт боловч, кибер орон зайд бодит ертөнцөөс ангид улс орны хил хязгаар, хол ойр, өдөр шөнө ялгаагүй, кибер довтолгоог зогсоох, хянах боломжгүй. Энэ нь нөхцөл байдлыг нарийн төвөгтэй болгож байдгийг харьцуулж, кибер тоглогчид интернэт орчин, програм хангамж, дижитал зэвсгээ ашиглан сүлжээнд ямарч төвөггүй нэвтэрч, маш ноцтой үр дагаврыг бий болгож, улс төр, үзэл суртал, шашны зорилгоор кибер халдлага, дайралт зохион байгуулж, дэлхий, хүн төрөлхтөнг цөмийн дайн, бүс нутгийн сөргөлдөөн, эсхүл кибертерроризмын аюул заналхийллийн ирмэгт аваачиж чадах хэмжээнд хүрээд байгааг судалгаанд оруулсан нь цаг үеэ нөхцөл байдал, ирээдүйд ямар нөхцөл үүсэх магадлалтай байгааг урьдчилан таамаглах, судлаачдын анхаарлыг хандуулах гэж оролдлоо.

²⁴ Кибер дайн “ news.mn 2016.11.24. Б.Тэмүүжин

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ



Д.Гомбосүрэнжав
Замын цагдаагийн албаны Нийслэлийн
замын хөдөлгөөний хяналтын газрын СХД
дэх замын цагдаагийн хэлтсийн ахлах
зохицуулагч, цагдаагийн ахлах дэслэгч,
магистрант

Э.Энхболд
Хууль сахиулахын их сургуулийн
Цагдаагийн сургуулийн Замын цагдаагийн
тэнхимийн дэд профессор, цагдаагийн
ахмад, магистр

Товч агуулга: 2015 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль” хэрэгжиж, зөрчил гаргагчид хүлээлгэх хуулийн хариуцлага нэмэгдэж, оногдуулах торгуулийн хэмжээ нэмэгдсэнээс хойш 2015 оны зам тээврийн осол, хэргийн статистик мэдээг 2016 оны статистик дүн мэдээтэй харьцуулан авч үзэхэд гарсан гэмт хэрэг -11.3 хувь, амиа алдсан хүний тоо -7.0 хувь, гэмтсэн хүний тоо -9.8 хувиар тус тус буурсан байна. Энэ байдал нь нэг талаасаа замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт сайн байгаатай холбон албаныхан тайлбарласан байдаг. Гэвч улсын хэмжээнд



2017 оны 01 дүгээр сард гарсан Хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн -215/ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нийт хэрэг 2.1 дахин, орон нутагт 3.7 дахин өссөн үзүүлэлттэй байгаа нь яагаад өсөх болов гэсэн асуудлыг дагуулж байна.

Түлхүүр үгс: Зам тээврийн осол, Замын хөдөлгөөний аюулгүй байдал, Жолоочийн сэтгэл зүй.

Үндсэн хэсэг

Дэлхийн улс орнуудад замын хөдөлгөөний аюулгүй байдал хэрхэн хангагдсан, учруулах хор хохирлын хэмжээг тооцон үзэхдээ хамгийн чухал үзүүлэлт нь хүний амь нас хохирсон осол, хэргийн тоог бууруулж чадсан эсэхийг харгалзан үнэлдэг.

Энэ үзүүлэлтийн хүрээнд 2015 оны тоо мэдээг 2016 оны тоо мэдээтэй харьцуулан үзэхэд амиа алдсан хүний тоо 429-өөс 399 болж, -7 хувиар буурсан эерэг нөхцөл бий болсон. Үүнийг албаныхан тайлбарлахдаа, шинэ хууль хэрэгжсэн, жолооч нар хариуцлагатай болсон, торгуулийн хэмжээ нэмэгдсэн, хяналт сайжирсны үр дүнд замын хөдөлгөөний аюулгүй байдал хангагдлаа гэж мэдээлж байсан. Гэвч энэ байдал өөрчлөгдөж, хөдөлгөөний аюулгүй байдалд ухралт гарч байгааг хайхрахгүй орхиж болохгүй юм.

“Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай” хууль батлагдан хэрэгжиж эхэлснээр иргэд замын хөдөлгөөний зөрчил гаргах нь харьцангуй багассан боловч Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад оролцдог байгууллага, аж ахуйн нэгжүүдийн хариуцлага, хайнга ажиллагаа, хяналт тавих үүрэг бүхий цагдаагийн албаны алба хаагчийн хяналт, осол, хэргийг шалгаж байгаа мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч нарын ажлын гүйцэтгэл зэрэг учир дутагдалтай байдал ажиглагдаж байна.

Энэ бүхнийг судлаачийн зүгээс 2017 оны 01 дүгээр сард гарсан зам тээврийн осол, хэргийн тоо мэдээ, цагдаагийн мэдээллийн санд бүртгэгдсэн хүний амь нас хохирсон эрүүгийн хэргийн хүрээнд судалгааг явуулж, 2016 онд буурсан зам тээврийн осол, хэргийн тоо яагаад дахин эрчимтэй нэмэгдэх болсон шалтгааныг тал бүрээс нь судлан тогтоох зорилгоор тодорхой хэргийн материалыг дүн шинжилгээ хийх, түүвэр байдлаар судалгааг явуулах арга зүйгээр энэхүү илтгэлийг бичиж байна.

2017 оны 01 дүгээр сард Улсын хэмжээнд гарсан Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн талаар дүн шинжилгээг Цагдаагийн

байгууллагын мэдээллийн нэгдсэн сан, Замын цагдаагийн албанаас ирүүлсэн гэмт хэргийн тоон мэдээнээс түүвэрлэн авч дүн шинжилгээ хийж үзэхэд зам тээврийн гэмт хэргийг шалган шийдвэрлэж буй мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч нар нь зам тээврийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг мэдээллийн санд бүртгэхдээ гэмт хэргийн тоо бүртгэл -ГХТБ \2301\, \2100\ маягтыг үнэн зөв гүйцэд бүртгэдэггүйн улмаас гарч буй осол хэргийн шалтгаан нөхцөлийг нарийвчлан тогтооход хүндрэл учирсан. Иймд

1. Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн санд гэмт хэргийг ГХТБ-ын маягтын дагуу бүрэн гүйцэд бөглүүлдэг болгох тал дээр анхаарах шаардлагатай байна.

2. Замын цагдаагийн албанаас ирүүлж буй мэдээ Цагдаагийн байгууллагын мэдээллийн санд бүртгэгдсэн мэдээлэл нь хоорондоо өөр байх тул нэгдсэн нэг мэдээнд тулгуурлаж дүн шинжилгээ хийдэг болох хэрэгцээ шаардлага байгааг энд дурдахгүй өнгөрч болохгүй юм. Мөн орон нутагт бүртгэгдэн шалгагдсан зам тээврийн осол, хэргийн мэдээ, мэдээллийн нэгдсэн сангаас авч ашиглах боломжтой байгаа зэрэг нь түүвэр судалгааг явуулахад саад болж байв.

Хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн -215/-ийн улмаас амь насаа алдаж хохирсон гэмт хэрэгт хийсэн дүн шинжилгээгээр 2017 оны 01 дүгээр сард Улсын хэмжээнд бүртгэгдсэн \хүний амь нас эрсэдсэн\ зам тээврийн хэргийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад :

Хүн амь насаа алдсан зам тээврийн ослын тохиолдлын тоо


Нийслэлд 2016 оны 1 сард 8 байсан бол 2017 оны 1 сард 4 буюу -50 хувиар буурсан, орон нутагт 2016 оны 1 сард 9 байсан бол 2017 оны 1 сард 23 буюу 2.5 дахин өссөн, улсын хэмжээнд 2016 оны 1 сард 17 бүртгэгдэж байсан бол 2017 оны 1 сард 27 буюу 58.8 хувиар өссөн дүн мэдээтэй байна.

Бодит амь насаа алдсан хүний тоо / ослын улмаас амь насаа алдсан /

Нийслэлд- 2016 оны 1 сард 8 байсан бол 2017 оны 1 сард 4 буюу -50 хувиар буурсан, орон нутагт-2016 оны 1 сард 9 байсан бол 2017 оны 1 сард 32 буюу 3.5 дахин өссөн, улсын хэмжээнд-2016 оны 1 сард 17 байсан бол 2017 оны 1 сард 36 буюу 2.1 дахин өссөн үзүүлэлттэй гарч байна.



Зам тээврийн осолын улмаас амь нас нь хохирсон 36 иргэний хувьд:



Гэмт хэрэг үйлдэгдсэн гарагийг нь тэмдэглээгүй байсан тул гаргах боломжгүй байв.

Зам тээврийн осол, хэрэг гарсан шалтгаан нөхцөлд судалгааг хийхэд дараах зөрчлийн улмаас гарсан байна.



Зам тээврийн осол, хэрэг гарсан хэлбэрт судалгааг хийхэд дараах хэлбэрийн улмаас гарсан байна. Үүнд:

Онхолдсон, зорчигч унагасан, зорчигч дайрсан-10

Тээврийн хэрэгслийн урд хэсгээрээ мөргөлдөх, гүйцэд түрүүлэх, эгнээ байр эзлэх-9

Тээврийн хэрэгслийн ар талаар мөргөлдөх, хөдөлгөөн эхлэх, зогсох, тоормослох-3

Хажуу талаар мөргөлдөх, эгнээ байр эзэлж гүйцэд түрүүлэх, эргэх саад тойрох, буцаж эргэх, замд нийлэх-4

Үл хөдлөх зүйл мөргөсөн-1 осол бүртгэгдэн шалгагдаж байна.

Гэмт хэрэг үйлдэгдсэн тээврийн хэрэгслийн тоогоор нь авч үзэхэд нийт осол хэргийн 71 хувь нь буюу 25 тохиолдолд хөдөлгөөнд оролцож явсан тээврийн хэрэгсэл өөрөө үл хөдлөх зүйл мөргөх, онхолдох хэлбэрээр гарчээ. Тухайлбал:

- 1 тээврийн хэрэгсэл-25
- 2 тээврийн хэрэгсэл-8
- 3 тээврийн хэрэгсэл-1
- 4 тээврийн хэрэгсэл өртсөн тохиолдол 1

удаа бүртгэгдсэн байв.

Энэ нөхцөл байдлаас Монгол улсын хэмжээнд 2017 оны 01 дүгээр сард гарсан Хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн -215/ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нийт хэрэг 2.1 дахин, орон нутагт 3.7 дахин өссөн үзүүлэлттэй байна. 2015 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль" шинээр хэрэгжиж, хууль, эрх зүйн орчин сайжирч, зөрчил гаргагчид хүлээлгэх хуулийн хариуцлага нэмэгдсэн, оногдуулах торгуулийн хэмжээ нэмэгдсэнээс хойш 2015 оны зам тээврийн осол, хэргийн статистик мэдээг 2016 оны статистик дүн мэдээтэй харьцуулан авч үзэхэд гарсан гэмт хэрэг -11.3 хувь, амиа алдсан хүний тоо -7.0 хувь, гэмтсэн хүний тоо -9.8 хувиар тус тус буурсан байна. Энэ байдал нь нэг талаасаа замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт сайн байгаатай холбон албаныхан тайлбарлаж байсан. Гэвч энэ оны эхний сард гарсан зам тээврийн осол, хэргийн тоо, амиа алдсан хүний тоо өссөн дүнтэй байгаа нь дараах яагаад гэсэн асуудлыг дагуулж байна.

Яагаад-1 Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг /эрүүгийн хуулийн -215/ өсөв.

Яагаад-2 Булган аймагт-5, Сэлэнгэ аймагт-5, Сүхбаатар аймагт-4, Баянхонгор аймаг, Өмнөговь, Төв аймагт тус бүр 3 бүртгэгдсэн нь бусад аймгуудаас өссөн үзүүлэлт гарав.

Яагаад-3 Гэмт хэрэг дахин гарахаас нь өмнө урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй хийж чадахгүй байна.

Яагаад-4 Зам тээврийн гэмт хэрэг гарахад нөлөөлсөн хүчин зүйлийг нь тогтоож чадахгүй байна.

Яагаад-5 Гэмт хэргийн мэдээлэл, судалгаа бүрэн гүйцэд нэгтгэгдэн гарч ирэхгүй байна.

Дээрх нөлөөлөгч хүчин зүйлсийг дараах байдлаар авч үзэх нь зүйтэй гэж судлаач бид үзсэн болно.

1. Замын хөдөлгөөний дүрэм хэрэгжихгүй байна. Арга хэмжээ тооцох тусам илэрч буй зөрчил буурдаг. Гэтэл энэ зүйл эсрэгээрээ хариуцлага тооцож буй зүйл нь осол хэрэг гарахад нөлөөлөхгүй байгаа зүйл дээр арга хэмжээ авагдаж байна. \Зогсолт зогсоол, түгжрэлийг бууруулах, хөдөлгөөн зохицуулах чиглэл дээр голчлон ажиллаж байна\ Зам тээврийн осол хэрэг гарахад гол нөлөө үзүүлдэг байрлан явах, бүрэн бус, хурд, эгнээ байр, хүн ба ачаа, гэрэл дохио, явган зорчигч зэрэг зөрчил дээр дүрмийн



шаардлагыг жигд тавиагүйгээс энэ төрлийн зөрчил, осол хэргийн тоо буурахгүй байна.

2. Орон нутгийн замд хийж буй хяналт, шалгалтыг тогтмол хийдэггүй, нэр төдий хийдэг. Зөвхөн жолоочид арга хэмжээ тооцох бус хажууд нь сууж яваа зорчигч нь замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн эсэх, амь нас, эрүүл мэнд нь аюултай нөхцөл байдалд тээвэрлэгдэж байгаа байдалд шалгалт хийж, зөрчлийг нь арилгуулах, хариуцлага үр дүнг нь тооцдог байх. Тухайн орон нутгийн Засаг дарга холбогдох байгууллагын хүмүүс нь нутгийнхаа онцлог, эрсдэлийг нь тооцож мэддэггүй байдал нөлөөлж байна.

3. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар мөрдөн байцаалт явуулахдаа гол шалтгаан нөхцөлийг тогтоож дахин гэмт хэрэг гаргахгүй байх арга хэмжээ авах ёстой боловч зөвхөн жолоочийг буруутгадаг. Хэрэг осол гарч буй шалтгаан нөхцөлийг тогтоож, түүн рүү чиглэсэн ажлыг холбогдох байгууллагад нь хүргэж чаддаггүй. Замын хөдөлгөөний гол цөм нь “Зам-Тээврийн хэрэгсэл-Хүн-Орчин” гэсэн 4 элементийг зөв сонговол замын хөдөлгөөний аюулгүй байдал бүрэн хангагдана. Гэтэл хүнийг илүү анхаарч, Зам-Орчин-Тээврийн хэрэгсэл”-ийг нь анхаарахгүй орхигдуулж байна. Зам нь замын хөдөлгөөнд оролцогч жолооч нарт хэрхэн тохирсон, аюулгүй байж чадаж байгаа эсэх, замын тэмдэг тэмдэглэгээ тухайн замдаа бүрэн гүйцэд тавигдсан эсэх, шаардлагатай засвар үйлчилгээ хийгдсэн байдлыг нь сайтар судалж мэдээлэх, тээврийн хэрэгсэл нь техникийн хувьд бүрэн бүтэн, аюулгүй байдлыг нь хангаж чадаж байгаа эсэх, ашиглахыг хориглосон тээврийн хэрэгсэл замын хөдөлгөөнд оролцсоноос болж осол хэрэг гарч байгаа байдлыг зөв тодорхойлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухайн анхаарал татсан хэсэг рүү хандуулах шаардлагатай байна.

4. Замын хөдөлгөөнд оролцогчдыг “Ур чадвар-сэдэл-бэлтгэгдсэн байдал” гэсэн гол зүйл дээр анхаарлаа хандуулж ажиллах.

5. Мэдээлэл судалгаан дээр боловсруулалт хийгдэхгүй зөвхөн мэдээ гаргаж байгаагаас урьдчилан сэргийлэх ажил явагдахгүй байна. Мэдээлэл судалгаан дээр суурилж, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоосны дараа урьдчилан сэргийлэх ажлаа төлөвлөх ёстой. Мэдээлэл судалгаа бүрэн гүйцэд гардаггүй учир явуулж буй үйл ажиллагаа бодит бус ажил болж байна гэсэн дүгнэлтэд хүрч байна. Мөн хяналт шалгалтыг сайжруулах ажлын хүрээнд дараах хэд хэдэн ажлыг эрчимжүүлэх шаардлага байна.

Дүгнэлт

2017 оны 01 дүгээр сард Улсын хэмжээнд

гарсан \хүний амь нас хохирсон\ зам тээврийн хэргийн хувьд жолоочийн анхаарал болгоомжгүй үйлдлээс шалтгаалж, хүний амь нас нь хохирсон хэрэг өнгөрсөн оны мөн үеийнхээс улсын хэмжээнд 2.1 дахин, орон нутагт 3.7 дахин өссөн үзүүлэлттэй байна. 2017 оны 01 дүгээр сард Булган, Сэлэнгэ аймагт 5, Сүхбаатар аймагт 4, Баянхонгор аймаг, Өмнөговь, Төв аймагт 3 хүний амь нас хохирсон нь бусад аймгуудтай харьцуулахад өндөр байна.

Санал

Цаашид зам тээврийн осол, хэргийн гаралтыг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр дараах ажлыг хийж хэрэгжүүлэх саналтай байна.

-Орон нутагт гарсан зам тээврийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг харахад тээврийн хэрэгслээр зорчиж явсан зорчигчдын амь нас, эрүүл мэнд нь илүү хохирч байна. Учир нь тээврийн хэрэгслээр зорчихдоо хамгаалалтын бүсийг хэрэглэж хэвшээгүй, хүүхдийг тээврийн хэрэгслээр тээвэрлэхдээ зориулалтын хамгаалалтын суудал, хамгаалах бүсийг нь хэрэглэдэггүй зэрэг буруу дадал зуршил нөлөөлж байна. Иймд хамгаалах бүсээр тоноглогдсон тээврийн хэрэгсэл жолоодож яваа жолооч, зорчиж яваа зорчигчдыг хамгаалах бүс, \ хамгаалалтын суудал\ -ыг нь хэрэглэж хэвшүүлэх тал дээр анхаарах. Жолоочийг торгоод явуулдаг бус хажууд нь сууж яваа зорчигч нь хамгаалах бүс хэрэглэж байгаа эсэхэд хяналт тавьж зөрчлийг нь арилгуулах, хор уршгийн талаар иргэд олон нийтэд мэдээ мэдээллийг хүргэх, энэ чиглэлээр сэрэмжлүүлэг, зөвлөмж хийж байршуулах.

-Орон нутгийн замд хөдөлгөөнд оролцож буй жолооч хурд хэтрүүлснээс болж онхолдож байна. Орон нутгийн замд эрсдэл ихтэй буюу огцом эргэлттэй, өгсүүр, үзэгдэх орчин хязгаарлагдсан, зам тээврийн осол хэрэг ихээр гардаг цэг, гарч болзошгүй газруудад хөдөлгөөнт эргүүлийг нэг цэгт бус байршлыг нь байнга сольж ажиллуулах. Баяр ёслол, амралт зугаалгын цагт хүч нэмэгдүүлсэн байдлаар буюу хэв журам, хэсгийн, сумын төлөөлөгч, байцаагч олон нийтийн урамшуулалт эргүүлийг ажиллуулах, шаардагдах техник хэрэгсэл, шатахууны асуудлыг шийдвэрлэж өгдөг байх. \Зөөврийн хурд хэмжигчтэй болгох асуудлыг нэн түрүүн шийдвэрлүүлэх\ Энэ чиглэлээр хэвлэл мэдээллийн бүхий л хэрэгслээр олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах.

-Ямар төрлийн зөрчил, осол хэрэг аль аймаг, дүүрэгт гарч байгаа байдлыг нь судлан арга хэмжээг оновчтой хэлбэрээр



явуулж, тодорхой хугацааны дараа үр дүнг нь тооцох. Хэрэв буурсан үзүүлэлттэй гарвал дараагийн ямар зөрчил нь дийлэнх хувийг эзэлж байна тэр чиглэл рүү нь анхаарлаа хандуулж ажиллах. Учир нь, орон нутаг, дүүрэг болгонд өөр өөр төрлийн зөрчил, осол хэрэг бүртгэгддэг тул хамгийн их бүртгэлтэй хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг чиглүүлэн явуулдаг болох.

-Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцож, зам тээврийн осол хэрэгт холбогдсон жолооч нарын маршрутыг нарийвчлан тогтоох. Зөвхөн жолооч бус тухайн хүнд согтуугаар жолоо барихад нөлөө үзүүлсэн бусад хүмүүс, ямар маршрутаар явж байгаад зам тээврийн осол, хэрэг үйлдсэн, цагдаагийн хяналтын хажуугаар өнгөрсөн тохиолдолд алба хаагч үүргээ хэрхэн гүйцэтгэсэн зэрэг шалтгаан нөхцлийг тогтоож урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах.

-Бүрэн бус тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцсоноос шалтгаалж, замд унтрах, эвдэрч зогсох, ослын зогсолтын тэмдгийг дүрэмд заасан зааврын дагуу байршуулаагүйгээс болж замын хөдөлгөөнд оролцож буй жолооч нарт өгөх мэдээлэл байхгүйн улмаас нарийн, гэрэлтүүлэггүй, үзэгдэх орчин хязгаарлагдсан, уруу замуудад зогсож байсан тээврийн хэрэгслийн араас мөргөх, замын хажуу руу онхолдох зэрэг зам тээврийн ослоуд ихээр

гарч байдаг. Иймд “Техникийн бүрэн бүтэн байдал”-ыг сайжруулах тал дээр анхаарч, бүрэн бус тээврийн хэрэгслийг хөдөлгөөнд оролцуулахгүй байх, хүнд даацын ачааны авто машины арын тэвш болон хажуу талд нь цацруулагч наалгах ажлыг зохион байгуулах.

-Зам тээврийн ослын хор уршгийг олон нийтэд хүргэхдээ жолоочийн ур чадвар, сэтгэл зүй, эдийн засаг, эрүүл мэнд зэрэг олон талаас нь судалж, мэргэжлийн багш, төрийн болон төрийн бус байгууллагыг оролцуулан зорилтот бүлэгт сургалт явуулах. \Жолооч, явган зорчигч, зорчигч, хүүхэд гэх мэт\

-“Жолоочийн сэтгэл зүй”, “Анхны тусламж”, “Жолоочийн ур чадвар”, “Жолоочийн үүрэг хариуцлага-ёс зүй”-г зам тээврийн осол хэрэг дээр суурилж, жолооны сургалтад тусгаж оруулах, системийг нь өөрчлөх.

-Алба хаагчид үүрэг гүйцэтгэх хугацаандаа хариуцсан хэсэг, маршрутын дагуу хөдөлгөөний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болохуйц зөрчил дутагдлыг илрүүлсэн. Улмаар холбогдох албан тушаалтан, байгууллага, аж ахуй нэгжид тухайн илрүүлсэн зөрчлөө арилгуулах чиглэлээр мэдээлж, ямар төрлийн ажлыг хугацаанд нь гүйцэтгэсэн байдлаар нь ажлын үзүүлэлт болгон үнэлж, дүгнэдэг хариуцлагын тогтолцоог бий болгох.

ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИКИЙН ОЙЛГОЛТ, ХӨГЖИЛ, ЧИГ ХАНДЛАГА

*М.Хатанзориг
ХСИС-ийн магистрант*

А.Кетле нэгэнтээ “Статистик бол нийгмийн физик мөн” гэж хэлсэн байдаг. Шинжлэх ухааны олон салбар мэдлэгийг босгох тооцооллын хамгийн чухал арга бол математикийн томъёонуудад тулгуурласан статистикийн арга гарцаагүй мөн. Нийгмийн хувьслын үйл явцыг зөв зүйтэй тогтоож, цаашдын чиг хандлагыг тодорхойлох, урьдчилан таамаглаж, аливаа сөрөг, үр нөлөөллүүдээс сэргийлэх, эерэг хүчин зүйлсийг дэмжиж, эрчимжүүлэх зэрэг үйл ажиллагааны суурь араг яс нь статистик тооцооллын арга билээ.

Төрөөс явуулж буй гэмт хэргийн талаарх бодлого хэрхэн үр дүнгээ өгч буй, аливаа гэмт хэрэг үйлдэгдэхэд орон зай, цаг хугацаа, эзэн бие буюу субъект зэргийн аль нь илүүтэй нөлөөлж, ямар учир шалтгаан, нөхцөл

зонхилж буйг тогтоох, аль хүчин зүйлсэд хэрхэн нөлөөлвөл гэмт хэргийн гаралт буурах гэх мэтийг статистикийн судалгааны аргуудад тулгуурлаж тодорхойлдог билээ.

Статистикийн шинжлэх ухааны үүсэл хөгжил, судлах зүйл, арга зүй

Статистикийн мэдээлэл цуглуулах нь эртнээс үндэс сууриа тавьсан, олон зууны турш хэрэглэгдэж ирсэн арга юм. Хүн төрөлхтөний түүхэнд төр улсууд бий болсон цагаас тоо мэдээлэл цуглуулах, нэгтгэн дүгнэх шаардлага, хэрэгцээ урган гарсан байдаг. Эртний улсууд газар нутаг, хүн ам, мал, хөрөнгийнхөө талаар тоо мэдээ цуглуулж, төр, аж ахуй, цэрэг дайны үйл хэрэгтээ өргөн ашиглаж байжээ.

Жишээ нь: Манай эриний өмнөх 5000 жилийн тэртээгээс эртний Хятадад хүн амаа тоолж байсан тухай, МЭӨ 2200 оноос Эртний Вавилон, Египет, Римд цэрэг дайны зориулалтаар хүн ам, эд хөрөнгийн бүртгэл хийдэг байсан тухай түүхэнд тэмдэглэгдсэн байдаг.

Германы гүн ухаанч, эрх зүйн профессор



Г.Ахенваль “статистик” гэсэн үгийг “статус” гэсэн латин үгнээс гаралтай гэж үзэж байсан ба статистик нь “Улс судлал” гэсэн үгний утгаар анх удаа 1746 онд дараа нь Геттингений их сургуульд шинэ хичээл болон заагдаж эхэлжээ.

Орчин үед “статистик” гэсэн нэр томъёог дэлхий нийтээрээ гурван утгаар ойлгож, хэрэглэж байна.

Нэгдүгээрт: Нийгэм, эдийн засгийн хөгжлийн талаарх тоон мэдээг цуглуулан боловсруулж, шинжилгээ хийхэд чиглэгдсэн хүмүүсийн үйл ажиллагааны салбар гэж ойлгож байна.

Хоёрдугаарт: Статистикийн практикт ашиглагдах онол, арга техникүүдийг боловсруулдаг шинжлэх ухаан гэж үзсэн байна.

Гуравдугаарт: Аливаа тоо мэдээ, үүний дотор статистикийн эмхэтгэл, лавлах, тогтмол хэвлэлүүдэд гардаг тоо мэдээллийг “статистик” гэж нэрлэж заншжээ.

Хэрэглээний статистик 4000 гаруй жилийн түүхтэй байхад онолын статистик сүүлийн 300 гаруй жилийн хугацаанд үүсэн эрчимтэй хөгжиж байна. Статистик нь арга зүйн шинжлэх ухаан болтлоо сонирхолтой, бас хялбар биш урт замыг туулсан түүхтэй билээ.

Монгол улсын бүртгэл статистикийн хөгжлийн түүхэн дэх хамгийн анхны бүртгэл нь хүн ам зүй, мал аж ахуйн бүртгэл юм. Монгол улсад 1921 оноос эдийн засгийн алба, түүний дотор бүртгэл статистикийн алба шинжлэх ухааны үндэстэй хөгжих бодит бололцоо нээгдсэн юм. Монгол ардын намын III их хурал, Улсын анхдугаар их хурлаас тоо бүртгэлийн албыг бий болгож хүн ам, өрх, мал, эд хөрөнгийг үнэн зөв, тодорхой тоо баримттай болохын чухлыг зааж, энэ үндсэн дээр 1924 онд тоо бүртгэлийн хэлтсийг байгуулан улсын тоо бүртгэлийн ажлыг эрхлэх үүргийг хариуцуулсан үеэс эхлэн Монгол улсын Үндэсний статистикийн алба хөгжих үндэс суурийг тавьжээ.

Статистикийн шинжлэх ухаан нь бүтцийн хувьд статистикийн ерөнхий онол, эдийн засгийн статистик, нийгмийн статистик болон салбарын статистик гэж хуваагдана. Статистикийн ерөнхий онол нь статистик судалгаа шинжилгээний ерөнхий онол, арга зүй, аргачлал, зарчим, статистикийн ерөнхий үзүүлэлтүүдийг боловсруулдаг. Эдийн засгийн статистик нь улс орны эдийн засгийн байдлыг тусгаж байгаа үзүүлэлтийг боловсруулан шинэчлэх, салбар хоорондын харилцан хамаарал, үйлдвэрлэл, материал, хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн бэлэн байгаа нөөц, зарцуулалт, ашиглалтын байдал, үр дүнг судалдаг.

Нийгмийн статистик болон салбарын

статистикт тээвэр, холбоо, хүн ам, соёл, боловсрол, эрүүл мэнд, шүүх, гэмт хэргийн статистик гэх зэрэг орно.

Статистикийн аргыг төрөл бүрийн салбар шинжлэх ухаанд эрчимтэй хэрэглэж байна. Орчин үед төрийн удирдлагын аппарат статистикийн арга зүй, аргачлалыг зайлшгүй хэрэглэх хэрэгцээ, шаардлага улам өссөөр байгаа бөгөөд статистикийн арга зүй, аргачлалыг анагаах ухаан, биологи, астрономи, археологи зэрэг шинжлэх ухааны олон салбарт хэрэглэж байна.

Статистикийн шинжлэх ухааны судлах зүйл нь нийгэм, эдийн засгийн юмс, үзэгдлийн тоо мэдээллийг чанарын агуулгатай нь нягт холбоотойгоор тодорхой орон зай (улс орны, тодорхой бүс нутаг), цаг хугацаанд судлах явдал байдаг. Статистикийн юмс, үзэгдлүүд нь статистикийн хэмжигдэхүүнээр тодорхойлогддог. Статистикийн хэмжигдэхүүн гэдэг нь судлагдаж буй юмс, үзэгдлийн шинж чанарын тоон үнэлгээ юм. Статистикийн үзүүлэлтийн тусламжтайгаар судлагдаж байгаа үзэгдлийн цар хэмжээ, тэдгээрийн харилцан уялдаа хамаарал, өөрчлөлтийн зүй тогтлыг тодорхойлж болдог.

Статистикийн шинжлэх ухааны аргуудыг гүйцэтгэх үүргийг нь харгалзан боловсруулалт, шинжилгээний гэсэн хоёр бүлэгт хуваадаг.

Тоо мэдээллийн бүлэглэлт, товчоолалт хийх, тархалтын цуваа байгуулах, статистик хүснэгт, график дүрслэлээр илэрхийлэх, харьцуулах, зэрэгцүүлэх, дундажлах, хэлбэлзэл тооцох аргуудыг статистикийн боловсруулалтын бүлэгт хамруулна.

Шинжилгээний бүлэгт боловсруулсан тоо мэдээллээ ашиглан индекс, түүвэр судалгааны арга, динамик эгнээний, дисперси, нөлөөлж буй хүчин зүйлсийн корреляци, ререссийн шинжилгээ, магадлал таамаглал дэвшүүлэх зэрэг аргууд багтана.

Статистик нь задлан шинжлэх (анализ), нэгтгэн дүгнэх (синтез), хийсвэрлэх (абстракт), түүхчлэх, ерөнхийгөөс тодорхой, тодорхойгоос ерөнхийд хандах зэрэг шинжлэх ухааны түгээмэл аргуудыг шууд баримтална.

Статистикийн шинжлэх ухааны арга зүй нь математик статистикийн шинжлэх ухааны арга зүй дээр тулгуурласан нийгмийг судалдаг нийгмийн шинжлэх ухаан юм. Чухамдаа “Томъёог тайлж сурах, тоог уншиж сурах, тоог өгүүлбэрт оруулж сурах” гэдэг зарчим статистикийн шалгуурын нэг болж байдаг.

Статистикийн арга зүй гэдэг нь нийгэм, эдийн засгийн бүтэц, динамик болон хамаарлын зүй тогтлыг судлахад чиглэгдсэн арга, аргачлалын тогтолцоог юм.

Гэмт хэргийн статистикийн тухай



ойлголт, судлах зүйл, арга зүй

Статистикийн шинжлэх ухааны цар хүрээ, бусад салбартай уялдах байдал нь шинжлэх ухааны салбарууд дундаа харьцангуй өргөнд тооцогдож олон төрлийн салбар мэдлэгүүдийн судалгааны голчлох арга болох нь бий. Ялангуяа шүүх, прокурор, цагдаагийн байгууллагын удирдах ажилтан, алба хаагч болон мэргэжилтэн статистикийн тоо мэдээллийг уншин ойлгож хэрэглэхээс гадна түүнд дүн шинжилгээ хийж, практик ажиллагаандаа ашиглаж чаддаг байхыг нийгэм өөрөө шаардаж байна.

Гэмт хэргийн талаарх тоо мэдээллийг цуглуулж бүртгэх нь статистикийн шинжлэх ухааны зөвхөн нэг хэсэг болох тоо бүртгэл юм. Харин статистик нь тоо бүртгэлийг хөтлөн явуулахаас гадна, цуглуулсан тоо мэдээллийг боловсруулан, энэ үндсэн дээр санал, дүгнэлт гаргадаг юм. Ингэснээрээ гэмт хэргийг судалдаг салбар шинжлэх ухаанаас гэмт хэргийн статистикийн үүрэг, ач холбогдол илүү үнэ цэнэтэй.

Тухайн байгууллагын авч хэрэгжүүлэх тодорхой, ажил хэрэгч санаа, дүгнэлтээр удирдлагыг хангах, төлөвлөгөө боловсруулах, энэ үндсэн дээр гэмт хэрэг, зөрчилтэй хийх тэмцлийн чиглэлийг тодорхойлох нь гэмт хэргийн статистикийн үндсэн үүрэг билээ. Энэ үүргийг хэрэгжүүлэх гол арга зам нь гэмт хэргийн судалгаа, шинжилгээний ажлын чанар, үр нөлөөг үндсээр нь өөрчлөн сайжруулах, үр дүнг практикт түлхүү нэвтрүүлэхэд цаг алдалгүй хандах явдал юм.

Эрүүгийн эрх зүйн бусад салбаруудтай харьцуулахад криминологи, гэмт хэргийн статистикт нийтлэг зүйл олон байдаг. Энэ хоёр шинжлэх ухаан нь судалгааны ажлын объект, субъект, эцсийн зорилго, агуулга, ач холбогдол, давтагдах хугацаа, эх үүсвэр, хамрах хүрээ, үе шат, хэлбэр, чиглэлээрээ ямар нэгэн хэмжээгээр нийтлэг байдаг. Криминологи, гэмт хэргийн статистик нь бол гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр төр засаг, олон нийт, шүүх болон хууль сахиулах байгууллагын бүх шатны удирдлагын арга барил, ажлын үр дүнг сайжруулах, хамгийн оновчтой, зөв шийдвэр гаргахад тулгуур болдог байх ёстой.

Криминологийн шинжлэх ухаан нь нийгмийн үзэгдэл болох гэмт явдлын тооны ба чанарын агуулгыг судална.

Гэмт явдлын гаралтын байдал: тодорхой цаг хугацаа, орон зайд үйлдэгдсэн гэмт хэргийн тоо үзүүлэлтүүдийн илэрхийлэл юм.

Гэмт явдлын бүтэц: гэмт явдлын дотор эзлэх гэмт хэргийн тодорхой төрөл, бүлгүүдийн харьцаагаар илэрхийлэгддэг гэмт хэргийн бүтэц, гэмт үйлдлийн арга, нийгмийн хор

аюул, криминологи шинж чанар зэрэг үндсэн шинжүүдээр судална.

Гэмт явдлын хөдөлгөөн: гэмт явдлын гаралтын байдал, бүтцэд гарсан цаг хугацааны өөрчлөлт юм.

Гэмт явдлын шалтгаан: Криминологийн шинжлэх ухаан нь гэмт явдлын шалтгааныг судлахдаа гэмт явдлын шалтгаан, тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан, нийгмийн янз бүрийн хүрээнд үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан зэрэг олон түвшинд авч үздэг.

Гэмт хэрэгтэн: бие хүний нийгэм, хүн ам зүй, эрүүгийн эрх зүй, ёс суртахуун, сэтгэл зүйн шинж чанаруудыг судална. Ингэхгүйгээр гэмт хэргийн шалтгааныг ч, тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгааныг ч иж бүрэн тогтоож чадахгүй.

Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх: ерөнхий, тусгай, нэг бүрчилсэн арга хэмжээ боловсруулна.

Гэмт хэргийн талаарх тоо мэдээллийг ашиглан статистик судалгаа, шинжилгээ хийхэд магадлалын онолын их тооны хуулийг ашиглана. Энэ нь санамсаргүй үзэгдлийн тоо ихсэх тутам түүний зүй тогтлыг олоход хялбар дөхөмтэй бөгөөд алдааны нарийвчлал бага гэсэн үг юм. Олон тооны гэмт хэргийг судлах нь гэмт хэргийн гаралт, хөдөлгөөн, бүтэц, тархалт, зүй тогтлыг тогтооход хялбар дөхөмтэй байх бөгөөд алдааны нарийвчлал харьцангуй байна. Гэмт хэргийн статистикийн бүтцэд гэмт хэрэг, гэмт үйлдэгчид, хохирогч иргэн, байгууллага, түдгэлзүүлсэн, хэрэгсэхгүй болгосон, яллах дүгнэлт үйлдүүлэх саналтай прокурорт шилжүүлсэн нөхөн илрүүлсэн хэрэг, прокурорын байгууллагын гэмт хэргийн талаарх статистик мэдээ, тайлан зэрэг багтах юм. Гэмт явдал, гэмт хэрэг, түүнийг үйлдэгчид гэсэн томъёолол байгаа цагт гэмт халдлагад өртсөн хохирогч иргэн, байгууллага гэсэн ойлголт зайлшгүй байна.

Мэдээлэл, судалгааны төв нь гэмт халдлагад өртсөн хохирогч иргэн, байгууллагын талаар тоо бүртгэлийн анхан шатны маягтыг боловсруулан 2007 оны 01 дүгээр сараас шинээр хөтлөх болсон байна. Гэмт хэргийн статистик нь гэмт хэргийн виктомологийн шинжлэх ухаантай нягт холбоотой бөгөөд гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх ажлын чиглэлийг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм. Гэмт хэргийн статистик бас нэг чухал зорилго нь улс орны болон тухайн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг бүрийг тоо бүртгэлд оруулан судлах явдал юм. Энэ нь тухайн нутаг дэвсгэрийн болон улсын хэмжээний гэмт хэргийн байдлыг бүрэн тодорхойлох үндэс болно.

Гэмт хэргийн статистик судлалын түүхэн хөгжил, чиг хандлага



Мэдээлэл, судалгааны алба нь цагдаагийн байгууллага үүссэн үеэс анх бий болж, 1967 он хүртэл бусад албаны харьяанд гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөн, түүний шалтгаан нөхцөлийг судлах, удирдлагыг мэдээллээр хангах үүрэгтэйгээр ажиллаж байсан байна. Энэ үед цагдаа, прокурор, шүүхийн байгууллагууд тус тусдаа тоо бүртгэл хөтөлж байсан бөгөөд улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн нэгдсэн тоо бүртгэл, судалгаа хийдэггүй байжээ.

МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны 1965 оны 305 дугаар тогтоолд гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг улам сайжруулах, гэмт хэргийн гаралт, түүнд нөлөөлж байгаа шалтгаан нөхцөлийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр гүнзгий судалж, эрүүгийн гэмт хэргийн болон урьдчилан сэргийлэх тоо бүртгэл хөтлөн, урьдчилан сэргийлэх арга хэмжээ боловсруулах аппаратыг Улсын Цагдан сэргийлэх ерөнхий газрын дэргэд байгуулахыг заасан нь энэ албыг бие даан хөгжих үндсийг тавьжээ. Сайд нарын зөвлөлийн 1966 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 422 дугаар тогтоолоор Улсын Цагдан сэргийлэх ерөнхий газарт гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах ажлыг улсын хэмжээнд 1967 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн хийлгэх болсноор энэ ажил эрхэлсэн тусгай тасгийг байгуулж, гарч байгаа эрүүгийн гэмт хэргийн байдалд дүн шинжилгээ хийж ажиллах болсон байна.

Эрүүгийн гэмт хэргийн тоо бүртгэл, түүний шалтгаан нөхцөлийг судлах тусгай тасаг нь улсын хэмжээнд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулж шүүхээр шийтгүүлсэн бүх хэргийг нэгтгэн бүртгэж, тэдгээрийн шалтгаан, нөхцөлийг судалдаг байснаа 1980-аад оноос үйл ажиллагаа нь улам боловсронгуй болж, Улсын статистикийн газарт мэдээллээ нэгтгэж, компьютерээр ангилан ялгаж, мэдээлэл бүрдүүлэх болсон байна. Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, судалгааны төвд иргэд гэмт хэрэг үйлдсэн тухай цагдаагийн байгууллагад мэдээлэх идэвх эрс дээшилж, латент чанартай буюу нуугдмал гэмт хэргийн түвшин багасах болсон. Гэмт хэргийн статистикийн чухал зорилго нь улс орны болон тухайн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг бүрийг тоо бүртгэлд оруулан судлах явдал юм. Энэ нь тухайн нутаг дэвсгэрийн болон улсын хэмжээний гэмт хэргийн байдлыг бүрэн тодорхойлох үндэс болно.

Цаашид гэмт хэргийн статистик судлал нь гагцхүү цагдаагийн байгууллага, холбогдох алба хаагч нар гэхээсээ илүүтэйгээр нийгмийн харилцааны бүхий л оролцогч нарт хүртээмжтэй болж чадвал гэмт хэргийн гаралт, олон нийтийн аюулгүй байдалд ч ач холбогдолтой юм.

Дүгнэлт

Нийгмийг аюулаас хамгаалах зорилгын хүрээнд гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судалж, чанарын болон тоон үзүүлэлтүүдийг бууруулах, хэтийн байдлыг тодорхойлж, таамаглал хийх зэрэгт гэмт хэргийн статистик судлал чухал ач холбогдолтой. Нийгмийн шинжлэх ухаан нь байгаль судлалтай харьцуулахад шинжлэх ухааны гол судалгааны арга болох индукцыг туршилтын аргаар баталгаажуулах нь бэрхшээлтэй байдаг боловч байгаль судлалд буй туршилтын давуу талыг нийгэм судлалд өмнөх онолын алдаа, хэрэгжилтээр нөхөж ойлгодог. Энэ ч утгаараа нийгэм судлалд статистик, математикийн тооцооллууд нь байгаль судлалд туршилтын гүйцэтгэдэг үүргийг нөхөж гүйцэтгэдэг юм.

Гэмт хэргийн судалгааны хувьд ч, онолын болон практик түвшинд ч төрийн үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй бодлого зэргийн үр дүнг статистикийн аргаар боловсруулдаг нь түүний судалгааны түвшний ач холбогдлыг практик хэрэгцээ шаардлагатай давхар илэрхийлэх учиртай. Харин цаашид статистик судлалын аливаа мэдээлэл, тэдгээрийн ач холбогдол, гагцхүү шинжлэх ухааны бус, өдөр тутмын амьдрал, үйл ажиллагаандаа хэрхэн ашиглах талаар олон нийтэд хандсан мэдээллүүд тараах нь чухал байна. Жишээ нь: тодорхой цагт гэмт хэрэг илүүтэй үйлдэгддэг газруудад тухайн цагт цагдаа сэргийлэхийн байгууллага анхаарч ажиллахаас гадна иргэд өөрсдөө түүгээр зорчихгүй байх, тухайн цагт илүү бага гэмт явдлын үзүүлэлттэй газар нутгийг сонгож зорчих зэрэг боломжийг нэмэгдүүлэх юм.

Статистик судлалыг нийгмийн шинжлэх ухааны онолын хүрээнд харьцуулан судлах нь гэмт хэргийн статистикийн хувьд ач холбогдолтой байх болно.

ШҮҮХИЙН БАЙГУУЛЛАГА ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИКИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ



Г.Уянга
ХСИС-ийн магистрант

Хураангуй

Улс орон болон бүс нутаг, аймаг, сум, багийн түвшинд статистикийн мэдээллийн хэрэгцээ шаардлага өсөн нэмэгдсээр байна. Шүүхийн байгууллага дахь статистик мэдээллийг олон улсад хүлээн зөвшөөрөгдөх аргачлалын дагуу цуглуулан боловсруулж, нэгтгэн гаргаснаар зөвхөн улс орныхоо хөгжлийн түвшинг тооцохоос гадна Монгол Улс олон улсын хэмжээнд ямар түвшинд үйл ажиллагаа явуулж байгааг тодорхойлох ажил нэн чухал юм. Түүнчлэн Шүүхийн статистикийн мэдээллийн чанарыг сайжруулж, хэрэглэгчийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлж, орчин үеийн шинжлэх ухаан, дэвшилтэд технологийг ашиглан богино хугацаанд ойлгомжтой, хүртээмжтэй байлгах нь нэн чухал юм.

Түлхүүр үгс: Шүүхийн статистик, статистикийн алба, тоо бүртгэл

“Чам шиг бичиг үсэгтэй хүнд харуулахад ч ичмээр дамшиг даа” гээд Эрдэнэд үзүүлдэг Итгэлт баяны дансны дэвтэр^[25] бол түүний малын статистикийн баримт бичиг юм. Тэрхүү дэвтэрт бод, бог малыг хээлтэй, хээлгүйгээр ялган дугуй болон дөрвөлжин дүрсийг дундаа цэгтэй гэх мэтээр төлөөлүүлэн зурсан байдаг. Итгэлт хэдийгээр бичиг үсэг мэдэхгүй боловч зэхсэн сэргэлэн хүн тул малын тоо толгойгоо бүртгэлжүүлэн данслах нь чухал гэдгийг ойлгосон бололтой. Олон жил мал маллаж, наймаа панз үсэргэн малчин ажиллуулахад юу эсийг үзэх билээ. Энэ их хөрөнгийг цуглуулахад тохиолдсон алдаа онооноос урган гарсан туршлагын үр шим нь энэ данс ч юм бил үү.

Итгэлт баяны дансны дэвтрийг статистик ач холбогдлоор авч үзвэл судалгаа, шинжилгээний чухал баримт болох нь харагдана. Тус дэвтрээс ямар ямар үзүүлэлтүүдийг харж болох вэ?

1. Түүний нийт малын тоо толгой

2. Адууны тоо толгой

- Эр
- a) Азарга
- b) адуу
- Эм
- a) Хээлтэй
- b) Хээлгүй

3. Үхрийн тоо толгой

- Эр
- a) Бух
- b) Эр үхэр
- c) Шар
- Эм
- a) Тугалтай
- b) Хээлтэй
- c) Хээлгүй

4. Хонины тоо толгой

- Эр
- a) Хуц
- b) Ирэг
- Эм
- a) Хургатай
- b) Хээлтэй
- c) Хээлгүй

5. Ямааны тоо толгой

- Эр
- a) Ухна
- b) Эр ямаа
- Эм
- a) Ишигтэй
- b) Хээлтэй
- c) Хээлгүй

Гэх мэтээр төрөлжүүлэн ангилж болохоос гадна тарган, туранхай, хурдан удмын, сайн үйлдрийн, уналга ачилга, тэрэгний, сэтэртэй гэхчилэн өөрт шаардлагатай ямар ч аналитик үзүүлэлтүүдээр өгөгдлийг ангилж болно. Малын тоо толгойн нэмэгдэл хорогдол, онд орох эрсдэл, орлого, зарлагыг тооцож байж Итгэлт баяны богино, дунд, урт хугацаанд олох ашиг орлого, малын өсөлт хорогдлын дундаж үзүүлэлтийг гаргаж ирж болно. Ингэхдээ ган зуд, үер нүүрлэх, малын халдварт өвчин гарах эрсдлийг тооцохоос гадна улс төр, нийгэм эдийн засгийн нөхцөл байдал зэрэг олон хүчин зүйлүүдийг таамаглан статистикийн аргуудыг ашиглан ерөнхий прогноз гаргана. Шилийн сайн эрчүүдийг ч мартаж болохгүй.

“Итгэлт баян”-аар жишээ авч, статистикийн шинжлэх ухааны үндсэн ойлголтыг ойлгуулах гэсэн явдал юм.

“Статистик нь мэдээллийг бүртгэх, цуглуулах, эрэмбэлж цэгцлэх, товчоолж танилцуулах, шинжлэн дүгнэх ухаан юм”^[26] гэсэн нь Итгэлт баяны дансны дэвтэр хөтлөхтэй агуулгын хувьд таарч байгаа нь

²⁶ Д.Нарантуяа “Статистик” УБ.,2014

²⁵ Ч.Лодойдамба “Тунгалаг тамир” роман УБ.,1971



олон зүйлийг нэг дор ойлгуулж байх шиг.

Өдгөө дэлхий дээр тоон мэдээ ашигладаггүй нэг ч салбар байхгүй. Өрх айлаас эхлээд улс орны түвшин дэх бүхий л институт нь тоо мэдээг энгийнээс нарийн хүртэлх үйл ажиллагаандаа ашигладаг билээ. Тоогоор өөрчлөлт, харьцуулалтыг тодорхойлж, үнэнийг нотолдог болсон.

Тоон мэдээ тэр бүр ойлгомжтой байдаггүй. Юуг, хэзээ, ямар нэгжээр илэрхийлсэн нь тодорхойгүй үед тухайн мэдээллийг цэгцэлж, хөрвүүлж, харьцуулан нэг мөр ойлголт өгдөг ухааныг статистик гэж ойлгож болно.

Сүүлийн үед мэдээллийн технологи асар хурдацтай хөгжиж байгаатай уялдан байгууллагын үйл ажиллагааны хэв маяг ч өөрчлөгдөж байна.

Байгууллагууд цаасгүй технологид хурдацтай шилжиж байгаа энэ үед шүүхийн байгууллагын тоо бүртгэл, мэдээ тайланг үнэн зөв гаргаснаар үр дүнг, цаашид хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох боломжтой болох юм. Ингэхдээ техник технологийн дэвшлийг ашиглах нь өнөө цагийн шаардлага бөгөөд энэ нь мэдээллийг үнэн зөв, хүртээмжтэй, хэрэглэхэд хялбар, хайлт хийх, статистик дүн мэдээ гаргах, олон төрлийн судалгаанд ашиглах боломжтой болох практик ач холбогдолтой билээ.

20-р зуунаас өнөөг хүртэл хэрэглэж ирсэн арга барилаа халж, мэдээлэл технологийн эрин үетэй хөл нийлүүлэн алхах зорилгоор өдөр тутам хийгддэг ажил үүргийг цахимжуулснаар ажлын үр дүн нэг түвшин дээшлэх билээ. Иймд компьютерийн тусламжтайгаар шүүхийн байгууллага дахь гэмт хэргийн тоо бүртгэлийг цахимжуулснаар тайлан мэдээ зөв гарч, шүүхийн болон төрийн мусад байгууллага, хуулийн этгээд, иргэнийг мэдээллээр хангах, дүн шинжилгээ, хайлт хийхэд хялбар болно. Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2006 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 17-р тогтоолоор батлагдсан “Шүүхийн статистикийн мэдээлэл, тайлан гаргах журам”-ын хавсралт дахь хүснэгтийн дагуу шүүх бүрээс тогтоосон хугацааны дотор мэдээллээ жилд 2 удаа Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх судалгааны хүрээлэнд албан бичгээр хүргүүлдэг. Ирсэн мэдээллийг судалгааны хүрээлэнгийн статистикч нар excel програмын 169 багана дээр нэгтгэдэг бөгөөд энэ нь мөн л алдаа гаргах эрсдэлийг нэмэгдүүлдэг. Шүүхийн ерөнхий зөвлөл нь шүүхийн бүртгэлийн програмтай боловч одоогийн байдлаар зөвхөн эрүүгийн хэргийн шүүх хуралдааны хөдөлгөөнийг бүртгэдэг. Дээрх арга зүй, аргачлал нь шүүхийн статистикийн үйл

ажиллагааны

- Хараат бус, бие даасан байх
- Шинжлэх ухааны үндэслэл бүхий нэгдмэл арга зүйтэй байх
- Үнэн бодитой, шуурхай байх
- Олон нийтэд хүртээмжтэй, хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээнд ил тод байх
- Үзүүлэлт арга зүй нь Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын статистикийн стандарт, арга зүй, шүүхийн үйл ажиллагааны онцлогт нийцсэн байх
- Бага зардлаар, мэдээлэгчид ачаалал багатай арга, хэлбэрээр цуглуулах^[27] гэсэн зарчмуудыг хангаж ажиллаж чадаж байгаа эсэх нь эргэлзээтэй.

Шүүхийн байгууллага дахь гэмт хэргийн тоо бүртгэлийг хөтлөх арга зүй, аргачлал нь өнөөдрийг хүртэл цахимжаагүй байгаа нь нийгмийн шаардлагыг хангаж чадахгүй байгаа учраас түүний эрх зүйн зохицуулалт, арга зүйг боловсронгуй болгох ажлыг нэн даруй хийх шаардлагатай байна.

Гэмт хэрэг нь тодорхой цаг хугацаа, орон зай, нутаг дэвсгэрт буй болдог өөрийн гэсэн өвөрмөц онцлог, зүй тогтол, шинж чанар бүхий нийгмийн сөрөг үзэгдэл юм. Гэмт хэрэг бол өөрөө нийгмийн амьдралын сөрөг үр дагавар бөгөөд улс орны эдийн засаг доройтон ажилгүйдэл, ядуурал нэмэгдэж, үнэ, инфляци өсөхийн хирээр гэмт хэргийн гаралт ч бас нэмэгдэж байдаг зүй тогтолтой. Энэ ч утгаараа гэмт хэргийн статистикийн үзүүлэлтийг олон улсын түвшинд амьдралын чанарын үзүүлэлтэд тооцдог байна.^[28]

Гэмт хэргийн тоо бүртгэлийн үндсэн мэдээлэл, статистикийн үндсэн үзүүлэлтүүд нь хууль сахиулах ажиллагааны удирдлага, төлөвлөлт, бодлого боловсруулалтын эх үүсвэр болохоос гадна үндэсний болон олон улсын байгууллагуудаас эдийн засаг, нийгмийн хөгжлийн түвшинг үнэлэх, хянахад чухал ач холбогдолтой юм.

Гэмт хэргийн статистикийн мэдээллээр гэмт хэргийн гаралт, тархалт, бүтэц, хөдөлгөөн, гэмт хэргийн шалтгаан, нөхцөл зэргийг судлахаас гадна гэмт хэрэгтний нийгэм, хувь хүн байгууллагад учруулсан хохирол, хохирлын нөхөн төлүүлэлт, гэмт хэргийн хохирогчийн эрхийг хамгаалах талаарх хууль сахиулах байгууллагуудаас хэрэгжүүлж буй бодлого хөтөлбөрийн хэрэгжилт, хохирогчийн эрхийг хамгаалах талаарх хууль эрх зүйн орчин ямар хэмжээнд байгаа, хүний эрх түүний дотроос гэмт

²⁷ “Шүүхийн захиргааны удирдлага” Эрх зүйн баримт бичгийн эмхтгэл-3. УБ., 2010

²⁸ “Гэмт хэрэг, хууль сахиулахын статистикийн системийг боловсронгуй болгох нь” гарын авлага, НҮБ-ын ЭЗНГ болон НҮБСК, 2003 он



хэргийн хохирогчийн эрхийн хамгаалалт ямар түвшинд байгаа, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт ямар хэмжээнд байгаа гэх мэтчлэн олон асуудлыг хөндөн судалдаг.^[29]

Гэмт хэргийн тоо бүртгэлийн нэгдсэн цогц мэдээллийн сангүгээс цагдаа, прокурор, шүүхийн байгууллагуудын мэдээллийн харилцан уялдаа муу, статистикийн үзүүлэлтийн зөрүүтэй байдлаас удирдах бүрэлдэхүүнд үл ойлголцох байдал үүсдэг. Цагдаагийн байгууллагын дотоод ажлыг дүгнэхдээ тодорхой шалгуур үзүүлэлт болгодогос гэмт хэргийн мэдээллийн сан бүрдүүлэх ажил бодит байдалд нийцэхгүй байна.

Монгол улсад сүүлийн 10 жилд гэмт хэрэг өсч^[30], шинэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэж байгаа нь гэмт хэргийн тоо бүртгэлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, орчин үеийн мэдээллийн технологийг ашиглан тусгай программ хангамжаар гэмт хэргийн мэдээллийг үнэн зөв бүртгэх, цуглуулсан мэдээ мэдээллийг үнэлэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого боловсруулах, хууль сахиулах байгууллага тэр дундаа шүүх, цагдаа, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагууд гэмт хэргийн тоо бүртгэлийг хэрхэн явуулж байгаа аргачлалийг практик талаас нь судлан түүнд дүн шинжилгээ хийж, хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны нэгдсэн цогц механизмтай болох нь нэн тэргүүний асуудал болоод байна.

Ашигласан материал

1. Я. Баатар, Д.Тархаашин “Гэмт хэрэг судлах статистикийн арга зүй” УБ., 1998
2. С.Жанцан, П.Ихзаяа “Гэмт хэргийн статистик” УБ., 2007
3. МУИС-ийн ЭЗС-ийн багш нар “Статистикийн онол” УБ., 2005
4. Ч.Нямсүрэн “Гэмт хэргийн виктимологи” УБ., 2005
5. “Гэмт хэрэг, хууль сахиулахын мэдээллийг үнэлэх хэрэгсэл” НҮБ-ын ГХМБТГ, 2006 он
6. **Мэдээлэл судалгааны төв. “Монгол улс дахь гэмт хэргийн байдал” УБ, 2006-2016 он.**
7. Л.Эрдэнэсүвд “Бизнесийн статистик” УБ.,2004
8. Д.Нарантуяа “Статистик” УБ.,2014
9. Д.Тунгалаг “Олон улсын статистик” УБ.,2007
10. Ч.Лодойдамба “Тунгалаг тамир” роман УБ.,1971

²⁹ “Гэмт хэрэг, хууль сахиулахын мэдээллийг үнэлэх хэрэгсэл” НҮБ-ын ГХМБТГ, 2006 он

³⁰ Мэдээлэл судалгааны төв. “Монгол улс дахь гэмт хэргийн байдал” УБ, 2006-2016 он.

11. “Шүүхийн захиргааны удирдлага” Эрх зүйн баримт бичгийн эмхтгэл-3. УБ., 2010
<http://nomooo.blogspot.com/2012/05/blog-post.html>
<http://www.nso.mn/>
<http://1212.mn/>

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ХЭРГИЙН ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦААГ ГАДААДЫН ОРНУУДЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ХУУЛЬЧИЛСАН БАЙДАЛ, ТҮҮНД ХИЙСЭН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Г.Гантөмөр
ОТИС-ийн Хууль зүйн сургуулийн
Нийтийн эрх зүйн тэнхимийн
багш, доктор, профессор

О.Амарсайхан
ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Мөрдөх
ажиллагааны тэнхимийн дэд профессор,
докторант, цагдаагийн дэд хурандаа

Монгол улсын Эрүүгийн эрх зүй дэх цаг хугацааны нэг төрөл нь Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 72-р зүйлд заасан хэргийн хөөн хэлэлцэх хугацаа юм.

Хэргийн хөөн хэлэлцэх хугацаа буюу эрүүгийн хариуцлага хүлээлгэх хугацаа нь зөвхөн материаллаг эрх зүй болох Эрүүгийн эрх зүйд төдийгүй процессын эрх зүй – ЭБШЭЗүйд онолын болон практик ач холбогдол бүхий ойлголт, судлагдахуун, институт мөн.

Хэргийн хөөн хэлэлцэх хугацааны үндэсний эрх зүйн зохицуулалтын асуудал манай улсын Эрүүгийн эрх зүйд сурах бичиг, нэг сэдэвт бүтээлийн хүрээнд харьцангуй судлагдсан^[31] боловч уг асуудлыг гадаадын орнуудын Эрүүгийн хуульд хуульчлагдсан байдлыг тусгайлан судалсан бүтээл одоогоор байхгүй байна.

Мөн 2015 онд УИХ-аар Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж буй энэ цаг үед хүчин төгөлдөр

³¹ Г.Совд. БНМАУ-ын ЭЭЗүйн курс. Ерөнхий анги. УБ.1973 он, С.Нарангэрэл. Монгол улсын ЭЭЗүй. Ерөнхий анги. УБ. 1999 он, С.Жанцан. Монгол улсын ЭЭЗүйн онол. II боть. Ялын тухай сургаал. УБ.2014 он, Г.Гантөмөр, О.Амарсайхан. Монгол улсын ЭЭЗүй дэх цаг, хугацаа. УБ.2004 он.



үйлчилж буй Эрүүгийн хуулийн холбогдох хэм хэмжээг боловсронгуй болгох зорилгоор хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гадаадын зарим орнуудын Эрүүгийн хуульд хуульчилсан байдлыг харьцуулсан эрх зүйн үүднээс судлах хэрэгцээ, шаардлага илүүтэй тавигдаж байгаа билээ.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд өөр өөр эрх зүйн бүлийн төлөөлөл болгон 30 гаруй орны Эрүүгийн хууль тогтоомжийг судалсан бөгөөд үр дүнг дараах байдлаар тоймлон авч үзэж байна. Үүнд:

1.Хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хууль тогтоомжид хуульчилсан байдал.

Судалгаанд хамрагдсан орнуудын хувьд хэргийн хөөн хэлэлцэх хугацааг өөр өөрийн онцлогтойгоор холбогдох хууль тогтоомжид хуульчилсан ба хэрхэн хуульчилсан байдлаас нь хамааран хөөн хэлэлцэх хугацааг Эрүүгийн хуульдаа хуульчилсан, ЭБШХ-даа хуульчилсан гэж ангилж болохоор байна.

Ихэнх орнууд /Азербайджан, Армен, Украин, Беларусь, Молдов, Казакстан, Кыргызстан, Узбекистан, Гүрж, Тажикстан, Туркменистан, ОХУ, БНХАУ, Монгол, Тайланд, Австри, Болгар, Польш, ХБНГУ, Голланд, Швед, Швейцари, Турк, Аргентин/ хэргийн хөөн хэлэлцэх хугацааг Эрүүгийн хуульдаа зааж өгчээ.

Эдгээрээс ОХУ болон ТТУХН-ийн гишүүн дийлэнх улсууд хэргийн хөөн хэлэлцэх хугацааг Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн “Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх”, Аргентин улс “Эрүүгийн хариуцлага /ял/ хүлээлгэж болохгүй байдал”, Болгар, Голланд, Дани, Турк улсууд “Гэмт хэргийн үр дагавар арилах” гэсэн бүлэгт хуульчилсан бол Австри, Герман, Польш, Швейцари, Тайланд улс “Хөөн хэлэлцэх хугацаа” гэсэн бие даасан бүлэгт шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацааны хамт хуульчилсаны зэрэгцээ, хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй байх гэмт хэргүүд, хэргийн хөөн хэлэлцэх хугацаа, түүнийг тоолох журмыг нарийвчлан зааж өгсөн нь илүү оновчтой зохицуулалт болсон гэж үзэж байна.

Харин Франц, Бельги, Израйль, Япон, Солонгос зэрэг орнууд хэргийн хөөн хэлэлцэх /эрүүгийн хариуцлагад татах/ хугацааг Эрүүгийн хуульд зааж өгөөгүй, ЭЭЗүй дэх хөөн хэлэлцэх хугацааны өөр нэг төрөл болох шүүхийн шийтгэх тогтоолын хөөн хэлэлцэх хугацааг зааж өгсөн нь ихээхэн анхаарал татаж байна. Дээрх орнуудад хэргийн хөөн хэлэлцэх хугацааг Эрүүгийн

журмаар мөрдөн шалгах /мөшгих/ хугацаа хэмээн тодорхойлж, түүнийг процессын агуулгаар нь Эрүүгийн байцаан шийтгэх хуульд тодорхойлжээ. Тухайлбал: Япон улсын ЭБШХ-ийн 2-р хэсгийн “Прокурор яллах” гэсэн 2-р бүлгийн 250-р зүйлд “... Цаазаар авах ялтай хүн амины хэргээс бусад хэрэг үйлдсэнээс хойш дараах хугацаа өнгөрсөн бол яллагдагчаар татаж болохгүй. Үүнд:

1. Цаазаар авах ялтай бусад гэмт хэрэг үйлдсэнээс хойш 30 жил,

2. Хугацаагүйгээр хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 25 жил,

3. 15 жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 10 жил,

4. 15 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулах гэмт хэрэг үйлдсэнээс хойш 7 жил,

5. 10 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 5 жил,

6. 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх гэмт хэрэг үйлдсэнээс хойш 3 жил,

7. баривчлах, торгох ял оногдуулах гэмт хэрэг үйлдсэнээс хойш 1 жил өнгөрсөн бол...”^[32] гэж заасан байна.

Англи-Саксоны эрх зүйн бүлийн орнуудад хэргийн хөөн хэлэлцэх хугацааг Эрүүгийн хуульд бус, процессын хуульд заадаг нь уг эрх зүйн бүлийн жишиг юм. Бидэнд биетээр байгаа Австралийн Холбооны улсын Эрүүгийн хууль, АНУ-ын Техас муж улсын Эрүүгийн хуульд хэргийн хөөн хэлэлцэх хугацааг заасан хэм хэмжээ байхгүй.

Харин АНУ-ын зарим муж улсын хууль тогтоомжид мисдиминор ангиллын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа 2 жил байхаар заасан тухай энэ чиглэлээр гарсан зарим бүтээлд дурджээ^[33].

Мусульманы шашинт орнуудын Эрүүгийн хуульд хэргийн хөөн хэлэлцэх хугацааг зааж өгөөгүй байна. Учир нь Мусульманы шашны ариун, үнэт зүйлд халдсан ноцтой гэмт хэрэг, ялангуяа худуд, тазир ангиллын хэрэг нь хэзээ үйлдсэнээс үл хамаарч нүгэл, муу зан үйлд тооцогддогтой холбоотой. Харин зарим оронд /Сири, Иордани/ зөвхөн шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацаа буюу ялыг эдлүүлэх хугацааг заасан байдаг.^[34]

³² www.htrr://law.e-gov.go.jp/htmldata-523/S23HO131.html

³³ В.Н.Додонов. Сравнительное уголовное право. Учебник. изд. Юрлитинформ. М. 2009 г. стр 392

³⁴ Г.Ф.Елаян. Основы мусульманского уголовного права. Учебное пособие. Махачкала. 2002 г. стр 72-73



2. Хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тодорхойлсон нэр томъёо. Судалгаанд хамрагдсан орнуудын Эрүүгийн хуульд судалж буй ойлголт, ухагдахууныг хуульчлахдаа өөр өөр нэр томъёо хэрэглэсэн байна. Хуучнаар ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан болон социалист системийн орнуудад хамаарч байсан ихэнх улсуудын Эрүүгийн хуульд “хэргийн хөөн хэлэлцэх хугацаа”, “эрүүгийн хариуцлагад татах хугацаа”, “эрүүгийн хариуцлага хүлээлгэх хугацаа”, Литва, Швед улсад “Ял оногдуулж болохгүй хугацаа”, Польш, Дани улсад “эрүүгийн хэргийн ял хүлээх үр дагавар арилах хугацаа” гэсэн материаллаг эрх зүйн үүднээс нэр томъёо хэрэглэсэн бол Ром-Германы эрх зүйн бүлийн зарим орнууд, тухайлбал: Голланд, Австри, Аргентин, Швейцари, Турк болон Тайланд улсуудад процессын эрх зүйн утгаар “эрүүгийн журмаар мөрдөн шалгах хугацаа”, “эрүүгийн журмаар мөрдөн мөшгих хугацаа”, Япон улсад “яллагдагчаар татаж болохгүй хугацаа” гэсэн нэр томъёогоор хууль тогтоомждоо тодорхойлсон байдаг.

3. Хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тогтоохдоо баримталсан шалгуур, үндэслэл.

Судалгаанд хамрагдсан орнууд хэргийн хөөн хэлэлцэх тогтоохдоо

- а. Гэмт хэргийн ангилал
- б. Гэмт хэргийн төрөл /хэргийн өнгө/
- в. Гэмт буруугийн хэлбэр
- г. Гэмт хэргүүдэд оногдуулахаар заасан ялын төрөл
- д. Гэмт хэргүүдэд оногдуулахаар заасан тодорхой ялын хэмжээ гэсэн 5 шалгуурыг харгалзан тогтоосон нь харагдаж байна.

Хэргийн хөөн хэлэлцэх хугацааг зөвхөн гэмт хэргийн ангиллыг харгалзан тогтоосон орнууд. ОХУ болон ТТУХН-ийн гишүүн ихэнх орнуудын Эрүүгийн хуульд^[35] хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргийн 4 ангиллыг шалгуур болгон хуульчилсан юм. Үүний учир нь 1995 онд батлагдсан ТТУХН-ийн гишүүн орнуудын “Эрүүгийн загвар хууль”-ийн 77-р зүйлд хэргийн хөөн хэлэлцэх хугацааг дээрх шалгуураар хуульчилсан зөвлөмжийг баримтлан гишүүн орнууд хэргийн хөөн хэлэлцэх хугацааг ижил төстэй байдлаар хуульчилсан байдагт оршино. Тухайлбал, ОХУ-ын Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 78-р зүйлд “...Гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш дор дурдсан хугацаа өнгөрсөн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

- а. Хөнгөн гэмт хэрэг үйлдсэнээс хойш 2 жил

б. Хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэнээс хойш

³⁵Литва, Эстони, Гүрж улсыг эс тооцвол. Зохиогч

6 жил

- в. Хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш 10 жил
- г. Онц хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш 15 жил өнгөрсөн бол...” гэж заажээ^[36]. Харин Молдов улсын Эрүүгийн хуулийн 60-р зүйлд

- а. Хөнгөн гэмт хэрэг үйлдсэнээс хойш 2 жил

- б. Хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэнээс хойш 5 жил,

- в. Хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш 15 жил
- г. Онц хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш 20 жил

- д. Туйлын /онцгой/ хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш 25 жил өнгөрсөн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө гэж хэргийн хөөн хэлэлцэх 5 хугацааг заажээ.^[37]

Мөн ТТУХН-ийн гишүүн бус ч хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тогтоохдоо гэмт хэргийн ангиллыг шалгуур болгосон бусад орнууд бий. Жишээ нь: Эстони улсын Эрүүгийн хуулийн 53-р зүйлд “...Гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш дор дурдсан хугацаа өнгөрсөн бол эрүүгийн хариуцлагад татаж болохгүй...” гээд хөөн хэлэлцэх хугацааг

- а. Гуравдугаар зэрэглэлийн гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш 2 жил өнгөрсөн,

- б. Хоёрдугаар зэрэглэлийн гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш 5 жил өнгөрсөн.

- в. Нэгдүгээр зэрэглэлийн гэмт хэрэг үйлдсэнээс хойш 10 жил өнгөрсөн бол гэж заасан байдаг.^[38]

Хэргийн хөөн хэлэлцэх хугацааг Эрүүгийн хуулийн Тусгай ангид оногдуулахаар заасан ялын төрөл, хэмжээнээс хамаарч хуульчилсан орнууд: Ийм орнуудад Австри, Аргентин, Болгар, Герман, Дани, Швейцари, Турк, Тайланд, Хятад, Япон зэрэг улс хамаарна.

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн V хэсгийн “Эрүүгийн хэргийн хөөн хэлэлцэх хугацаа” гэсэн 1-р бүлгийн 78-р зүйлд:

1. Бүх насаар нь хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 30 жил өнгөрсөн,

2. Арваас дээш жилийн хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 20 жил өнгөрсөн,

3. Таваас доошгүй арван жилээс дээшгүй хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 10 жил өнгөрсөн,

³⁶ Уголовный кодекс Российской Федерации / по состоянию на 01.09.1916 года / . М. Изд. Проспект. 2014 г.

³⁷ Молдов улсын Эрүүгийн хуулийн 16-р зүйлд зааснаар гэмт хэргийг нийгмийн хор аюулын шинжээр 5 зэрэглэлд ангилдаг. Уголовный кодекс Республики Молдова. г. Кишинев. 2003 г. стр 6

³⁸ Уголовный кодекс Эстонской Республики. Изд Юридический Центр Пресс. СПб. 2001г. стр 34



4. Нэгээс доошгүй таван жилээс дээшгүй хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 5 жил өнгөрсөн, 5. Нэг жил хүртэл хугацаагаар хорих буюу бусад төрлийн ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 3 жил өнгөрсөн бол гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татахгүй байхаар тогтоожээ.^[39] Тайландын Вант улсын Эрүүгийн хуулийн “Хөөн хэлэлцэх хугацаа” гэсэн 9-р бүлгийн 95-р зүйлд зааснаар

1. Цаазаар авах, бүх насаар нь хорих болон хорин жилийн хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 20 жил өнгөрсөн,

2. Долоогоос дээш хорин жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 15 жил өнгөрсөн,

3. Нэгээс жилээс дээш долоон жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 10 жил өнгөрсөн,

4. Нэг сараас дээш нэг жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 5 жил өнгөрсөн,

5. Нэг сар хүртэл хугацаагаар хорих эсвэл өөр төрлийн ялаар шийтгэхээр заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 1 жил өнгөрсөн бол эрүүгийн журмаар мөрдөн шалгахгүй, шүүхэд татагдахгүй^[40].

Мөн БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 87-р зүйлд хөөн хэлэлцэх хугацааг тухайн хэрэгт Тусгай ангид оногдуулахаар заасан ялын төрөл, хэмжээнээс хамааран:

а) 5 жил хүртэлх хорих ял шийтгэлээр заасан хэрэг үйлдсэнээс хойш 5 жил өнгөрсөн,

б) 5-10 жил хорих ял шийтгэлээр заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 10 жил өнгөрсөн, в) 10 жилээс дээш хугацаатай хорих ял шийтгэхээр заасан ял гэмт хэрэг үйлдсэнээс хойш 15 жил өнгөрсөн,

г) Хугацаагүй хорих ял, цаазаар авах шийтгэх гэмт хэрэг үйлдсэнээс хойш 20 жил өнгөрсөн байхаар тогтоосон юм.^[41]

Хэргийн хөөн хэлэлцэх хугацааг заахдаа холимог шалгуурыг хэрэглэсэн орнууд: Ийм орнууд нь хэргийн хөөн хэлцэх хугацааг дээр дурдсан гэмт хэргийн ангилал, гэмт хэргийн төрөл /хэргийн өнгө/, гэм буруугийн хэлбэр, гэмт хэргүүдэд оногдуулахаар заасан ялын төрөл, хэмжээ зэрэг 2-3 шалгууруудыг үндэслэн тогтоосон байх ба Литва, Гүрж, Польш, Голланд зэрэг орнуудыг нэрлэж болно. Тухайлбал, Голланд улсын Эрүүгийн

хуулийн 70-р зүйлд эрүүгийн журмаар мөрдөн шалгах хугацааг заасан ба дор дурдсан хугацаа өнгөрсөн бол мөрдөн шалгаж болохгүй.

а) Эрүүгийн зөрчил үйлдсэн бол 2 жил өнгөрсөн,

б) Торгох ял болон 3 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш 6 жил өнгөрсөн,

в) 3-10 жил хорих ял оногдуулсан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 12 жил өнгөрсөн,

г) 10 жилээс дээш хугацаатай хорих ялаар шийтгэх гэмт хэрэг үйлдсэнээс хойш 15 жил өнгөрсөн,

д) Бүх насаар нь хорих ял шийтгэхээр заасан хэрэг үйлдсэнээс хойш 18 жил өнгөрсөн бол гэж зааснаас үзэхэд гэмт хэргийн ангилал^[42], гэмт хэрэгт оногдуулахаар заасан ялын төрөл, хэмжээг шалгуур болгосон нь харагдаж байна.

Мөн Литва улсын Эрүүгийн хуулийн 95-р зүйлд:

а. Эрүүгийн зөрчил үйлдсэнээс хойш хоёр жил өнгөрсөн,

б. Болгоомжгүй гэмт хэрэг эсвэл хөнгөн болон хүндэвтэр гэмт хэргийг санаатай үйлдсэнээс хойш 4 жил өнгөрсөн ,

в. Хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш 8 жил өнгөрсөн,

г. Онц хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш 12 жил өнгөрсөн,

д. Хүнийг санаатай алах гэмт хэрэг үйлдсэнээс хойш 15 жил өнгөрсөн бол ял оногдуулж болохгүй...” гэж хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хуульчлахдаа гэмт хэргийн ангилал, гэм буруугийн хэлбэр, гэмт хэргийн төрөл гэсэн 3 шалгуурыг удирдлага болгосон байх жишээтэй^[43].

4. Хэргийн хөөн хэлэлцэх хугацааны төрөл, хэмжээг тогтоосон байдал. Гадаадын улс орнууд хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хуульчлахдаа төрөл, түүний доод дээд хэмжээг харилцан адилгүй хуульчилсанг харж болно.

ОХУ болон ТУУХН-ийн гишүүн зарим орнууд, Хятад, Монгол, Дани улс гэмт хэргийн ангиллаас хамааран хөөн хэлэлцэх төрлийн 4 хугацааг заасан бол Австри, Аргентин, Болгар, Герман, Голланд, Польш, Литва, Молдов, Тайланд - 5, Итали, Турк - 6, Эстони, Швейцарь хамгийн цөөн буюу 3, Испани, Сан-Марино, Япон хамгийн олон буюу 7 хугацааг зааж өгчээ.

Хэргийн хөөн хэлэлцэх хугацааны хэмжээг / доод ба дээд хэмжээг/ заасан байдлыг авч

³⁹ Уголовный кодекс ФРГ. Изд МГУ.М.1996 г. стр 60.

⁴⁰ Уголовный кодекс Тайланда. Изд Юридический Центр Пресс.СПб.2005 г. стр 68-69

⁴¹ Уголовный кодекс КНР. Изд Юридический Центр Пресс.СПб.2001 г. стр 52-53

⁴² Голланд удсын Эрүүгийн хуулиар гэмт хэргийг эрүүгийн зөрчил, гэмт хэрэг гэж хоёр ангилдаг. Уголовный кодекс Голландии. Изд Юридический Центр Пресс. СПб. 2001г. стр 190-191

⁴³ Уголовный кодекс Литовской Республики. Изд Юридический Центр Пресс.СПб. 2002 г. стр 19



үзвэл Латви 6 сараас 15 жил, Туркэд 6 сараас 25 жил, Австри, Испани, Тайланд 1 жилээс 20 жил, Эстони 5 жилээс 10 жил, Аргентин, Армен, Беларусь, Дани, Казакстан, Кыргызстан, Литва, ОХУ, Украйн, Тажикстан, Туркменистан 2 жилээс 15 жил, Голланд 2 жилээс 18 жил, Швейцари, Хятад 2 жилээс 20 жил, Молдов, Норвеги, Гүрж, Швед 2 жилээс 25 жил, Польш 1 жилээс 30 жил, Герман 3 жилээс 30 жил, Болгар 2 жилээс 35 жил гэх мэтээр тогтоосон байх ба дунджаар авч үзвэл доод хэмжээ нь хэмжээ 2 жил, дээд хэмжээ нь 15-20 жил байна.

5. Хэргийн хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй байх нөхцөл /хэргүүд/.

Судалгаанд хамрагдсан орнууд хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хуульчлахдаа хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэхгүй тохиолдол, гэмт хэргүүдийг харилцан адилгүй зааж өгчээ.

1968 оны 11-р сарын 26-ны өдөр НҮБ-аас баталсан “Дайны гэмт хэрэг болон хүн төрөлхтөний эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа үл хэрэглэх тухай” Конвенци, 1974 оны 1-р сарын 25-ны өдрийн “Хүн төрөлхтөний эсрэг болон цэргийн гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй байх тухай Европын конвенци, 1998 оны “Олон улсын Эрүүгийн шүүхийн /Ромын/ дүрэм”-ийг соёрхон баталсан, нэгдэн орсон улс орнууд энх тайван, хүн төрөлхтөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэхгүй тухай заалтыг үндэсний хууль тогтоомжид хуульчилжээ. Ийм зохицуулалт Беларусь улсын Эрүүгийн хуульд бие даасан зүйл буюу 85-р зүйлд, ОХУ-ын Эрүүгийн хуулийн 78-р зүйлийн 5 дахь хэсэг, Молдов улсын Эрүүгийн хуулийн 60-р зүйлийн 8 дахь хэсэг, Кыргызстан улсын Эрүүгийн хуулийн 67-р зүйлийн 5 дахь хэсэг^[44], Болгар улсын Эрүүгийн хуулийн 79-р зүйлийн 2 дахь хэсэгт бий.

Зарим орны Эрүүгийн хуульд хэргийн хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй байх ердийн эрүүгийн хэргийг заасан нь манай улсын эрүүгийн эрх зүйд судалж үзэх туршлага байж болох талтай. Тухайлбал, Япон улсын ЭБШХ-ийн 250-р зүйлд цаазаар авах ялтай хүн амины хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй^[45], Австри улсын Эрүүгийн хуулийн 57-р параграфт бүр насаар нь хорих ял шийтгэхээр заасан хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй^[46] байхаар заажээ.

Түүнчлэн цаазаар авах болон бүх насаар нь хорих ялтай хэрэгт хөөн хэлэлцэх

хугацаа хэрэглэх эсэхийг шүүх, зарим оронд прокурор шийдвэрлэх талаар заасан орнууд /Азербайджан, Армен, Гүрж, ОХУ, Казакстан, Кыргызстан, Латви, Монгол, Молдов, Узбекистан, Хятад/ байна. Тухайлбал, Латви улсын Эрүүгийн хуулийн 56-р зүйлийн 4 дэх хэсэгт “...энэ зүйлийн 1.5-д заасан цаазаар авах, бүх насаар нь хорих ял шийтгэхээр заасан хэрэг үйлдсэнээс хойш 30 жил өнгөрсөн бол хэргийн хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ. Шүүх хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэхгүй гэж үзвэл цаазаар авах ялыг хорих ялаар солино...”^[47] гэж заасан манай улсын эрүүгийн хуулийн хэм хэмжээтэй ойролцоо юм.

Мөн Гүрж улсын Эрүүгийн хуулийн 71-р зүйлийн дэх хэсэгт хугацаагүй хорих ял шийтгэхээр заасан хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ. Хэрэв хөөн хэрэлцэх хугацааг шүүх хэрэглэхгүй гэж үзвэл хугацаагүй хорих ялыг хугацаатай хорих ялаар солино гэж заасан байна^[48].

БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 87-р зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар цаазаар авах болон бүх насаар нь хорих ялтай гэмт хэрэг үйлдсэнээс хойш 20 жил өнгөрсөн тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх эсэхийг Бүх Хятадын Ерөнхий Прокурор шийдвэрлэдэг.^[49]

6.Хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох журам. ЭЭЗүйд хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох журмыг онолын хүрээнд төдийгүй хууль тогтоомжийг хүрээнд тодорхойлдог. Хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох журам гэдэг ойлголтод хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолж эхлэх, хөөн хэлэлцэх хугацааг зогсоох, үргэлжлүүлэн тоолох, хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тасрах, шинээр тоолох, хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дуусах зэрэг ойлголтууд хамаарах бөгөөд улс орнууд тэдгээрийг өөр өөрийн гэсэн онцлогтойгоор эрүүгийн хууль тогтоомждоо хуульчилсан байна.

Хэргийн хөөн хэлэлцэх хугацааг ямар хугацааны дотор /эхлэх, дуусах/ тоолох онцлог. Австри, Болгар, Герман, Латви, Дани, Норвег, Испани Польш Турк, Швед, Швейцари, Эстони зэрэг улсад хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эрүүгийн журмаар мөрдөн шалгах өдөр хүртэл, Голланд улсад хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэний дараа маргааш өдрөөс эрүүгийн журмаар мөрдөн шалгах өдөр хүртэл тоолдог

⁴⁴ Уголовный кодекс Кыргызской Республики. Бишкек. 2003 г.

⁴⁵ www.htrr://law.e-gov.go.jp/htmldata-S23/S23HO131.html

⁴⁶ Уголовный кодекс Австрии. Изд. Юридический Центр Пресс.СПб. 2004 г. стр 108

⁴⁷ Уголовный кодекс Республики Латвии. Изд. Юридический Центр Пресс.СПб. 2002 г. стр 19

⁴⁸ Уголовный кодекс Грузии. Изд. Юридический Центр Пресс.СПб. 2002 г. стр 134

⁴⁹ Уголовный кодекс КНР. Изд. Юридический Центр Пресс.СПб. 2004 г. стр 53



бол Тайландын Вант улсад хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хэргийг / хэрэгнийг/ шүүхэд шилжүүлэх хүртэл, Японд гэмт хэрэг үйлдсэн өдрөөс прокурор хэргийг яллах хүртэл, Кыргызстан, Турк, Литва улсад гэмт хэрэг үйлдсэн өдрөөс шүүхийн шийтгэх тогтоол гаргах хүртэл тоолдог онцлогтой.

Харин ОХУ болон ТТУХН-ийн гишүүн зарим орнуудын хувьд хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн гэмт этгээдэд ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болох хүртэл тоолно. Ийм зохицуулалт ОХУ-ын Эрүүгийн хуулийн 78-р зүйлийн 1 дэх хэсэгт байдаг нь манай улсын Эрүүгийн хуулийн хэм хэмжээтэй ижил байна.

Хэргийн хөөн хэлэлцэх хугацаа зогсох, сэргээн тоолох, тасрах, шинээр тоолох онцлог. Болгар улсын Эрүүгийн хуулийн 81-р зүйлийн 1 дэх хэсэгт "...эрх бүхий байгууллагаас гэмт хэрэг үйлдсэн этгээдийг мөрдөн шалгах зорилгоор тодорхой ажиллагаа явуулснаар, Швейцари улсын Эрүүгийн хуулийн 72-р зүйлийн 2 дахь хэсэг, ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 78-р параграф, Турк улсын Эрүүгийн хуулийн 104-р зүйлд зааснаар гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн тоологдож эхэлсэн хэргийн хөөн хэлэлцэх эжигтэн, яллагдагчийг мөрдөн шалгах зорилгоор процессын ямар нэг ажиллагаа / хуулийн байгууллагаас зарлан дуудах хуудас явуулах, баривчлах, түр саатуулах, үзлэг, нэгжлэг хийх, байцаах, эрүүгийн хэрэг үүсгэх г.м./ явуулснаар, Гүрж улсын Эрүүгийн хуулийн 71-р зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар гэмт хэрэг үйлдсэн этгээдийг яллагдагчаар татсанаар, Испани улсын Эрүүгийн хуулийн 132-р зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эсрэг эрүүгийн хэрэг үүсгэснээр, Голланд улсын Эрүүгийн хуулийн 72-р зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар гэмт хэрэг үйлдсэн этгээдийг мөрдөн шалгаж эхэлсэн тухай эрх бүхий байгууллагаас түүнд мэдэгдсэнээр хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсоох ба энэ ажиллагаанууд дуусахад уг хугацааг үргэлжлүүлэн тоолно.

Харин ОХУ /ЭХ-ийн 78-р зүйлийн 3 дахь хэсэг/, Казахстан /ЭХ-ийн 69-р зүйлийн 3 дахь хэсэг/, Кыргызстан /ЭХ-ийн 67-р зүйлийн 3 дахь хэсэг/, БНХАУ /ЭХ-ийн 88-р зүйл/, Молдав /ЭХ-ийн 60-р зүйлийн 5 дахь хэсэг/ зэрэг улсад хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолж эхэлсэнээс хойш гэмт этгээд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс орговол хөөн хэлэлцэх хугацаа зогсох бөгөөд уг этгээд өөрөө сайн дураар хуулийн байгууллагад хэргээ илчлэн ирэх, эсвэл түүнийг хуулийн байгууллагаас эрэн сурвалжилж баривчлах, саатуулах үеэс уг хугацааг үргэжлүүлэн /сэргээн/

тоолохоор заасан нь манай улсын Эрүүгийн хуулийн зохицуулалттай үндсэндээ ижил байна.

Хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тасрах, шинээр тоолохтой холбоотой зохицуулалт гадаадын зарим орнуудын Эрүүгийн хуульд байгааг үндэсний Эрүүгийн хуулийн холбогдох хэм хэмжээг боловсронгуй болгоход анхаарах нь зүйтэй гэж судлаачийн хувьд үзэж байна.

Зарим орнуудын хувьд хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тасрах, сэргээн тоолоход гэмт этгээдийн эхний болон дараагийн үйлдсэн гэмт хэргийн ангилал, төрөл, ялын хэмжээ ач холбогдол үзүүлдэгийг судалгаа харууллаа.

Украин, Латви, Литва, Эстони, Молдав, Хятад зэрэг орны Эрүүгийн хуульд өмнөх хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дуусаагүй байхад / тоологдож байхад/ шинээр гэмт хэрэг үйлдвэл сүүлийн үйлдсэн хэргийн ангилал, төрөл, гэм буруугийн хэлбэр, оногдуулах ялын хэмжээ хамаарахгүйгээр хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тасрах ба сүүлийн гэмт хэрэг үйлдсэн өдрөөс уг хугацааг сэргээн тоолох журам үйчилдэг. Тухайлбал, БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 89-р зүйлд "...хэрэв хэргийн хөөн хэлэлцэх хугацааны дотор шинээр гэмт хэрэг үйлдвэл өмнөх хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тасарч, сүүлийн гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг шинээр тоолно..." заасан байдаг.

Харин Кыргыз улсын Эрүүгийн хуулийн 67-р зүйлийн 3 дахь хэсэгт "...хэрэв хэргийн хөөн хэлэлцэх хугацааны дотор шинээр санаатай гэмт хэрэг үйлдвэл өмнөх хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тасарч, сүүлийн гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг шинээр тоолно...", Молдав улсын Эрүүгийн хуулийн 60-р зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар хэрэв хэргийн хөөн хэлэлцэх хугацааны дотор хоёр жил хүртэл хугацаагаар хорих оногдуулахаар заасан гэмт хэрэг шинээр үйлдвэл хөөн хэлэлцэх тухай тасрах бөгөөд хөөн хэлэлцэх хугацааг сүүлийн хэрэг үйлдсэн өдрөөс шинээр тоолох заалт байгаа нь манай өмнөх эрүүгийн хууль буюу 1986 оны Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн зохицуулалттай ижил байна.

Мөн Армен улсын Эрүүгийн хуулийн 75-р зүйлийн 2 дахь хэсэгт "...хэрэв хэргийн хөөн хэлэлцэх хугацааны дотор хүндэтгэр, хүнд, онц хүнд гэмт хэрэг шинээр үйлдвэл хөөн хэлэлцэх тухай тасрах бөгөөд хөөн хэлэлцэх хугацааг шинээр гэмт хэрэг үйлдсэн өдрөөс сэргээн тоолно..." гэж заасан нь хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тасрах, шинээр тоолоход сүүлийн үйлдсэн хэргийн ангилал, ялын төрөл нөлөөлж байгаагийн жишээ мөн.

Үүний эсрэг гэмээр зохицуулалт Казакстан улсын Эрүүгийн хуулийн 69-р зүйлийн 4 дэх хэсэгт бий. Уг хэсэгт "...Хэрэв урьд нь хүнд, онц



хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээд хэргийн хөөн хэлэлцэх хугацааны дотор дахин шинээр гэмт хэрэг үйлдвэл хөөн хэлэлцэх хугацаа тасрах бөгөөд хөөн хэлэлцэх хугацааг сүүлийн үйлдсэн гэмт хэрэг үйлдсэн өдрөөс шинээр тоолно. Харин бусад гэмт хэрэг үйлдсэний дараа дахин шинээр гэмт хэрэг үйлдвэл хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тасрахгүй, хоёр хэргийн хөөн хэлэлцэх хугацаа зэрэгцэн тоологдоно...” гэж заасан нь тус улсын хууль тогтоогч хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тасрах, шинээр тоолоход эхний үйлдсэн гэмт хэргийн ангиллыг харгалзсаныг гэрчилж байна.

Зарим орнуудын /ОХУ, Азербайджан, Гүрж, Туркменистан/ хувьд хэргийн хөөн хэлэлцэх хугацаа шинээр гэмт хэрэгт үйлдэхэд тасрах, сүүлийн гэмт хэрэг үйлдсэн өдрөөс уг хугацааг сэргээн тоолох ойлголт байдаггүй, харин эхний гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тоологдож байхад шинээр гэмт хэрэг үйлдвэл хоёр хэргийн хөөн хэлэлцэх хугацаа зэрэгцэн тус тусдаа тоологдох журам үйлчилнэ. Тухайлбал: Азербайджан улсын Эрүүгийн хуулийн 75-р зүйлийн 2 дахь хэсэгт “...Хэргийн хөөн хэлэлцэх хугацааны дотор гэмт хэрэг шинээр үйлдвэл хоёр хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тус тусдаа зэрэгцэн тоологдоно. ...”^[50] гэж заажээ.

Дүгнэлт

1. Судалж буй асуудал болох хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гадаадын улс орнууд өөрийн эрх зүйн уламжлал, эрх зүйн шинжлэх ухааны хөгжлийн төвшин, эрх зүйн бүлийн болон өөрийн орны онцлог зэргийг харгалзан харилцан адилгүйгээр үндэсний эрүүгийн хууль тогтоомждоо хуульчилсан байна.

2. Гадаадын орнуудын эрүүгийн хууль тогтоомжид хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хуульчилсан байдлыг харьцуулсан эрх зүйн хүрээнд судалж, авч үзэж буй судлагдахууны талаарх орчин үеийн эрх зүйн сэтгэлгээний хөгжил, эрх зүйн зохицуулалт, олон улсын жишиг, чиг хандлагыг тодорхойлбол хэргийн хөөн хэлэлцэх хугацааг зөвхөн гэмт хэргийн ангиллаар бус гэмт хэргийн төрөл, гэм буруугийн хэлбэр, оногдуулахаар заасан ялын төрөл, хэмжээ зэргийг харгалзан илүү олон төрөлтэйгээр, түүний доод, дээд хэмжээг харьцангуй доошлуулах замаар, хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох журмыг гэмт хэрэгтэнд илүү энэрэнгүй байдлаар ялгамжтайгаар хуульчлах чиг хандлага ажиглагдаж байна.

3. Гадаад орнуудын эрүүгийн хууль тогтоомжид хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн хуульчилсан эрх зүйн зохицуулалт,

⁵⁰ Уголовный кодекс Республики Азербайджан. Изд. Юридический Центр Пресс.СПб. 2004 г. стр 92

олон улсын жишиг, чиг хандлагыг тодорхойлж судлахгүйгээр үндэсний эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох боломжгүй бөгөөд хүчин төгөлдөр үйлчилж буй эрүүгийн хууль болон УИХ-аар хэлэлцүүлж буй “Эрүүгийн хуулийн шинэчлсэн найруулгад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлд тусгах, санаа авахуйц, цаашдын судалгаанд анхаарахуйц онолын үзэл баримтлал, шинэлэг санаа, шийдэл цөөнгүй байгааг анхаарах хэрэгтэй юм.

Санал

1. Эрүүгийн хуулийн Шинэчилсэн найруулгад хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хэдий хүртэл хугацаанд тоолохыг тодорхой зааж өгөх, тухайлбал “...ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болох хүртэл хугацаанд тоолно...” гэж оруулах,
2. Эрүүгийн хуульд хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тогтоохдоо гэмт хэргийн ангиллаар бус, Тусгай ангид оногдуулахаар заасан ялын төрөл, хэмжээ, гэм буруугийн хэлбэрээс хамаарч ялгамжтайгаар хуульчлах,
3. Олон улсын жишиг, хандлагад нийцүүлэн хэргийн хөөн хэлэлцэх хугацаа шинээр гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд тасрахгүй байх, хоёр гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тус тусдаа зэрэгцэн тоологдохоор хуульчлах зэрэг болно.



МОНГОЛ УЛСЫН ЯЛЫН БОДЛОГЫН ӨӨРЧЛӨЛТ (2012-2016)

С.Гантулга (Ph.D),

Б.Энхболд (Ph.D)

Хууль сахиулахын их сургууль

Монгол Улс Ардчилсан нийгмийн харилцааг сонгож, ардчилсан Үндсэн хуулиа батлаад 20 гаруй жил боллоо. Энэхүү нийгмийн харилцаанд тохирсон, Монгол Улсын Үндсэн хуульд тунхагласан хүний эрх, эрх чөлөөг илүү баталгаажуулсан, олон улсын нийтийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагад нийцсэн хууль батлах зүй ёсны шаардлагыг үндэслэн 2015 онд УИХ-аас Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан, 2016 онд Монгол Улсын Засгийн газраас Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл (цаашид “хуулийн төсөл” гэх)-ийг боловсруулж, УИХ-д өргөн бариад байна.

2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга, өргөн барьсан хуулийн төслөөс үзэхэд, Монгол Улсын ялын бодлого, ялын тогтолцоонд зарчмын шинжтэй хэд хэдэн өөрчлөлт оржээ. Тухайлбал,

Нэг.Ялын бодлогын талаар:

Санкц нь ялын төрөл, хэмжээг илэрхийлдэг тул аливаа ял нь гэмт хэргийн нийгмийн аюулын хэр хэмжээ, шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм буруу, хувийн байдалд тохирсон байх учиртай.^[51]

Ялангуяа хорих ялын санкцын хэмжээ нь тухайн үеийн нийгэм-улс төрийн нөхцөл байдлаас шууд хамааралтай хуульчлагдаж ирсэн байдаг. Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Эрүүгийн хуульд хорих ялын хэмжээ **1-15** жил, онцгой тохиолдолд **25** жил хүртэл хугацаатай байгаа бол хуулийн төсөлд **6 сараас 20 жил** хүртэл хугацаатай, эсхүл бүх насаар нь хорихоор (одоогийн хуульд цаазаар авах оногдуулахаар заасан гэмт хэрэгт) тусгажээ.

2002 оны Монгол Улсын Эрүүгийн хууль	2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга	2016 оны Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
Үндсэн хугацаа: 1-15 жил	Хугацаатай хорих ял 7 хоног-20 жил	Хугацаатай хорих ял 6 сар-20 жил
Тусгай ангид заасан тохиолдолд 25 жил хүртэл		
	Энэ хуульд заасан тохиолдолд бүх насаар хорих	Энэ хуульд заасан тохиолдолд бүх насаар хорих

Эндээс үзэхэд, хорих ялын хэмжээг урьд байгаагүйгээр зөөлрүүлсэн нь гэмт хэргийг тогтоон барихад ялын хатуу чанга нь бус гарцаагүй байх нь чухал бөгөөд шийтгэлгүй өнгөрөх бол уу гэсэн найдлага дагуулсан хатуу ялаар шийтгэгдэх айдсаас хөнгөн боловч гарцаагүй шийтгүүлнэ гэсэн мэдрэмж илүү нөлөөтэй гэсэн онол, олон улсын хандлагатай нийцэж байна.

Хорих ялын дээд, доод хэмжээг тогтоох, ялын бодлогыг зөөлрүүлэх, ялын олон сонголттой, уян хатан болгох, хорих ялыг эцсийн арга хэмжээ болгон оногдуулах, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгмээс тусгаарлалгүйгээр хорихоос өөр төрлийн ял оногдуулах, албадлагын арга хэмжээ хэрэглэх зэргээр нийгэм, хамт олны дунд хүмүүжүүлэх, дахин нийгэмшүүлэхэд анхаарч, хөгжингүй улсуудын туршлага, хууль тогтоомжийн баялаг уламжлалтай гадаадын зарим улсын эрүүгийн хуулийг харьцуулан судалж, өөрийн орны онцлог, уламжлалд нийцүүлэн тусгажээ.

Тухайлбал, хорих ялын хэмжээг тодорхойлохдоо гадаадын улс орнуудын эрүүгийн хууль тогтоомжийг харьцуулан судалсан.

ХБНГУ-ын Эрүүгийн хууль §38	БНСУ-ын Эрүүгийн хууль §42	ОХУ-ын Эрүүгийн хууль §56	БНХАУ-ын Эрүүгийн хууль §45
-----------------------------	----------------------------	---------------------------	-----------------------------

⁵¹ С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй (Ялын тухай сургаал) II боть. УБ., 2014. 142 дахь тал



Хорих ял хугацаатай болон хугацаагүй байна. Хугацаатай хорих ял 1 сар-15 жил	Хугацаатай хорих ял 1 сар-15 жил онцгой тохиолдолд 25 жил, Хугацаатай хорих ял шоронд хөдөлмөр эрхлүүлдэг, эрхлүүлдэггүй.	Хугацаатай хорих ял 2 сар-20 жил нийлмэл гэмт хэргийн хувьд 25 жилээс ихгүй байна.	Хугацаатай хорих ял 6 сар-15 жил
Хугацаагүй хорих ял нь бүх насаар хорих	Хугацаагүй хорих ял нь бүх насаар хорих		Хугацаагүй хорих ял нь бүх насаар хорих

Гэвч 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад ялын бодлогын хувьд оновчгүй, хууль шүүхийн өмнө эрх тэгш байх Монгол Улсын Үндсэн хуулийн зарчмыг гажуудуулсан зохицуулалт байна. Тухайлбал,

	Хүн хулгайлах гэмт хэрэг §13.2	Хулгайлах гэмт хэрэг §17.1	Мал хулгайлах гэмт хэрэг §17.12
Үндсэн бүрэлдэхүүн	1.Хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хууран мэхэлж, эсхүл сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй байдлыг ашиглаж эрхшээлдээ оруулан авч явсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. (1-5 жил хорих)	1.Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан бол долоо хоногоос таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл долоо хоногоос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. (7 х- 5 жил хорих)	1.Бусдын малыг хулгайлсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. (2-8 жил хорих)

Иргэд, практик байгууллагын ажилтнууд, эрдэмтэн, судлаачид хүний эрх, эрх чөлөөг хамгаалах баталгаа болдог, цэг таслал бүр нь хүний амьдралыг асуудлыг шийдвэрлэх гол хуульд энэ мэт гажуудал гарсныг таагүй хүлээн авч байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан бүх гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг зөөлрүүлж, гэмт этгээдүүдийн толгой элээгүй. Харин эсрэгээрээ хүүхдийн эсрэг гэмт хэрэг, бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, авлигын гэмт хэргүүдийн ялын бодлогыг чангатгасан нь мөн л олон улсын туршлага, хандлагыг харгалзан үзсэн явдал юм. Тухайлбал,

Биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийн тухайд:

2002 оны Эрүүгийн хууль	2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга
124 дүгээр зүйл.Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг	12.3.Бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг
124.2.Үндсэн бүрэлдэхүүн: торгох, албадан ажил хийлгэх, эсхүл 5 жил хүртэл хугацаагаар хорих	Үндсэн бүрэлдэхүүн: 1-5 жил хүртэл хугацаагаар хорих
124.3.Хүндрүүлэх бүрэлдэхүүн: 5-10 жил хүртэл хугацаагаар хорих	Хүндрүүлэх бүрэлдэхүүн: 12-20 жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл бүх насаар хорих

Энэ гэмт хэргийн үндсэн, хүндрүүлэх бүрэлдэхүүнээс торгох ялыг хассан. Охидын биеэ үнэлэхийг зохион байгуулж, их хэмжээний ашиг олсон караокены гадаад эздийн үйлдлийг ЭХТА 124.2 дахь хэсгээр зүйлчилж, тус бүрд 20 орчим сая төгрөгийн торгох ял оногдуулсан явдлыг иргэд шүүмжилж байсантай холбоотой.

ОХУ, БНХАУ, БНСУ, Япон зэрэг улсын эрүүгийн хууль тогтоомжоос үзэхэд, энэ төрлийн



гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ял харьцангуй өндөр, ялын бодлогын хувьд чанга байна. Тухайлбал,

БНХАУ-ын Эрүүгийн хууль	ОХУ-ын Эрүүгийн хууль
§358. Биеэ үнэлэхийг зохион байгуулах	§241. Биеэ үнэлэхийг зохион байгуулах
Үндсэн бүрэлдэхүүн: 5-10 жил хүртэл хугацаагаар хорих, нэмэгдэл ял торгох	Үндсэн бүрэлдэхүүн: 3-10 жил хүртэл хугацаагаар хорих, нэмэгдэл ял 15 жил хүртэл хугацаагаар тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах
Хүндрүүлэх бүрэлдэхүүн: 10 дээш жил хорих, эсхүл бүх насаар хорих, эд хөрөнгө хураах ял	

Авлига, албан тушаалын гэмт хэргийн хайд:

2002 оны Эрүүгийн хууль	Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
263 дугаар зүйл.Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах гэмт хэрэг	22.1.Эрх мэдэл, албан тушаалын байдал, эрх нөлөөгөө урвуулан ашиглах гэмт хэрэг
263.1.Үндсэн бүрэлдэхүүн: ХХДХ 5-50 торгох, эсхүл 1-3 сар хүртэл хугацаагаар баривчлах 1.2-12 сая	5400-27000 нэгжтэй тэнцэх төгрөгөөр торгох, 1-5 жил зорчих эрхийг хязгаарлах, 1-5 жил хорих 5.4-27 сая
263.2.Хүндрүүлэх бүрэлдэхүүн: 5 жил хүртэл хугацаагаар хорих	2-8 жил хүртэл хугацаагаар хорих /тэнсэхгүй/
2002 оны Эрүүгийн хууль	Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
268 дугаар зүйл. Хээл хахууль авах	22.3.Хахууль авах
268.1.Үндсэн бүрэлдэхүүн: ХХДХ 51-250 торгох, эсхүл 5 жил хүртэл хугацаагаар хорих	2700-14000 нэгжтэй тэнцэх төгрөгөөр торгох, 6 сар-3 жил зорчих эрхийг хязгаарлах, 6 сар-3 жил хорих
263.2.Хүндрүүлэх бүрэлдэхүүн: Эд хөрөнгө хурааж, 5-10 жил хүртэл хугацаагаар хорих	5-12 жил хүртэл хугацаагаар хорих

БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлэг. 382-396 дугаар зүйл Авлигын гэмт хэрэг	
5000 юаны авлига авсан бол	2 жил хүртэл хугацаагаар хорих, 6 сар хүртэл хугацаагаар баривчлах, төрийн албанд ажиллах эрхийг хасах
5000-50.000 юаны авлига авсан бол	1-7 жил хорих, ноцтой бол 7-10 жилийн хугацаагаар хорих
50.000-100.000 юаны авлига авсан бол	5-10 жил хорих, ноцтой бол бүх насаар хорьж, эд хөрөнгийг хураах
100.000 юанаас дээш авлига авсан бол	10 жилээс дээш хугацаагаар хорьж, эд хөрөнгө хураах, ноцтой бол цаазаар авах

Мөн хуулийн төсөлд эдийн засгийн гэмт хэрэг гэсэн шинэ бүлгийг орчин үеийн нийгмийн харилцааны онцлог, олон улсын хандлагыг харгалзан оруулж, тухайн бүлэгт:



- Зах зээл дэх монополийг, давамгайл байдлаа хууль бусаар ашиглах
- Валют, үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшид нөлөөлөх
- Хууль бусаар дампууруулах
- Аж ахуйн үйл ажиллагааны нууцад халдах,
- Нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөс зайлсхийх,
- Хууль бусаар нийгмийн халамж, үйлчилгээ, даатгалын нөхөн төлбөр авах зэрэг шинэ гэмт хэргийг тусгасан.^[52]

Мөн Монгол Улсын эрүүгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, улмаар:

- * Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх
- * Хүүхдийг шийтгэх

Хоёр. Ялын төрлийн талаар:

* Монгол Улс Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколд нэгдэн орсонтой^[53] холбогдуулан цаазаар авах ялын төрлийг хасч, энэ онцгой ялын оронд бүх насаар хорих ялын төрлийг хуулийн төсөлд тусгасан.

Гэвч иргэд, судлаачдын дунд цаазаар авах ялыг бүх насаар хорих ял орлож чадах эсэх талаар маргаан байна. Бид цаазаар авах ялыг бүх насаар хорих ял орлох боломжгүй, эсхүл боломжгүй эсэх талаар хэлж мэдэхгүй байна. Учир манай улсад энэ төрлийн ялаас татгалзаад бүх насаар хорих ялыг хэрэглэж ирсэн туршлага байхгүй. Иймд цаазаар авах ялыг халж, бүх насаар хорих ялаар орлуулж ирсэн практиктай улсуудын эрдэмтэн, судлаачдын бичиж тэмдэглэсэн зүйлтэй танилцахад бүх насаар хорих ял цаазаар авах ялыг орлох боломжтой, илүү үр нөлөөтэй гэж үзсэн байна.^[54] Учир нь монголчууд, хүн төрөлхтөний үхэлд хандах хандлага ижил байдаг.

Хүн төрөлхтөн үхэл бол мөнхийн амгаланд хүрэх, зовлон бэрхшээлээс ангижрах арга үздэг. Харин бүх насаараа торны цаана сууж, бусдын эрхшээлд байхыг хэн ч хүсдэггүй бөгөөд энэ нь түүний зовлон гачаалын төгсгөл биш, харин эхлэл болох учраас^[55] бүх насаар хорих ял цаазаар авах ялаас илүүтэй бусдад нөлөөлж, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлж чаддаг.

Монгол Улс цаазаар авах ялыг практикт халсан улс байсан бол Эрүүгийн хуульдаа халсан дэлхийн 103 дахь улс болсон. Ингэснээр манай улс олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүллэ.

* Ялын үр нөлөө бага, хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй баривчлах ялыг мөн ялын төрлөөс хасч, хуулийн төсөлд тусгасан. Учир нь Монгол Улсын Эрүүгийн хуульд баривчлах ялыг гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлан тодорхой дэглэм бүхий байранд **ганцаарчилан** эдлүүлэхээр заасан^[56] боловч санхүүгийн боломжгүй байдлаас шалтгаалан баривчлах ял шийтгэгдсэн 4-10 ялтан хамт байрлаж, хуульд заасан нөхцөл, журмын дагуу хэрэгжихгүй байна.

• Олон улсын туршлага, зөвлөмж, хөгжингүй зарим улсын эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг судалж үзсэн үндсэн дээр хуулийн төсөлд **зорчих эрхийг хязгаарлах** ялын шинэ төрлийг нэмсэн. Монгол Улсын хэмжээнд 2002-2012 онд нийт 40.119 хүн хорих ял эдэлж суллагдснаас 19.000 хүн буюу 47% нь дахин гэмт хэрэг үйлджээ.^[57]

Эндээс үзэхэд, хорих ялын үр нөлөө хангалтгүй, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэх, хүмүүжүүлэх, иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах эрүүгийн хариуцлагын зорилго хангагдахгүй байгаа нь харагдаж байна. Иймд хорих ял оногдуулах явдлыг багасгаж, зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулснаар гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлалгүйгээр нийгэмд нь хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх боломж бүрдэнэ гэж төсөөлж байна.

2015 онд ХБНГУ-д зохион байгуулагдсан “Дэлхийн ял шийтгэлийн бодлого, чиг хандлага” сэдэвт эрдэмтдийн уулзалт-хэлэлцүүлэгт дэлхийн хэмжээний эрдэмтэн Ханнс Ёорг Албрехт Их сургууль бол гэмт хэрэгтнүүдийг бэлтгэдэг их сургууль юм. Дэлхий нийт аль болох шоронд хорихоос татгалзах хандлагатай байгаа талаар хэлсэн.

ХБНГУ нийт гэмт хэргийн зөвхөн 5%-д хорих ял оногдуулж, биечлэн эдлүүлдэг.

* Зорчих эрх хязгаарлах ял нь олон улсын жишгийн адил гэмт хэрэг үйлдсэн хүнийг оршин суух газраас явах болон тодорхой газар очихыг хориглох, шүүхээс тогтоосон замаар зорчих, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр оршин суугаа газраа өөрчлөх, зорчих үүргийг тодорхой хугацаагаар даалгах хэлбэрээр хэрэгжих юм.

Гурав. Албадлагын арга хэмжээний талаар:

⁵⁶ //Төрийн мэдээлэл. 2002. №5
⁵⁷ “Давтан гэмт хэргийн шалтгаан, нөхцөл” судалгааны тайлан. ЦЕГ, ХЗҮХ. УБ., 2012. 62 дахь тал

⁵² Хууль зүйн яам. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл. УБ., 2015

⁵³ 2012 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар соёрхон баталсан.

⁵⁴ Дэлхийн 144 улс цаазаар авах ялыг хуулиараа эсхүл практикт халсан байна. “Death Penalty,” 2014.09.20-нд үзсэн, <http://www.amnestyusa.org/our-work/issues/death-penalty>.

⁵⁵ Чезаре Беккариа. Гэмт хэрэг ба ялын тухай (орч Г.Эрдэнэбат). УБ., 2009. 87 дахь тал



* Хуулийн төсөлд тэнсэхийг албадлагын арга хэмжээний төрөлд оруулж, хуульд заасан үндэслэлийг хангасан тохиолдолд тухайн зүйл, хэсэгт заасан **ялыг оногдуулахгүйгээр** 5 жил хүртэл хугацаагаар тэнсэхээр заажээ. Өөрчлөлт нь гэмт хэрэг үйлдсэн, хуульд заасан үндэслэл хангасан этгээдэд хорих ял оногдуулж, улмаар тодорхой хугацаагаар тэнсэн харгалздаг байсан бол хуулийн төсөлд ял оногдуулахгүйгээр тэнсэхээр тусгасан нь **олон улсын жишигтэй нийцж байна**. * Хөнгөн гэмт хэрэг үйлдсэн хүн гэм буруугаа хүлээн зөвшөөрч, гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлж, хор уршгийг арилгасан, гэмт хэргийн улмаас учруулсан **хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн** болон бусад нөхцөл байдлыг харгалзан тэнсэж болохоор заасан. Шүүхээс гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо төлөхөө илэрхийлж тэнсэгдсэн хүн хохирлоо нөхөн төлөх хугацааг шүүх тогтоохоор хуулийн төсөлд заасан.

Мөн шүүх тэнсэгдсэн хүнд хүлээлгэх үүрэг, хязгаарлалтыг нэг бүрчлэн хуулийн төсөлд тусгасан. Энэ нь тэнсэгдсэн хүнийг хариуцлагажуулах, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, улмаар эрүүгийн хариуцлагын зорилго хангагдах боломж бүрдүүлнэ.

Харин гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх болон хүүхдийн эсрэг зарим гэмт хэрэгт тэнсэх арга хэмжээ хэрэглэхгүй байхаар заасан нь хууль шүүхийн өмнө эрх тэгш байх Монгол Улсын Үндсэн хуулийн зарчмыг гажуудуулсан гэж **“Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь” судалгааны үндсэн тайланд дурдсантай санал нэг байна.**

Дөрөв. Ял оногдуулах талаар:

* Хүүхэд гэнэн томоогүй зан, өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн агуулга, мөн чанарыг ойлгохгүй, бусдын нөлөөнд амархан автдаг зэргээс шалтгаалан гэмт хэрэг үйлдэх явдал цөөнгүй байдаг. Иймд анх удаа хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн хүүхдийг нийгмээс тусгаарлахгүй, архаг ялтнуудын хортой нөлөөнд автуулахгүй байлгах зорилгоор хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг авч хэрэгжүүлж ирсэн.

Хуулийн төсөлд өсвөр насны хүнд оногдуулах ялын төрөл, ял оногдуулах журам, түүнд хэрэглэх албадлагын арга хэмжээг тусгай бүлгээр зохицуулж өгсөн. Ингэснээр өсвөр насны хүний бие, сэтгэл зүйн онцлогийг харгалзан насанд хүрэгчдээс ялгамжтай ял оногдуулах, аль болох хорих ял оногдуулахаас зайлсхийж, хүмүүжлийн

чанартай албадлагын арга хэмжээг үр дүнтэй хэрэглэж, нийгэм, хамт олны дунд хүмүүжүүлэх боломж бүрдэнэ.

Хуулийн төсөлд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ял оногдуулахаар, шүүх хөнгөн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан ял оногдуулахыг тэнсэж, нэгээс гурван жил хүртэл хугацаагаар хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авах^[58], өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулж болохоор тус тус тусгасан.

Гадаадын зарим улсад өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл, хүлээлгэх тусгай журмыг зохицуулсан бүлгийг Эрүүгийн хуульдаа тусгасан байна. Тухайлбал,

* *ОХУ-ын Эрүүгийн хуулийн 14 дугаар бүлэг “Насанд хүрээгүй хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх онцлог”. Энэ бүлэгт насанд хүрээгүй хүнд оногдуулах ялын төрөл, ял оногдуулах, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ хэрэглэх, ялаас чөлөөлөх үндэслэл журам, насанд хүрээгүй хүний үйлдсэн гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолох талаар 87-94 дүгээр зүйлд тус тус заасан.*

“Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь” судалгааны үндсэн тайланд “Өсвөр насны хүнд оногдуулах ял, албадлагын арга хэмжээ хэрэгжүүлэх институт, салбар хоорондын хамтын ажиллагаа шаардагдана” гэсэнтэй санал нэг байна.

Учир нь өсвөр насны хүнд оногдуулах ял, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд прокурор, хууль сахиулах байгууллага, хүүхдийн хууль зүйн хороо хамтран оролцохоор заасан.

* Хуулийн төслийн 9 дүгээр бүлэгт **“Хуулийн этгээдэд ял оногдуулах тусгай журам”-ыг** тусгасан. Монгол дахь уул уурхай, барилгын салбарын хөрөнгө оруулалт нэмэгдсэн жилүүдэд экологийн гэмт хэргийн гаралт өсч, хүрээлэн буй орчинд их хэмжээний хохирол учруулах болсон. Энэ төрлийн гэмт хэрэгт цөөн тооны албан тушаалтан эрүүгийн хариуцлага хүлээж, хуулийн этгээд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулж, байгаль орчныг сүйтгэсээр байдаг. Хуулийн төсөлд хүрээлэн

⁵⁸ Хууль зүйн яам. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл. УБ., 2016



буй орчны болон олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг зарим гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд **торгох** (торгох ялын хэмжээ иргэнд оногдуулах торгох ялын хэмжээнээс харьцангуй өндөр) ял оногдуулах, шүүх шаардлагатай гэж үзвэл **эрх хасах, татан буулгах, хөрөнгө, орлогыг хураах** албадлагын арга хэмжээ хэрэглэж болохоор заасан нь энэхүү практикт тулгамдсан дээрх асуудлыг шийдвэрлэх боломж олгоно.

2016 оны Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд **хуулийн этгээд гэдэгт** хэнийг хамааруулж ойлгох, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн нь хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргасан, зөвшөөрөл өгсөн **эрх бүхий албан тушаалтныг ялаас чөлөөлөх үндэслэл болохгүй** талаар тодорхой зааж өгсөн.

Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг туршлага дэлхийн хэд хэдэн улсад байдаг. Тухайлбал, БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 4 дүгээр хэсгийн 31, 32 дугаар зүйлд: “Энэ хуульд заасан гэмт хэрэгт компани, аж ахуйн нэгж, байгууллага, хоршоо ял оногдуулна. Хуулийн этгээдийг торгох ял, хууль болон гэрээгээр тусгайлан үүрэг хүлээсэн, хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтанд ял оногдуулна.

* Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйлд гэмт хэргийг тодорхой шалгуураар 4 ангилж, шүүхээс оногдуулах ялын төрөл, хэмжээг гэмт хэргийн ангилалд нийцүүлэн “хайрцаглаж” өгсөн байдлыг өөрчилсөн. Өөрөөр хэлбэл, шүүх ял оногдуулахдаа гэмт хэргийн ангилалыг харгалзалгүй гэмт хэрэг үйлдсэн хүний гэм буруу, учруулсан хохирлын шинж болон бусад байдлыг харгалзан үзэхээр хуулийн төсөлд тусгав.

Гэмт хэргийг хөнгөн, хүнд гэж 2 ангилсан. Гэхдээ энэ ангилал Эрүүгийн хуулийн тусгай ангийн ялын санкцийг “хайрцаглах” үндэслэл болохгүй.

2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад ялын дээд, доод хэмжээг харьцангуй сунгаж хуульчилсан. Тухайлбал, хулгайлах гэмт хэрэгт 7 хоногоос 5 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан учир шүүхээс ял оногдуулахад хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлыг хэрхэн үнэлэх талаар аргачилсан зөвлөмж (sentencing guideline) шаардлагатай гэж “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь” судалгааны үндсэн тайланд дурдсантай

санал нэг байна.

• Хуулийн төслийн 6.7-д **“Гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд оногдуулах хорих ялыг хөнгөрүүлэх, хорих ялаас чөлөөлөх, албадлагын арга хэмжээ хэрэглэх” тусгай журмыг** тусгажээ.

- Гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон
- Гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүний
- Гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, хувийн байдал, хохирлоо төлж, хор уршгийн арилгасан байдал, эсхүл учруулсан хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн бол
- Хорих ялын дээд хэмжээг:
- 3 жил хүртэл
- 5 жил, түүнээс бага
- 2-8 жил
- Дээд хэмжээг 12, 15 жил
- 20 жил
- Бүх насаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэн –хугацаатай хорих ял оногдуулах эсэхийг шүүх шийдвэрлэхээр ялын 6 интервалыг харгалзан ялаас чөлөөлөх, тэнсэх, ял хөнгөлөх зохицуулалт бүрдсэн.
- Энэ нь Монгол Улсын эрүүгийн эрх зүйн түүхэнд анхны зохицуулалт бөгөөд хүнд гэмт хэрэг үйлдсэн боловч гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, хохирлоо нөхөн төлсөн, нөхөн төлөхийг илэрхийлсэн зэргийг харгалзан шүүх тухайн зүйл, хэсэгт заасан ялын хэмжээг тодорхой хувиар багасгаж ял оногдуулахаар заасан. **Ингэснээр шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын ажлын ачаалал буурах, гэмт хэргийн илрүүлэлт, хохирол нөхөн төлөлт нэмэгдэх зэрэг ач холбогдолтой гэж үзэж байна.**

• Эрүүгийн эрх зүйн онолоор санкцыг туйлын тодорхой, харьцангуй тодорхой, сонгох, заах, тодорхой бус гэсэн төрөлд хуваан судалдаг. Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан зарим гэмт хэргийн санкц харьцангуй тодорхой байгаагаас шүүхээс ял оногдуулахад бэрхшээлтэй байгаа болох нь төрийн болон төрийн бус байгууллагын хийсэн судалгааны үр дүнгээс харагддаг^[59]. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 91-97, 108, 112, 126, 145.4, 146.4, 147.1, 2, 3, 150.3, 181.3 дугаар зүйлүүдэд сонгох ялгүйгээр хорих ял оногдуулахаар заасан учраас шүүх зөвхөн хорих ял хэрэглэхэд хүргэж байна. Иймд шүүхээс энэ хуулийн тусгай ангид хорихоос

⁵⁹ Гэмт хэргийн ангилал ба ялын тохироо. судалгааны тайлан. ХЗҮХ. УБ., 2005. 25 дахь тал



өөр төрлийн ялыг сонгон оногдуулах өргөн боломжтой, хорих ялын дээд болон доод хэмжээг сунгаж, харьцангуй уян хатан байдлаар хуулийн төсөлд тусгасан. **Ингэснээр гэмт хэргийн ангилал, шүүхээс оногдуулах ял хоорондоо уялдаагүй, хатуу хязгаарын хүрээнд гэм буруугийн шинжид тохирохгүй ял оногдуулдаг гэсэн шүүмжлэл багасч, шударгаар хэргийг шийдвэрлэхэд дөхөм болно гэж үзэж байна.**

• Онц аюултай гэмт хэрэгтэн, ялтай байдал, урьд ял шийтгүүлсэн болон гэмт хэрэг давтан үйлдэх талаар заасан, хууль зүйн үр дагавар үүсгэдэг ойлголтыг өөрчилж тусгай ангийн хүндрүүлэх бүрэлдэхүүн болгон авч үзэхгүй байхаар хуулийн төсөлд тусгасан. Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Эрүүгийн хуулийн нийт 49 зүйлд гэмт хэргийг давтан үйлдсэн, 13 зүйлд урьд ял шийтгүүлсэн бол хүндрүүлж үзэхээр заажээ. **Энэ нь нэг хэрэгт нэг удаа ял шийтгэх буюу олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн "Non double jeopardy" зарчмыг гажуудуулахад хүргэж, аливаа гэмт хэрэгт ял шийтгүүлж, эдэлсний дараа түүний үр дагаврыг хүндрүүлэн хэрэглэж байгааг зохимжгүй гэж үзээд дээрх нөхцөл байдлыг хуулийн ерөнхий ангид "ял хүндрүүлэх нөхцөл байдал" гэсэн хэсэгт тусгасан.**

ХБНГУ, БНСУ зэрэг улсуудад онц аюултай гэмт хэрэгтэн, урьд ял шийтгүүлсэн хүн, давтан гэмт хэрэг, ялтай байдал ойлголт байхгүй.

Дүгнэлт

2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдан мөрдөгдөж эхлэхтэй холбоотойгоор шинээр хэд хэдэн ялын төрөл нэмэгдэж, ялын үр нөлөө бага, хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй хэд хэдэн ялын төрөл хасагдаж, зарим ялын санкцын хэмжээг багасгаж, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд хуульд зааснаас хөнгөрүүлж хорих ял оногдуулах, чөлөөлөх, өсвөр насны хүн, хуулийн этгээдэд ял оногдуулах тусгай журам, ял оногдуулахдаа гэмт хэргийг ангилалыг харгалзалгүй гэмт хэрэг үйлдсэн хүний гэм буруу, учруулсан хохирлын шинжийг харгалзан үзэж ялгамжтай оногдуулах, шүүхээс энэ хуулийн тусгай ангид хорихоос өөр төрлийн ялыг сонгон оногдуулах өргөн боломжтой, хорих ялын дээд болон доод хэмжээг сунгаж, харьцангуй уян хатан байдлаар хуулийн төсөлд тусгасан зэрэг олон улсын чиг

хандлагад нийцсэн, дэвшилттэй зохицуулалт бүрдүүлж чадах юм.

Монгол Улсын ялын тогтолцоо, ялын бодлогод орж буй өөрчлөлтийг нийтэд нь харвал ялын бодлого зөөлөрч, хүний суурь эрхийг баталгаажуулах, хохирогчийн эрхийг сэргээн тогтоох, шударга ёсны тогтолцоо бүрдүүлэх эрх зүйн үндсийг улам бэхжүүлж, дэлхий дахинтай хөл нийлүүлэн алхах нөхцөл бүрдэхээр байна.

Цаашид төрийн эрүүгийн бодлогыг шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлж, тогтвортой хэрэгжүүлэн шинээр болон шинэчлэн баталсан хуулиудын үзэл баримтлалаас ухрахгүй, эрүүгийн эрх зүйн хөгжлийн хувьд дэвшил болж чадсан ялын шинэлэг бодлого, хорихоос өөр төрлийн шинэ ял, албадлагын арга хэмжээний төрлүүд, хохирол нөхөн төлүүлэх тогтолцоо, ял оногдуулах, тэнсэх шинэлэг зохицуулалтуудыг хэвээр хадгалж, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчид хандлагыг өөрчилж, эрүүгийн эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

ХҮҮХДИЙГ ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭХЭД ТАТАН ОРУУЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИД ХУУЛЬЧИЛСАН БАЙДАЛ



Э.Золбоо

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Мөрдөх
албаны тэнхимийн багш,
цагдаагийн дэслэгч

Судлаач Ц.Ариунцэцэг “Хүүхэд гэж нас бие сэтгэцийн хувьд эрчимтэй хөгжлийн замыг туулж яваа, нийгмийн харилцаанд бие даан оролцох чадвар хараахан төлөвшөөгүй, эцэг эх асран хамгаалагчдын хараа хяналтад байдаг, өөрийн гайхамшигт ертөнцөөр хүрээлэн буй орчин болон бусдыг танин мэдэж буй 18 хүртэлх насны хүн бүрийг хэлнэ”^[60] гэж тодорхойлсон. Тиймээс нийгмийн харилцаанд бие даан оролцох чадвар төлөвшиж буй хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулсан тохиолдолд тухайн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг. Манай улсад хүүхдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж ирсэн түүхэн уламжлалыг сөхөж үзэхэд, Юань гүрний нэвтэрхий хуульд гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүнд оногдуулах ял насанд хүрсэн этгээд /тэр үед 15 нас хүрсэн/-ээс ялгамжтай хандсан анхны зохицуулалтыг тусгасан нь өмнөх цаазуудтай харьцуулахад дэвшилттэй тал болсон.

Монголын эртний хууль цаазууд болон тэдгээрийн үйлчилж байсан орон зай, цаг хугацааны зэрэг асуудлыг харгалзан дараах хуулийн заалтуудыг хооронд нь харьцуулах, системчлэх байдлаар авч үзлээ.

Их засаг хууль: Төв Азид байгуулагдсан Монгол туургатны тулгар улсад хүчтэй төвлөрсөн төрөөс гадна нэгдмэл хууль цааз зайлшгүй шаардлагатай байсан ба төрийн онолын үүднээс аливаа улс төрийн бодлого, үйл ажиллагаа, хууль цааз тогтоон түүнийгээ хүндэтгэн биелүүлэх замаар хэрэгжүүлдэг жамтай. Ийнхүү дурдсан нь Монгол Улсын эрүүгийн эрх зүйн түүхэн хөгжлийн хамгийн эртний дурсгалт бичиг юм. Өмч хөрөнгө, өв залгамжлах тухай цаазад өрхийн дотор **өв залгамжлах** эрхтэй холбогдуулан эл

⁶⁰ Ц.Ариунсүрэн. “Хүүхэд гэж хэн бэ?”. УБ., 2008. 26дах тал

хуульд, алив хүний олон гэргий болохул анхны авааль нь авмой. Татвар эмээс гарсан хүүхдүүд хууль ёсоор гарсан хүүхдийн адил эрхтэй. Эцэг нь мэдэж өв хөрөнгө таслан өгч болно. Ахмад хөвгүүн нь дүү нараас илүү авмой. Отгон хөвүүн нь эцгийн гэрийн өрхийг өвлөн хатамжилмой”, “татвар эмээс гарсан хүүхдүүд хууль ёсоор гарсан хүүхдийн адил эрхтэй”^[61] гэсэн хүүхдийн эрхийг хамгаалсан заалт гэж үзэж болохоор байна

Эрт дээр үеэс эхлэн Монголын ард түмэн хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх ариун бөгөөд нэр хүндтэй эрхэм үүргээ ёсчлон биелүүлсээр ирсний нэгээхэн илрэл нь уг заалт мөн гэж үзэж болохоор байна.

Юань гүрний нэвтэрхий хуульд: Монгол хүн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хөнгөрүүлж үзэхээр заасан байна. Жишээ нь: “Монгол хүний үр хүүхдийг уйгар, хятад хүн худалдан шивэгчин болгохыг хориглох” гэх зэрэг заалт байсан байна.

Энэхүү хуульд гэмт хэргийн заалтын их муу гэж нэрлэж байсан бөгөөд урван самуурах самуун дэгдээх, газар худалдах, ах дүүс, бэр хадам зэргийг алах, эцэг эх, үр хүүхэд, өвгөдийн хүүрийг ухах, буруу зурьцал үйлдэх, хулгай худал, зарга зальхай, нанчилдан гөвшилдөх, алах, шархдуулах, эд хөрөнгө идэх явдал хэмээн онцгойлон зааж байсан боловч уг гэмт хэрэгт хамаарах заалт мэдэгдэхгүй байна.

Алтан хааны цааз бичиг нь XVI зууны үеийн Монголын нийгмийн харилцааны гол талуудыг хуульчлан зохицуулсан хуучин хууль цаазын нэн ховор дурсгалт бичиг юм. Уг цааз бичгийн эр, эм гэр бүлийн цаазад эмэгтэйчүүд, хүүхдийг хамгаалах, эмс охидыг эрд гаргахад тэдний санаа бодлыг хүндэтгэх, садар самууныг үл тэвчих, гэр бүлийн доторхи хүчирхийллийг таслан зогсоох зэрэг харилцааг зохицуулж байсан байна. Мөн хулгайн цаазад “Арван наснаас доош бол хулгайчид үл тооц, арван наснаас дээш бол хулгайчид тооц” гэж зааснаас гадна төрүүлсэн эцэг эх, тэжээсэн эцэг эх гэж субъектыг нарийвчлан заасан заалт ч байгаа юм. Хүнд туслах талын зүйлд “.. толгой нь эргэж төөрсөн хүүхдийг хэн тусалж авчирваас нэг сайн морь ав, охин бол нэг сайн гүү ав. ..” хэмээн хүүхдийг хамгаалж ирсэн уламжлал харагдаж байна. Алтан хааны хууль цаазын бичигт заалт нь хүүхдийн эрх ашгийг хамгаалж байсан заалт бий гэж үзэх боловч насанд хүрээгүй хүнийг **гэмт хэрэгт татагдан орохоос урьдчилан**

⁶¹ Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан. “Монгол улсын тэр эрх зүйн түүхэн уламжлал”. УБ.,1997.75 дахь тал



сэргийлж байсан тодорхой хэм хэмжээ алга байна.

Монгол Ойрадын Их цааз нь Монголчуудын цааз эрх зүйн хөгжлийн бүхэл бүтэн нэгэн үеийг төлөөлөн харуулах чадамжтай, эрх зүйн нэн чухал дурсгалт бичиг юм. Монгол Ойрадын хуульд "...аливаа хүн сургасан багшаа, эцэг эхээс занчвал гурван ес ав, дундаас хоёр ес ав, багаас нэг ес ав"^[62] гэх мэт бүрхэг заалтууд байдаг байжээ. Гэхдээ энэ заалт нь хүүхдийн эрх ашгийг хамгаалж байсан заалт бий гэж үзэх боловч насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэгт татагдан орохоос урьдчилан сэргийлж байсан тодорхой хэм хэмжээ алга байна.

Халх журам хуульд: Зарлигаар тогтоосон Манж Чин улсын бүгд хууль Халх журам Гадаад монголын засаг төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг хэмээх хууль цаазны дурсгалт бичгүүд нь Манжийн ноёрхлын үеийн Монголын төр, захиргаа эрх зүйг судлахад гол үндсэн эх сурвалж болох юм. Уг хуульд насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэгт үйлдэхэд татагдан орохоос урьдчилан сэргийлж байсан хэм хэмжээг тусгасан заалт үгүй байна.

Богд хаант Монгол улсын үед батлагдсан 1918 оны зарлигаар тогтоосон монгол хууль зүйн бичиг Богд хаант Монгол улсын үед боловсруулагдсан феодалын төр хууль цаазны гол эх сурвалж болох зарлигаар тогтоосон Манж улсын хууль зүйлийн бичиг хамгийн сүүлд үйлчилж, тухайн үедээ үүргээ гүйцэтгэсэн байна.

Чингисийн Их засаг хуулиас Зарлигаар тогтоосон хууль зүйлийн бичиг хүртэл Монголын хууль цаазын дурсгалт бичгүүдэд насанд хүрээгүй хүнийг согтуурал, мансуурал, тэнүүчлэл, гуйланчлалд татан оруулах гэмт хэрэгтэй тэмцэх зорилготой хэм хэмжээ байгаагүй ч эрүүгийн хууль тогтоомжийг улам боловсронгуй болгож, уламжлагдаж ирсэн гэж үзэж байна.

Тухайлбал, 1921 оноос өмнөх хууль цаазын бичгүүдэд энэ талаар бараг тусгагдаагүй байгаа нь учир дутагдалтай боловч өнөөгийн эрүүгийн хууль тогтоомжийн үндэс суурь эндээс тавигдсан билээ.

Монгол Улсын эрүүгийн эрх зүйн хөгжилтөд 1921 оны Ардын хувьсгал шинэ үеийг нээж, хуучин төрийн аппаратыг устгаж, түүний хууль цааз ёс суртахуунд халдахгүйгээр ардчилсан өөрчлөлтийг гүнзгийрүүлж болохгүй байв. Монгол Улсын анхны Эрүүгийн хууль нь "БНМАУ-ын шүүх цаазны бичиг" нэртэйгээр ерөнхий ангийг

⁶² Т.Алтангэрэл. "XVI-XVII зууны Монгол цаазын бичгүүд". УБ., 1999. 27 дахь тал

нь Засгийн газрын 1926 оны 1-р сарын 16-ний өдрийн нэгдүгээр хурлаар, тусгай ангийг нь 1926 оны 11-р сарын 11-ний өдрийн Улсын 3 дугаар Их Хурлаар тус тус батлан гаргажээ.

1926 оны Шүүх цаазны бичигт анх удаа "Ард олны хэв сурталыг зөрчих нь" хэмээх 17-р бүлгийн 129-р зүйлд "Насанд хүрээгүй хүүхдийг гуйланч /гуйлгачин/ болгогсдыг 6 сар хүртэл гянданд хорино"^[63] гэсэн нь гэмт хэрэгт татан оруулсан хэлбэр биш насанд хүрээгүй хүнийг

хамгаалсан, тэдний эрх ашгийн үүднээс бусдыг /насанд хүрэгсдийг/ шийтгэх тухай анхлан заасан цааз болсон юм.

1929 оны Шүүх цаазын бичгийн 94-р зүйлд "Насанд хүрээгүй багачуудыг асран хамгаалах, хүмүүжүүлэх үүрэг бүхий эцэг, эх, ураг төрлийн зэрэг хүмүүс тэрхүү багачуудыг архи уух, хар тамхи татах зэрэг хор бүхий зүйлүүдийг удирдан хэрэглүүлж дадал болговоос анх удаа шүүх таслах газраас шүүмжлэн өчиж, учрыг ятгаж ухуулмой. Хоёрдугаар удаа 25 төгрөг хүртэл торгомой. Гуравдугаар удаа тийнхүү ухуулан тушаасан зэргийг үл хайхран цаг ямагт тэрхүү хор бүхий зүйлүүдийг хэрэгжүүлсээр байсан эцэг эх болон хүмүүсийн эдэлвээс зохих эрхийг хасаж бусад итгэмж бүхий этгээд буюу Ардын гэгээрүүлэх яамны харьяат газрууд дор шилжүүлэн өгөхөөс зохимой"^[64] гэсэн нь насанд хүрээгүй хүн архи уух, хар тамхи татах зэрэг элдэв муу хэрэгт татагдан орохоос сэргийлсэн, архи уух, хар тамхи татах зэргээр мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдэж болзошгүй гэж урьдчилан сэргийлсэн, насанд хүрээгүй хүүхдийг архи уух, хар тамхи татах зэрэг муу хэрэгт татан оруулсан этгээдийг Шүүх таслах газраас донгодох, торгох зэрэг эрүүгийн ял хэрэглэж түүнчлэн эцэг, эх байх эрхийг хасч байгаа нь хүүхдийн эрх ашгийг бүрэн хамгаалсан дэвшилтэй цааз болсон.

1934 оны Шүүх цаазын бичгийн тусгай ангийн 6 дугаар бүлэг "Хүний амь бие ба эрүүл мэнд, эрх чөлөө, нэр алдарт харшлах гэмт хэргүүд" хэмээх бүлгийн 131 дүгээр зүйлд "Алив хүн бие бэлэг боловсроогүй эмэгтэйчүүд, насанд хүрээгүй эрэгтэйчүүдтэй явалдсаны хугацаагаар ял шийтгэвэл зохино"^[65]. Энэ шүүх цаазын бичгийн дээрх

⁶³ Д.Адъяабазар. "Монгол Улсын 1921 оноос хойшхи эрүүгийн хууль тогтоомжийн хөгжил". /1 дэвтэр/ УБ., 1998. 23 дахь тал

⁶⁴ Д.Адъяабазар. "Монгол Улсын 1921 оноос хойшхи эрүүгийн хууль тогтоомжийн хөгжил". /1 дэвтэр/ УБ., 1998. 52 дахь тал

⁶⁵ Д.Адъяабазар. "Монгол Улсын 1921 оноос хойшхи хууль тогтоомжийн хөгжилт". УБ., 1998



заалт нь өмнөх шүүх цаазын бичгүүдийн заалтуудыг бодвол хамрах хүрээ нь хумигдсан буюу зөвхөн садар самуунд уруу татсан заалт хэвээр байгаа нь харагдаж байна.

Харин 1942 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 96-р зүйлд энэ зохицуулалтыг улам боловсронгуй болгож, "Насанд хүрээгүй хүмүүсийн аливаа нэгэн гэмт хэргийг үйлдэх явдалд хатгах буюу татан оролцуулах, мөн түүнчлэн насанд хүрээгүй хүнийг анхны ажлыг хийх буюу мөлжигтгий худалдаа хийх зэрэг явдалд шахах бол 2 жилээс доошгүй хугацаагаар хорих ялд шийтгэвээс зохино" гэж зааснаар насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэгт татан оролцуулах гэмт хэргийн үндсэн шинжүүдийг тодорхойлсон байна.

1961 оны Эрүүгийн хуулинд Насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэгт татан оруулсан бол хэргийг хүндрүүлэх нөхцөлтэй байхаар хуульчилсан байна. Уг хуулийн Иргэдийн амины өмчийн эсрэг гэмт хэргүүд буюу тавдугаар бүлгийн хулгай хийх хэмээх 109-р зүйлд:^[66]

а. Иргэдийн амины хөрөнгийг хулгайлах буюу хүч заналхийлэл хэрэглэхгүйгээр булаан авбал 5 жил хүртэлх хугацаагаар хорих буюу 10 жил 6 сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлнэ.

б. Хулгайн хэрэгт удаа дараа шийтгэгдсэн буюу эсхүл улс олон нийтийн хөрөнгийг ашиглах, шамшигдуулсан, дээрэмдсэн гэмт хэрэгт урьд шийтгэгдсэн этгээд дараа нь иргэдийн хөрөнгийг хулгайлахдаа хохирогч этгээдэд их хэмжээний хохирол учруулсан буюу нийтэд аюултай арга хэрэглэсэн эсхүл анх удаа боловч насанд хүрээгүй хүмүүсийг зохион байгуулж, хулгай хийлгэсэн байвал 2-5 жил хүртэл нутаг зааж суулгах буюу суулгахгүйгээр 7-15 жил хүртэл хугацаагаар хорьж, бүх хөрөнгийг хураах буюу цаазаар авч бүх хөрөнгийг хураана" гэсэн байна. Мөн уг хуульд анх удаа 171-р зүйлд "Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэрэгт татан оролцуулах нь" хэмээн бие даасан зүйл болгож түүндээ "18 насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэгт татан оруулбал уг нутгаас зайлуулах буюу зайлуулахгүйгээр 5 жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ" хэмээн тусгажээ.

Эрүүгийн хуульд тусгагдсан дээрх заалт нь Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилд анх удаа насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах гэмт хэргийг бүрэлдэхүүний хувьд бие даасан гэмт хэрэг болгон хуульчилсан явдал бөгөөд

⁶⁶ БНМАУ-ын 1961оны Эрүүгийн хууль. 109-р зүйл

цаашид боловсронгуй болгох эх үндэс тавигдахад чухал алхам болсон байна.

1986 оны шинэчлэн найруулсан БНМАУ-ын Эрүүгийн хууль, 1987 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн арван нэгдүгээр бүлэг "Нийгмийн аюулгүй байдал, нийгмийн хэв журам, хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг" хэмээх бүлгийн "Насанд хүрээгүй этгээдийг гэмт үйл ажиллагаанд татан оруулах" хэмээх 241 дүгээр зүйлд "...Насанд хүрээгүй этгээдийг гэмт үйл ажиллагаа болон ууж согтуурах, мөрийтэй тоглоход татан оруулсан, түүнчлэн бусдын хүчийг сорон мөлжин амьдрах зорилгодоо тэднийг ашигласан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ" гэж заасан.

Мөн 1985 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан "Насанд хүрээгүй хүмүүсийн талаар шүүн таслах ажиллагаа явуулах наад захын жишиг дүрэм"-ийн 2.2-т зааснаар "Насанд хүрээгүй хүн гэж үйлдсэн хэрэгт нь тухайн улсын эрх зүйн тогтолцоо насанд хүрсэн хүнээс ялгаатай хэлбэрээр хариуцлага хүлээлгэхээр заасан хүүхэд буюу залуу хүнийг хэлнэ..." насанд хүрээгүй хүн гэдэг ойлголтыг 7-18 буюу түүнээс доош насны хүмүүсийг хамаарч байгаа юм" гэж тайлбарлаж байсан байна^[67].

2002 оны Эрүүгийн хуульд "Насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах гэмт хэрэг"-ийг дараах байдлаар хуульчилжээ. Үүнд:

114 үгээр зүйл. Насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах

1. Насанд хүрээгүй хүнийг хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, хууран мэхлэх болон бусад аргаар гэмт хэрэг үйлдэхэд татан оролцуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

2. Энэ хэргийг насанд хүрээгүй хүнийг хүмүүжүүлэх үүргийг хуулиар хүлээсэн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч үйлдсэн бол хоёр зуун тавин нэгээс таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3. Насанд хүрээгүй хүнийг зохион байгуулалттай бүлэг буюу гэмт бүлэглэлд элсүүлсэн, эсхүл онц хүнд гэмт хэрэг үйлдэхэд татан оруулсан бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.^[68] гэж заасан.

⁶⁷ "Насанд хүрээгүй хүмүүсийн талаарх НҮБ-ын баримт бичгүүд" эмхтгэл. УБ., 2003., 93 дүгээр тал

⁶⁸ Монгол Улсын Эрүүгийн хууль. УБ., 2002 114 дүгээр зүйл



“Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг” гэсэн энэ бүлэгт өмнөх хуульд байсан хүүхэд солих, хууль бусаар үрчлэх, хүүхэд хаях, төөрүүлэх, асран хамгаалах үүргээ урвуулах, сургуулийн өмнөх насны хүүхдийг халамжлах үүрэгт ажилдаа хайнга хандах, хүүхдээ тэжээж тэтгэхээс ноцтой зайлсхийх зэрэг одоогийн хуулийн хүний амь бие, эрүүл мэнд, эрх чөлөө, мөн нийгмийн аюулгүй байдал, нийгмийн хэв журам, хүн амыг эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг гэсэн бүлгээс насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг үйлдэхэд татан оролцуулах, булш сүйтгэх гэсэн 2 хэргийг тус тус энэ бүлэгт хамруулснаас гадна, тэнүүчлэл, гуиланчлалд татан оруулах, хүүхдийг албадан болон хүчээр хөдөлмөрлүүлэхийг шинээр гэмт хэрэгт тооцсон байна.

Аливаа гэмт хэрэг эрүүгийн хариуцлага хүлээлгэхүйц шинжтэй байдаг хувьдаа зайлшгүй хор аюул учруулсан байхыг шаарддаг. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17-р бүлэгт хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт оруулсан насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэгт татан оруулах гэмт хэрэг нь учирч буй хор аюул түүний ирээдүйд бий болох сөрөг үр дагаврын хувьд ноцтойд тооцогдох хэрэг юм.

Энэ хэрэг нь төгссөнөөр насанд хүрээгүй хүн эрүүгийн хариуцлагад татах нөхцөл бүрдэх ба тус гэмт хэргийг үйлдэгч зөвхөн өөрөө төдийгүй түүний идэвхтэй үйлдлээр насанд хүрээгүй хүн гэмт хэргийн субъект болж буйг, тус гэмт хэргийн нийгмийн хор аюул оршино.

Эрүүгийн хуулийн 16-р зүйлийн 1-д гэмт хэргийг тодорхойлохдоо “Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ” гэж заасан ба 114-р зүйлийн хувьд насанд хүрсэн этгээд шууд санаатай идэвхтэй үйлдлээр насанд хүрээгүй хүний эрх, ашиг сонирхол хүмүүжилд сөрөг нөлөө үзүүлж, түүнийг гэмт хэрэгтэн болгож байгаа учир гэмт хэргийн бүрэлдэхүүний бүх шинжийг хангаж байгаа юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 11 дэх хэсэгт “... хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална”^[69] гэж заасан ба энэ нь хүүхэд хэвийн өсөж бойжих, чөлөөтэй хөгжих боломжийн эдийн засаг, нийгмийн баталгааг бүрдүүлэх төдийгүй үүнээс илүүтэйгээр хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөхгүй байх, түүнийг зөрчихтэй тэмцэх хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх хууль зүйн баталгааг бүрдүүлж, хүүхдийн эрх ашигт гэмт халдлага, эрх зүйн бусад зөрчлөөс ангид байлгах үүргийг төр өөртөө үүрэг болгож хариуцсан хэрэг мөн.

Мөн Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 1-р зүйлд “Хэрэв тухайн хүүхдэд үйлчлэх хуулийн дагуу түүнээс эрт насанд хүрсэн гэж үзэхгүй бол, энэхүү конвенцийн зорилгын үүднээс 18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд

гэнэ”^[70] хэмээн томъёолсон бөгөөд энэ нь хүүхдийн эрх ашиг, сонирхол аливаа гэмт халдлагаас ангид байх явдал нь зөвхөн үндэсний эрх зүйгээр төдийгүй олон улсын эрх зүйгээр хамгаалагдаж байдгийн тод илрэл юм.

Насанд хүрээгүй хүнийг зөвхөн Эрүүгийн хууль тогтоомжид төдийгүй бусад хуулиар тухайлбал, Монгол Улсын хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 7-р зүйлийн 4 дэх хэсэгт “... хүүхдийн гэмт хэрэг, эрх зүйн зөрчил, хүчирхийлэл, мөрийтэй тоглоом, садар самуун, архи, тамхи, мансууруулах болон хордуулах бодис хэрэглэхэд татан оруулах, доромжлох, гүтгэх, барьцаанд авах, худалдаа, санаатай солих, хаях, төөрүүлэх, тарчлаан зовоох, хууль бусаар үрчлэх, гадаад авч гарахыг хориглоно” гэж заасан байдаг.

Насанд хүрээгүй хүнийг гэмт хэргийг үйлдэхэд татан оруулж буй гэмт хэргийн шууд объект нь хүүхдийн эрх, хэвийн хөгжилд, хүмүүжих учир хуулиар хамгаалагдвал зохих үнэт зүйл болдог бөгөөд үүнд бодит хохирол учруулсан, эсвэл учрах боломж бий болгож байгаа нь тус гэмт хэргийн нийгмийн аюултай байх шинжийг бүрдүүлдэг.

Манай улсын Эрүүгийн эрх зүйд хүүхдэд хорих ял хэрэглэж байсан уламжлалыг авч үзвэл, 1926, 1929, 1934, 1942, 1961 оны төрөлжсөн Эрүүгийн хуулиудад хорих ялын хугацаа 6 сараас 10 жил харин 1986 оны шинэчлэн найруулсан эрүүгийн хуульд хорих ялын үндсэн хугацааг 6 сараас 15 жилээр тогтоосон байна.

Хорих ял эрүүгийн ялын хамгийн хүнд хэлбэр учраас Эрүүгийн хуульд заасны дагуу шүүх хүндэвтэр, хүнд, онц хүнд болон дахин давтан гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй этгээдэд оногдуулдаг.

Хууль тогтоогчийн зүгээс насанд хүрээгүй этгээдэд оногдуулах хорих ялын дээд хэмжээг 15 жилээр тогтоосон нь эрүүгийн ялын бодлоготой нийцүүлсэн заалт гэж үзэж байна. Гэхдээ насанд хүрээгүй этгээдийн бие сэтгэхүйн онцлог, тэдний цаашдын засрал хүмүүжилд энэ урт удаан хугацааны ял хир зохистой эсэх нь эргэлзээтэй юм.

Түүхэн уламжлалаас үзэхэд, 1986 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийг эс тооцвол насанд хүрээгүй этгээдэд 10 жилээс дээш хугацаагаар хорих ялыг хэрэглэдэггүй байсан байна. Түүнчлэн, бусад орны эрүүгийн хуулийг судлахад мөн 10 жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулдаггүй байна.

⁶⁹ Монгол Улсын Үндсэн хууль // Төрийн мэдээлэл 1992 №1

⁷⁰ Хүний эрх // Олон улсын гэрээ, хэлэлцээрүүдийн эмхтгэл. УБ., 1998.50 дахь тал 1-р зүйл

ИРГЭДИЙН УЛС ТӨРИЙН (СОНГУУЛИЙН ЭСРЭГ) ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙГ ЗҮЙЛЧЛЭХЭД АНХААРАХ АСУУДАЛ



Д.Ганзориг
ОХУ-ын ДХЯ-ны харъяа Удирдлагын
академийн адъюнкт,
цагдаагийн дэд хурандаа

Товч агуулга: Сонгуулийн эрх, бүх нийтийн санал асуулгатай холбогдолтой гэмт хэргийг зүйлчлэхэд анхаарах асуудлын талаар дурдсан.

Түлхүүр үг: Сонгуулийн эрх, бүх нийтийн санал асуулга, гэмт хэрэг.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18 дугаар бүлгийн Иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн Иргэн сонгуулийн эрхээ эдлэхэд болон сонгуулийн хорооны ажилд саад хийх (ЭХ-ийн 130-р зүйл), Сонгууль болон ард нийтийн санал асуулгад хууль бусаар илүү санал өгөх (ЭХ-ийн 130¹-р зүйл)^[71]. Сонгуулийн болон бүх нийтийн санал хураалтын баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санал хураалтын дүнг буруу гаргах (ЭХ-ийн 131-р зүйл) болон 14 дүгээр бүлгийн Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн Сонгуулийг будлиантуулж төрийн эрх мэдлийг хууль бусаар авах хуйвалдаан зохион байгуулах (ЭХ-ийн 82¹-р зүйл)^[72] зэрэг зүйл заалтуудаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурал, орон нутгийн хурлын сонгуультай холбогдолтой хэрэг маргаануудыг шийдвэрлэж байна. Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах нь Эрүүгийн хуулийн нэг гол зорилт юм^[73].

Иргэдийн улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг гэдэг нь тэдний сонгох, сонгогдох, бүх нийтийн санал асуулгад оролцох эрхэд халдсан Эрүүгийн хуульд заасан нийгэмд аюултай үйлдэл, эс

үйлдэхүүнүүдийн цогц бүрдэл^[74]. Монгол улсын Үндсэн хуульд иргэн “шууд буюу төлөөлөгчийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг 18 наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно”^[75] гэж заасан. Энэ төрлийн гэмт хэргийн субъект нийтлэг (16 нас) боловч ЭХ-ийн 131-р зүйлд заасан гэмт хэргийнх тусгай субъект (зохион байгуулах хорооны гишүүн, бусад албан тушаалтан) байдаг.

Манай улсад сонгуультай холбогдолтой эрүүгийн хэрэг анх 2008 оны УИХ-ын сонгуулийн жил бүртгэгдэн шалгагдсан^[76]. Энэ хэргүүд нь саналын хуудсыг нуун дарагдуулсан, сонгуулийн-р хэсгийн хороон дээр сонгогчийн эрхийг зөрчсөн, УИХ-ын гишүүн нь хүн бүрт 10000 төгрөг тараасан, сонгуулийн-р хэсгийн хороон дарга нь хэсгийн хорооны тогтоолыг хуурамчаар үйлдэн санал хураалтын дүнг нуун дарагдуулсан хэргээр ЭХ-ийн 130, 131 дүгээр зүйл ангиудаар 4 гомдол, мэдээлэлд эрүүгийн хэрэг үүссэн шалгаж шийдвэрлэсэн байна^[77]. Үүнээс хойш 2009-2016 онуудад тогтмол энэ төрлийн гэмт хэргийг Цагдаагийн байгууллага, Тагнуулын байгууллагууд нь шалгах болсон. Сүүлийн жилүүдэд энэ төрлийн гэмт хэргүүд нь маш эрчимтэй өсөж байгаа ба сонгуулийн болон бүх нийтийн санал асуулгатай холбогдолтой гэмт хэргийн үйлдлийн арга нь ч өөрөө нууц далд, ямар нэгэн халхавчтайгаар үйлдэгдэж, сонгууль явагдах тусам зохион байгуулалтын арга нь нарийсаж байна. Энэ нь намуудын хоорондын өрсөлдөөн, УИХ-ын суудлын эрх мэдлийн төлөөх тэмцэл, цаашлаад төрийн эрх мэдлийг авах гэсэн санаархлын тэмцэл болон хувирч байна. Үүний тод жишээ нь, 2008 оны УИХ-ын сонгуулиар эрүүгийн 4 гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдсан бол 2012 оны сонгуулиар 21 гэмт хэрэг бүртгэгдэн^[78] Цагдаагийн байгууллагад шалгагдсан нь эрчимтэй, хурдтай энэ төрлийн гэмт хэрэг нь өссөж байгаа нь харагдаж байна.

Цагдаагийн байгууллагаас Үндсэн хуульд заасан Монгол улсын иргэний сонгох, сонгогдох эрхээ хэрэгжүүлэхтэй

⁷⁴ С.Жанцан. Монгол улсын эрүүгийн эрх зүй. УБ., 2011, 334 тал.

⁷⁵ МУ-ын Үндсэн хууль. УБ., 1992. 16 дугаар зүйл.

⁷⁶ ЦЕГ-ын Мэдээлэл судалгааны төв. Статистик мэдээ. УБ., 2009 он.

⁷⁷ УЕПГ-ын Төв архив. УБ., 2016 он.

⁷⁸ ЦЕГ-ын Мэдээлэл судалгааны төв. Статистик мэдээ. УБ., 2015 он.

⁷¹ Энэ зүйлийг 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хуулиар нэмсэн.

⁷² Энэ зүйлийг 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хуулиар нэмсэн.

⁷³ МУ-ын Эрүүгийн хууль. УБ., 2002. 1 дүгээр зүйл.



холбогдолтой үйл ажиллагаанд нь хяналт тавьж эрүүгийн хуулийн гол зорилтоо хэрэгжүүлэн ажиллах явдал юм. Иймд цагдаа, тагнуулын байгууллагын ажилтан нарын хувьд сонгуулийн холбогдолтой эрүүгийн хуулинд заасан зүйл заалтууд, түүнчлэн эрүүгийн хуулийн болон улсын дээд шүүхийн тайлбаруудтай нэг бүрчлэн танилцаж, зөв ойлголтод хүрч, хэргийг үнэн зөвөөр шуурхай шалган шийдвэрлэх явдал юм.

Сонгуулийн болон бүх нийтийн санал асуулгатай холбогдолтой энэ төрлийн гэмт хэргийн ойлголтгүйгээр хэргийг шалган шийдвэрлэхэд маш их хүндрэлтэй байдаг ба эрүүгийн хэрэг үүсгэн шалгах явцдаа хэрэгсэхгүй болгох явдал ч цагдаагийн алба хаагч нарын дунд цөөнгүй байна. Энэ төрлийн гэмт хэрэг өөрөө шинэ төрлийн гэмт хэрэг ба маш эрчимтэйгээр шинээр гарч, өсөж байна. Сонгуулийн холбогдолтой өргөдөл, гомдол, дуудлага мэдээллийг хүлээн авч шалгахдаа хойшлуулшгүй ажиллагааг түргэн шуурхай явуулж, эрүүгийн хэрэг мөн эсэхийг нягтлан тогтоох нь маш чухал. Ингэснээр намуудын хооронд бие биенээ хардах, элдэв цуурхал маргаануудаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хэн нэгнийг зохиомлоор хэрэгт татаж оруулах гэсэн үйлдлүүдийг таслан шийдвэрлэнэ.

Сонгуультай холбогдолтой шалгагдаж байсан эрүүгийн хэргүүдээс 9 эрүүгийн хэргийг ЭБШХ-ийн 24.1.1-д зааснаар гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон^[79] байна. Тэгвэл анх яагаад гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй байхад эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан нь анхаарал татсан асуудал болж байна. Энэ нь хэн нэгний захиалга, дарамт шахалтаар эрүүгийн хэрэг үүсгэн шалгав уу, эсвэл хэрэгсэхгүй болгов уу гэдэг асуудал урган гарч ирнэ. Иймд төрийн алба хаагч та бид Монголын ард иргэдийн засаг төрөө байгуулах, бүх нийтийн дуу хоолой болох төлөөлөгчөө УИХ-д сонгох гэж байгаа ийм хариуцлагатай үйл ажиллагаанд шударгаар оролцож, эрүүгийн хуулийн гол зорилтоо хэрэгжүүлэн хэрэг маргааныг шийдвэрлэх нь чухал.

Энэ төрлийн гэмт хэргүүд нь голчлон саналын хуудсыг ба сонгуулийн дүнг нуун дарагдуулсан, буруу гаргасан, сонгогчийн эрхийг зөрчсөн, иргэдийн саналыг санаатайгаар өөр хүний нэр дээр тоолж уншуулсан, эд зүйл тараасан (нүүрс, архи, ⁷⁹ ЦЕГ-ын Мэдээлэл судалгааны төв. Статистик мэдээ. УБ., 2015 он.

хүнсний бүтээгдэхүүн гэх мэт), хоолонд оруулах, мөнгө тараах, нэр дэвшигчийг нэрээ татаж авахыг шаардах, сонгуулийн хорооны ажилтны үйл ажиллагаанд хөндлөнгөөс хууль бусаар оролцох зэргээр илрэн гарч ирсэн байдаг.

Сонгуулийн болон бүх нийтийн санал асуулгатай холбогдолтой энэ төрлийн гэмт хэргийн зүйл заалтуудад заагдсан зарим нэр томъёог хууль зүйн талаас нь зөв ойлголтой болгох хэрэгтэй. Тухайлбал:

✓ Сонгох, сонгогдох болон бүх нийтийн санал асуулгад оролцох эрхэд *саад хийсэн* гэдэгт^[80] Монгол улсын Үндсэн хууль болон холбогдох хуульд тусгайлан заасан хориг, хязгаарлалтаас бусад тохиолдолд иргэний дээрх эрхийг аливаа хэлбэрээр эдлүүлэхгүй байгаа санаатай үйлдэл (эс үйлдэхүй) юм.

✓ *Сонгуулийн хорооны ажиллагаанд саад хийсэн* гэж^[81] хууль тогтоомжоор сонгууль болон ард нийтийн санал асуулгыг эрхлэн явуулах эрх бүхий сонгуулийн төв, орон нутгийн байгууллагын үйл ажиллагаа явуулах боломжгүй байдалд хүргэсэн эсхүл хүндрэл учруулсан аливаа санаатай үйлдэл (эс үйлдэхүй) байна.

✓ *Хуурч мэхлэх* гэдэгт УДШ-ийн 2006 оны 12-р сарын 21-ны өдрийн 51-р тогтоолын 3-т зааснаар буюу үгээр болон үйлдлээр бодит байдлыг гуйвуулах, нуун дарагдуулах эсвэл зохиомол байдлыг зориудаар бий болгох замаар төөрөгдүүлэхийг хэлнэ.

✓ *Хүч хэрэглэх* гэж^[82] иргэний сонгох, сонгогдох эрхээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан цохиж зодох, бие эрхтэнд нь гэмтэл учруулах, хууль бусаар баривчлах, саатуулах зэрэг үйлдлээр илэрнэ.

✓ *Санал худалдаж авах* гэж иргэнийг сонгуульд оролцохоос татгалзуулах эсвэл нэр дэвшигчид санал өгүүлэхийн тулд мөнгө, эд хөрөнгө өгсөн, эсвэл эд хөрөнгийн давуу байдал эрх олгосон, аливаа ажил үйлчилгээг төлбөргүй үзүүлсэн зэргийг хамааруулна.

✓ *Хүч хэрэглэхээр заналхийлэх* гэдэг^[83] нь иргэнийг сонгуулийн эрхээ эдлэхтэй нь холбогдуулан элдэв хэлбэрээр сэтгэл санааны тавгүй байдалд оруулах, цохиж зодно, ална, ойр дотны хүмүүсийн амь биед халдана, эд хөрөнгийг устгана, гэмтээнэ, нэр төрийг гутаана, хувийн нууцыг задруулна гэж айлган сүрдүүлж дарамтлахыг хэлнэ.

⁸⁰ С.Жанцан. Монгол улсын эрүүгийн эрх зүй /Ерөнхий ба тусгай анги/. УБ., 2011, 337 тал.

⁸¹ Монгол Улсын Дээд шүүхийн тайлбар. 2009 оны 5-р сарын 22-ны №16 тогтоол

⁸² Монгол Улсын Дээд шүүхийн тайлбар. 2007 оны 10-р сарын 29-ны №41 тогтоол

⁸³ С.Жанцан. Монгол Улсын эрүүгийн эрх зүй /Ерөнхий ба тусгай анги/. УБ., 2011, 337 тал.



✓ *Бусад албан тушаалтан гэдэгт*^[84] нэр дэвшигчдийн болон сонгогчдын нэрсийн жагсаалт, нэр дэвшигчийн үнэмлэх, саналын хуудас, сонгогчийн үнэмлэх зэрэг сонгуулийн баримт бичгийг олгох үндэслэл болж буй анхан шатны бүртгэл, баримт бичиг, иргэний үнэмлэхийг энэ зүйл, заалтад дурдсан зорилгоор хуурамчаар үйлдсэн албан тушаалтныг хамааруулж ойлгоно.

✓ *Саналаа чөлөөтэй илэрхийлэх эрхийг зөрчсөн үйлдэл*^[85] нь Монгол улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хуулиар тогтоосон саналаа чөлөөтэй илэрхийлэх журмыг зөрчсөн, сонгуулийн хэсэгт саналаа тэмдэглэх тасалгаа, хаалтгүй байх, саналаа тэмдэглэхэд нь элдэв саад үүсгэх, тухайн сонгогчоос өөр гадны хүнийг дэргэд нь байлгах, саналаа хэрхэн өгч байгаа байдалд нь шууд хяналт тавих, саналын хайрцгийг битүүмжлэхгүй байх, саналын хуудсанд тэмдэглэл хийж чадахгүй сонгогчийн саналыг итгэмжлэгдээгүй хүнээр тэмдэглүүлэх, тухайн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн даргын гарын үсэг, тэмдэггүй саналын хуудсаар санал өгүүлэх зэрэг хэлбэрээр илэрч болно.

✓ *Хуурамчаар үйлдсэн гэдэг*^[86] нь сонгогчдын нэрсийн жагсаалтад тухайн тойрог хэсэгт бүртгэлгүй хүмүүсийн нэрийг нэмж бичсэн, сонгогчдын үнэмлэхийг буруу бичсэн, иргэний үнэмлэхийг хуурамчаар үйлдсэн, санал өгсөн сонгогчдын саналын хуудсыг засварласан, сольсон, санал хураалтын дүнг санаатайгаар худал гаргасан байх явдал юм.

✓ *Хуйвалдаан зохион байгуулах гэдэг* нь хоёр ба түүнээс дээш тооны хүмүүс төрийн эрх мэдлийг хууль бусаар авах зорилгын дор нэгдсэн, төлөвлөгөө боловсруулсан, арга замаа тодорхойлсон, гишүүддээ үүрэг хуваарилсан нууц далд ажиллагаа явуулахыг хэлнэ.

Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах хуйвалдаан зохион байгуулахад оролцсон боловч гэмт үйлдэл эхлэхээс өмнө энэ тухай төрийн зохих байгууллага, албан тушаалтанд сайн дураараа мэдэгдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө. Монгол Улсын Үндсэн хуулийн 3 дугаар зүйлд: "Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож,

мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ"^[87] гэж заасан. Төрийн эрх мэдэл нэг улс төрийн хүчнээс нөгөөд зөвхөн сонгуулийн үр дүнд шилжинэ. Зэвсэгт мөргөлдөөн, нууц хуйвалдааны аргаар төрийн эрх мэдлийг олж авах нь гэмт хэрэг болно.

Сонгуультай холбогдолтой энэ төрлийн гэмт хэргүүд (ЭХ-ийн 130, 130¹, 131-р зүйл) нь үндэсний аюулгүй байдалтай салшгүй холбоотой тул ЭХТА-ийн арван дөрөвдүгээр бүлэгт оруулан санкцийг хүндрүүлэх нь зүйтэй гэж судлаач миний зүгээс үзэж байна. Учир нь, сонгуулиар сонгогдсон нам, эвсэл нь цаашлаад Засгийн газраа байгуулах, төрийн эрх мэдлийг гартаа авч, улс орны дотоод аюулгүй байдалд шууд оролцдог учир онцлон анхаарч, Эрүүгийн хуулийн зүйл заалт, бүлэгт өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг гэдэг нь Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, төрийн эрх мэдэл, батлан хамгаалах хүчин чадал, эдийн засгийн аюулгүй байдал, үндэсний эв нэгдэл, хил хязгаарын халдашгүй дархан байдал, төр, нийгмийн зүтгэлтний хуульд нийцсэн ажиллагаа, амь биеийн эсрэг төрийн амин чухал эрх ашигт халдаж хохирол учруулдаг, учруулах боломжтой нийгэмд аюултай, гэм буруутай идэвхтэй үйлдэл, эс үйлдэхүйн цогц бүрдлийг хэлнэ^[88] гэж заасан байдаг.

Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал, үндсэн хуульт байгууллын аюулгүй байдал, нэгдмэл байдлыг хамгаалан бататгах нь үндэсний аюулгүй байдлыг хангах анхдагч нөхцөл мөн. Хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх зарчим, парламентын засаглалд суурилсан, нийгмийн тогтвортой байдлыг хангасан ардчилсан төрийн тогтолцоо нь үндэсний аюулгүй байдлыг хангах баталгаа мөн. Монгол Улсын төр, нийгэм, иргэний аюулгүй байдал харилцан уялдаатай хангагдсанаар Монгол Улсын үндэсний аюулгүй байдал баталгаажна (Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал)^[89]. Сонгуультай холбогдолтой эрүүгийн хэрэг нь өөрөө Монгол улсын дотоод аюулгүй байдалд халдсан гэмт хэргийн шинжийг агуулсан байдаг.

⁸⁴ Монгол Улсын Дээд шүүхийн тайлбар. 2009 оны 5-р сарын 22-ны №16 тогтоол

⁸⁵ Монгол Улсын Дээд шүүхийн тайлбар. 2009 оны 5-р сарын 22-ны №16 тогтоол

⁸⁶ С.Жанцан. Монгол улсын эрүүгийн эрх зүй /Ерөнхий ба тусгай анги/. УБ., 2011, 339 тал.

⁸⁷ Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992.

⁸⁸ С.Жанцан. Монгол улсын Эрүүгийн эрх зүй. УБ., 2011.

⁸⁹ Монгол Улсын Их Хурлын 2010.07.15-ны 48-р тогтоол

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ГЭМТ ХЭРЭГ МӨРДӨН ШАЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРЧНЫ НӨХЦЛИЙГ ҮНЭЛЭХ ОНОЛ АШИГЛАХ НЬ ЗАГВАРЫГ



Г.Бямбадорж
ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн
ЦЭЗТ-ийн
ахлах багш, цагдаагийн хошууч

Товч агуулга: Гэмт хэрэг мөрдөн шалгах үйл ажиллагаанд орчны нөхцөл байдлын үнэлгээг хийхдээ шинжлэх ухааны онол, аргуудыг ашиглах, түүнд түшиглэн мөрдөн шалгах үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх, үйлдэгдсэн гэмт хэргийн гаралт, ангилал төрөл, нэг дүүрэг, аймаг, сум, баг, хороонд үйлдэгдсэн гэмт хэргийн нягтрал, гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй эмзэг цэгийг тодорхойлох, гэмт явдлын прогноз гаргах ач холбогдлын талаар дурдаж, гэмт хэрэг мөрдөн шалгах үйл ажиллагаанд орчны нөхцөлийг үнэлэх загварыг тодорхойлох оролдлого хийж, түүнийг хэрэгжүүлэх талаар энэхүү илтгэлдээ авч үзсэн.


Түлхүүр үг: Онол, гэмт хэрэг, мөрдөн шалгах ажиллагаа, загвар, орчин нөхцөл

Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүн амын төвлөрөл, барилгажилт, хот төлөвлөлт, хотын амьдралын хэв маяг, нийгмийн ёс суртахууны доройтол, хотжилтыг даган эрчимжиж буй гэмт явдлын чиг хандлага, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, гэмт хэргийн гаралт, шалтгаан нөхцөл зэргийг харьцуулан судалж, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлээ онолын болон практикийн түвшинд тодорхойлж, ажиллах шаардлага зүй ёсоор тулгарсаар байна^[90].

Цагдаагийн байгууллагын мэдээлэл судалгааны алба үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн гаралт, гэмт хэрэг, зөрчлийн төрөл, өсөлт бууралт, хэрэг зөрчлийн ангилал, халдаж буй нийгмийн харилцаагаар нь, гэмт хэрэг үйлдэгдсэн цаг хугацаагаар

нь сар бүр дүн шинжилгээ хийж байгаа ч энэхүү статистик мэдээг гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд ашиглахад төдийлөн үр дүнд хүрэхгүй байгааг өнөөгийн үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн гаралтын байдлаас харж болно.

График №1. Сүүлийн 5 жилд бүртгэгдсэн гэмт хэргийн харьцуулалт:



Дээрх тоон үзүүлэлтээс үзэхэд жил бүр бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өсөж, тогтвортой байдлаа хадгалсан нь ажиглагдана.

Иймээс хэргийг шалгах түүвэр болон календарчилсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх, гэмт хэргийг мөрдөн шалгах арга тактикийг тодорхойлохуйц түвшинд хийгдсэн орчны нөхцөлийг үнэлэх онол загваруудыг ашиглах нь зүйтэй байна.

Бидний мөрдөн шалгах үйл ажиллагааны хүрээлэн буй орчин нь хариуцсан нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын тухай ойлголтоос илүү өргөн хүрээтэй ойлголт юм.

Биднийг хүрээлэн буй юмс үзэгдэл объектив ертөнц: Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын орчин хамаарна.

Харин эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал нь харьцангуй бага хүрээнд тодорхойлогдоно.

Гэхдээ бид хүрээлэн буй орчны нөхцөл болон хариуцсан нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг гэмт хэрэг мөрдөх үйл ажиллагаанд ашиглах шаардлагатай.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны нэг зорилго нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх явдал бөгөөд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоож, арилгах үүргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 190-р зүйлд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорт үүрэг болгожээ. Үүнд: ЭБШХ-ийн 190 дүгээр зүйл. Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ

190.1. Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг тогтоомогц хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор

⁹⁰ Цагдаа судлал сэтгүүл 2013 №3. 47 дахь тал



нь зохих хуулийн этгээдэд тэрхүү шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ авахуулахаар мэдэгдэл бичиж хуулбарыг хэрэгт нь хавсаргана.

190.2. Хуулийн этгээд нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын мэдэгдлийн дагуу шаардлагатай арга хэмжээ авч, 1 сарын дотор тэр тухай хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорт хариу мэдэгдэх үүрэгтэй^[91] хэмээн заажээ.

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор нар энэхүү үүргээ хэрэгжүүлэхдээ гэмт хэрэг үйлдэгдсэн орчин нөхцөл, цаг хугацаа, газар орон, гэмт хэргийн шалтгаан зэргийг судлан мэдэгдэл, шаардлага хүргүүлдэг. Энэхүү нөхцөлийг судлахдаа хүрээлэн буй орчны онолыг ашиглах нь зүйтэй. Иймд хүрээлэн буй орчны онолын талаар товч авч үзье.

Хүрээлэн буй орчны онолыг АНУ-ын судлаач Бурнс болон Сталкер нар уг онолыг санаачилсан юм. Тэд нөхцөл байдлыг сайтар судалж “хүрээлэн буй орчныг нь сайтар унших” тухайн байгууллагад тохирсон бүтцийн загвар болон үйл ажиллагааг тодорхойлон сонгох ёстой гэж үздэг юм^[92].

Иймээс энэхүү онолд үндэслэн гэмт хэргийг мөрдөх үйл ажиллагаанд орчны нөхцөлийг сайтар судалж, түүнд тохирсон арга тактик, үйл ажиллагааг тодорхойлох боломжтой.

Нөөцийн хамаарлын онолыг үндэслэлтэй тайлбарласан судлаачид бол Преффер болон Сланцик нар юм. Тухайн онолын үндсэн санаа нь аливаа байгууллага нэгж үйл ажиллагаа явуулахын тулд заавал хүрээлэн буй орчноос нөөц хэрэгслийг авах ёстой гэсэн үзэл санааг дэвшүүлсэн юм^[93].

Өөрөөр хэлбэл, гэмт хэргийг мөрдөх үйл ажиллагаанд хүрээлэн буй орчныг зөв үнэлж чадахгүй бол гэмт хэрэг мөрдөх үйл ажиллагааны арга тактик алдагдаж, тухайн нөхцөл байдлаас хамааралтай болж зөвхөн түүнд тохирсон үйл ажиллагаа явуулж, түүнийг хянаж чадахгүйд хүрнэ.

Иймд нөхцөл байдлыг хяналтандаа авсны дараа түүнээс хамааралгүй болж байгууллага нэгж амжилтад хүрнэ хэмээн үзжээ.

Нөгөө талаар цагдаагийн байгууллага хүн хүч, чадавхаа нэмэгдүүлэх, нөөц хэрэгслийг хангах нь амжилтад хүрэх чухал хэрэгсэл гэдгийг нотолжээ.

Хүн амын экологийн онолыг Герман Улсын эрдэмтэн Ханнан болон Фриман нар үндэслэсэн бөгөөд 1970-аад оны сүүл

үеэс эхлэн газар авч эхэлсэн ба уг онолоор нэг чиг үүрэгтэй олон байгууллагууд өрсөлдөн хүн амын нягтаршил, газар нутгийн байрлал, түүний онцлог зэрэгт илүү анхаарал хандуулснаар байгууллагууд илүү их амжилтад хүрнэ гэдгийг тодорхойлох оролдлого хийжээ.^[94]

Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг мөрдөх чиг үүрэгтэй алба, тасаг, нэгж хариуцсан нутаг дэвсгэрийн хүн амын тоо, оршин суух иргэдийн нягтаршил газар нутгийн хэмжээ, байрлал онцлог зэргийг судалж, дүн шинжилгээ хийснээр гэмт хэргийг мөрдөн шалгах чиг үүргийг амжилттай хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

Зэргэлдээ орших аймаг, дүүрэг, сум, баг, хорооны хүн амын нягтаршил, газар нутгийн байрлал, түүний онцлог зэргийг судлан мэдэж байх нь үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлэх, гэмт этгээдийг эрэн сурвалжлах ажил явуулах зэргээр мөрдөн шалгах чиг үүргийг амжилттай хэрэгжүүлэх үндэс болно хэмээн тайлбарлаж болох юм.

Мөн дээрх онолуудад тулгуурлан орчны нөхцөлийг судлах нь дараах ач холбогдолтой байна. Үүнд:

Үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг тодорхойлох

➤ Үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн ангилал, төрлийг тодорхойлох

➤ Үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нягтрал байршил тодорхойлох

➤ Үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн циклийг тодорхойлох

➤ Гэмт явдлын прогноз гаргах

➤ Гэмт явдлын шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгуулах

➤ Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх

➤ Цагдаагийн байгууллагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээг оновчтой болгох

➤ Гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх ажлын алдаа дутагдлыг ирүүлж, арилгуулах

➤ Цагдаагийн байгууллага гэмт хэрэг мөрдөх үйл ажиллагаандаа дүн шинжилгээ хийх

➤ Цагдаагийн байгууллага гэмт хэрэг мөрдөх үйл ажиллагаандаа үнэлэлт өгөх гэх мэт ач холбогдолтой байна.

Түүнээс гадна цагдаагийн хэв журмын эргүүлийн төлөвлөлтийг судлан үзэхэд жилд хоёр удаа эргүүлийн чиглэл (эргүүлийн нэгдсэн байршил)-ийг шинэчлэн батлаж байгаа нь учир дутагдалтай оновчтой бус байгаа бөгөөд эргүүлийн чиглэл бүрийг тухайн чиглэлд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн байдал өөрөөр хэлбэл, хариуцсан

⁹¹ www.legalinfo.mn

⁹² Larry K. Gaines, John L. Worrall, Police Administration, 2011. 124-139 дэхь тал

⁹³ Larry K. Gaines, John L. Worrall, Police Administration, 2011. 124-136 дахь тал

⁹⁴ Larry K. Gaines, John L. Worrall, Police Administration, 2011. 124-129 дэхь тал



нутаг дэвсгэрийн нөхцөл байдалд тулгуурлах ёстойг орхигдуулснаас гэмт хэрэг буурахгүй байх нэг шалтгаан болж байгааг дурдах нь зүйтэй.

Судлаач бид гэмт хэргийг мөрдөх үйл ажиллагаанд дээр дурдсан онолыг үндэслэл болгон орчны нөхцөл байдлыг судлах дараах загварыг бий болгож, ашиглаж болно гэж үзэж байна.

Үүнд: Хүснэгт дээр харуулав.

Хүснэгт №1

	Хүрээлэн буй орчин	Хүрээлэн буй орчны хүчин зүйлс
	Мөрдөгч нарын орон тоо	Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бүрдүүлэлт
2	Мөрдөгчийн ур чадвар арга тактик	Албаны сургалтын агуулга, чанар, үр дүн
3	Мөрдөгч нарын ажлын ачаалал	Шалгаж буй өргөдөл гомдол мэдээлэл, эрүүгийн хэргийн тоо
4	Гүйцэтгэх ажлын мэдээлэл	Тодорхой төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийн судалгаа, тэдний яриа өгүүлэл үйл хөдлөл, үйлдэж буй гэмт хэрэг, зөрчил
5	Хорих ял эдлээд суллагдсан ХӨТЯШ хүмүүстэй ажиллаж буй байдал	Гэмт хэрэг үйлдээд суллагдсан болон гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдүүдийн ажил хөдөлмөр эрхлэлт, тэдний нийгмийн байдал
6	Дотоод орчин	Туслах хүч, сайн дурын ба олон нийтийн цагдаагийн ажилтны тоо, тэдний үйл ажиллагаа, үр дүн
7	Удирдлагын манлайлал	Удирдлагын манлайлал, арга, мэдлэг ур чадвар, нөлөөлөл Байгууллагын үйл ажиллагааны уялдаа холбоо хамтын ажиллагаа
8	Бусад байгууллага нэгжийн үйл ажиллагаа	Үндсэн чиг үүрэгтэйгээс бусад алба, нэгжийн үйл ажиллагаа, тэдгээрийн нөөц боломж Бусад агентлагууд байгууллагуудын үйл ажиллагаа Төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа, оролцоо
9	Эдийн засгийн орчин	Эдийн засгийн өнөөгийн байдал Эдийн засгийн төлөв Эдийн засгийн уналт Эдийн засгийн өсөлт Үнийн хөөрөгдөл
10	Улс төрийн орчин	Улс төрийн төлөв байдал Улс төрийн тогтвортой байдал ЗГ-ын бодлого үйл ажиллагаа Эрх мэдэлтнүүдийн нөлөөлөл
11	Улс орны нийгмийн байдал	Ажилгүйдлийн тоо Ядуурлын түвшин Архидалт Мансуурах явдал Биеэ үнэлэлт Үйлдвэр, аж ахуй эрхлэлт Нийгмийн халамжийн үйлчилгээ, тэтгэвэр тэтгэмж
12	Гадаад орчин	Байгалийн гамшиг, жагсаал цуглаан бослого тэмцэл, томоохон үйлдвэрлэлийн осол, олныг айдас автуулсан хүнд, онц хүнд гэмт хэрэг аллага, мансууруулах бодис, хүний наймаатай холбоотой гэмт хэрэг зэрэг улс төр, нийгэм, эдийн засагт хор хохирол учруулсан гэмт хэргийн өргөцтэй холбоотой үйлдэл, нэмэлт төсөв хөрөнгө шаардлагатай ажил арга хэмжээнүүд
13	Эрх зүйн орчин	Үндсэн хууль бусад хууль тогтоомж Үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж Тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам Эрх зүйн хамгаалалт бий болсон орчин Эрх зүйн зохицуулалтын давхардал, хийдэл
14	Хуулийн байгууллагуудын үйл ажиллагаа	Хуулийн байгууллагуудын үйл ажиллагаа Шүүхийн ял оногдуулалтын байдал Захиргааны шийтгэл ногдуулалт Ялныг нийгэмшүүлэх ажил, түүний үр дүн Ялныг хүмүүжүүлэх ажил, түүний үр дүн Өмгөөллийн үйл ажиллагаа Цагдаагийн байгууллага, алба хаагч нарын үйл ажиллагаа
15	Техник технологи	Үйл ажиллагаагааны ил тод байдал, цахим үйлчилгээний төрөл, хэлбэр шинжлэх ухааны ололт амжилт, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээний ашиглалт шинэ арга, технологи

Түүнээс гадна гэмт хэргийг мөрдөн шалгах үйл ажиллагаанд орчны нөхцөлийг судлах ажлын зорилго, хэрэгцээ шаардлагад тохирсон анализийн арга, синтезийн арга, индукцийн арга, дедукцийн арга, аналогийн арга, харьцуулалтын арга, системт хандлагын арга, бүтэц үргэрийн арга, хэмжилтийн арга, түүврийн арга, ажиглалтын арга, баримт бичиг судлах арга, социометрийн арга, бүлэглэх арга, сурвалжлагын зэрэг аргыг өргөнөөр ашиглах нь зүйн хэрэг.

Түүнчлэн гэмт хэргийг мөрдөн шалгах үйл ажиллагаанд орчны нөхцөлийг үнэлэх, шинжлэх ухааны ололт амжилт, орчин үеийн техник технологи ашиглах талаар цагдаагийн албаны



тухай хууль заасан зарчмыг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай. Тухайлбал, АНУ-ын Нью-Йорк хотын цагдаагийн газрын дарга, комиссар Уильям Брантон анх 1994 онд мэдээлэлд суурилсан удирдлагын Comp.Stat загварыг танилцуулсан бөгөөд энэхүү загвар нь АНУ даяар маш хурдан тархаж, энэ нь гэмт хэрэг бууруулахад чиглэсэн орчин үеийн менежментийн загвар болж чадсан байна^[95].

Comp.Stat загвар нь гэмт хэрэг, түүний шалтгаан нөхцөл, стратегийн ач холбогдолтой асуудлыг шийдвэрлэх, тодорхой үйл ажиллагаанд анализ хийх, гэмт хэргийн гаралт, төрөл, гэмт хэрэг гарсан цэг бусад нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлоход ашиглагдаж байгаа мэдээ мэдээлэл, түүний үнэн зөв эсэхийг цаг хугацаанд нь дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүлж байна.

Энэхүү нөхцөл байдлын үнэлгээн дээр тулгуурлан, тохирсон хариу арга хэмжээ авах, алба хаагч ажилтан болон нөөц хүчийг зохих газар хурдацтай байршуулах байдлаар хэрэгжүүлж, гэмт хэрэг бууруулах зорилго, зорилтыг хэрэгжүүлдэг байна^[96].

Иймд Comp.stat системийг цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлж ашигласнаар тухайн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал долоо хоног бүр дүн шинжилгээ хийж, тухайн долоо хоногт үйлдэгдсэн гэмт хэргийн тоо, гэмт хэргийн төрөл, гэмт явдлын шалтгаан нөхцөл, тохироо, гэмт хэрэг үйлдэгч, хохирогч, халдлагын зүйл зэрэгт дүн шинжилгээ хийж цаашид авах арга хэмжээг төлөвлөж ямар ямар гэмт хэрэг ихээр үйлдэгдэж байна түүнийг бууруулах урьдчилан сэргийлэх үйл ажиллагаагаа оновчтой тодорхойлох, гэмт явдалд прогноз хийх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

Мөн "Crime mapping" буюу гэмт хэргийн зураглал үйлдэх системийг бүрэн ашиглаж болно.

"Crime mapping" буюу гэмт хэргийн зураглал нь: Гэмт явдлын гаралт, төрөл, ангилал, нягтаршил, өдөр гариг, цаг хугацаа зэрэгт дүн шинжилгээ хийхийн тулд хууль сахиулах байгууллага ашигладаг систем юм.

Энэ нь гэмт хэрэгт дүн шинжилгээ хийх, цагдаагийн стратегийн Comp.Stat загварын нэг гол бүрэлдэхүүн хэсэг юм. "Crime mapping" буюу гэмт хэргийн зураглал үйлдэх системийг газар зүйн мэдээллийн систем (GIS) ашиглан гэмт явдлын төлөв байдлыг шинжээчийн түслэмжтайгаар тодорхойлж,

гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй цэгүүдийг тодорхойлох боломжийг олгодог систем юм^[97].

Энэхүү системийг ашигласнаар тухайн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийг зураглал дээр тусгай тэмдэглэлээр тэмдэглэж ямар гэмт хэрэг өссөн, аль дүүрэг, хороонд хичнээн гэмт хэрэг үйлдэгдсэн, ямар төрлийн гэмт хэрэг үйлдэгдэж байгааг аль ч үед (шаардлагатай үед) харж болох боломжтой бөгөөд энэхүү зураглалыг "Comp.stat системтэй хослуулан ашиглавал илүү үр дүнд хүрч болно.

Тэрчлэн үйлдэгдэж буй гэмт хэргийн гаралтад дүн шинжилгээ хийж, аль дүүрэг, хороо, хэсэгт ямар төрлийн гэмт хэрэг өсөж байна тэр дүүрэг хороонд эргүүлийн чиглэлийг түлхүү ажиллуулах, цагдаагийн алба хаагч болон урамшилт эргүүл, сайн дурын цагдаагийн ажилтныг байрлуулан ажлуулж цагдаагийн хүн хүчийг зөв хуваарилах ач холбогдолтой болно.

Мөн нутаг дэвсгэрийн хүн амын нягтаршил үйлдэгдэж буй гэмт хэргийн гаралтын тоо, хэргийн ангилал, үйлдлийн арга зэрэгт дүн шинжилгээ хийж, шаардлагатай бол нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн хэсэг бий болгон ажиллуулж болно.

Дүгнэлт

Гэмт хэрэг мөрдөн шалгах үйл ажиллагаанд орчны нөхцөл байдлын үнэлгээг шинжлэх ухааны онол, аргуудыг ашиглан хийж, түүнд түшиглэн мөрдөн шалгах үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх, үйлдэгдсэн гэмт хэргийн гаралт, ангилал төрөл, нэг дүүрэг, аймаг, сум, баг, хороонд үйлдэгдсэн гэмт хэргийн нягтрал, гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй эмзэг цэгийг тодорхойлох, гэмт явдлын прогноз гаргах, гэмт явдлын шалгаан нөхцөлийг тогтоож, гэмт хэрэгтэй тэмцэх ажлын алдаа дутагдлыг илрүүлж арилгуулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой төлөвлөн хэрэгжүүлэх, түүний үр нөлөөг дээшлүүлэх, мөрдөн шалгах ажиллагаанд дүн шинжилгээ хийж уг ажиллагааны зорилго зорилтыг хангах шаардлагатай гэж бид дүгнэж байна.

Санал

Гэмт хэрэг мөрдөн шалгах үйл ажиллагаанд орчны нөхцөл байдлын үнэлгээг шинжлэх ухааны онол, загвар арга зүйд тулгуурлан хийх загвар болгож, хэрэгжүүлэх;

- Орчны нөхцөл байдлын үнэлгээг хийхдээ comp.stat, crime mapping зэрэг дүн шинжилгээ хийхэд тус дөхөм болох системүүдийг нэвтрүүлж ашиглах;

- Орчны нөхцөл байдлын үнэлгээнд тулгуурлан гэмт хэрэг мөрдөн шалгах үйл ажиллагааны бодлого боловсруулж, хэрэгжүүлж;

- Цагдаагийн албаны тухай хуулийн зүйлд 16.1.4 дэх хэсэгт заасан судалгааны төвийн судалгаа хийх чиглэлд "орчны нөхцөлийг судлах" гэж нэмэлт өөрчлөлт оруулах.

⁹⁷ http://en.wikipedia.org/wiki/Crime_mapping.

⁹⁵ <http://www.compstat.umd.edu>

⁹⁶ <http://www.compstat.umd.edu>



ШҮҮХИЙН АЖИГЛАЛТ, ХЭРГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ МЕНЕЖМЕНТ БА АНХАН ШАТНЫ ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОВ

С.Эрдэнэболор
Отгонтэнгэр Их сургуулийн
Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн
тэнхимийн эрхлэгч

М.Ариунаа
Хууль зүйн клиник
сургалтын төвийн эрхлэгч

Түлхүүр үг: Шүүх хуралдаан, шүүхийн ажиглалт, хэргийн хөдөлгөөний менежмент, шүүх хуралдааны тов

Шүүхийн ажиглалт нь шүүхийн үйл ажиллагаанд олон нийт, иргэний нийгмийн хяналтыг сайжруулах үндсэн зорилгын хүрээн дэх хүний эрхийг хамгаалах, сэргээх үндсэн механизм болохын хувьд шударга шүүхээр шүүлгэх хүний эрх хэрхэн хангагдаж байгаад тодорхой баримтад тулгуурлан дүгнэлт өгөх зорилготой.

Монгол Улсын шүүхийн хараат бус байдалд дүн шинжилгээ хийх, шүүхийн шинэтгэлийн үйл явцад оролцогч талуудын оролцоотойгоор судалгаан дээр үндэслэсэн бодит мэдээлэл цуглуулан хөндлөнгийн анхны шүүхийн ажиглалт, мониторингийг 2005 онд Азийн сан, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн “Шүүх эрх мэдлийн шинэтгэл” төслөөс Отгонтэнгэр Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, оюутнуудтай хамтран “Монголын шүүхийн тогтолцооны бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа, бодлого, хуулиуд зэргийн чухам аль нь иргэдэд болон шүүх, шүүгчдэд бэрхшээл учруулж байгааг судалж, тодорхойлох^[98]” зорилгоор хэрэгжүүлсэн.

Энэхүү шүүхийн ажиглалтын хөтөлбөр бэлтгэл ажлын болон ажиглалтын гэсэн 2 үе шаттай хэрэгжиж, ажиглагчийн гарын авлага, сургалтын хөтөлбөрийг анх удаа боловсруулж, нийслэлийн болон орон нутгийн шүүхүүдийн эрүү, иргэний хэргийн шүүх хуралдаануудад ажиглалт хийж, мэдээлэл цуглуулан ажилласан юм. Эхний удаагийн шүүхийн ажиглалтаар холбогдох хуулиудын хэрэгжилт, шүүхийн байрны нөхцөл, боломж, шүүгч, шүүхийн

ажилтнуудын харилцааг тусгайлан боловсруулсан ажиглалтын асуултаар үнэлэн дүгнэж, шүүхийн үйлчилгээг сайжруулахад шүүхүүд шүүхийн мэдээлэл-лавлагааны албатай байх санал дэвшүүлсэн нь практикт амжилттай хэрэгжсэн.

Нээлттэй нийгэм форум 2009 оны 7 сараас эхлэн Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллага болон Хүний эрхийн Хельсинкийн хорооны шүүхийн мониторингийн зөвлөх Лукаш Боярскийин дэмжлэгтэйгээр Монгол дахь шүүхийн ажиглалтын арга зүйг боловсруулж, шүүхийн ажиглагч бэлтгэх сургалт зохион байгуулж, шүүхийн ажиглалт хэрэгжүүлж мэдээлэл цуглуулах, мэдээлэлдээ боловсруулалт хийж тайлан бичих, тайланг ажиглалтын оролцогч талуудад танилцуулах зэрэг үе шаттай ажлуудыг хууль зүйн их, дээд сургуулиудын хууль зүйн клиник сургалтын төвийн багш, оюутнууд, хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж буй иргэний нийгмийн байгууллагын төлөөлөлтэй хамтран 2010 оноос^[99] хэрэгжүүлсэн.

Нээлттэй нийгэм форумтай хамтран хэрэгжүүлсэн шүүхэд ажиглалтын оролцогчоор ажилласан нь хууль зүйн их, дээд сургуулиудын хувьд эрх зүйн бакалаврын сургалтын шинэ арга хэлбэр болж байсан ч Отгонтэнгэр Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, оюутнуудын хувьд шүүхийн ажиглалтын туршлагыг 2005 оны ажиглалтын явцад хуримтлуулсан байсан юм.

Нээлттэй нийгэм форум хууль зүйн их, дээд сургуулийн багш, оюутнуудтай хамтран 2014^[100], 2016 онуудад шүүхийн ажиглалтын судалгаа, мониторинг хэрэгжсэн бөгөөд Отгонтэнгэр Их сургуулийн Хууль зүйн сургуулийн хууль зүйн клиник сургалтын төвийн багш, оюутнууд 2015-2016 оны хичээлийн жилд “Хууль зүйн клиник сургалтад шүүх хуралдааны ажиглалтыг турших нь” төсөл хэрэгжүүлэн Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 240^[101] шүүх хуралдаанд шударга шүүхийн стандартын хэрэгжилтийн байдалд ажиглалт хийсэн.

Энэ удаагийн шүүх хуралдааны ажиглалт 2010, 2014 онд хийсэн шүүхийн ажиглалтын үндсэн арга зүйд тулгуурласан бөгөөд захиргааны хэргийн анхан шатны шүүх

⁹⁹ Туяа Н., Ариунаа М., Оюунбадам Р., Мойлтмаа С нар. Шүүх хуралдааны ажиглалтын тайлан. УБ. 2011 он.

¹⁰⁰ Туяа Н., Бадамрагчаа П нар. “Шүүх хуралдааны ажиглалт” судалгааны нэгдсэн тайлан. УБ. 2015 он

¹⁰¹ 2015 оны 10 сараас 12 сар хүртэлх хугацаанд болсон шүүх хуралдааны ажиглалт

⁹⁸ Шүүхийн ажиглагчийн гарын авлага. Азийн сан, АНУ-ын ОУХА-ийн Шүүх эрх мэдлийн шинэтгэл төсөл, Отгонтэнгэр Их сургуулийн хамтарсан хөтөлбөр. УБ. 2005 он. / ОТИС-ийн архив/



хуралдаанд ажиглалт хийснээрээ нэлээд онцлогтой юм. Дэлхийн улс орнуудад хийсэн шүүхийн ажиглалтууд ихэвчлэн “эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх процессын хувьд гарах шийдвэр нь хувь хүнийг гэм буруутай гэж үзэн үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарлах нөхцөл байдал үүсдэг тул олон улсад эрүүгийн шүүх хуралд түлхүү ажиглалт хийдэг¹⁰²” нийтлэгээс жишигт баригдалгүйгээр захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралдааныг бид сонгон ажигласан болно.

Захиргааны хэрэг маргааныг анхан шатны шүүх хуралдаанаар иргэн, хуулийн этгээдээс гаргасан нэхэмжлэлд үндэслэн захиргааны байгууллага, албан тушаалтны гаргасан актын талаар нотлох баримтыг цуглуулан шинжлэн судалж, үнэлэн хэргийн шинж байдлыг бодитойгоор тогтоож хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны гол үр дүн болсон шүүхийн шийдвэр гаргадаг.

Захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралдааны ажиглалтыг -шүүх хуралдааны тухай ерөнхий мэдээлэл, -шүүх хуралдаанд оролцогчдын ирц, -шүүх хуралдааны нээлттэй байдал, - хараат бус, шударга шүүхээр шүүлгэх эрхийн хэрэгжилт -нотлох баримт гаргах, үнэлүүлэх эрхийн хэрэгжилт, талуудын тэгш байдлыг хангах, -хэлмэрч, орчуулагч авах эрх, -шүүхийн шийдвэр, шүүхийн нөхцөл байдал болон шүүгч, шүүхийн ажилтнуудын харилцаа, -ажиглагчийн зүгээс анхаарал татсан асуудал зэрэгт анхааран ажиглалт хийсэн болно.

Бидний ажиглалт анхан шатны шүүхээс хэрэг маргааныг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэх үеийг хамарсан бөгөөд тайлангаа нэгтгэж байх явцад анхан шатны шүүх хуралдаантай холбоотой хэд хэдэн тулгамдсан асуудлын талаар мэдээлэл цуглуулсан бөгөөд тэдгээрийн нэг нь шүүхийн хэргийн хөдөлгөөний менежментийн нэлээд чухал хэсэгт тооцогддог шүүх хуралдаанд бэлтгэх, шүүх хуралдаан явуулах ажиллагааны практикт шүүх хуралдааны товтой холбоотой шийдвэрлэх ёстой асуудлыг энэ удаа авч үзэж байна.

Английн улс төрийн зүтгэлтэн Вильям Глэдстоун нэгэнтээ “шүүх хуралдааныг хойшлуулах нь шударга ёсыг тогтоохоос татгалзаж буй хэрэг юм” гэсэн байдаг ч хүний амьдрал, нийгмийн харилцаа өөрөө баялаг учир шалтгааны гинжин холбоотой учраас хуульд заасан үндэслэл журмын дагуу нэгэнт товлогдсон шүүх хуралдаанууд хойшлох явдал байна.

¹⁰² Туяа Н., Бадамрагчаа П нар. “Шүүх хуралдааны ажиглалт” судалгааны нэгдсэн тайлан. УБ. 2015 он. х.6

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 49 дүгээр зүйл¹⁰³д заасны дагуу захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэхэд хангалттай нотлох баримт цугларсан гэж үзсэн, эсхүл энэ хуулийн 47.1-д заасан хугацаа дууссан, түүнчлэн шаардлагатай бусад тохиолдолд шүүгч захирамж гаргаж, шүүх хуралдааныг хэзээ, хаана болохыг товлон зарлана гэсэн хуулийн зохицуулалтай.

Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны 240 шүүх хуралдаанд хийсэн ажиглалтаар 49 шүүх хуралдаан буюу 20,4 хувь нь анх тов зарласан өдрөө явагдсан бол харин 191 шүүх хуралдаан буюу 79,6 хувь нь анхны товд заасан өдрөөс хойшилж хуралдсан байлаа. Анхан шатны шүүх хуралдааны дийлэнх нь анхны тов зарласан өдрөө хуралдаагүй байна.

Мөн шүүх хуралдаан товлосон цагтаа эхэлж байгаа эсэхэд ажиглалт хийхэд дараах үзүүлэлт гарлаа. Үүнд:

Шүүх хуралдаан эхлэлгүй хүлээлгэсэн хугацаа	Шүүх хуралдааны тоо -240
30 минут хүртэл	125 буюу 52,1 хувь
30-60 минут	42 буюу 17,5 хувь
1 цагаас 2 цаг	14 буюу 5,8 хувь
2-оос дээш цаг	3 буюу 1,3 хувь
Товлосон цагтаа эхэлсэн	51 буюу 21,3 хувь
Тов дээр хуралдаан эхлэх цагийг бичээгүй	5 буюу 2 хувь

Ийнхүү товлосон цагтаа эхлээгүй шүүх хуралдаануудад нөлөөлсөн хүчин зүйлийг ажиглалтын явцад тогтоохыг зорьсон бөгөөд эдгээрийн голлох шалтгааныг авч үзвэл:

- 75 шүүх хуралдаан буюу 40 хувь нь шүүх хуралдааны танхим хүрэлцээгүй шалтгаанаар
- 49 шүүх хуралдаан буюу 26 хувь нь шүүгч хуралдаанд хоцорч ирсэн шалтгаанаар
- 48 шүүх хуралдаан буюу 25 хувь нь хэргийн болон бусад оролцогчид шүүх хуралдааны товлосон цагаас хоцорч ирсэн шалтгаанаар
- 5 шүүх хуралдаан буюу 3 хувь нь шүүх хуралдааны танхимын техник хэрэгслийн ажиллагааны хэвийн бус байдлаас
- 12 шүүх хуралдаан буюу 6 хувь нь бусад шалтгаанаас болж тус тус хоцорч эхэлсэн байна.

Монгол Улсын Шүүхийн тухай хуульд ¹⁰³Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. 2002 он



зааснаар шүүх хуралдааны танхим нь шүүхийн үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй, ил тод байх^[104]-ын илэрхийлэл, шүүхийн зохион байгуулалтын баталгаа^[105] болно. Бидний хийсэн ажиглалтаар 240 шүүх хуралдааны 75 буюу 40 хувь нь танхимын хүрэлцээгүй байдалтай, 5 буюу 3 хувь нь шүүх хуралдааны танхимын техник хэрэгслийн үйл ажиллагаатай шууд холбоотойгоор товлосон цагтаа эхлээгүй нь Шүүхийн тухай хуулийн холбогдох заалтын практик хэрэгжилт хангалттай биш байна гэж дүгнэж болохоор байна.

Өнөөгийн нөхцөл байдалд шүүхүүд шүүх хуралдааны хангалттай тооны танхимгүй байгаа ч гэлээ шүүх хуралдааныг танхимынхаа тоонд тохируулан явуулах “нэгэнт тогтоосон хуралдааны товыг хатуу мөрдөж ажиллах” нь шүүхийн хэргийн хөдөлгөөний менежментийн нэг хэсэг болно.

Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 240 шүүх хуралдааны хувьд 75 шүүх хуралдаан хойшлолгүй хуралдаж үлдсэн 165 шүүх хуралдаан хойшилсон байна. Шүүх хуралдаан хойшилсон шалтгааныг авч үзэхэд хуульд заасан нийтлэг үндэслэлүүд байхаас гадна 5 шүүх хуралдааны шүүгч нь “хурал давхцсан” гэснээр хойшилсон байна.

Ажиглалт хийсэн нийт шүүх хуралдааны бараг 5/1 нь товлосон хугацаанаасаа хойшилж хуралдсан, энэ байдалд тухайн хэрэг маргааны нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд, тэдгээрийн өмгөөлөгч, төлөөлөгч зэрэг хэргийн оролцогчид маш бухимдалтай хандаж байлаа. Тэдгээр оролцогчдын хувьд товлосон шүүх хуралдаан хойшилсноос болж үүсч байгаа сөрөг үр дагавруудыг эдийн засгийн болон эдийн засгийн бус гэж хувааж үзсэн болно. Ингээд хэргийн оролцогчдод шүүх хуралдаан товлосон хугацаанаасаа хойшлоход хэргийн оролцогчдын хувьд шүүх хуралдаанд оролцохоос бусад төлөвлөгдсөн ажлууд тасалдах, хойшлох, зогсох, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдон гарах бусад зардлууд шүүх хуралдаан хойшилсон хоногийн хэмжээгээр өсөх, шүүх, шүүгчийн хувьд ажлын ачаалал өсөх, хэрэг хянан шийдвэрлэх ажлын цаг, хугацаа нэмэгдэх зэрэг сөрөг үр дагаврууд бий болж байна. Харин эдийн засгийн бус хэлбэрийн гэж үзэж болохоор хэргийн оролцогчдын хооронд үл ойлголцол бий болох, шүүх, шүүгчтэй хамаатуулан бие биенээ хардах, шүүхийн

үйл ажиллагаанд итгэхгүй болох, шүүхэд итгэл алдрах, нөгөө талаас шүүгч хуульд заасан хугацаанд хэргийг шийдвэрлэх боломжгүй болох, улмаар хууль зөрчихөд хүргэх сөрөг байдлууд бий болж байна.

Шүүхийн шинэтгэлийн багц хуулиудын үйлчлэлийн хүрээнд “шүүхийн эдийн засаг” хэмээх ойлголтыг хуульчилсан бөгөөд энэ нь шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах Шүүхийн Ерөнхий зөвлөлийн чиг үүрэгт хамаарч байгаа. Бидний хувьд “шүүхийн эдийн засаг” хэмээх ойлголтыг агуулгын хувьд нэг талаас шүүх, шүүгчийн үйл ажиллагаатай холбон үзэхийн зэрэгцээ нөгөө талаас хэргийн оролцогчдын хувьд үүсэн гарах эдийн засгийн зардлуудыг багтаан өргөн хүрээгээр авч үзэж дээрхи ангилалтыг хийсэн болно.

Хэргийн хөдөлгөөний менежментийн онолоор бол “шүүх нь стратегийн зорилт, зорилгодоо хамгийн сайн нийцэх дотоодын болон гадны үйлчлүүлэгчдийн хэрэгцээг ханган^[106] ажиллах ёстой. Шүүхийн шинэтгэлийн гол оролцогч нь шүүгч бөгөөд шүүгчийн манлайлал, хариуцлага, ажил хэрэгч хандлагаас нийгмийн шударга ёсны хөгжил зохих хэмжээгээр хамаарч байна.

Шүүх хуралдаан товлосон хугацаанаасаа хойшлох нь шүүхэд хэрэг маргааныг удаашруулалгүй, цаг хугацааны хувьд бусдыг хохироолгүйгээр хэрэг хянан шийдвэрлэх бүхий л процесс ажиллагааг хуульд заасан арга, журмын, стандартын дагуу шийдвэрлэх хэргийн хөдөлгөөний менежментийг зөрчиж буй хэлбэр болно.

Шүүхийн практик нэлээд шүүх хуралдааныг хойшлуулах нь түгээмэл болох хандлагатай байгаад хэргийн оролцогчдоос товлосон шүүх хуралдааныг хүлээн өнгөрүүлсэн цаг хугацааг эдийн засгийн агуулгаар хэрхэн яаж үнэлэх арга, аргачлалыг шүүхийн менежментийн практикт нэвтрүүлэх шаардлагатай байгааг харуулж байна. Мөн шүүх хуралдаан товлосон цагтаа л эхэлж байх эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгосноор шүүх, шүүгчийн ачаалал багасах нэг арга зам болох юм.

Ийнхүү манай улсын шүүх эрх мэдлийн шинэтгэлийн үйл явцад олон улсын хэмжээнд өргөн хэрэглэгдэж хүлээн зөвшөөрөгдсөн шүүхийн ажиглалтын арга зүйг өөрийн нөхцөлд тохируулан боловсруулсан арга зүй бий болж, туршилтын ажил ч амжилттай болж, улмаар шүүхийн мониторинг, ажиглалтын үйл ажиллагааны үндэсний стандарттай болох эхлэл бий болж, шүүхийн

¹⁰⁴ www.legalinfo.mn. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь заалт.

¹⁰⁵ www.legalinfo.mn. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 29 дүгээр зүйл.

¹⁰⁶ Шүүхийн судалгаа, мэдээллийн төв. Хэргийн хөдөлгөөний менежмент. УБ.2013 он. х.21



ажиглалтыг тогтмол, үр нөлөөтэй явуулах боломж бүрдсэн.

Хууль зүйн клиник сургалтын практикт “шүүхийг ажиглах” сургалтын аргыг туршин хэрэгжүүлснээр оюутанд нэг талаас танхимд олж авсан материаллаг болон процессын эрх зүйн мэдлэгээ баяжуулах, хууль хэрэглээний ур чадварыг практикаас олж авах, шүүх хуралдааны явцад хэргийн оролцогчдоос хийж буй хууль хэрэглээний гарц, гаргалгаа, шийдлийг мэдэж авах гээд сургалтын хувьд ач холбогдолтой, нөгөө талаас шүүх хуралдааны талаарх эрх зүйн хэм хэмжээ, стандартын хэрэгжилтэд мониторинг хийх чадварт суралцах, практикт шүүхийн нээлттэй байдал хэрхэн хангагдаж байгаад ирээдүйн хуульчийн хувьд үнэлгээ өгөх, шүүхийн үзүүлж буй шударга ёсны үйлчилгээг сайжруулах арга замыг мэргэжилтний хувьд тодорхойлох, байр сууриа илэрхийлэх зэрэг олон давуу талтай байлаа. Шүүх хуулийн хүрээнд бие даан шударгаар ажиллахад учирч байгаа бэрхшээлүүдийг тодорхойлох, шүүхийн ажиглагчаар ажилласан хуулийн сургуулийн оюутнуудад мэргэжлийн болон

ёс зүйн зөв хандлага төлөвших зэрэг мэдлэг, ур чадварт суралцсан.

Шүүхийн ажиглалтын хөндлөнгийн судалгаа, мониторингийн тайлан, мэдээ, мэдээлэл нь иргэд, олон нийт, судлаачдад шүүхийн үйл ажиллагаа, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх “шударга ёс тогтоох үйл явцыг ард иргэд харж мэдрэх”-д чухал нөлөө үзүүлнэ.

Энэхүү өгүүллээр дэвшүүлж байгаа асуудал нь 2016 оны 7 сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж буй “Захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”-ийн хэрэгжилт, практикт дүгнэлт өгөөгүй бөгөөд цаашдын судалгаагаар харьцуулан үзэх боломжтой юм. Мөн хуулиар анхан шатны шүүх хуралдаанаас өмнө шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийх хуулийн зохицуулалт хэрэгжиж эхэлснээр хэргийн хөдөлгөөний менежментэд эерэг үр дагавар гарч, шүүх хуралдаан хойшлох явдал багассан гэдэгт итгэлтэй байна.

ХЭРГИЙН ГАЗРЫН ҮЗЛЭГИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

*Х.Бат-Эрдэнэ
ХСИС-ийн 811 дүгээр дамжааны
суралцагч, магистрант*

Товч утга: Монгол Улсад 2016 оны эхний 9 сарын байдлаар 23080 гэмт хэрэг бүртгэгдсэн ба эдгээр хэргүүдийн 30 гаруй хувь нь нууц, далд аргаар үйлдэгдсэн бөгөөд хулгай, хүн амины гэмт хэргүүд зонхилох хувийг эзэлж байна.^[107] Эдгээр нууц далд аргаар үйлдэгдсэн гэмт хэрэг төдийгүй нийт гарсан гэмт хэргийг илрүүлэх, шийдвэрлэхэд хэргийн газрын үзлэгийг түргэн шуурхай, чанартай хийж гүйцэтгэхийн тулд баг, бүрэлдэхүүнийг зөв удирдан, зохион байгуулах шаардлага зүй ёсоор урган гардаг.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар хэргийн газрын үзлэгийг удирдан зохион байгуулах эрх бүхий субъектыг зааж өгсөн ч практикт энэ байдал төдийлөн биелэлээ олохгүй байна. Хэргийн газрын үзлэгийг ямар байгууллага, түүний эрх бүхий албан тушаалтан, хэрхэн зохион байгуулах, хэн

¹⁰⁷ http://mongolianforensics.blogspot.com/2015/01/blog-post_35.html

ямар үүрэгтэй оролцох талаар нарийн тусгасан онолын ойлголт төдийгүй эрх зүйн зохицуулалт дутагдалтай.

Энэхүү судалгааны ажлаар гэмт хэрэг илрүүлэхэд ихээхэн ач холбогдолтой хэргийн газрын үзлэгийг ямар шинжлэх ухааны үндсэн дээр, хэн, хэрхэн удирдан, зохион байгуулах, хамтын ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг онол, эрх зүй, практик туршлага дээр үндэслэн судалж, түүнийг шийдвэрлэх арга замыг эрэн хайхыг зорилго.

Түлхүүр үгс: Хэргийн газрын үзлэг, удирдлага, зохион байгуулалт, хэргийн газрын үзлэгийн баг, жижүүрийн шуурхай бүрэлдэхүүн, криминалистик, хэргийн газрын үзлэгийн менежмент.

Удиртгал

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хэргийн газарт үзлэг хийх тухай ойлголт, хэргийн газрын үзлэгт шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээч, мэргэжилтний оролцоо, тэдгээрийн эрх, үүрэг, удирдлага зохион байгуулалтын өнөөгийн байдал, хэргийн газрын үзлэгт шүүх шинжилгээний багийг оролцуулах, эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудлыг менежментийн шинжлэх ухааны



үүднээс судлах бөгөөд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга замыг эрж хайж тодорхойлох явдал юм. Ингэснээр хэргийн газрын үзлэг хийхийн ач холбогдол болон түүнд оролцогчдийн эрх, үүрэг тодорхой болох бөгөөд хэргийн газрын үзлэг хийх баг, бүрэлдэхүүний удирдлага, зохион байгуулалтын онолын ойлголт бий болж хэргийн газрын үзлэг хийхэд практик ач холбогдолтой.

Хэргийн газрын үзлэгийн тухай онолын ойлголтыг Криминалистикийн шинжлэх ухааны ном сурах бичигт тодорхой тусгасан байдаг. Жишээ нь, Ж. Хурцгэрэл “Криминалистик 1, 2”, Б. Жаргалсайхан “Учралын газрын үзлэг”, Б. Лхагвасүрэн “Мөр”, “Гэмт үйлдлийн мөр”, Т. Очирбат “Хэргийн газрын үзлэг”, Мөрдөн байцаах газраас орчуулсан “Хэргийн газрын үзлэгийн үндэс” орчуулгын бүтээл зэрэг ном сурах бичиг байна.

Хэргийн газрын үзлэгийн тактик ажиллагааг криминалистикийн тактикаар судалдаг ба хэргийн газрын үзлэгийн удирдлага, зохион байгуулалт, хамтын ажиллагааны чиглэлээр Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Шинжилгээний бүртгэл мэдээллийн хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа, Хууль сахиулахын их сургуулийн докторант Т.Очирбат “Хэргийн газрын үзлэг буюу хэргийн газарт хийх мөрдлөгийн цогц ажиллагааг бий болгох асуудал” сэдэвт эрдэм шинжилгээ судалгааны ажил хийжээ. Энэхүү судалгааны ажилд хэргийн газрын үзлэг хийхэд тулгамдаж буй асуудлыг эрх зүйн зохицуулалт, бүтэц зохион байгуулалт, техник технологийн инноваци, сургалт хүний нөөцийн асуудал гэсэн бүлгүүдэд хуваан судалжээ. Судалгааны ажлаар “Хэргийн газрын үзлэгийг “Хэргийн газрын үзлэгийн мөрдлөг” гэж томъёолох, онолын хувьд “хүний биед хийх үзлэг”, “эд зүйлд хийх үзлэг” зэргээс салгаж тусад нь томъёолох, Цагдаагийн байгууллагын мөрдөн байцаагч, хэсгийн төлөөлөгч нарт хэргийн газрын мөрдлөгийн бүхий л ажиллагааг хийдэг эрх, үүргийг нь ойлгуулж ажиллуулах, өөрөөр хэлбэл сэтгэхүйн шинэчлэл хийх, Хэргийн газрын мөрдлөгийн үед ажиллах тэмдэглэл хөтлөгч, гэрэл зурагчин, ул мөр цуглуулах чиг үүрэг бүхий орон тоог бий болгох...” зэрэг дүгнэлтүүдийг өгчээ.

Хэргийн газрын үзлэг хийгдэж буй өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх зорилгоор Нийслэлийн хамгийн их гэмт хэргийн дуудлага, мэдээлэл ихтэй /2016 оны 10 сарын байдлаар Улсын хэмжээнд

23080 гэмт хэрэг бүртгэгдсэнээс Нийслэлд 15257 гэмт хэрэг бүртгэгдсэн нь нийт гэмт хэргийн 66.1%-ийг эзлэж байна. Харин Нийслэлийн Сонгино хайрхан дүүрэгт 2440, Баянзүрх дүүрэгт 3519 гэмт хэрэг бүртгэгдсэн нь Нийслэлийн хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэргийн нийт гэмт 39%-ийг эзэлж байна.^[108] /Нийслэл болон хөдөө орон нутгийн хэргийн газрын үзлэг хийх баг бүрэлдэхүүн, үзлэг хийгдэж буй байдалд ажиглалт, ярилцлагын аргаар мөрдөн байцаагч, шинжээч, мэргэжилтэн нараас судалгаа авч статистик тоо баримт, мэдээ, онолын үзэл баримтлал, эрх зүйн актуудад дүн шинжилгээ хийв.

Хэргийн газрын үзлэг

Хэрэг учрал болсон газарт үзлэг хийх нь гэмт хэргийг түргэн шуурхай ирүүлэх, гэмт үйлдлийн мөрийг илрүүлэх, бэхжүүлэх, түүнд криминалистик, хими, физик, биологи, шүүх эмнэлэг, шүүх нягтлан бодох бүртгэлийн шинжилгээ хийж гэмт этгээдийн үйлдлийг нотлон тогтооход ихээхэн ач холбогдолтой юм.

Үзлэг гэдэг нь “1. Биеийн эрүүл мэндийг шинжлэх нь, 2. Үзэж шалгах нь, 3. Далд юмыг бэлгэдэх бэлгэдэл, мэргэ төлгө.”^[109] гэсэн утгуудыг илэрхийлэх ба үзлэг хэмээх үгийн нийтлэг шинж нь аливаа зүйлсийг үзэж шалгах, шинжлэн судлах гэсэн агуулгыг илэрхийлж байна.

Хууль зүйн шинжлэх ухаан болон шинжлэн магадлахуйн ухаанд үзлэг, түүний төрөл, ойлголтыг ерөнхийлөн судалж тодорхойлсон байдаг. Заримаас дурдвал “Үзлэгийг гэмт хэргийн ул мөр илрүүлэх, гэмт хэрэг гарсан байдал ба гэмт хэрэгт ач холбогдол бүхий бусад байдлуудыг тодруулах зорилгоор гэмт хэрэг гарсан газарт, эд зүйл, баримт бичигт үзлэг хийнэ.”^[110] Мөн мөрдөн байцаалтын үзлэг ч гэж нэрлэдэг. “Мөрдөн байцаалтын үзлэг гэдэг нь гэмт хэргийн ул мөр, эд мөрийн бусад баримтыг олох, гэмт хэрэг гарсан байдал, гэмт хэрэгт ач холбогдол бүхий бусад байдлуудыг тодруулах зорилгоор мөрдөн байцаагчаас явуулж буй ажиллагаа юм.”^[111] Доктор Ж. Хурцгэрэл “Үзлэг нь эрүүгийн хэрэгт ач холбогдолтой төрөл бүрийн материаллаг объект, түүн

¹⁰⁸https://www.police.gov.mn/media/Statistic_medee/2016_10_sar_medee/2016.10_burtgegsden_gemt_hereg.pdf

¹⁰⁹ <http://Mongoltoli.mn>.

¹¹⁰ Б.Бат-Эрдэнэ., Монгол улсын эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй /альбом схем/, 2009 он., Улаанбаатар., 93 дах тал.

¹¹¹ Б.Баяр., Г.Ганбаатар., Б.Жаргалсайхан., Б.Лхагвасүрэн., Д.Мөрөн., Т.Очирбат., Т.Оюунчимэг., Ж.Өнгөтхүү., Л.Цогтбаяр., М.Чинбат., Гэмт хэрэг илрүүлэхүй., Улаанбаатар., 2015 он., 256 дах тал.



дээрх мөр, түүний шинж тэмдэг, шинж, байдал, өөр хоорондын байрлалыг шууд илрүүлэх, бэхжүүлэх, шинжлэх ажиллагаа юм.^[112] гэж үзлэг, түүний зорилго, агуулга, мөн чанарыг тодорхойлжээ.

Дээрх судлаачдын тодорхойлолтыг авч үзвэл дараах нийтлэг шинж байдал илэрч байна. Үүнд:

1. Аливаа зүйлийн шинж байдлыг тогтоох,
2. Ямарваа нэгэн эд зүйл, газар, оронд үзлэгийг хийх,
3. Мөр илрүүлж, бэхжүүлэх,
4. Гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал, илрүүлж бэхжүүлсэн мөрийг шинжлэх ажиллагаа гэсэн ерөнхий нийтлэг шинж тогтоогдож байна.

Иймд үзлэгийг гэмт хэрэгт ач холбогдолтой ямарваа нэгэн зүйлийн шинж байдлыг тогтоох зорилгоор хэрэгт ач холбогдол бүхий эд зүйл, газар орноос мөр илрүүлж бэхжүүлэх, шинжлэн судлах ажиллагаа гэж тодорхойлж болохоор байна.

Үзлэгийг дараах байдлаар ангилдаг.

Объектоор нь:

- Хэргийн газар
- Цогцос
- Хүн
- Эд зүйл
- Бичиг баримт
- Мал, амьтанд гэх мэт

Хэмжээгээр нь:

- Үндсэн
- Нэмэгдэл

Дарааллаар /хугацаа/ нь:

- Анхны
- Дахин^[113] /практикт нөхөн үзлэг гэж нэрлэх нь бий./

Цагдаа, шүүхийн шинжилгээний байгууллагын алба хаагчид /жижүүрийн шуурхай бүрэлдэхүүн/ гэмт хэргийн тухай мэдээлэл хүлээн авмагц үйл явдал өрнөсөн газарт очиж үзлэг хийдэг. Үүнийг эрдэмтэн, судлаачид өөр өөрөөр нэрлэх нь бий. Жишээ нь “Учралын газар”, “Хэргийн газар” гэх мэт.

Хэргийн газар гэдэг нь бодит явдал эхэлсэн, өрнөсөн, төгссөн орон зай, түүнийг хүрээлэн буй орчныг хэлнэ.^[114] Хэргийн газрын үзлэгийг хууль, эрх зүйн актад нарийн тусгаж тодорхойлсон тодорхойлолт байхгүй байна. Харин криминалистикийн шинжлэх ухааны ном, сурах бичигт онолын хүрээнд судалж тодорхойлсон нь бий.

¹¹² Ж. Хурцгэрэл., Криминалистик-2., Улаанбаатар., 2004 он., 116 дахь тал.

¹¹³ Б. Лхагвасүрэн., Мөр., Улаанбаатар., 2011 он., 45 дах тал.

¹¹⁴ Б. Лхагвасүрэн., Мөр., Улаанбаатар., 2011 он., 46 дах тал.

Криминалист эрдэмтэн Ж. Хурцгэрэл: “Хэрэгт ач холбогдолтой бодит баримт цуглуулж, нэгтгэсэн дүгнэлт хийх зорилгоор, учрал болсон материаллаг байдал, үйл явдлын механизм, гэмт хэрэг, гэмт хэрэгтний мөр, бусад объект илрүүлэх, шинжлэх, бэхжүүлэхэд чиглэсэн мөрдөн байцаах хойшлуулшгүй ажиллагааг учрал болсон газар хийх үзлэг гэнэ.”^[115], хууль зүйн доктор Т.Оюунчимэг: “Хэргийн газрын үзлэг хийх нь шалгаж буй үйл явдалд гэмт хэргийн шинж тэмдэг байгаа эсэх, байгаа нь нотлогдвол зохих байдлууд гэмт этгээдийн тухай тодорхой төсөөлөл авах зорилгоор мөрдөн байцаагчаас хийдэг ажиллагааг хэлнэ.”^[116], хууль зүйн доктор Б. Жаргалсайхан: “Учралын газрын үзлэг бол Монгол улсын ЭБШХ-д заасан, мөрдөн байцаалтын хойшлуулшгүй ажиллагаа бөгөөд зорилго нь: болж өнгөрсөн явдал, гэмт этгээд, гэмт үйлдлийн сэдэлт болон гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулж тогтоовол зохих бусад зүйлийг тодруулахаар, учрал болсон газарт буй материаллаг объектуудын байгаа төлөв, мөн чанарыг биечлэн мэдэрч, онцлог шинжийг илрүүлэх, бэхжүүлэх, шинжлэн судалж ашиглахад оршино.”^[117], хууль зүйн ухааны магистр Б. Лхагвасүрэн: “Хэргийн газрын үзлэг гэдэг нь хэрэг болсон орон зай, орчноос гэмт үйлдлийн мөр цуглуулах, гэмт үйл, гэмт этгээдийг оношлох зорилгоор хуульд заасан үндэслэл, журмын дагуу мөрдөгчийн хийж буй криминалистик ажиллагаа мөн”^[118] гэж хэргийн газрын үзлэг, зорилгыг тодорхойлсон байна.

Дээрх тодорхойлолтуудаас хэргийн газрын үзлэгийн мөн чанар, агуулга, зорилго тодорхой харагдах буй за.

Хэргийн газарт үзлэг хийх нь гэмт хэргийн улмаас үүссэн гэмт үйлдлийн мөр^[119] илрүүлэх, бэхжүүлэх, гэмт хэрэг гарсан байдал, хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлыг тогтоох, гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдлыг сэргээн тогтооход чухал үүргийг гүйцэтгээд зогсохгүй хэргийн хувь заяаг шийдэх тохиолдол ч бий. Иймд хэргийн газрын үзлэгийн удирдлага, зохион байгуулалтын онолын ойлголтыг бий болгох, түүнд оролцогчдын эрх

¹¹⁵ Ж. Хурцгэрэл., Криминалистик-2., Улаанбаатар., 2004 он., 116 дах тал.

¹¹⁶ Т. Оюунчимэг ... нар., Криминалистик тактик., Улаанбаатар., 2003 он., 32 дах тал.

¹¹⁷ Б. Жаргалсайхан., Учралын газрын үзлэг., Улаанбаатар., 2008 он., 8 дах тал.

¹¹⁸ Б. Лхагвасүрэн., Мөр., Улаанбаатар., 2011., Улаанбаатар., 47 дах тал.

¹¹⁹ Гэмт үйлдлийн улмаас бий болсон бүх өөрчлөлт, хөдөлгөөн.



үүргийг тодорхой болгох, хэргийн газрын үзлэгт шүүх шинжилгээний баг оролцохын ач холбогдлыг тодорхойлох эрдэм шинжилгээний бүтээл, судалгааны ажил хийгдэх зайлшгүй шаардлага бий болж байна.

Хэргийн газрын үзлэгийн үр дүн нь мөрдөн байцаагч, шинжээч, мэргэжилтэнд цаашдын хийх ажиллагааны чиглэлийг зөв тодорхойлох, тухайн үйл явдлын механизм, гэмт этгээдийн талаар зарим нэг төсөөлөлтэй болоход тус дөхөм үзүүлдэг ба ихэнх тохиолдолд хэргийн газрын үзлэгийн чанараас мөрдөн байцаалтын ажлын амжилт шууд шалтгаалдаг онцлогтой. Энэ нь хэргийн газрын үзлэгийн ач холбогдол юм.

Хэргийн газарт үзлэг хийх нь нарийн тогтсон криминалистикийн техник, тактикийн хосолсон дэс дарааллаар хийгдэх учиртай. Үүгээр хэргийн газрын үзлэгийн чанар тодорхойлогдоно.

Хэргийн газрын үзлэгээр хийгдэх ажиллагаа нь маш өргөн хүрээг хамрах учир хэргийн газарт үзлэг хийхэд тулгамдаж буй асуудлуудыг хөндөн авч үзье.

Хэргийн газарт үзлэг хийх эрх зүйн зохицуулалтад хийсэн судалгаа

Хэргийн газрын үзлэг хийхэд шаардлагатай холбогдох хууль, журамд заасан зүйл заалтуудад судалгаа хийв.

Хэргийн газарт үзлэг хийх, мөр илрүүлж бэхжүүлэх, цуглуулах ажиллагааг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 126 дугаар зүйлийн 1-д заасан “Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч гэмт хэрэг гарсан байдал, хэргийн ул мөр, эд мөрийн баримтыг олох, гэмт хэрэгт ач холбогдол бүхий байдлыг тодруулах зорилгоор хэрэг гарсан газар болон бусад эд зүйл, баримт бичигт үзлэг хийнэ” гэсэн үндэслэлээр хийдэг. Мөн зүйлийн 2-т зааснаар мөрдөн байцаалтын үзлэгийг “Хойшлуулшгүй тохиолдолд эрүүгийн хэрэг үүсэхээс өмнө” хийж болно. Хэргийн газрын үзлэгийг хийхдээ мэргэжилтэнг оролцуулах талаар уг хуулийн 127 дугаар зүйлийн 127.5-д зааснаар “Үзлэг хийхэд уг хэрэгт хувийн сонирхолгүй мэргэжилтэнг урьж оролцуулж болно.” гэж мөн Шүүхийн шинжилгээний тухай хуулийн Тавдугаар бүлэг: Шүүхийн шинжилгээний байгууллага, түүний тогтолцоо, шинжилгээний байгууллагын ажилтны эрх зүйн байдал. 37 дугаар зүйлийн 37.1-д “Шүүхийн шинжилгээний байгууллага нь эрүү, иргэн захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан

шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтыг илрүүлж, бэхжүүлж авах, ул мөр, эд мөрийн баримтад үзлэг, шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий төрийн байгууллага мөн.” гэж тус тус заажээ. Ингэснээр хэргийн газрын үзлэг болон ямар нэгэн эд зүйлд үзлэг хийхэд мэргэжилтэн оролцуулах эрх зүйн үндэслэл бий болж байна. Гэхдээ гол удирдлага болгож буй Эрүүгийн байцаан шийтгэх хууль, шүүхийн шинжилгээний тухай хуульд “мэргэжилтэн” гэх ойлголтыг тодорхойлоогүй байгаа учир хэргийн газрын үзлэгт оролцох мэргэжилтний эрх, үүрэг тодорхойгүй байна.

Дээрх хуулийн заалтыг үндэслэн Цагдаагийн ерөнхий газрын дарга, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын хамтарсан 73/102 дугаар тушаалаар батлагдсан “Хамтран ажиллах журам”, а/278, 385 дугаар тушаалаар батлагдсан Хэргийн газрын үзлэгт хамтран ажиллах журам, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын а/474 дугаар тушаалаар батлагдсан Онц хүнд гэмт хэргийн газрын үзлэг багаар ажиллах журам зэрэг эрх зүйн актуудаар зохицуулагдаж байна.

Дээрх эрх зүйн актууд нь хэргийн газрыг үзлэгийг хэн, хэрхэн зохион байгуулж ямар ажиллагаа хийж гүйцэтгэхийг ерөнхийлөн зохицуулсан байдаг ба практикт хэргийн газрын үзлэг хийх явцад үүсдэг нарийн төвөгтэй үйл ажиллагаануудыг /гэмт хэргийн талаарх дуудлага, мэдээллийг шинжээч, мэргэжилтэнд дутуу мэдээллэх, цаг хугацааг хожимдуулж өгөх, хэргийн газрын үзлэгт очих, хэргийн газрын үзлэгийн хэмжилт, илрүүлж, бэхжүүлсэн мөрийг эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэн өгөх гэх мэт./ хийж гүйцэтгэх, зохион байгуулах, хамтын ажиллагаа, алба хаагчдын үүрэг, хариуцлагыг бүрэн дүүрэн зохицуулж байна гэвэл бас үгүй юм. Эдгээр асуудлуудыг эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулаагүйн дээр алба хаагчдын үүрэг, хариуцлагаа хэрхэн ухамсарласан байдал, хоорондын харилцаа, мэдлэг ур чадвараас ихээхэн хамааралтай байгаа нь практикаас харагдаж байдаг.

Хэргийн газрын үзлэгт оролцогчдын эрх, үүрэг, тодорхой бус байдлаас дараах зөрчил судалгаа хийх явцад гарч байна. Жишээ нь: Зам тээврийн хэргийн газрын үзлэгт схем зураг хэн үйлдэх, хэмжилтийг хэн хийх зэрэг үл ойлголцол байдаг боловч эдгээр асуудлыг оролцогчид харилцан тохиролцох, тогтсон заншлаар ажил үүргийг гүйцэтгэж байна.



Хэдий хуулинд үзлэгийг хэрэг бүртгэгч мөрдөн байцаагч үзлэг хийнэ гэдэг боловч бодит байдал дээр хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдлыг бичиж тэмдэглэдэг, шинжээч, мэргэжилтэн мөр илрүүлж бэхжүүлдэг, гэрэл зураг авдаг ажил хийж байгаа нь хэргийн газрын үзлэг хийж буй бүрэлдэхүүнд ажиглагдаж байна. Мөн чанартаа хуулиа баримталбал хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар үзлэгийг хийнэ. Шаардлагатай бол мэргэжилтэн оролцуулж болно гэж заасан байдаг. Энэ нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч үзлэг хийж тэмдэглэлээ бичиж, гэрэл зураг авч, мөр илрүүлж бэхжүүлэх, цуглуулах чадвартай байх ёстой санааг илтгэнэ. Гэвч өнөө үед гэрэл зураг авахад тусгай мэдлэг шаардлагагүй болжээ. Учир нь бидний хэрэглээ болох гар утас бүр мэргэжлийн гэрэл зургаас дутахааргүй зураг авдаг, дэлгэмэл зураг авах, макро зураг авах зэрэг нэмэлт функцүүдтэй болж тэр бүр мэргэжилтэн оролцуулах шаардлагагүй болжээ.

Хэргийн газарт үзлэг хийх бүрэлдэхүүний бүтэц, зохион байгуулалтын өнөөгийн байдал.

Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн цагдаагийн жижүүрийн шуурхай бүрэлдэхүүн нь мөрдөн байцаагч, эрүүгийн төлөөлөгч, нохойн төлөөлөгч, шинжээч гэсэн ерөнхий бүрэлдэхүүнтэйгээр үзлэгийг хийж байна.

Хэргийн газарт үзлэг хийх нь тодорхой баг, бүрэлдэхүүн бүхий эрх бүхий албан тушаалтнуудын зорилгодоо хүрэх үйл ажиллагаа юм.

Аливаа зорилгодоо хүрэх үйл ажиллагаа нь төлөвлөлт, удирдлага, зохион байгуулалт, хяналт үнэлгээ гэсэн үе шаттай арга хэмжээг хэрэгжүүлж байж зорилгодоо хүрэх ба үүнийг менежментийн ухаанаар судалдаг. Үүнээс үзвэл хэргийн газрын үзлэгийн менежмент гэсэн ойлголт урган гарч ирж байна.

Хэргийн газрын үзлэгийн тухай дээр тодорхой хэмжээнд дурдсан учир энэхүү хэсэгт менежмент, тэр дундаа хэргийн газрын үзлэгийн менежментийн тухай авч үзье.

Менежмент гэдэг үг нь эрт үед “to manage” буюу анх Англи хэлнээ “морь унах”, “морь унаж сурах” гэсэн утгатай байжээ.^[120] Харин өнөө үед энэ суурин соёл иргэншлийн хөгжил, үйлдвэржилт, худалдаа, арилжаа бий болсноор менежмент гэдэг үг нь

¹²⁰ Д. Цэрэндорж., Дэлхийн менежмент, хамаарахуйн Монгол ухаан., Улаанбаатар., 2013 он., 17 дах тал.

“захирах, удирдах, тушаах, гүйцэтгэх, чиглүүлэх, эхлүүлэх, хянах, шалгах, хөтлөх, жолоодох, арга эвийг олох, нөлөөлөх, гэх мэт 30 гаруй утга санааг илэрхийлдэг. Харин эрт цагийн Монгол сэтгэлгээнд менежмент гэсэн ойлголт засах ухаан хэмээх ойлголтоор гарч ирдэг байна.”^[121]

Нийгмийн амьдралын аль ч хүрээнд хамтын хөдөлмөр, баг, бүрэлдэхүүний түвшинд хүмүүсийн үйл ажиллагааг нэгтгэн чиглүүлэх, зохион байгуулах үүрэг буюу менежмент зайлшгүй хэрэгтэй. “Тийм учраас **менежмент** нийгэм дэх хүмүүсийн **тодорхой хамтлаг, бүлэг, нэгж, бүтцийн тодорхой хэсгүүд дээр хамгийн бүрэн төгс, цогц байдлаар илэрч хэрэгждэг**” гэж үздэг.

Үүнээс үзэхэд хэргийн газрын үзлэгийн зорилгыг хангахын тулд төлөвлөх, хийж гүйцэтгэх, удирдан зохион байгуулах, бичиг баримт бүрдүүлэх, хөтлөх, үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж үнэлэлт дүгнэлт өгөх ойлголт зүй ёсоор урган гарч байна.

Менежментийн шинжлэх ухаан нь дараах үндсэн ойлголт, судлагдахуунтай. Үүнд:

1. Зорилго
2. Төлөвлөлт
3. Зохион байгуулалт
4. Удирдлага, манлайлал
5. Хяналт

Эдгээр ойлголтууд нь дан ганц том бүтэц, зохион байгуулалт бүхий байгууллага гэхгүйгээр тодорхой зорилго бүхий бүлэг хүмүүсийн тэр бүү хэл хувь хүн ч өөрийн менежменттэй байж болно. Иймд дээрх ойлголтуудыг хэргийн газрын үзлэгийн бүрэлдэхүүний байр сууринаас авч үзье.

Зорилго, зорилт:

Менежментийн шинжлэх ухааны үүднээс байгууллага, хамт олны хүрч болох, хүрэхээр тэмүүлж буй үр дүнг зорилго гэдэг. Тэгэхээр хэргийн газарт үзлэг хийх баг бүрэлдэхүүний эцсийн зорилго бол тодорхой. Гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдлыг тогтоох, гэмт хэргийг нотлон тогтооход шаардлагатай мөр илрүүлж бэхжүүлэх, гэмт хэргийг илрүүлэх явдал юм. Дээр үзлэг, тэр дундаа хэргийн газрын үзлэгийн ойлголт, зорилгыг тодорхой дурдсан тул энд нуршихаа больё. Иймд хамгийн ойрын, тодорхой зорилгыг тавьж үзлэгээ хийнэ гэсэн үг.

Төлөвлөлт:

Төлөвлөлт гэдэг нь зорилгодоо хүрэх үе шатаа урьдчилан үндэслэлтэй боловсруулах, тодорхойлох үйл явц. Өөрөөр хэлбэл байгууллага өмнөө тавьсан зорилгодоо хүрэхийн тулд нийт арга замыг олон

¹²¹ <https://mn.wikipedia.org/wiki/Менежмент>.



хувилбараар боловсруулж, түүнээс аль оновчтойг сонгох ажиллагаа юм.^[122] Иймд хэргийн газрын үзлэгийн баг бүрэлдэхүүн өмнө дурдсан зорилгоо биелүүлэхийн тулд нөхцөл байдалд тохирсон хийж гүйцэтгэх ажлаа боловсруулж төлөвлөх ажиллагаа гэж ойлгож болох юм. Үүнд үндэслэн хэргийн газрын үзлэгийн төлөвлөгөө гэсэн ойлголт зайлшгүй байх шаардлагатай.

Төлөвлөх гэдэг нь үзлэгийг хийх нэгэн төрлийн тактик бөгөөд хэрэгт хамгийн ач холбогдолтой эд зүйл, ул мөр, нотлох болон эд мөрийн баримтыг илрүүлж, бэхжүүлж, хураан авч болох газар, цаг хугацаа, эд зүйлсийн дэс дарааллыг ач холбогдлоор жагсаана гэсэн үг.^[123] Энэ үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шинжээч, мэргэжилтэн голлох үүргийг гүйцэтгэнэ.

Хэргийн газрын үзлэгийн үндсэн элементүүдийг /хийж гүйцэтгэвэл зохих ажилбар/ тодорхойлж цаг хугацаа, ач холбогдлоор эрэмбэлэн хариуцан хийж гүйцэтгэх субъектүүд, нөөц бололцоог тооцох, тодорхойлох явдал юм.

Өнөөгийн байдалд төлөвлөлт гэдэг зүйл нь криминалистикийн шинжлэх ухаанаар тайлбарлагдаж байдаг бөгөөд тактикийн арга зүйгээр боловсруулагдаж байна. Криминалистикийн тактик нь арга зүйн зөвлөмж байдаг учир албан ёсны шинжийг агуулдаггүй дутагдалтай.

Зохион байгуулалт:

Төлөвлөсөн үйл ажиллагааг ямар боловсон хүчин, хүмүүсээр, ямар бүтэцтэйгээр хэрэгжүүлэх үйл явц юм.^[124] Зохион байгуулах хэсэгт хэрэг үйлдэгдсэн газарт хэргийн төрлөөс /хүн амины, хулгай, дээрэм, хүчин, цахим гэмт хэргийн гэх мэт./ хамааран ямар техник, тоног төхөөрөмжөөр, ямар төрлийн хэдэн мэргэжилтэн /баг, бүрэлдэхүүн, компьютерийн шинжээч, мэргэжилтэн, гал зэвсгийн шинжээч мэргэжилтэн, химийн шинжээч, мэргэжилтэн гэх мэт/, ямар бүтэц /эрүүгийн цагдаа, мөрдөн байцаах, шүүх шинжилгээний, зам цагдаа гэх мэт/ зохион байгуулалтаар хийж гүйцэтгэх вэ? гэдгийг зохин байгуулна.

Хэргийн газрын үзлэгийн цагдаа, шүүхийн шинжилгээний байгууллага хамтран зохион байгуулж байна. Одоогийн байдлаар хэргийн газрын үзлэгийн баг бүрэлдэхүүнд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч,

эрүүгийн төлөөлөгч, нохойн төлөөлөгч, шинжээч /шүүх эмнэлэг, криминалистик, хими, физик, биологи, компьютер гэх мэт/, криминалистикийн мэргэжилтэн, шаардлагатай тохиолдолд прокурор гэсэн бүрэлдэхүүнтэй хэргийн газрын үзлэгийг хийдэг. Хэргийн өнгө /төрөл/, хохирол, цар хүрээндээс хамааран нэмэгдэл техник хэрэгсэл, хүн, хүч, хөрөнгө санхүү шаардагдах тохиолдол бий.

Хяналт:

Төлөвлөсөн ажил бодит байдалд яаж хэрэгжиж байгааг олж тогтоон, шаардлагатай бол засвар өөрчлөлт хийх үйл явц.^[125] Хяналтын хэсэгт төлөвлөсөн ажлаа бүрэн гүйцэд хийсэн эсэх, дэвшүүлсэн таамаглалаа шалгах, мухарлах, хэргийн газрын үзлэгийн үйл явц, үр дүнг бүрэн дүүрэн хийж гүйцэтгэсэн эсэхэд хяналт тавьж дутуу хийгдсэн ажлыг гүйцээж хийх зэрэг үзлэгийн төгсгөлд болон үзлэгийн үр дүнг үнэлэх ажиллагаа хамаарна. Үзлэг хангалтгүй, дутуу хийгдсэн гэж үзэж үнэлэлт, дүгнэлт өгвөл дахин /практикт нөхөн үзлэг гэж хэлдэг/ хийгдэх үндэслэл болно.

Хяналт нь зорилгод хүрэхэд холбоотой төдийгүй, алдаатай үйл ажиллагааг илрүүлэн арилгах хэрэгсэл болж байдаг. Иймд хэргийн газрын үзлэг хэр чанартай хийгдсэнийг хяналтын үйл явц, үр дүнгээс хамаарна.

Ингэж хэргийн газрын үзлэгийг менежментийн шинжлэх ухааны үндсэн ойлголтууд дээр үндэслэн хийвэл илүү үр дүнд хүрэх боломжтой юм.

Хэргийн газрын үзлэгт шүүхийн шинжилгээний багаар ажиллах ойлголт, ач холбогдол, тулгамдсан асуудал:

Баг гэдэг нь “Тодорхой ажил үүргийг хамтран биелүүлэхээр нэг зорилгоор нэгдсэн бүлэг хүн”^[126] Бид “нэг хүний толгойноос хоёр хүний толгой илүү” гэж ярьцгаадаг. Хүн үүсэн бие болсноос хойш бүлгээр хамтран амьдарч ажил хөдөлмөр эрхэлсээр ирсэн. Баг, бүлгийн агуулга нь ямарваа нэгэн хүчин зүйлийн үндсэн дээр өмнөө тавьсан зорилгод хүрэхийн тулд ажил үүргээ хуваарилж хамтран ажлыг чанартай, богино хугацаанд хийж гүйцэтгэх явдал юм.

Нийтлэг байдлаар багийг ямар нэгэн ажил буюу үйл ажиллагааг гүйцэтгүүлэхээр ажиллаж буй хэсэг бүлэг хүмүүс гэсэн утгаар тодорхойлдог. “Баг” хэмээх үгийн гүнзгийрүүлсэн тодорхойлолт нь тодорхой

¹²² С. Авирмэд., Менежмент., Улаанбаатар., 2008 он., 4 дэх тал.

¹²³ Э. Болор-Эрдэнэ., Хэргийн газрын үзлэгийн үндэс / аргачилсан зөвлөмж/, Улаанбаатар., 2013., 21 дэх тал.

¹²⁴ С. Авирмэд., Менежмент., Улаанбаатар., 2008 он., 5 дах тал.

¹²⁵ С. Авирмэд., Менежмент., Улаанбаатар., 2008 он., 6 дах тал.

¹²⁶ <https://Mongoltoli.mn>.



үр дүнд хүрэхийн тулд ажлын үйлдвэр ба хариуцлагаараа өөр хоорондоо хуваагдсан бодгиуудын бүлэг мөн.^[127]

Баг нь хэдийгээр хүмүүсийн бүлэг боловч энэхүү хоёр ойлголт нь ялгаатай. Баг бол нэг эрхэм зорилготой хамтын хариуцлага хүлээдэг бүлэг юм. Харин бүлэг бол ямар нэгэн нийтлэг шинжээр ямар нэгэн харьяалалд хуваагдах хүмүүс юм. Жишээ нь, эрэгтэй, эмэгтэй хүнийг хүйсийн шинжээр нь, насны байдлаар гэх мэт.

Хэргийн газрын үзлэг нь багийн үйл ажиллагаа.^[128] Иймд тэрхүү баг бүрэлдэхүүн хамтран ажил үүргийг гүйцэтгэх явдал юм.

АНУ-ын Холбооны мөрдөх товчоо, Солонгос, Япон зэрэг цагдаа, шүүхийн шинжилгээний байгууллагад хэргийн газрын үзлэг хийдэг баг ажилладаг. Баг нь дараах гишүүдтэй ба дараах эрх үүрэгтэй байдаг.

- Багийн ахлагч /team leader/
- Гэрэл зурагчин /photographer/
- Гар, схем зураг гаргагч /sketch, prepare/
- Мөр илрүүлэх ажилтнууд /evidence recovery personnel/
- Мөр бэхжүүлэх, битүүмжлэх ажилтан /evidence recorder/custodian/
- Мэргэжилтнүүд /specialist/

Манай улсын хувьд 5 хүний хийх ажлыг мөрдөн байцаагч, шинжээч гэсэн хоёр хүн хийж гүйцэтгэж байгаа нь хэргийн газрын үзлэгт тодорхой хэмжээнд нөлөөлж байгаа нь дамжиггүй.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын а/474 дугаар тушаалаар батлагдсан “Онц хүнд гэмт хэргийн газрын үзлэг багаар ажиллах журам” гарснаар хэргийн газрын үзлэгт багаар ажиллах эрх зүйн үндэс бүрджээ. Хэргийн өнгөөс хамааран түүнд оролцогч шинжээч нарын тодорхойлогдоно. Манай орны хувьд нэг мэргэжлийн хэд хэдэн шинжээч хамтран хэргийн газрын үзлэгт оролцдог тал бий. Энэ нь ажил үүргийн давхардал гарах сөрөг нөлөөтэй. Иймд ажил үүргийн давхардал гаргалгүй зохион байгуулах нь чухал.

Дүгнэлт

Хэргийн газрын үзлэг нь хуульд заасан гэмт хэрэг илрүүлэхэд чухал үүрэг бүхий ажиллагаа бөгөөд энэхүү үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулсаны үр дүнд чанарт ахиц гарч, гэмт

хэрэг илрүүлэлтэд шууд нөлөөлдөг хүчин зүйл юм.

Эрх зүйн зохицуулалтын хувьд ерөнхийлөн зохицуулагдаж уламжлалт хэв маягаар үзлэг хийгдэж байгаа хэдий ч цаашид нэгдсэн ойлголт, шийдэлд хүрч ажил үүрэг гүйцэтгэх явцад гардаг төвөгтэй ажиллагаануудыг зохицуулсан нарийн зохицуулалт шаардагдаж буй нь судалгаанаас харагдаж байна.

Хэргийн газрын үзлэг хийх бүрэлдэхүүн нь хот, хөдөө ялгаагүй адилхан байгаа бөгөөд нэг бүрэлдэхүүний ачаалал, ар араасаа гарах дуудлагууд нь тодорхой хэмжээнд хэргийн газрын үзлэгийн чанарт нөлөөлөх ба хэргийн газрын үзлэгийг нарийн тогтсон үйл ажиллагааг нарийн мэргэжлийн олон хүн хийснээр цаг хугацаа хэмнэх, ачааллыг тэнцвэржүүлэх, чанарт ахиц гарах ач холбогдолтой.

Хэргийн газрын үзлэгийн мөн чанар нь гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдлыг тогтоох, гэмт хэргийг илрүүлэх, шийдвэрлэхэд ач холбогдолтой ул мөрийг илрүүлж бэхжүүлэх явдал бөгөөд үзлэг хийх нь багийн үйл ажиллагаа байдаг учир түүний үндсийг менежментийн шинжлэх ухааны үүднээс судалж, онолын ойлголт бий болгох хэрэгцээ шаардлага өнөө үед бий болсон нь харагдаж байна.

Ном зүй

Хууль, эрх зүйн акт:

1. Шүүхийн шинжилгээний тухай хууль
2. Эрүүгийн байцаан шийтгэх хууль
3. Цагдаа, шүүхийн шинжилгээний байгууллагын хамтран ажиллах журам
4. Хэргийн газрын үзлэгт хамтран ажиллах журам
5. Онц хүнд гэмт хэргийн газрын үзлэгт багаар ажиллах журам

Ном, сурах бичиг, гарын авлага:

1. С. Авирмэд., Менежмент., Улаанбаатар хот., 2008 он.
2. Б.Бат-Эрдэнэ., Монгол улсын эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй /альбом схем/., Улаанбаатар., 2009 он.
3. Б.Баяр., Г.Ганбаатар., Б.Жаргалсайхан., Б.Лхагвасүрэн., Д.Мөрөн., Т.Очирбат., Т.Оюунчимэг., Ж.Өнгөтхүү., Л.Цогтбаяр., М.Чинбат., Гэмт хэрэг илрүүлэхүй., Улаанбаатар., 2015 он.
4. Э. Болор-Эрдэнэ., Хэргийн газрын үзлэгийн үндэс., Улаанбаатар., 2013 он.
5. Ж. Хурцгэрэл., Криминалистик-2., Улаанбаатар хот., 2004 он.
6. Б. Жаргалсайхан., Учралын газрын үзлэг., Улаанбаатар хот., 2008 он.

¹²⁷ БХИС-ийн Удирдлага Технологийн дээд сургуулийн Төрийн захиргаа удирдлагын тэнхим., Бизнесийн нөхжилд төрийн байгууллагаас үзүүлэх дэмжлэг сургалт., Менежмент., Улаанбаатар хот., 2007 он.

¹²⁸ Б. Лхагвасүрэн., Мөр., Улаанбаатар., 2011 он., 59 дэх тал.



7. Б. Лхагвасүрэн., Мөр., Улаанбаатар., 2011 он.

8. Д. Цэрэндорж., Дэлхийн менежмент, хамаарахуйн монгол ухаан., 2013 он.

Эрдэм шинжилгээний бүтээл, илтгэл, өгүүлэл:

1. Хэргийн газрын үзлэг хийх мөрдлөгийн цогц ажиллагааг боловсронгуй болгох нь., Т. Очирбат.

Цахим эх сурвалж:

1. Google.mn
2. Wikipedia.org
3. Mongoltoli.mn
4. Mongolianforensics.blogspot.com
5. 1212.mn

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ДОТООД АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА: МОНГОЛ УЛС БА ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЖИШЭЭН ДЭЭР

Б.Энхболд
ХСИС-ийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн
Цагдаа судлалын төвийн эрхлэгч, доктор
(Ph.D), цагдаагийн хошууч

М.Баярсайхан
Налайх дүүргийн Цагдаагийн хэлтсийн
Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасгийн
мөрдөн байцаагч, цагдаагийн ахмад,
магистрант

1. Онолын үндэслэл

Нийгэм хөгжиж, аж үйлдвэржилтийг дагасан төвлөрөл бий болсноор аюулгүй байдлын шинэ шинэ хэрэгцээ бий болжээ. Эрт үед зөвхөн амь насаа хамгаалах зорилготой байсан энэ хэрэгцээ аажмаар өргөжиж, улс орон, иргэдийн эд хөрөнгө, үзэл бодол, шашин шүтлэг зэрэг олон үнэт зүйлсийг хамрах болсон нь төрийн тусгай чиг үүрэгтэй байгууллагууд буюу цагдаа, цэрэг үүсэхэд нөлөөлжээ.

Дэлхийн ихэнх улсад цэргийг гүйцэтгэж байгаа чиг үүргээс нь хамааруулан дөрвөн төрөлд ангилдаг байна. Нэгдүгээрт, улс орныг гадны аюулаас хамгаалах чиг үүрэг бүхий зэвсэгт хүчин; хоёрдугаарт хил хамгаалах, хилийн доторх үндэсний аюулгүй байдал, язгуур эрх ашгийг хамгаалах, гадны халдлага түрэмгийлэл болсон үед зэвсэгт хүчин эхсүл НҮБ-ын хүчин орж иртэл хилийг хамгаалж байх үүрэгтэй хилийн цэрэг; гуравдугаарт улс орны тусгаар тогтнол, бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хангах, хүний эрх, эрх чөлөөг бусад гэмт халдлагаас хамгаалах үүрэг бүхий дотоодын цэрэг; дөрөвдүгээрт тодорхой онц

чухал объектын хамгаалах цэрэг гэж хувааж байна.

Дотоодын цэрэг дээр дурдсан өөрийн үндсэн чиг үүргээс гадна туслах чиг үүргийг мөн гүйцэтгэдэг. Тухайлбал, НҮБ-ын дүрмийн дагуу терроризм, зохион байгуулалттай алан хядагчид, хүний наймаа, хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлтэй тэмцэх зэрэг чиг үүргийг гүйцэтгэх ёстой^[129].

Улсын дотоод аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах ажлыг дэлхийн дахинд цагдаагийн байгууллага хариуцан гүйцэтгэдэг боловч улс оронд эмх замбараагүй байдал үүсэх, дотоодын үймээн самуун, зэвсэгт мөргөлдөөн бий болох, төрийн эрх мэдлийг хууль бусаар авах оролдлого гарч цагдаагийн хүчээр таслан зогсоох боломжгүй болсон тохиолдолд дотоод аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагыг ашигладаг.

Зэвсэгт хүчнийг дотоодын үймээн самуун, зэвсэгт бослогыг дарахад ашиглах нь зэвсэгт хүчнийг ард түмний эсрэг ашиглахын нэг хэлбэр бөгөөд энэ нь зэвсэгт хүчний эх орноо хамгаалах үндсэн чиг үүргээс гажсан, хүний эрх, эрх чөлөөнд хууль бусаар халдах өндөр эрсдлийг дагуулдаг төдийгүй зэвсэгт хүчнийг улс төрийн тэмцэлд ашиглах, хутган оролцуулах боломж нээгдэж олон улсын тавцанд улс орны нэр хүндэд сөргөөр нөлөөлөх алхам болдог.^[130]

Тиймээс дотоодын цэрэг, түүнтэй төстэй зэвсэгт хүчний бус байгууллагыг цомхон, мэргэшсэн бүтэц, бүрэлдэхүүнтэйгээр байгуулан түүний бие даасан байдлыг хангаж улсын онц чухал объектыг хамгаалах, шаардлагатай үед нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, дотоодын бусад үймээн самууны үед

¹²⁹ Ш.Арвай. "Хууль төрөхийн өмнө" сэдэвт нээлттэй хэлэлцүүлэг" /Дотоодын цэргийн тухай хуулийн төсөл/ 2017 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр, УБ хот, ХЗҮХ

¹³⁰ П. Сайнзориг. "Дотоодын цэргийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалын танилцуулга", Хууль төрөхийн өмнө" сэдэвт нээлттэй хэлэлцүүлэг, 2017 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр, УБ хот, ХЗҮХ."



иргэн, байгууллагын аюулгүй байдал, өмч хөрөнгийг хамгаалах, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааг гүйцэтгүүлэх, гамшиг, аюулт үзэгдэл, техникийн осол, гал түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан үед аврах болон хорио цээрийн дэглэмийг сахиулахад оролцуулдаг жишиг дэлхийн улс бүрт тогтсон байна.

2. Дотоод аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллага, нэршлын талаар

2016 оны байдлаар дэлхийн 80 гаруй улсад дотоодын аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий алба цагдаагийн байгууллага болон Засгийн газрын аль нэг яамны харьяанд ажиллаж байна^[131]. Дээрх улсуудад байгаа дотоод аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагууд нь 70 орчим хувь нь цагдаагийн байгууллагын дэргэд, 20 орчим хувь нь Хууль зүйн яам болон тухайн яамныхаа дэргэд бие даасан статустай, 10 орчим хувь нь цэрэг гэдэг утгаараа Батлан хамгаалах яамандаа харьяалагдаж байна.

Улсын дотоодыг хамгаалах чиг үүрэг бүхий энэхүү албыг улс бүр өөрийн орны онцлогт тохируулан харилцан адилгүй нэрлэж байгаа бөгөөд олон улсын хэмжээнд хамгийн түгээмэл хэрэглэгддэг нэршил нь "Жандармерие" юм. Жандармерие (Gendarmerie) нь "Зэвсэгт хүн" гэсэн утга илэрхийлэх Франц гаралтай үг бөгөөд орчин үед энэ нэр томъёо нь энгийн иргэдийн дунд хууль сахиулах, дотоод аюулгүй байдлыг хангах үүрэг гүйцэтгэдэг цэргийн алба хаагч гэсэн утгаар хэрэглэгдэж байна.

Дэлхийн улсуудад дотоодын аюулгүй байдлыг хамгаалах чиг үүрэг гүйцэтгэж буй байгууллагын нэршлыг авч үзвэл дараах нэр томъёонуудыг түгээмэл хэрэглэж байна^[132]. Үүнд: "Gendarmerie-Жандармерие", "Carabinieri-Карбиньер буюу карбин буугаар буудагч", Испанид "Civil Guard-Иргэний гвард", Мексикт "Federal police-Холбооны цагдаа", Бразилд^[133] "Military police-Цэрэг маягийн цагдаа", "Rapid Action force-Шуурхай ажиллааны хүчин" ОХУ болон АНУ-д "National Guard- Үндэсний Гвард", Канад улсад "Royal Canadian Mounted police-Канадын эзэн хааны морьт цагдаа", БНХАУ-д "People's Armed Police-Хятадын Ардын зэвсэгт цагдаа", "Carabiniers Troops-Карабинт цэргүүд", "Public safety service-Олон нийтийн аюулгүй байдлыг хангах

алба", Ливан Улсад "Дотоодын аюулгүй байдлыг хангах алба", Египт Улсад "Central Security Force-Аюулгүй байдлын төв алба", "National task Force-Үндэсний тусгай хүчин", Бангладеш Улсад "Bangladesh Ansar-Бангладешын Ансар", Азербайджаны Улсад "Internal troop-Дотоодын цэрэг" гэсэн нэршлүүд багтаж байна.

3. Гадаадын зарим орны дотоод аюулгүй байдлыг хангах байгууллага, чиг үүрэг

Улсын дотоод аюулгүй байдлыг хангах байгууллагын бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийг гадаадын зарим улсад хэрхэн шийдвэрлэж байгаа талаарх харьцуулсан судалгаа хийж, үр дүнг өөрийн орны онцлогт нийцүүлэн нутагшуулах нь дэлхийн нийтийн хөгжлийн өнөөгийн жишигт нийцэх юм. Дээрх зорилгоор гадаадын зарим улсын дотоодын цэрэг, түүнтэй төстэй байгууллагуудын талаар авч үзэхийг зорьсон болно.

ОХУ-ын Үндэсний Гвард:

1992 онд ОХУ-ын Дотоод хэргийн яамны дэргэд Дотоодын цэрэг байгуулж, улс орны дотоод аюулгүй байдлыг хангах чиг үүргийг гүйцэтгэж ирсэн бол ОХУ-ын Ерөнхийлөгчийн 2016 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн ДХЯ-ны Дотоодын цэргийн бүтэц суурин дээр Үндэсний Гвардын цэргийн холбооны албыг байгуулах тухай шийдвэрээр байгуулж, Үндэсний Гвардын цэргийн холбооны албаны тухай багц хуулийг Төрийн Дум 2016 оны 06 дугаар сарын 22-ны өдөр, Холбооны зөвлөлөөр 2016 оны 06 дугаар сарын 29-ны өдөр тус тус хэлэлцэж баталсныг ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин 2016 оны 07 дугаар сарын 03-ны өдөр "ОХУ-ын Үндэсний Гвардын холбооны цэргийн албаны тухай" хуульд гарын үсэг зурснаар үйл ажиллагаа нь эхэлсэн байна.^[134]

Холбооны шинэ агентлаг нь гүйцэтгэх засаглалын байгууллага, иймд, бусад хууль сахиулахын байгууллагуудын адил бие даасан байх бөгөөд Ерөнхийлөгчийн захиргаан дор байна.

Шинэ тутам байгуулагдаж буй үндэсний гвардын бүрэлдэхүүнд шуурхай арга хэмжээ авах тусгай тасаг, хувийн хэвшлийн хамгаалалт, аюулгүй байдлын хэлтэс, тасгууд, ДХЯ-ны "Хамгаалалт" байгууллага, ДХЯ-ны агаарын хүчин, тусгай ажиллагаа, шуурхай хүчний төв зэргийг багтаасан 400 гаруй мянган ДХЯ-ны алба хаагч үүрэг гүйцэтгэж байна.

ОХУ-ын Үндэсний Гвард нь "Үндсэн

^[134] Haberfeld. "Comparative policing". USA. Los Angeles, 2007. Sage express

¹³¹ Haberfeld. "Comparative policing". USA. Los Angeles, 2007. Sage express

¹³² Jack R.Greene "The encyclopedia of police science", New York, 2007.

¹³³ Larry K.Gaines "Police administration" New York, 2010.



хууль боллон ардчилалын ололт амжилтаа хамгаалж, улс орныхоо нутаг дэвсгэр дээр хууль ёс, дэг журмыг сахиулах, баталгааг бүрдүүлэхэд хүч нэмэгдүүлэх зорилгоор байгуулагдсан” бөгөөд “ОХУ-ын Үндэсний гвардын холбооны цэргийн албаны тухай” хуульд зааснаар Үндэсний Гвард нь ОХУ-ын ДХЯ-тай нягт холбоотой ажиллаж дараах чиг үүргийг гүйцэтгэнэ. Үүнд,^[135]

- ОХУ-ын цагдаагийн байгууллагатай хамтран нийгмийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах, онц байдлын үед арга хэмжээ авах;
- Терроризмтой тэмцэх, алан хядах ажиллагаатай тэмцэх;
- Хэт даврагсадтай тэмцэх;
- ОХУ-ын нутаг дэвсгэрийг батлан хамгаалахад оролцох;
- ОХУ-ын Засгийн газраас тогтоосон улсын онц чухал объект, тусгай ачааг хамгаалахад оролцох;
- ОХУ-ын хил хамгаалахад Аюулгүй байдлын албаны хилийн байгууллагад дэмжлэг үзүүлэх;
- Галт зэвсгийн эргэлийн салбар болон хувийн хамгаалалтын үйл ажиллагааны салбарт ОХУ-ын хууль тогтоомжийг мөрдүүлэхэд тавих хяналтыг хэрэгжүүлэх.

ОХУ-ын Үндэсний Гвардийн холбооны цэргийн алба нь жилд 1 сая гаруй хууль зөрчсөн үйлдэл, 10 мянга орчим гэмт хэрэгтэн, улсын тусгай хамгаалалтын зориулалттай объект хориотой бүсэд нэвтэрсэн 30 гаруй мянган зөрчил, хойд Кавказад 100 гаруй террорист болон 120 гаруй гэмт хэрэг, дээрмийн бүлгийг тус тус илрүүлэн ажиллаж, үүний үр дүнд зөвхөн 1 жилд 15 мянган офицер, ахлагч түрүүч, дайчид байгууллагаас шагналаар, 300 гаруй алба хаагч төрийн одон медалиар тус тус шагнагдсан байна.

ОХУ-ын Үндэсний Гвардийн цэргийн холбооны алба нь сөрөг тагнуулын шугамаар ажиллах болон мөн бусад хүчний байгууллагатай хамтран харилцан холбоотой ажиллах боломжтой юм. Дэлхий дахины туршлагаар тус чиглэлийн байгууллагууд өөрсдийн улс орны аюулгүй байдалд оруулдаг хувь нэмэр нь улам бүр өссөөр байна.

БНХАУ-ын Ардын зэвсэгт цагдаа ^[136]

Хятадын ардын зэвсэгт цагдаагийн алба нь 1983 оны 4 дүгээр сард байгуулагдсан. Хятадын Ардын зэвсэгт цагдаа нь улсын

дотоод аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий Нийгмийг аюулаас хамгаалах яам болон Төв цэргийн хорооны харьяанд багтдаг төрийн тусгай нэгж юм.

Бүтэц, зохион байгуулалтын хувьд тусгай хамгаалалт, хилийн хамгаалалт, гал түмэртэй тэмцэх, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, нийтийн үйлчилгээний онц чухал объект хамгаалах, алт, мод болон цахилгаан холбоог хамгаалах албадуудаас бүрддэг ба 1.5 сая орон тооны хаагч үүрэг гүйцэтгэдэг.

БНХАУ-ын Цагдаагийн тухай хуульд Ардын зэвсэгт цагдаа нь “Нийгмийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн төрийн үүрэг даалгаврыг гүйцэтгэнэ” гэж заасан бол “БНХАУ-ын зэвсэгт цагдаагийн тухай хууль”-д нарийвчилсан зохицуулалтыг тусгасан. Тус алба нь энхийн цагт улсын дотоодын аюулгүй байдлыг хангах ажиллагааг улсын хэмжээнд нэгдсэн удирдлагаар хангаж ажилладаг бол дайн бүхий байдлын үед төв цэргийн штабын удирлагад байлдааны хамгаалалт, нэвтрэлтийг хориглох болон эргийн хамгаалалтын үүрэг гүйцэтгэдэг байна. Хуульд зааснаар Ардын зэвсэгт цагдаа даарх чиг үүргийг гүйцэтгэхээр тодорхойлсон:

1. Бүх төрлийн халдлага, хорлон сүтгэх ажиллагааны сөрөг тусгай хамгаалалт;
2. Хуулиар тодорхойлсон хувь хүн, байгууламж хамгаалах;
3. Олон улсын болон үндэсний дээд хэмжээний хурал, олон нийтийг хамарсан спорт урлагийн арга хэмжээний хамгаалалт;
4. Иргэний нисэх, радио станц, нууцын зэрэглэлтэй барилга байгууламж, улсын эдийн засаг болон батлан хамгаалах салбарт хамаарах онц чухал объект зэргийг хамгаалах;
5. Онц чухал авто замын гүүр болон хонгил хамгаалах;
6. Цагдан хорих байр болон хорих ангийн харуул хамгаалалтыг хангах;
7. Төрөөс тодорхойлж нэрлэсэн том, дунд, жижиг хотууд болон тусгай бүсийн хэв журам сахиулах ажиллагаа;
8. Хил хамгаалалтанд дэмжлэг үзүүлэх.

2016 оны байдлаар өдөрт дунджаар 260,000 орчим зэвсэгт цагдаа харуулын үүрэг гүйцэтгэж, улсын онц чухал объектод халдсан 12 удаагийн халдлага, гэмт хэрэг үйлдсэн болон хорих байгууллагаас оргох оролдлого хийсэн 3000 орчим хүн саатуулж, 1000 орчим байгууллагад түр хугацааны хамгаалалт зохион байгуулж, Засгийн газрын түвшинд зохион байгуулагдсан 19 удаагийн олон улсын хэмжээний хурал,

¹³⁵ ОХУ-ын үндэсний гвардын тухай хууль, орчуулга

¹³⁶ Haberland. “Comparative policing”. USA. Los Angeles, 2007. Sage express



чуулга уулзалт болон иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангаж ажилласан байна.

Тус алба нь террорист халдлагын эсрэг сөрөг тусгай ажиллагаа явуулах үүргийг хариуцаж ажилладаг бөгөөд дотоодын төдийгүй олон улсын хэмжээний алах хядах ажиллагаатай тэмцэх чиглэлээр 17 улстай хамтарсан сургалт, хэлэлцээр хийсэн байна.

Сүүлийн жилүүдэд тус байгууллагын чадавхи, хүний нөөцийн менежментийг боловсронгуй болгох, зэвсэг, техник, технологийн чадамжийг нэмэгдүүлэх чиглэлээр шат дараатай арга арга хэмжээ авч байна.

Францын Улсын Үндэсний Жандармерие^[137]

Франц Улсын Үндэсний Жандармерие нь 1791 онд байгуулагдсан Францын үндэсний цагдаагийн газрын үндсэн бүрэлдэхүүний нэг хэсэг нь юм. Жандармерие нь тухайн нутаг дэвсгэрийн Дотоод хэргийн яамны харьяанд багтаж үүрэг гүйцэтгэдэхээс гадна Францын Батлан хамгаалах яаманд давхар харьяалагддаг зэвсэгт хүчний нэг салбар гэж үздэг.

Бүтэц, зохион байгуулалтын хувьд Жандармерие нь хоёр хүчинд хуваагддаг бөгөөд түүний бүтцэд төрөл бүрийн тусгай нэгжүүд үүрэг гүйцэтгэдэг байна. Жандармериег газар зүйн хувьд 7 цэргийн хамгаалалтын бүсэд харьяалуулдаг ба энэ нь тэдний өмнөх түүх болон одоогийн гүйцэтгэж буй үйл ажиллагаатай холбоотой.

2016 оны байдлаар Жандармериегийн жилийн төсөв 7.7 тэрбум ам.доллар ба 100 мянга гаруй алба хаагч үүрэг гүйцэтгэж байна. Тэдгээрийн гүйцэтгэдэг үүргийн 53 хувь хууль сахиулах, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбогддог бол 35 хувь нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх, 12 хувь нь нийтийн хамарсан эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, террорист халдлагатай тэмцэх чиглэлд хамаардаг байна.

Францын Улсын Үндэсний Жандармерие нь хуулиар хүлээсэн даарх үүрэг гүйцэтгэнэ:

1. Цагдаагийн байгууллагын харьяалах нутаг дэвсгэрт хамаарагддаггүй 20.000 доош хүн амтай жижиг тосгогон, хөдөөгийн бүс, гол нууруудын сав газарт гэмт хэрэгтэй тэмцэх, хэв журам сахиулах зэрэг цагдаагийн байгууллагын үүргийг гүйцэтгэх;

2. Алан хядах үйл ажиллагаатай тэмцэх болон барьцаалагдсан хүмүүсийг аврах үүрэг гүйцэтгэдэг;

3. Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх хүрээнд гэмт хэрэг мөрдөн шалгах ажиллагааг тодорхой хяналтан доор гүйцэтгэх;

¹³⁷ Haberfeld. "Comparative policeing". USA. Los Angels, 2007. Sage express

4. Хамгаалалт шаардсан олон нийтийн арга хэмжээ болон жагсаал цуглааны үед нийгмийн хэв журам сахиулах;

5. Тэнгисийн болон эргийн хамгаалатад хууль сахиулах;

6. Иргэний нисэх онгоцны буудал, цөмийн энерги агуулсан объект, цэргийн агуулахын харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэх;

7. Францын нутаг дэвсгэрээр гадаад орны байгууллага, тусгай хүчний албад дамжин өнгөрөх, үйл ажиллагаа явуулахад цэргийн хяналт тогтоох;

8. Төрийн дээд хэмжээний чуулга уулзалт, ёслолын арга хэмжээний хамгаалалт.

Цэргийн статустай учраас Жандармерие нь мөн үндэсний аюулгүй байдалтай холбоотой зарим нэг үүргийг гүйцэтгэдэг. Тухайлбал, цөмийн зэвсэгтэй холбоотой нөөц хэрэгслийг хамгаалах болон эргүүлэн татах, Ливан, Албани, Гайти, Косово болон Зүүн Тимор зэрэг НҮБ болон НАТО-гийн энгийн цагдаагийн үйл ажиллагаанд алба хаагчид тогтмол илгээж байна.

Европын Жандармерын холбоо

Европын Жандармерын холбоо нь 2006 онд Франц, Итали, Недарланд, Португаль, Испани зэрэг Европын холбооны гишүүн 5 улсын санаачлагаар үүсгэн байгуулагдсан. Тус холбоонд Румын Улс 2009 онд, Польш улс 2011 онд тус тус нэгдсэн байна. Тус холбооны зорилго нь холбооны гишүүн улсуудын нутаг дэвсгэрт бий болсон дотоод аюулгүй байдлыг хангах ажиллагаанд цэрэгжсэн цагдаагийн хүчээр хууль сахиулах, нийгмийн дэг журмыг сэргээн тогтооход харилцан туслалцаа үзүүлэх явдал болно. Энэ холбоо нь Европын холбооны цэргийн штабд захирагддаг бөгөөд 900 орчим байнгын алба хаагч мэдээлэл солилцох чиг үүрэгтэй ажиллаж байна^[138].

2007 оноос хойш улсын дотоод аюулгүй байдлыг сэргээн тогтоох чиглэлээр холбооны болон холбооны гишүүн бус улс орнуудын 4500 орчим алба хаагчдад хамтарсан сургуулиалт явуулсан байна. 2010 онд Гайти улсад болсон газар хөдлөлтийн дараа иргэдийг нүүлгэн шилжүүлэх, дотоодын хямралт байдлыг арилгах, амьдралын хэвийн байдлыг сэргээн тогтоох зорилгоор гишүүн улс орнуудаас 350 алба хаагч үүрэг гүйцэтгэж оролцсон байна.

4. Монгол Улс дахь дотоодын аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагын онцлог

Монгол Улсад дотоодын цэрэг анх 1922 онд үүсгэн байгуулагдаж улсын чухал

¹³⁸ Haberfeld. "Comparative policeing". USA. Los Angels, 2007. Sage express



объектын харуул хамгаалалт, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, олзлогсод болон хоригдлыг хуяглан хүргэх, төр засгийн шийдвэрээр улс оронд гарсан үймээн самууныг таслан зогсоох үүргийг голчлон гүйцэтгэж иржээ. Энэ нөхцөл байдлыг харгалзан Монгол Улсын Их Хурлаас 1995 онд Дотоодын цэргийн тухай хуулийг баталсан хэдий ч 2014 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуулиар хүчингүй болгож дотоодын цэргийг татан буулгаж чиг үүргийг цагдаагийн байгууллагад шилжүүлсэн. Дотоодын цэрэг нь НАХЯ-ны /хуучин нэрээр/ Хилийн ба дотоодын цэргийн удирдлагад, 1990 оноос 2014 онд татан буугдах хугацааг хүртэл цагдаагийн төв байгууллагын удирдлагад чиг үүргээ хэрэгжүүлж байсан.

Гэсэн хэдий ч улс орны дотоод аюулгүй байдлыг алдагдах чиг хандлагатай гэмт хэрэг, зөрчил жилээс жилд өсөн нэмэгдэж байгааг харгалзан Монгол Улсын Засгийн газраас Дотоодын цэргийн тухай хуулийн төслийг 2016 оны 12 дугаар сарын 23-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлж, 2017 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэн баталж, 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөхөөр заасан. Хууль санаачлагч хуулийн төсөл боловсруулахдаа дор дурьдсан эрх зүйн болон практик үндэслэлийг удирдлага болгосон байна.

Эрх зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”-д^[139] “Төрийн үйлчилгээг хүртээмжтэй ил тод болгох, хүний эрхийг баталгаатай хангах, нийгэм дэх аюулгүй орчныг бий болгох эрх зүйн зохицуулалтыг тус тус боловсронгуй болгоно”, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын^[140] 3.3.4.4-т “Нийгэмд хууль ёс, дэг журам, сахилга хариуцлага суларч эмх замбараагүй байдал бий болохоос сэргийлнэ”, Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” бодлогын баримт бичгийн 7.1-д “Монгол Улсын төрийн цэргийн байгуулал нь тайван цагт зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагаас бүрдэнэ. Дайны байдлын үед хилийн ба дотоодын

цэрэг, онцгой байдлын байгууллага нь зэвсэгт хүчний бүтцэд үүрэг гүйцэтгэнэ.”, 7.3-т “Тайван цагт хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллага нь бие даасан үүрэг гүйцэтгэх бөгөөд тэдгээрийн бүтэц, чиг үүргийг хуулиар тогтооно”, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5.5.1-д “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс”-т нийцүүлэн, батлан хамгаалах тогтолцооны хууль тогтоомжийг шинэчилж, батлан хамгаалах үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлнэ” гэж тус тус заасан нь Дотоодын цэргийн тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болсон гэж үзжээ.

Практик үндэслэл

Дотоодын үймээн самуун, эмх замбараагүй байдал болон бусад аюул ослыг шатлан өргөжихөөс сэргийлэх, таслан зогсоох, иргэн, төрийн байгууллага, тэдгээрийн өмч хөрөнгө, объектын аюулгүй байдлыг хангах ажиллагааг уг ажиллагааны арга тактик бүхий тусгай бэлтгэгдсэн, удирдлага зохион байгуулалтын хувьд аливаа нөхцөл байдал, аюул осолд шуурхай хариу өгч чадахуйц, байнгын бэлтгэл сургуультай мэргэшсэн бүрэлдэхүүнээр хохирол багатай гүйцэтгүүлэх нь төрийн болон иргэд, нийгмийн эрх ашиг, сонирхолд нийцэхүйц алхам болно гэж үзжээ.

Энэ хуулиар Монгол Улсын дотоодын цэргийн тогтолцоо, чиг үүрэг, бүрэн эрх, үйл ажиллагааны эрх зүйн үндэс, алба хаагчийн эрх зүйн баталгаа, биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх нийтлэг үндэслэл, журмыг тодорхойлон зохицуулсан байна.

Дүгнэлт

1. Улсын онц чухал объектыг хамгаалах, шаардлагатай үед нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, дотоодын бусад үймээн самууны үед иргэн, байгууллагын аюулгүй байдал, өмч хөрөнгийг хамгаалах, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааг гүйцэтгэх, гамшиг, аюулт үзэгдэл, техникийн осол, гал түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан үед аврах болон хорио цээрийн дэглэмийг сахиулахад оролцох, хилийн хамгаалалтанд дэмжлэг үзүүлэх зэрэг чиг үүргийг гүйцэтгэж байна.

2. Дотоод аюулгүй байдлыг хангах чиг үүрэг гүйцэтгэж буй байгууллага нь тухайн улсын нийгэм эдийн засгийн байдал, гэмт хэрэг, аюулгүй байдлын түвшингээс хамаарч

¹³⁹ төрийн мэдээлэл 2008 №3-т нийтлэгдсэн

¹⁴⁰ төрийн мэдээлэл 2010№9-т нийтлэгдсэн



цагдаагийн байгууллагын харьяанд эсхүл Засгийн газрын харьяанд бие даасан статустай, зарим оронд нь Батлан хамгаалах яамны харьяанд үйл ажиллагаагаа явуулж байна. Тухайлбал, терроризмын аюул ихтэй, дотоодын үймээн самуун өндөртэй Европын зарим улсад ихэвчлэн бие даасан болон Батлан хамгаалах яамны харьяанд байдаг бол нөхцөл байдал харьцангуй тайван улсуудад цагдаагийн байгууллагын харьяанд олон нийтийн аюулгүй байдлыг

хангах үүрэг гүйцэтгэж байна.

3. Цаашид дотоодын цэргийн байгууллагын бүрэлдэхүүнийг мэргэшсэн алба хаагчдаас бүрдүүлэх, хугацаат цэргийн алба хаагчдаас татгалзаж, дотоодын цэрэг гэсэн нэр томъёог олон улсын жишигт нийцүүлэн өөрчлөх шаардлагатай.

МОНГОЛ УЛС ДАХЬ НИЙТИЙГ ХАМАРСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ, ГАДААДЫН ЗАРИМ УЛС ОРОНТОЙ ХАРЬЦУУЛАН АВЧ ҮЗЭХ НЬ

М.Батбаяр
ЦЕГ-ын Мэдээлэл нэгтгэн боловсруулах
газрын Дүн шинжилгээ, судалгааны
хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн
дэд хурандаа

Товчлол: Энэхүү өгүүллээрээ Монгол Улсад зохион байгуулагдсан нийтийг хамарсан арга хэмжээний нөхцөл байдал, удирдлага, зохион байгуулалт, түүний учир шалтгаан, учирсан хор уршиг, гадаадын зарим улс оронд зохион байгуулагдаж буй нийтийг хамарсан арга хэмжээний зохион байгуулалт, арга хэмжээний аюулгүй байдлыг хангах арга зүйн зарим асуудлын талаар авч үзэхийг зорилгоо.

Түлхүүр үг: Жагсаал, цуглаан, улс төр, суулт, санал асуулга, талбай, албан мэдэгдэл, хохирол,

Оршил

Нийтийг хамарсан арга хэмжээ гэдэг ойлголт нь нэлээн өргөн хүрээтэй ойлголт юм. Нийтийг хамарсан арга хэмжээ гэдэг нь хүмүүсийн улс төр, бие бялдар, оюуны хэрэгцээг хангах зорилгоор тэдгээрийн эрх ашигт нийцсэн олон түмний оролцоотойгоор явагдаж байгаа иргэдийн хүний эрх, эрх чөлөө хэрэгжих, өөр хоорондоо харилцах хэлбэр, бие хүн, хамт олон, нийгэм бүхэлдээ үзэл бодол, үйл хөдлөл, чиглэлээ нэгтгэх арга хэрэгсэл болсон зохион байгуулалттай үйлдлийн хэлбэр мөн.^[1]

Мөн зарим судлаачид өөр байдлаар тодорхойлсон байдаг байна. Тухайлбал,

¹ Ж. Таванжин. Монгол Улсын цагдаагийн эрх зүй. УБ. 2006. 228 дахь тал.

судлаач Л.Билгээ “олныг хамарсан арга хэмжээ гэдэг нь олон тооны иргэдийг оролцуулсан, тэдний хэрэгцээ, ашиг сонирхлыг хангахад чиглэгдсэн, нийгмийн харилцаан дахь бие хүн, бүлэг, хамт олны эрх, эрх чөлөөгөө хэрэгжүүлж буй зохион байгуулалттай үйл ажиллагааны нийлбэр цогц юм.^[2] хэмээсэн байдаг бол доктор Ж.Долгорсүрэн “Иргэд бүлэг хүмүүсээс өөрсдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо эдлэхээр болон улс төр, эдийн засаг, соёл, шашны болон буад хэрэгцээгээ хангахаар олон нийтийн газарт зохион байгуулалттай, идэвхтэй хэлбэрээр явуулж буй үйл ажиллагааг олон нийтийг хамарсан арга хэмжээ гэнэ^[3] хэмээн тодорхойлжээ

Нийтийг хамарсан арга хэмжээнд шашин, урлаг, соёл^[4], спорт^[5], улс төр, эдийн засаг, бизнесийн арга хэмжээ, тэмдэглэлт үйл явдлууд гэх мэт маш олон төрөл, хэлбэртэйгээр тодорхой зорилгын хүрээнд зохион байгуулагдаж байгаа иргэд, олон нийтийг өргөнөөр хамруулсан зохион байгуулалтын арга хэмжээнүүд хамаарна.

Улс төр-нийгмийн арга хэмжээ нь төрийн захиргааны болон бусад байгууллагын үйл ажиллагааг дэмжих, үндэстэн ястны хооронд гарсан зөрчил, үл ойлголцлыг арилгах, нийгэм дахь улс төрийн болон нийгмийн харилцааны зарим асуудлыг шийдвэрлэсэн төрийн байгууллагын шийдвэр нь нийгэм олон нийтийн сонирхолд нийцээгүй, сонгуулийн компани ажлын үеийн сурталчилгаа, төрийн байгууллага, албан тушаалтны зүгээс явуулсан хууль бус ажиллагааг дургүйцэн эсэргүүцэн

² Л. Билгээ. Цагдаагийн үйл ажиллагааны арга зүйн зарим асуудлууд. УБ. 2009. 100 дахь тал

³ Ж. Долгорсүрэн. Монгол Улсын цагдаагийн эрх зүй. УБ. 2004. 22 дахь тал

⁴ Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ. 476 дахь тал. Хүн төрөлхтөний үйлдвэр, нийгэмлэг, оюун ухааны талаар гаргасан ололтын цогц.

⁵ Хүний бие махбодыг чийрэгжүүлэхийн тулд хийх биен тамирын дасгал. Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ. 485 дахь тал



илэрхийлсэн ажиллагаанд ихэвчлэн байдаг ба зорилго нь төрөл бүрийн шаардлага тавьж санаа бодлоо илэрхийлэх, хурцадмал байдлыг намжаах гэсэн хоёр чиглэлтэй байж болно.

Соёл-олон нийтийн болон спортын арга хэмжээнд төрийн болон олон нийтийн байгууллагын тэмдэглэлт үйл явдал, үндэстэн ястны болон төрийн баяр наадмын үеэр зохиогддог өргөн олон түмнийг хамарсан арга хэмжээнүүд багтдаг ажиллагаагаа, улс эх орноо сурталчлах зорилго агуулдаг.

Шашны арга хэмжээ нь шашны зан үйлтэй холбоотой төрөл бүрийн ажиллагаа, баяр болон шашин дундын харилцаанд зөрчил, үл ойлголцох байдал бий болж хүндэрч хурцадсан үед зохиогддог шашнаа сурталчлах, зөрчилт байдлыг намжаах зорилго агуулсан арга хэмжээ байдаг.

Эндээс харвал нийтийг хамарсан арга хэмжээ нь дараах шинжүүдийг агуулж байна. үүнд:

- Тодорхой зорилго агуулсан байх;
- Хамтын зохион байгуулалтад тулгуурласан байх;
- Тодорхой хэмжээний хөрөнгө мөнгө зарцуулсан байх;
- Олон нийтийг хамарсан байх;
- Эрх бүхий байгуулагаас зөвшөөрөгдсөн байх;
- Хуулийн хүрээнд зохион байгуулагдсан байх;
- Тодорхой газар орчныг хамарсан байх;
- Урьдчилан төлөвлөгдсөн байх;

Нийтийг хамарсан арга хэмжээг ямар ч иргэн, байгууллага, аж ахуйн нэгж зохион байгуулж болно. Гагцхүү уг арга хэмжээ нь дээрх шинжүүдийг бүрэн агуулсан тохиолдолд бүрэн утгаараа хэрэгжинэ.

Нийтийг хамарсан арга хэмжээ ихэвчлэн олон нийтийн газар зохион байгуулагдах бөгөөд хуулиар баталгаажсан нийтээр тэмдэглэх баярын өдөр болон нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр зохион байгуулагдана.

Зарим тохиолдолд нийтийн эдэлбэрийн газарт нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулагдах тохиолдол гарч болно.

Нийтийн эдэлбэрийн газар – хот, тосгон, бусад суурины гудамж, талбай, зам, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшлийн бус амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэг, оршуулгын газар, хог хаягдлын цэг, цэвэршүүлэх талбай зэрэг газар⁶

2008-2012 он хүртэл зохион байгуулсан

⁶ С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. УБ. 2008. 295 дахь тал

жагсаал, цуглаан болон бусад олон нийтийг хамарсан арга хэмжээг тоо баримтаар дурьдвал:

- 2008 онд жагсаал 6, цуглаан 30, суулт 19, өлсгөлөн 24,
- 2009 онд жагсаал 3, цуглаан 28, суулт 10, өлсгөлөн 9,
- 2010 онд жагсаал 7, цуглаан 32, суулт 43, өлсгөлөн 13, санал асуулга 9, ажил хаялт 10
- 2011 онд жагсаал 26, цуглаан 119, суулт 56, өлсгөлөн 1, зогсолт 13, санал асуулга 20, хэлэлцүүлэг 30, их хуралдай 24, зам хаах 2, ажил хаялт 6, Төрийн ордны шалган нэвтрүүлэх хаалгыг хаах 1, шаардлага өгөх 2
- 2012 онд жагсаал 9, цуглаан 51, суулт 15, өлсгөлөн 8, санал асуулга 5, хэлэлцүүлэг 2, их хуралдай 2, зам хаах 1, Төрийн ордны шалган нэвтрүүлэх хаалгыг хаах 6, шаардлага өгөх 6, гарын үсэг цуглуулах 9
- 2013 онд жагсаал цуглаан 71, өлсгөлөн 15,
- 2014 онд жагсаал цуглаан 87, суулт 7, ажил хаялт 2,
- 2015 онд жагсаал 38, цуглаан 70, суулт 13, санал асуулга 4, өлсгөлөн 1, ажил хаялт 1
- 2016 онд жагсаал 30, цуглаан 66, суулт 20, өлсгөлөн 1, санал асуулга 4 удаагийн арга хэмжээ тус тус зохион байгуулагдсан байна.

Бид одоогоос 11 жилийн өмнөх буюу 2006 онд зохион байгуулагдсан нийтийг хамарсан арга хэмжээний нөхцөл байдлыг авч үзье.

2006 онд жагсаал, цуглааны зорилго, шаардлагыг багцлан авч үзвэл Улсын Их Хурлыг тараах, Засгийн газрыг огцруулах, Тэтгэвэр тэтгэмжийг нэмэгдүүлэх, Ашигт малтмалын лицензийг хүчингүй болгох, гэрээг цуцлах, тогтвортой байдлын гэрээг ард түмэнд ил тод хийх, Сапугийн хохирогчдын хохиролыг барагдуулах, Хадгаламж зээлийн хоршоодын хохирогчдын хохиролыг төр засаг хариуцах, оюутны сургалтын төлбөрийг багасгах, ядуурлыг бууруулах, агаарын бохирдлыг багасгах зэрэг шаардлагуудыг тавьж байсан байна.

Энэ онд зохион байгуулагдсан жагсаал, цуглаанд нийтдээ 4000 орчим хүн оролцсон байна. Зохион байгуулагдсан жагсаал, цуглааны зохион байгуулалтын аргуудыг авч үзвэл:

- Төрийн байгууллагын үйл ажиллагааг алдагдуулах;
- Төрийн ордны баруун, зүүн хаалга руу дайрах;
- Төрийн ордны цонх руу чулуу шидэх;
- Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг эвдэж сүйтгэх;
- Төрийн алба хаагчийн шаардлагыг биелүүлээгүй эсэргүүцэж эрх чөлөөнд халдах;



- Замын уулзвар, гарцыг хаах, иргэдийг турхирах зэрэг үйлдлүүдийг гаргаж байсан байна. Жагсаал, цуглааны явцад гарсан хууль бус үйлдлийн улмаас үүссэн хохиролыг авч үзвэл замын хөдөлгөөнийг хааснаас болж зам тээврийн осол 45 гарч, эмнэлэгийн яаралтай түргэн тусламжийн машин 31 удаагийн дуудлага хоцорч очин, 1 хүн эмнэлэгт очиж чадалгүй гэртээ төрж, нийтийн тээвэрт төв замын дагуу үйлчилгээнд явдаг 38 тролейбус 322 цаг саатсанаас болж 1.872.000 төгрөгний хохирол учирсан байна.

Зөвхөн цагдаагийн алба хаагчдад учирсан хохирлыг тусгайлан авч үзвэл:

- 33 алба хаагч гэмтсэн;
- 127 алба хаагч гав, бороохой, малгайгаа алдсан;
- 70 алба хаагч хувцас, мөрдөсөө уруулж тасдуулсан;
- 230 алба хаагч ямар нэг байдлаар хохиржээ.


Харин авсан арга хэмжээг авч үзвэл Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу жагсаал, цуглаан оролцогч, зохион байгуулагч нарт албан мэдэгдэл, шаардлага өгч, жагсаал цуглааны нөхцөл байдалтай холбогдуулан 1 удаагийн хамгаалалтад 30-750 орчим цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдыг батлагдсан төлөвлөгөө, зураглалын дагуу ажилласан байна.

Жагсаал, цуглааны явцад хууль бус үйлдэл гаргасан иргэдэд хүлээлгэсэн хариуцлагын талаар авч үзвэл Төрийн ордны цонхыг хагалсан, төрийн алба хаагчийн шаардлагыг биелүүлээгүй эсэргүүцэж эрх чөлөөнд халдсан үйлдэлд харьяа дүүргийн шүүхээр жагсаал, цуглаан зохион байгуулагч 2 хүнийг 35.000 төгрөгөөр торгож арга хэмжээ авсан байна.

Тэгвэл Улаанбаатар хотод 2017 оны 02 дугаар сард 1 удаа цуглаан зохион байгуулагдсан ба өмнөх оны мөн үеийн дүн мэдээтэй харьцуулбал 6 нэгжээр буюу 87.8 хувиар буурсан дүн гарсан байна. Үүнийг зургаар харьцуулан авч үзвэл:

Зохион байгуулагдсан жагсаал, цуглааны талаар нарийвчлан авч үзвэл Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны урд талбайд 2017 оны 02 дугаар сарын 01-ны өдөр зохион байгуулагдсан цуглаан бүртгэлтэй байсан бөгөөд уг жагсаал цуглааныг МУИС-ийн оюутны холбооны тэргүүн С.Хосбаатар удирдан зохион байгуулж, нийтдээ 130 иргэн оролцсон байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Жагсаал цуглаан хийх журмын тухай хууль болон Жагсаал, цуглааны үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах журам⁷⁾ /код 502/-д заасны дагуу жагсаал, цуглаан зохион байгуулагчид албан мэдэгдэл шаардлага өгч, тухайн орчинд хэв журмын эргүүлийн чиглэл ажиллуулан мэдээ, мэдээлэл цуглуулан хяналт тавьж ажилласан байна.



⁷⁾ ЦЕГ-ын даргын 2015 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн а/44 тоот тушаалаар батлагдсан.



Тэгвэл одоо гадаадын зарим орнуудад жагсаал, цуглаан хэрхэн зохион байгуулах, хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар товчхон авч үзье. Жишээлбэл:

Их Британи: Жагсаал цуглаан зохион байгуулагчид ажлын зургаан өдрийн өмнө орон нутгийн цагдаагийн хэсгээс зөвшөөрөл авдаг. Мэдэгдэлд зохион байгуулагчийн овог нэр, хаяг, жагсагчдын зорилго, ороцогчдын тоо, хэзээ, хаана ямар замаар явах маршрутыг тодорхой бичнэ.

Эмх замбараагүй байдал үүссэн тохиолдолд зохион байгуулагчдыг 10 жил хүртэл хугацаагаар хорих, өдөөн хатгалга, хүчирхийлэлд уриалан дуудагсдыг зургаан сар хорих буюу 5000 еврогоор торгох, товлосон цаг, явах маршрутыг өөрчилбөл гурван сар хорих буюу 1000 еврогоор торгох шийтгэл ногдуулна.

Герман: Жагсаал цуглаан зохион байгуулахаас хоёр хоногийн өмнө орон нутгийн цагдаагийн хэсэгт мэдэгдлээ өгнө. Зөвшөөрөлгүй жагсаал хийвэл нэг жил хүртэл хугацаагаар хорих, явах замын чиглэлийг өөрчилбөл зохион байгуулагчдад торгууль ногдуулах буюу зургаан сар хүртэл хугацаагаар хорих шийтгэл ногдуулна.

Жагсаал цуглаан хяналтаас гарсан тохиолдолд зохион байгуулагчид тараах мэдэгдлээ даруй хийж, түүнээс хойш шаардлагад захирагдаагүй этгээдийг эрүүгийн болон бусад хариуцлагад хүлээлдэг юм байна.

Итали: Галт зэвсэг хэрэглээгүй бол энэ улсын иргэд дуртай газраа цугларах эрхтэй, харин олон нийтийн газарт жагсаал цуглаан зохион байгуулах хүсэлтээ гурван өдрийн өмнө цагдаагийн хэсэгт мэдэгдэнэ.

Зөвшөөрөл авалгүй цуглаан зохион байгуулсан тохиолдолд торгууль ногдуулах буюу 1-12 сар баривчлах, эмх замбараагүй байдал үүсгэсэн иргэд учруулсан эд материалын хохирлыг бүрэн барагдуулах үүрэгтэй.

АНУ: Жагсаал цуглаантай холбоотой асуудлыг мужуудын эрх баригчид шийддэг учраас газар бүрт өөр өөр байдаг. Нью-Йорк хотод цуглаан зохион байгуулах бол 45, Лос-Анжелест 40, Вашингтонд 15 хоногийн өмнө мэдэгдэнэ.

Засгийн газар, захиргааны барилгын ойролцоо жагсахыг хориглож, явах замын чиглэлийг хязгаарласан байдаг. Зөвшөөрөлгүй жагсаал, цуглаан явуулбал шууд л эмх замбараагүй байдал үүсгэсэн гэж үзэн цагдаа нар жагсаалыг хөөн тарааж, идэвхтэй гишүүдийг баривчлах эрхтэй. Ихэнх тохиолдолд захиргааны арга хэмжээ

авч, 3000 доллараар торгох шийтгэл ногдуулдаг.

Харин Техас зэрэг мужид зургаан сар хорих шийтгэл хүлээлгэдэг байна. Зөвшөөрөлгүй цуглааны үеэр галт зэвсэг хэрэглэж, эмх замбараагүй байдал үүсгэсэн тохиолдолд 10 хүртэл жилийн хугацаагаар хорих шийтгэл ногдуулдаг.

Франц: Жагсаал цуглаан зохион байгуулагчид 3-15 өдрийн өмнө өргөдөл гаргах ёстой. Урьдчилан зөвшөөрөл авалгүй жагсаал, цуглаан хийвэл зургаан сар хорих, 7500 еврогоор торгох шийтгэл хүлээлгэдэг юм байна.

Эмх замбараагүй байдал дэгдээсэн иргэдэд Эрүүгийн хуулийн дагуу шийтгэл хүлээлгэдэг. Галт зэвсэг хэрэглэсэн этгээдэд 5 хүртэлх жилийн хугацаагаар хорих, 75000 еврогоор торгох, нүүрээ нуусан жагсагч 3 жил хугацаагаар хорих буюу 45000 еврогоор торгох шийтгэл ногдуулдаг.

Монгол Улсад: Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн 15 дугаар зүйлд жагсаал цуглааныг зохион байгуулж, нийтийн эмх замбараагүй байдал үүсгэсэн гэм буруутай байгууллагад 150000-250000 төгрөгөөр торгох, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол иргэнд 20000-50000, албан тушаалтанд 25000-50000 төгрөгөөр торгох, эсхүл 14-30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл ногдуулдаг.



Монгол Улсад зохион байгуулагдаж буй нийтийг хамарсан арга хэмжээ 2017 оны 02 дугаар сард нийслэлд 30, орон нутагт 4, улсын хэмжээнд 55 удаа зохион байгуулагдсан ба өмнөх оны дүн мэдээтэй харьцуулбал 60 нэгжээр буюу 52.1 хувиар буурсан.

Нийтийг хамарсан арга хэмжээний өнөөгийн нөхцөл байдлыг авч үзье. 2017 оны 02 дугаар сард урлаг, спортын арга хэмжээ 4, төрийн тусгай хамгаалалт болон гадаадын зочин төлөөлөгчийн айлчлал 47, бусад арга хэмжээ 4 удаа тус тус зохион байгуулагдсан ба дээр арга хэмжээнд 3521 иргэд оролцож, хамгаалалтад 315 алба хаагч, 34 автомашинтай үүрэг гүйцэтгэжээ.

Зохион байгуулагдсан нийтийг хамарсан арга хэмжээнүүд нь Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Аймаг, нийслэлийн Засаг дарга нарын захирамжаар зохион байгуулагдсан байна.

Дээрх нийтийг хамарсан арга хэмжээний явцад цагдаагийн байгууллага Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах журам^[8] /код 500/- д заасны дагуу хэв журмын эргүүлийн

⁸ ЦЕГ-ын даргын 2015 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн а/44 тоот тушаалаар батлагдсан.



чиглэлийг ажиллуулан урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, объектын хамгаалалтыг авч ажилласан байна.

Дүгнэлт, санал:

Сүүлийн жилүүдэд манай улсад ажилгүйдэл ядуурал, улс төр, эдийн засгийн тогтворгүй байдал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль зэргээс үүдсэн нийгмийн сөрөг хандлагууд ихсэх төлөвтэй байна.

Ялангуяа иргэдийн зүгээс төрийн үйл ажиллагаа, удирдлагуудыг буруутгах, аливаа асуудлыг улс төржүүлэх, хууль бус жагсаал цуглаан зохион байгуулах, бусдыг өдөөн турхирах, хууль зөрчих явдал ихсэж болзошгүй хандлага ажиглагдаж байна.

Нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед дэг журам сахиулах, хууль бус жагсаал, цуглааныг албадан тараах төлөвлөгөөнөөс гадна согтууруулах ундаа хэрэглэсэн болон сэтгэцийн өвчтэй хүмүүсийг жагсаал, цуглаанд оролцуулах, жагсаал, цуглааны явцад жагсагчдад согтуурлах ундаа хэрэглүүлэх, гудамж, замын хөдөлгөөнийг бүслэн хаах, аливаа байгууллагын хэвийн ажиллагааг алдагдуулах, суулт хийх, өлсгөлөн зарлах шинж илэрсэн тохиолдолд түүнээс урьдчилан сэргийлж

ажиллах тусгайлсан төлөвлөгөө, арга зүйг боловсруулан хэрэгжүүлэх, удирдлага, зохион байгуулалтын шинэлэг аргуудыг авах шаардлага бий болжээ гэсэн дүгнэлтийг хийж байна.

Нийтийг хамарсан арга хэмжээний нөхцөл байдлыг хяналтад авч, гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр нөлөөг дээшлүүлэх үүднээс дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Нийтийг хамарсан арга хэмжээний зорилго, хүрэх дүнд урьдчилан дүн шинжилгээ хийж, нөхцөл байдлыг хяналтад авах арга зүйг боловсруулах мэргэшсэн нэгжийг байгуулах;

2. Цаг үеийн нөхцөл байдлын мэдээ, гарч болзошгүй эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө, эрсдлийн шалгуурыг тусгасан бүртгэлийн маягтаас бүрдсэн хавтасыг бий болгож Шуурхай удирдлагын штабт байршуулах;

3. Жагсаал, цуглааны үед цагдаагийн хууль сахиулах ажиллагаанд дэвшилтэт техник, технологи, шинэ санаачлага, гадаадын орнуудын туршлагыг судалж нэвтрүүлэх;

4. Нийтийг хамарсан арга хэмжээний аюулгүй байдлыг хангах алба хаагчдыг тусгайлан бэлтгэх, ухуулагч, сэнхрүүлэгч гэх мэт мэргэшсэн алба хаагчтай болох;

5. Жагсаал, цуглаан, нийтийг хамарсан арга хэмжээний талаарх мэдээллийн сан бий болгож, 2005-2016 онд зохион байгуулсан жагсаал, цуглааны нөхцөл байдлын мэдээллийг нэг бүрчлэн бүртгэж оруулах;

Ашигласан материал:

1. Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ. 1966.

2. Ж. Таванжин. Монгол Улсын цагдаагийн эрх зүй. УБ. 2006.

3. С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. УБ. 2008.

4. Л. Билгээ. Цагдаагийн үйл ажиллагааны арга зүйн зарим асуудлууд. УБ. 2009.

5. Ж. Долгорсүрэн. Монгол Улсын цагдаагийн эрх зүйн курс. УБ. 2014.

6. "Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах журам" /код 500/

7. "Жагсаал, цуглааны үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах журам" /код 502/^[9]

⁹ ЦЕГ-ын даргын 2015 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн а/44 тоот тушаалаар батлагдсан.



ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ИННОВАЦИЙГ НЭВТРҮҮЛЭХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

Б.Наргулан

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн
Цагдаагийн эрх зүйн тэнхмийн багш,
цагдаагийн дэд хурандаа

XX зууны сүүл хагасаас эхлэн дэлхий дахинд оюуны бүтээлийн үнэ цэнэ үлэмж нэмэгдэн мэдлэг, түүний үр дүн капитал, хөдөлмөрийн нэгэн адил эдийн засгийн нөөц, үйлдвэрлэлийн хүчин чадал, эрх зүйн зохицуулалт нь чухал үүрэг гүйцэтгэдэг болсон байна. Дэлхийн аль ч өнцөгт буланд байгаа, эсвэл баян, ядуу эсэхээс үл хамааран улс орон бүр мэдлэг бий болгох, дэлгэрүүлэх, ашиглахад суурилсан эрх зүйн зохицуулалттай нийгэм буюу өөрөөр хэлбэл, инноваци тийгэм байгуулахад зорих болсон нь олон улсын хөгжлийн орчин үеийн шатны нийтлэг чиг хандлага боллоо.^[1]

Инновацийн соёл, хөгжил эхлэлийн төдий байгаа Монгол орны тухайд инновацийн үйл явц нийгмийн цоо шинэ үзэгдэл болж байна. Зах зээлийн харилцаанд шилжих шилжилтийн жилүүдэд үндэсний инновацийн тогтолцооны зарим нэг элемент бий болсон хэдий боловч хөгжлийн явц нь урсгал шинжтэй, өөр хоорондоо уялдаа холбоо муутай байв. Энэ үед инновацийн тогтолцоог цогцоор бүрдүүлэх асуудал бие даасан бодлогын төвшинд тавигдаж байсангүй. XXI зууны босгон дээр Монгол Улс дотоод нөөц боломжоо тооцон алс хэтийг харсан хөгжлийн чиг шугамаа тодорхойлохдоо чухамхүү инновацийн замыг сонгож авсан. 2007 онд төрөөс үндэсний инновацийн тогтолцоог жинхэнэ утгаар нь бүрдүүлэн хөгжүүлэхэд чиглэсэн өргөн хүрээтэй үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулж баталснаар Монгол улсын инновацийн хөгжилд цоо шинэ үе эхэлсэн гэж үзэж болно.

Монгол Улс төвлөрсөн эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн жилүүдэд гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийг илрүүлэхэд гол ач холбогдол өгч байсан бол дараачийн шатанд гэмт хэрэгтэй тэмцэх асуудлыг гол зорилгоо болгож байна. Энэ зорилгод хүрэхийн тулд улс орныг инновацийн хөгжлийн замаар замнуулах нь улам бүр өсөн нэмэгдсээр буй нь гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх гол арга мөн гэсэн үзэл ойлголт манайд төлөвшөөд байна.

Бүтээгдэхүүн бий болгох шатан дээр аливаа мэдлэгийг бүрэн эзэмших хэрэглэх нь үлэмж хэмжээний нэмэгдсэн өртөг бүтээж,

тэр нь асар их ашиг орлого оруулж байна. Инновацийн онолын эцэг хэмээн нэрлэгддэг Й.Шумпетер үүнийг инновациас өгч буй шан харамж хэмээн нэрлэсэн байдаг.^[2] Орчин үед “Инноваци” (innovation) гэсэн ойлголт ерөнхий утгаараа “шинэчлэх” гэсэн утга санааг илэрхийлж байна. Инновацийн онолын үндэслэгч Й.Шумпетер инноваци бол “бизнесийн зорилгоор үйлдвэрлэлийн хүчин зүйлсийг шинжлэх ухаан-зохион байгуулалтын хувьд шинээр нэгтгэх явдал” гэжээ.^[3] Инновациар мэргэшсэн дэлхийн олон эрдэмтэн энэ ойлголтыг олон талаас нь шинжин янз бүрээр тодорхойлж байгаа ч эцсийн дүндээ үндсэн санаа нь адил төстэй байгааг ажиглаж болно. Я.Кук, П.Майерс нар “Энэ бол шинэ санаанаас зах зээл дээр борлуулж буй бэлэн бүтээгдэхүүн хүртэлх бүхэл бүтэн үйл явц” гэж үзсэн. Б.Твисс “Шинэ санаа, бүтээл эдийн засгийн агуулгатай болох процесс”, М.Додгсон “Инноваци бол шинэ (сайжруулсан) бүтээгдэхүүнийг, эсвэл шинэ (сайжруулсан) үйлдвэрлэлийн үйл явц, юмуу тоног төхөөрөмжийг худалдааны эргэлтэд оруулахад чиглэсэн эрдэм шинжилгээ, технологи, зохион байгуулалт, санхүүгийн үйл ажиллагаа юм.”^[4] Унгарын эрдэмтэн Б.Санго “Инноваци нь шинэ санаа, бүтээлийг практикт хэрэгжүүлэх замаар шинж чанарын хувьд нь илүү сайн бүтээгдэхүүн, технологи бий болгох нийгэм-эдийн засгийн процесс бөгөөд үүний тулд нэмэгдсэн өртөг бий болно” гэж үзсэн байна.^[5] 1993 оны Фраскатын удирдамж (1993 онд Италийн Фраскати хотод) Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага (ОЭСР)-аас баталсан баримт бичигт инновацийг “шинэ ба шинэчилсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх, технологийн процессыг боловсронгуй болгох, нийгмийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр явуулж буй үйл ажиллагааны эцсийн үр дүн” гэж тодорхойлсон бол 1996 оны Ослогийн удирдамжид “технологийн хувьд цоо шинэ, эсвэл сайжруулсан бүтээгдэхүүн, үйл ажиллагааг зах зээлд нэвтрүүлэхийг инноваци” хэмээн тодорхойлсон байдаг.

Монгол улсын Шинжлэх Ухаан Технологийн тухай хуульд “инноваци” гэж эрдэм шинжилгээний ажлын үр дүнг эцсийн бүтээгдэхүүн болгон зах зээл, үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх цогц үйл ажиллагаа^[6] гэж тодорхойлсон байдаг.

Тэгэхээр инновацийг хэмжих үндсэн

² <http://www.maxwell.syr.edu/collaboration/msu/Distance/Innovation/01-01.htm>

³ Н.Хүүхэнжимээ. “Инновацийн таатай орчинг бүрдүүлэх асуудал УБ 2006. 67-70

⁴ [Http://www.maxwell.syr.edu/collaboration/msu/Distance/Innovation/01-01.htm](http://www.maxwell.syr.edu/collaboration/msu/Distance/Innovation/01-01.htm)

⁵ О.Л.Молчанов “Понятие инновации и ее основные свойства” 2001. 35-42 дэхь тал

⁶ ШУТ-ийн тухай хуулийн 3.1.9-р зүйл

¹ Х.Маам “Инноваци” УБ. 2009 он 6 дахь тал.



шинжүүд (шалгуурууд) бол шинжлэх ухаан-технийн хувьд шинэлэг байх, (аж үйлдвэр, хөдөө аж ахуй, эрүүл мэндийг хамгаалах, хууль сахиулах, боловсрол зэрэг үйл ажиллагааны салбаруудад) хэрэгжихүйц, зах зээлд арилжаалагдах шинжтэй, энэ чанараараа хэрэглэгчдийн тодорхой эрэлт хэрэгцээг хангаж чадахуйц байх явдал юм. Зөвхөн шинэ бүтээгдэхүүн эсвэл шинэ процесст шингэж бүтээгдсэн шинэлэг санаа л сая инноваци болж байна.

Шинэ зүйл ба инноваци гэсэн хоёр ойлголтыг зааглаж үзэх хэрэгтэй байна⁷. Шинэ зүйл гэдэг бол үр ашгийг нь дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны аль нэг хүрээнд явуулсан суурь, хавсарга судалгаа, шинжилгээ, боловсруулалт болон туршилтын ажлын үр дүнгийн тодорхойлолт юм.

Шинэ зүйлийг өөрийнхөө хэрэгцээ (өөрийнхөө үйлдвэрт нэвтрүүлэхээр, эсвэл дараа нэвтрүүлэхээр хуримтлуулах)-г хангах үүднээс, худалдах зорилгоор өөрсдөө бүтээдэг.

Инноваци бий болгох судалгаа шинжилгээнээс эхлээд маркетингийн боловсруулалт хийх хүртэл явуулж буй бүх төрлийн ажиллагааг инновацийн үйл ажиллагаа гэнэ.

Гэмт хэрэг мөрдөхүйн хөгжлийг философи, ёс зүй, уламжлал, эрх зүй, соёл, нийгмийн байгуулал, эдийн засаг, улс төр хийгээд шинжлэх ухааны ололт амжилт, технологи гээд маш олон салбар мэдлэгийн тогтолцооны нэгдэл, диалектик зөрчилд нь авч үзэх шаардлагатай байдаг.

Гэмт хэрэг нийгмийн үзэгдлийнхээ хувьд түүний хөгжлийн хүрсэн түвшин хийгээд өөрийн гарал үүслээрээ үүсэн бий болох, өөрчлөгдөх (үгүй болох эсхүл үгүйсгэгдэх) зүй тогтолтой байдаг гэж үзвэл гэмт хэргийг мөрдөх нь мөн л тэрхүү зүй тогтолтой харилцан хамааралтай байна. Энэхүү хамаарлыг социодинамикийн үүднээс авч үзвэл, хөгжлийнхөө дээд эрэмбэ руу өөрөөр хэлбэл, энгийнээс илүү нарийн руу чиглэсэн тасралтгүй хөгжих үйл явц гэж үзэж болно. Нөгөөтэйгүүр боловсронгуй гэж үзэж байгаа үйл явц аажмаар өөрчлөгдөн хувьсаж байдаг зүй тогтол байдаг.

Нийгмийн хөгжил хөдөлгөөний үйл явцад тасралтгүй хөгжиж ирсэн бүхий л үзэгдэл юмсыг дагалдаж ямагт түүний сүүдэр болох гэмт хэрэг, зан үйл энэхүү цаг үеийг хүртэл тасралтгүй орон зайгаа үлдээсээр ирлээ. Аливаа нийгэмд төр нь хүчтэй байж, төр иргэдийнхээ эрхийг хамгаалж улс үндэстнийхээ аюулгүй байдлыг хангадаг нь зүй билээ. Хүчтэй төр оршин тогтнохын нэг үндэс бол цагдаа, хууль сахиулах байгууллагуудын мэргэжлийн өндөр түвшинд

⁷ Бурнышева "Управление инновациями и модернизация М. 1999. 7 дахь тал

орчин үеийн техник технологийн дэвшлийг ашиглан явуулж байгаатай холбоотой. Тийм учраас дэлхийн цагдаа, хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаанд шинжлэх ухаанд суурилсан инновацийг нэвтрүүлж улсынхаа үндэсний аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам, иргэдийн эрхийг ханган хамгаалах болжээ⁸.

Хууль сахиулах болон цагдаагийн байгууллагад төрийн бусад албаны нэгэн адилаар нийгмийн өөрчлөлтийг даган түүнд нийцүүлэн өөрийн үйл ажиллагааг шинэчлэх, хөгжүүлэн ажиллах шаардлага тавигдаж байна. Иймээс улс орнууд гэмт хэрэгтэй тэмцэх болон цагдаагийн байгууллагынхаа шинэчлэлтийг чухалчлан төрөл бүрийн инновацийг нэвтрүүлэн хэрэглэж байна.

АНУ-д 1980-1990 онуудад боловсруулсан инновацийг өнөөг хүртэл хөгжүүлэн хэрэглэж байна. XIX зуун болон XX зууны эхэн үед Америкийн хууль сахиулах байгууллагын ажилтан үндсэндээ улс төрийн үйлчилгээний ажилтанууд байсан ба эрүүгийн хуулийн болон иргэний эрхийн мэдлэг хязгаарлагдмал байсан байна. Цагдаагийн инновацийг АНУ-ын эрдэмтэд (Мооре, Спелман нарын) хөтөлбөрийн, захиргааны, технологийн болон стратегийн гэж ерөнхийд 4 ангилж байна. Хөтөлбөрийн инноваци нь цагдаагийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр хийгдэж байгаа төрөл бүрийн хөтөлбөрүүд тухайлбал, "хагархай цонх" / broken windows/ хөтөлбөр, "хөршийгөө харх" /neighborhood watch/ хөтөлбөр, сургуулийн насныханд хар тамхины хор хөнөөлийн талаар сургалт явуулах төрөл бүрийн хөтөлбөр, насанд хүрээгүйчүүдэд хорих ангийн бодит байдлыг мэдүүлэх ажиллагаа зэрэг хөтөлбөрүүд юм.

Захиргааны инноваци нь цагдаагийн байгууллага үйл ажиллагаандаа өөрсдийгөө хэрхэн бэлтгэх, ололт амжилтаа тооцоолох зэргийн өөрчлөлт шинэчлэл байдаг. Цагдаа, цагдаагийн хэлтэс, нэгжүүдийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг сайжруулах, түүнийг үнэлэх, түүнчлэн шинэ технологи, сургалт зэргээр дадлагажуулах зэрэг нь багтдаг байна.

Технологийн инноваци гэдэгт цагдаагийн хөнөөлт бус зэр зэвсэг, эдлэл хэрэглэл, ДНК-ийн шинжилгээ болон гэмт хэргийн цахим зураглал хийх зэргийг шинэчлэх асуудал хамаардаг. Технологийн инноваци мэдээлэлд суурилсан технологи (soft) болон материалд суурилсан технологи (hard) гэсэн 2 хэлбэртэй байдаг. АНУ-д технологийн инноваци асар хурдтай хийгдэж байгаа бөгөөд софт хэлбэрийн инновациудын хувьд компьютерийн шинэ програм

⁸ Б.Одонгэрэл " АНУ дахь цагдаагийн инноваци, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал, түүнээс суралцах нь" Хууль сахиулахуйн инноваци ОУЭШХ 2014 он 173 дахь тал.



хангамж, ангиллын систем, гэмт хэргийн анализ хийх техник, (Компстат), баримт мэдээ болон системийн холбооны техник, түүнчлэн материалд суурилсан технологийн хувьд хурууны хээний бүртгэл, гар утасны мэдээлэл хадгалах тусгай төв, цагдааг хамгаалах хэрэгсэл зэрэг (хүрэм, сум нэвтэрдэггүй хантааз, цагдаагийн машин гэх мэт) байдаг байна.^[9]

Стратегийн инноваци нь байгууллагын хэтийн чиг хандлага, түүний ерөнхий философийн үндсэн өөрчлөлт дээр суурилж хийгддэг. Эдгээр өөрчлөлтүүд нь цагдаагийн байгууллагын үндсэн зорилго, үйлчилгээний цар хүрээ, цагдаагийн байгууллагаар хангагдах үйл ажиллагаа, цагдаагийн ажилтны зорилгоо биелүүлэх арга хэрэгсэл, дотоод, гадаад харилцаа холбооны түлхүүр ойлголт зэргүүдийг дахин тодорхойлох явдал байдаг. Энэхүү инноваци нь “хууль сахиулах”-аас “асуудал шийдвэрлэх” руу шилжих ингэхдээ төрөл бүрийн тактикаар нийгмийн бусад хэсгүүдтэй хамтран ажиллах зэргийг чухалчилдаг. АНУ-ын цагдаагийн албанд хамгийн үр дүнтэй хэрэгжиж байгаа дараах инновациуд байна. Үүнд:

1. Нийгэмд суурилсан цагдаа.

2. Мэдээлэлд суурилсан цагдаа

Монгол улсад цагдаагийн инноваци хийх хэрэгцээ, шаардлага

Монгол улсын хуулиар цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүрэг бүхий хууль сахиулах байгууллага гэж тодорхойлсон байдаг. Цагдаагийн байгууллагад олон жилийн турш уламжлалаа хадгалсан шинэчлэл хийгдсээр байгаа ч шинжлэх ухаан, судалгаанд суурилсан томоохон инновациудыг нэвтрүүлэх шаардлагатай байна. Монгол Улсын цагдаагийн байгууллагад эрх зүйн шинэчлэл хийгдсэний нэг бол Цагдаагийн албаны тухай хууль батлагдан гарсан явдал юм. Хуучны дадсан, хэвшсэн, хэв маягаас гаргах ба нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн шинэ хандлага төлөвшүүлэх шаардлага зүй ёсоор тулгарч байгаа болно. Цагдаагийн төв байгууллага болон олон улсын холбогдох байгууллагуудын байнгын анхаарал, идэвхтэй оролцоо шаардлагатайг зөвлөсөн.^[10]

Монгол улсад гэмт хэргийн тоо өсөн нэмэгдэж, ард иргэдийн цагдаад итгэх итгэл, тэднийг үнэлэх сэтгэл хангамж сул байгаа нь 1960 оны АНУ-ын цагдаагийн байгууллага шинэчлэл хийх үндэслэл болсон шалтгаантай адил байгааг харуулж байна.

Одоо үед гадаадын болон манай улсын

⁹ Жеймс Бирне. Гарри Маркс “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон цагдаагийн үйл ажиллагаан дэхь технологийн инновацийн хэрэгжилт, үр нөлөөний судалгаа”. 2011 он.

¹⁰ Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрөөс

зарим судлаач, шинжээчид Монгол Улсын цагдаагийн байгууллагад мэргэжлийн болон технологийн шинэчлэл хийснээр үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, шуурхай хүргэх үндсэн нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзэж байна. Тийм учраас цагдаагийн байгууллагад шинэчлэл хийхийн тулд шинжлэх ухааны үндэслэлтэйгээр технологийн инноваци нэвтрүүлэх шаардлагатай байна.

Дүгнэлт

Монгол Улсын цагдаагийн байгууллага үндсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэхийн тулд гадаад зарим орнуудын цагдаагийн байгууллагуудын гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон цагдаагийн үйл ажиллагааг сайжруулах талаар үлгэр жишээ болохуйц олон ажлыг хэрэгжүүлж байгаа хэдий ч улс бүр соёл, ёс заншил, уламжлал, түүхийн үнэт зүйл, хэм хэмжээгээр ихээхэн ялгаатай тул тэдгээр аргыг шууд туршлага болгох нь учир дутагдалтай байж болох талтай юм.

Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрт, гэмт хэрэгтэй тэмцэхэд инноваци нэвтрүүлэх талаар тодорхой зүйлүүд дурдагдаагүй байна.

Хөтөлбөрийн “Олон нийттэй харилцах (үйлчлүүлэгч, хэрэглэгчтэй, маркетинг) зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2 дугаар заалтад “иргэд үйлчилгээ авах орон зай бий болгох, үйлчилгээний нэгдсэн стандартыг хэрэгжүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор албаны нэг загварын барилга байгууламж (ажлын байр)-тай болгож, орчин үеийн машин, техник хэрэгслээр хангах арга хэмжээ авч, гадаад өнгө төрхийг шинээр бий болгох” гэсэн нь орчин үеийн машин, техник хэрэгслээр хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр инновацийг хэрэгжүүлэхээр чиглэл заасан байж болох талтай юм. Гэхдээ тухайн ажлыг хэрэгжүүлэх талаар ямар арга хэмжээ авч, ямар үр дүнд хүрэх талаар гарсан бичиг баримт байхгүй байна гэж дүгнэж болохоор байна.

КРИМИНАЛИСТИКИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Б.Жаргалсайхан
ХСИС-ийн ЭШИГ-ын Хууль сахиулахын
инновацийн төвийн эрхлэгч,
доктор, цагдаагийн хурандаа

**МОНГОЛЫН КРИМИНАЛИСТИКИЙН
ТҮҮХИЙН ХУУДАСНАА НЭМЭРЛЭХҮЙ:
МӨР МӨШГИН ХОХИРОЛ
НЭХЭМЖИЛЖ БАЙСАН ТУХАЙ НЭГЭН
БАРИМТ**

Манай үндэсний архивын газрын хөмрөгт хадгалан буй баримтын дунд Манжийн үеийн Монгол оронд эрүүгийн хэргийг шийтгэн явуулж байсан тухай нугалбар цөөнгүй. Тэдний нэг, “Мөр мөшгисэн тухай” тэмдэглэлийг олны сонорт хүргэхийг энэ удаад зорилоо.

Хуулийн их дээд сургуульд криминалистик хичээлээр “Мөр судлал” сэдвийг заахдаа мөрийг илрүүлэх, бэхжүүлэх, цуглуулах, ашиглах гэсэн дөрвөн үндсэн шаттайгаар, дотор нь олон үе болгож заагладаг. Энэхүү ажиллагаанд, мөрийг илрүүлсний дараа түүний агуулж буй мэдээлэл-танин мэдэхүйн бүтэц буюу тухайн мөрийг үүсгэгчийн талаарх мэдээллийг гарган авах ажиллагаа багтана. Үүсгэгчийн талаарх мэдээлэлд мөр үүсгэгчийн ирсэн, буцсан чиглэл орох ба үүнийг мөр мөшгих хэмээн нэрийдэж, хаанаас ирээд хаа буцаж, хаана хүрснийг чухам энэ ажиллагаагаар тогтоодог.

Манай эрдэмтэд, судлаачид энэ чиглэлд анхаарлаа байнга хандуулж ирсэн ба үүнд доктор С. Бадарчи, Ж. Хурцгэрэл, Б. Бат-Эрдэнэ, Ц.Гантулга, магистр Ш.Довдон нарын бүтээл зүй ёсоор орно.

Архивт буй, дээр дурдсан нугалбарт бичсэнээс үзвэл мөрийг илрүүлэх, илрүүлсэн мөрний мэдээлэл-танин мэдэхүйн бүтцийг уншсаны үндсэн дээр хэдэн тооны ямар малыг ямар унаатай, хэдэн хүн хөөж явсныг тогтоон мөшгих, мөшгисэн мөрийг хүлээлгэн өгөх, түүндээ үндэслэн алдсан малыг нэхэмжлэн авч байсныг лавтай нотолж байна.

Бичигт сонирхол татам зүйл нэлээд ажээ. Үүнд:

- Юуны өмнө, Монгол бичгээр ямар утгатай бичвэрийг, ямар хэлбэртэй бичих тодорхой дэг байсан тул уншигч хүн захидлыг задалмагц уншиж эхлэхээсээ өмнө бичгийн хэвээр утгыг мэдэж болдог гэдэг. Хандажбайгаа талаа хүндэтгэсэн бичгийн сүүлийг тавиу, урт бичдэг бол, заргын бичгийн сүүлийг бичигч тал уцаар, ундууцлаа илэрхийлэн богино,огцом татаж төгсгөдөг байсан гэдэг^[12] бөгөөд энэ нугалбарт ч

¹² Дээр дурдсан заргын сүүлийн талаар академич Б.Ринчин: “Цэг тавихдаа зүүн гар талаас баруун гар тийш доош нь татасхийн тавьдаг зарчимтай нь, мөн л бичих

бичгийн хөдөлгөөний дийлэнхийг огцом, богино сүүлтэй төгсгөжээ.

- Өөрийн нэгэн аймгийн ханыг “Халхын Очирой бат Түшээт хаан” хэмээн өргөмжилсөн мөртөө Оросын хатан хааныг “Их Авай^[12] хан...” гэсэн нь нэн сонин.

- Бичгийн нэгэн зүйлд гурван морь хулгайлж, нэг унага алж аваад явсан гурван хулгайчийн мөрийг мөшгисөөр Оросын харуул зангид өгөхөд, занги хоёр бараа бологчтой ирж, гурван морийг зүсээр өгснөөр барахгүй, унаганы оронд шүдлэн байдас өгснийг дурдаад, дөчин яллыг өгөлтэй гэж нэхжээ. Үүнээс үзэхэд, алдсан нэг адуунд /эсвэл бодод/ ялал хэмээх торгууль арвыг төлдөг журам байсан бололтой. Харин тэрхүү торгуулийг “ялал, ял, ор ял, ор ялал, ялай” гэх мэт өөр өөрөөр нэрлэсэн байна.

- Малаа алдсан хохирогч Бат, Эмээл, Оросын харуул занги Мушман зэрэг хүмүүсийг зиндаа эс ялган, нэрний нь ард “...таны...” хэмээн хүндэлдэг байжээ.

- Хоёр ч зүйлд хулгайд алдсан болон ирж тууж явсан морьтны тоог мөрөөр тогтоож, гурван морийг хоёр хулгайч, хоёр хүний таван морийг дөрвөн хулгайч авсан тухайд: “...гурван морийг хоёр хулгайч авсан таван морийг мөшгиж...”, “...Шүр нэрт газраас Дорж тойн, Эмээл таны таван морь дөрвөн хулгайч авсан есөн морийг мөшгиж...” гэж, алдсан таван морины, ирж тууж явсан дөрвөн морьтны есөн мөрийг хүлээлгэж өгсөн тухай бичсэн байна.

- Хоёр ч тохиолдолд мөшгиж очсон мөрөө хүлээлгэн өгөхөд Оросын харуул занги өөрөөсөө гадна хоёр хүн дагуулж ирж

дөхмийн үүднээс заншсан тогтсон бичилгийн ёс аж. Ер аливаа үргэлжлүүлэн бичих үсгийн журам зүйд эргүүлж бүгдийг нар зөв эргүүлж бичихийг мэдүүштэй. Гагцхүү адгийн хойш татсан сүүл, “хэвтээд” гэдгийн гэдсэнд нар буруу эргэдэг зүйл буй. Тэр учраас ч заргын сүүлийг нар буруу эргүүлээд, дээш нь гадосхийн сүүлээ дээш нь хаясан шинж оруул гэж хуучуул ярьдаг үг байж билээ. Адаарсан хадарсан юмандаа заргын сүүл татаж болно. Ах ихэсийн өөдөөс тийм битгий хийгээрэй. Хичээнгүй сүүл татах нь зохино гэж гэж хуучид өвгөд ярьдаг зүйл байсныг цухас тэмдэглэхэд, хожмын хүнд сонин байж болох юм”. (bi-. -Riecia. Moekgo& biciti oa Hlea O ioil. DedA Debde. FoiB* Moehgo& oa Fereoa oa Hb;e& oa Horik t. 8 bet 10 dekiA De& t. Б. Ринчин. Монгол бичгийн хэлний зүй. Дэд дэвтэр. Авиан зүй. УБ.1966.13 дахь тал).*

¹² Авай хан – авай гэдэг үг нэлээд олон утгатай бөгөөд тайлбар толиос харвал энд утга дүйх нь эмэгтэй хүнийг хүндлэх үг, /Я. Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ.1966. 14 дэх тал, Norjia, J. Moehgo& ke;ea O Doxh. FoiB* Moehgo& oa fereoa oa keb;e& oa Horik t. CogololdO Hegel) t Hoda. 1997 foa. 27 dekiA De& t), хэргэмтний хатан эгч (Residoehroš. Forcia Ce(oa Moehgo& hexea O Dobck Dolk. FoiB* Moehgo& oa Sorgea Kimoji& oa keb;e& oa Horik t. Doieh;iyoo.2000 foa.11 dekiA De& t) зэрэг утгатай ба архивт буй хэд хэдэн бичвэрт Оросын хатан хааныг ингэж авгайлсан байна.



байсан баримтаас үзэхэд хөндлөнгийн хоёр гэрчийн үүрэг гүйцэтгэдэг байсан, эсвэл аюулгүй байдлаа хангах үүднээс ийм арга хэмжээ авдаг байсан болов уу гэж дүгнэж болохоор байна.

- Энэхүү бичгийг “Тэнгэрийн тэтгэсний хоёрдугаар оны^[13] өвлийн дунд сарын арван гурванаа” гэж төгсгөсөн байх ба бичвэрийн дээгүүр бичсэн кирил бичиг ч үүнийг нотлож байна. Мөхөс би эртний Слав үсэг үл мэдэх тул бүрэн гаргаж барсангүй, ямартай ч “1737 оны XII сарын 28-ны өдөр хүлээн авав” гэсэн байна. Энэ бичгээс Орос хэлэнд тухайн үед сарыг эхэлж, өдрийг дараа нь бичдэг уламжлал байсныг харж болно.

- Цаг тооны бичгээр хөөвөл 1737 он могой жил байсан ба архивт буй энэ нугалбараар нэхэмжилсэн таван хэргийн дөрөв нь могой, нэг нь луу жилд /1736 онд/ гарсан хулгайн хэрэгт хохирол нэхэмжилсэн байна. Бичгийг өвлийн дунд сард үйлдсэн ба өмнө жилийн зуны дунд сард үйлдсэн хэргийн хохирлыг нэхэмжилсэн байгаа нь хулгайн хэргээр бүртгэл хөтөлдөг байсныг харуулах ба тухайн үеийн журмаар, тодорхой хугацаанд хэргийг бөөгнүүлж байгаад нэгэнтээ нэхэмжилдэг байсан болохыг харуулна.

- Шинэ санааг илэрхийлэх догол мөрийг “О” үсэг маягийн дүрсийн араас “Нэгэн зүйл” хэмээн ялгаж гаргасан зэрэг байна.

Бичвэрийг бүрэн эхээр дор сийрүүлэв:
**«Думдад их дайчин гүрний зах
 хязгаарын хэргийг ялган захирагч,
 Халхын Очирой бат түшээт хааны
 бичиг.**

**Их авай ханы захын хэргийг захирагч
 бригадир комендат^[14] Иван Миитириец
 Пугульц дор илгээв.**

Могой жилийн намрын думдад сарын арван гурваны шөнө манай монгол Салх мэргэний гурван морийг аваад нэг унага алж аваад очсон гурван хулгайчийн мөрийг мөшгиж Хужирын эхээр, Модон хөлийн овоогоор Оросын газар оруулж Орос харуулын занги Бахай дор тушааж өгөв. Занги, Балхүү, Асмалжин гэгч гурвуул ирж гурван морь зүсээр буцааж өгөөд, унаганы ор нэг шүдлэн гэгч байдас өгөв. Дөчин ялалыг өгөлтэй.

О. Нэгэн зүйл. Намрын тэргүүн сарын аравны шөнө Эрин цаламын харуулын Бат таны гурван морийг хоёр хулгайч авсан таван мөрийг мөшгиж Хүдэрийн овоогоор оруулж, Орос харуулын занги Овоо дор тушааж өгөв. Тэр Овоо занги Дорж, Зарвий нэрт хоёр хулгайчаа барьж гурван морь зүсээр өгөөд ялалд бодож хоёр буу, хоёр адуу өгөв. Үлэгсэн хорин зургаан ялалыг

өгөлтэй байнам.

О. Нэгэн зүйл. Луу жилийн зуны думдад сарын тавны шөнө манай монгол Дорж дархан хиагийн дөрвөн морь хулгайч авсан мөрийг мөшгиж Хамар даваагаар Оросын газарт оруулж Орос харуулын занги Мушиман тан дор тушааж өгөв. Тэр Мушиман хүлээж аваад ор ялайг өгөөдүй байнам. Түүнийг өгөлтэй.

О. Нэгэн зүйл. Энэ намрын думдад сарын арван зургааны шөнө Шүрэн нэрт газраас Дорж тойн, Эмээл таны таван морь дөрвөн хулгайч авсан есөн мөрийг мөшгиж Тарвагатайн даваагаар Оросын газарт оруулж, Оросын харуулын занги Галдан тан дор тушааж өгөв. Тэр харуул занги хүлээж аваад чинагши мөшгиж Оросын хамниган Шинээ зайсангийн отгийн дөрвөн хүн ацарч байнам. Хулгайчийн нэр Шинээпүл, Ганнибал, Малх, Шитхэнц гэгчийг олов бид гэж тэр Галдан зангийн үг: “Та долоохон хоноод ирэгтүн. Таны таван морийг зүсээр өгье” гэж хэлээд өгсөн үгүй гэнэм. Түүнийг ор ялтай өгөлтэй байнам.


О. Нэгэн зүйл. Энэ намрын думдад сард арван гуравны шөнө Зэргэтийн харуулын Бичэн зангийн таван адуу хоёр хүн хулгай хийж авсныг мөрийг мөшгиж Оросын газраа оруулж, Оросын харьяат Элэг нэрт голд суусан Мушубан нэрт хүн дор тушааж өгөв. Тэр Мушубаны хэлсэн үг: “Би харуулын хүн биш. Манай харуулын занги Охин хүлээж авах байжээ” гэв. Төдүй бэйл Охин зангид тушаасанд тэр занги Охины хэлсэн үг: “Энэ Мушубан гэгч отгийн хүн болоод харуулын газарт өөрийн дураар орж байнам. Энэ мөрийг үүнд хүлээлгэхийг мөн” гэж хүлээв. Түүний ор ялал өгөлтэй байнам. Үүний тул өөрийн гараар батлаж, тамгаар бэхилэв.

¹³ Тэнгэрийн тэтгэсний анхдугаар он 1736 он байсан тул энэ нугалбарыг 1737 онд үйлджээ.

¹⁴ Бригадир комендат – энэ үгийг Монгол бичгээр “bereeedi* Homiedea – Бархадир хоминдад” гэсэн байна.

Тэнгэрийн тэтгэсний хоёрдугаар он өвлийн думдад сарын арван нэгнээ.»

Хавсралт 1



Монгол бичгээр бичсэний дээд талбай хэсгээр кирил үсгээр “Получено в селенгян..... Столняна Церена декабря 28 дня 1737 год...” гэж эртний Слав үсгээр, гараар, хар өнгийн будагчаар бичсэн байна /гаргаж эс чадсан үсгийн оронд гурван цэг хатгав/.

☐ Бичвэрийг гурван саланги цаасан дээр үйлдсэн байх ба дунд нь хоёр газарт ирмэгээр нь нарийхан зурвас зөрүүлэн цавуудаж үргэлж болгоод хуудас тус бүр дээр тэгш өнцөгт хэлбэртэй, өргөн хүрээтэй тамга даржээ.

☐ Хүрээн дотор Манж, Монгол хэлээр “Халхын очирой бат түшээт хааны тамга” гэж сийлсэн байна.

☐ Бичвэрийг эргүүлж үзэхэд баруун дээд булангийн орчимд 3см орчим дүгрэг, улаан лац дарсан байх ба дүрс нь тодорхой бус ажээ. Лацны баруун гар талд гараар, хар өнгийн будагчаар, латин үсгээр “No 25” гэж угалзлуулан бичсэн байх ба “No” гэсэн үсгэн дээгүүр хөндлөн, зэргэд хоёр зураас татсан байна. Бичвэрийн ар талын зүүн дээд булан орчимд гараар, хар өнгийн будагчаар, латин үсгээр “No 196” гэж угалзлуулан бичсэн байх ба “No” гэсэн үсгийг хөндлөн, нэг зураасаар зуржээ.

Хавсралт 2

Манжийн үеийн он тоолол

д/д	Он тооллын нэр	Он	Европын
1	Энх- Амгалангийн	1 – 58	1661-1719
2	Найралт төвийн	1 - 13	1720-1735
3	Тэнгэр тэтгэсний	1-60	1736-1796
4	Сайн Ерөөлтийн	1-25	1796-1820
5	Төр гэрэлтийн	1-30	1821-1850
6	Түгээмэл элбэгтийн	1-10	1851-1861
7	Бүрэн засагчийн	1-13	1862-1874
8	Бадруулт төрийн	1-21	1875-1895
9	Хэвт ёсны	1-3	1909-1911

Жич: Манжийн ноёрхлыг түлхэн унагасны дараа 1911 оныг “Олноо өргөгдсөний” анхдугаар он гэж нэрлэсэн ба энэ нэрээр 1940-өөд он хүрчээ. Энэ үеийн архивын баримтад “Олноо өргөгдсөний”, эсвэл “Монгол улсын” гэсэн нэр нэлээд тохионо.



Гэвч ДЯЯ-ны зэрэг зарим бичигт оныг ингэж нэрлэлгүйгээр, зүгээр л “15 он, 20 он” мэтээр нэрлэдэг байсан нь лав л 1945 оныг хүртэл үргэлжилсэн буй тул дээрхийг Европ тоололтой эндүүрэхгүй байхад анхаарах нь зүйтэй. Жишээлбэл, энэ тооллоор 35 он гэдэг нь 1945 оныг хэлж буй хэрэг.

Үүнд, анзаараагүй хандсаны харгайгаар түүхэн баримтыг 10 жилээр зөрүүлэх осолтой. Тухайлбал, Монгол цэргийн музейн нэгэн үзмэрт өөрийн үнэнч байснаа цусаараа бичин баталж, “29 он” гэж төгсгөсөн үзмэрийг тайлбартаа 1929 он хэмээн ташаарсан байна.

ТӨР, ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД ХҮЛЭЭЛГЭХ САХИЛГЫН

ШИЙТГЭЛ БА ХУУЛЬ ЗҮЙН ХУГАЦАА

/зарим хууль тогтоомжид хийсэн дүн шинжилгээ/

С.Эрдэнэболор

*Отгонтэнгэр Их сургуулийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч Н.Эрдэнэбаяр
Нийтийн эрх зүйн тэнхимийн багш*

ОРШИЛ

Төрийн албан хаагч чадварлаг, ёс зүйтэй, мэргэшсэн байх нь төрийн албаны нэр хүнд, үйлчилгээний үр өгөөж, чанарт шууд нөлөөлөх ач холбогдолтой төдийгүй Төрийн албаны тухай хууль дахь “төрийн алба мэргэшсэн, тогтвортой байх зарчим” хэрэгжих нэг гол нөхцөл болно. Харин төрийн албан хаагчдын хөдөлмөрийн харилцааны зохицуулалтын өнөөгийн байдал, төрийн албаны практиктай нийцэхгүй байх, хууль тогтоомж нь хийдэлтэй, өөр хоорондоо уялдаагүй, эсхүл зөрчилтэй байгаагаас үүдэн төрийн алба мэргэшсэн, тогтвортой байх зарчим алдагдахад хүрч байна. Үүнээс шалтгаалан хүний эрх хөндөгдөх, албан тушаалтан дур зоргоор аашлах, төрийн сахилга алдагдах, зөрчлийг хийдүүлж, хариуцлага ногдуулахгүй байх зэрэг олон сөрөг үр дагавар гарч байна. Ийм сөрөг үр дагаврыг арилгахад зайлшгүй хийгдэх ёстой нэгэн ажил бол төрийн албан хаагчдад оногдуулж буй сахилгын шийтгэл ба түүнд хамаарах хууль зүйн хугацааны талаарх зохицуулж буй зарим хууль тогтоомжийн агуулга, шүтэлцээ, эдгээрийн хэрэгжилтийг судлах зайлшгүй шаардлага тулгарч байна.

Энэ нь тухайн сэдвийг сонгон судлах болсон гол үндэслэл болох юм. Ийнхүү судалснаар Төрийн албаны тухай хуульд тусгагдсан болон төрийн албан хаагчдад оногдуулах сахилгын шийтгэл ба түүний хууль зүйн хугацааны үр нөлөө, үр дагаврын талаарх эрх зүйн зохицуулалтын агуулга, хэрэглэгдэх үндэслэл, нөхцөлүүд практикт яаж үйлчилж хэрэглэгдэж байгаа, энэ явцад маргаан үүсэх бодит шалтгаан гарч буй эсэх, маргаан нь шийдэгдэх бололцоотой эсэхийг тогтоох, мөн салбарын зарим хууль

ба Төрийн албаны тухай хууль хоорондын уялдаа шүтэлцээ хир байгааг тодорхойлох зорилгыг агууллаа.

ҮНДСЭН ХЭСЭГ

Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаа нь ямар нэгэн эрх зүйн фактаас улбаалж эрх зүйн байдал өөрчлөгдөх, дуусгавар болох нь ойлгомжтой. Гэхдээ ийнхүү эрх зүйн байдал өөрчлөгдөх, дуусгавар болох явдал нь төрийн хууль тогтоомжоор зохицуулагдахгүй бол ажиллах хүчний хөдөлгөөн тогтворгүй байдалтай болох, төрийн үйлчилгээний чанар, үр өгөөж муудах зэрэг нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бий болгох ажээ. Үүний зэрэгцээ хүний эрхийн хүрээнд ч хүн ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох зэрэг эрхүүдийн хэрэгжилтэд саад бэрхшээл тулгарах аюултай. Эдгээрээс сэргийлэхийн тулд төрийн оролцоо зайлшгүй шаарддаг хөдөлмөрийн харилцааны нэг гол хүрээ бол хөдөлмөрийн сахилгын хариуцлагад татахтай холбоотой харилцаа юм.

Энэхүү харилцааг 1926 онд батлан гаргасан шүүх цаазын бичигт^[15] Аливаа хүн эрх тушаалдаа эрдэж, албаны үйл хэргийг саатуулах, боогдуулах, бусдын амгалан тайван байдлыг алдагдуулах, ашгийг хичээж хууль зөрчих, айлган сүрдүүлж дарлах, аливаа хэргийг байцаах, шүүхдээ эрх хэмжээгээ хэтрүүлэх, албаны нэр хүндийг гутаах, шүүн таслах газрын түшмэд ашгийг хичээж шудрага бус тогтоол гаргах, албан тушаалтан хууль бусаар нэг нэгнийг баривчлах, хэрэгтэнг дарлаж айлгах, өлсгөх зэргээр эрүү шүүлт хэрэглэж өчиг мэдүүлэг авах, нууц задруулах, албан үүргээ үл биелүүлэх, аливаа албан хаагчид ашгийг хичээж худалдаа арилжааны зэрэг албан тушаал дор үл нийцсэн ажил явдал үйлдэх зэргийг гэмт хэрэгт тооцож хөрөнгө хураах, 10 төгрөгөөс дээш хэмжээтэй торгох, тушаалаас огцруулах...-аар зохицуулсан нь тусгаар тогтнолоо сэргээн тогтоосноос хойш төрийн албан хаагчдад сахилгын шийтгэл ноогдуулахаар зохицуулсан анхны нийтлэг үйлчлэх зохицуулалт гэж үзэж болохоор

¹⁵ Ж.Амарсанаа, Б.Баярсайхан, Б.Чимид нар Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл /III боть/УБ, 2010 он, 39 дэх тал



байна. Мөн БНМАУ-ын Хөдөлмөрийн хууль болон хөдөлмөрийн үлгэрчилсэн дотоод дүрэм батлагдаж сахилгын хариуцлага хүлээлгэх үндэслэлийг^[16] тодорхойлноос гадна иргэдийн хөдөлмөрлөх эрхийг хангах баталгаа нь ажилтан алба хаагчдыг хууль бусаар ажлаас халсан, ажилд авахаас хууль бусаар татгалзсан үйл ажиллагааг арилгах явдал^[17] гээд тус хуулийн 201-р зүйлд зааснаар ажлаас халсан тушаалыг хүчингүй болгож, 205-р зүйлд зааснаар бусдыг хууль бусаар ажлаас халсан гэм буруутай албан тушаалтнуудад 3 сар хүртэл хугацааны цалингаар материаллын хариуцлага хүлээлгэхээр заасан байна. Хөдөлмөрийн сахилгыг хангах нэг арга бол сахилга дэг журамд зөрчигчдөд хариуцлага хүлээлгэх явдал бөгөөд энэ хариуцлагыг дараах байдлаар тодорхойлсон.

Сахилгын арга хэмжээ гэж дотоод журам, сахилгын дэг журмыг зөрчсөн ажилчин, албан хаагчдад үйлдвэр, албан газар, байгууллагын тушаал шийдвэрээр ногдуулах арга хэмжээг хэлэх ба үүнд ажлаас хожимдох, тааслах, технологийн журам зөрчих, ажлын цагт сэлгүүцэх, хөдөлмөрийн дотоод журамд заасан журмуудыг зөрчих буруутай үйл ажиллагаанууд багтана.

Сахилгын арга хэмжээнд^[18] дараах арга хэмжээнүүд багтана. Үүнд:

- ✓ Сануулах
- ✓ Донгодох
- ✓ Хатуу донгодох
- ✓ 3 сар хүртэл хугацаагаар бага цалинтай ажилд шилжүүлэх
- ✓ Албан тушаал бууруулах
- ✓ Ажлаас халах зэрэг болно.

Мөн олон нийтийн шинжтэй нөлөөллийн арга хэмжээг сахилгын зөрчил гаргасан этгээдэд Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн зарилгыг^[19] үндэслэн авч байсан байна. Тухайлбал: Ажлын нэг жилийн дотор 2-оос доошгүй удаа сахилгын арга хэмжээ авагдсан боловч хөдөлмөрийн сахилга дахин зөрчсөн, эсвэл ажлын 2 өдөр дараалан ажил тасалсан ажилчин, албан хаагчийг олон нийтийн шүүх хүлээн авч 1 сараас 3 сар хүртэл хугацаагаар уг ажлын газарт засан хүмүүжүүлэх ажил хийлгэхээр шийтгэж, цалингийн 5-15 хувийг суутган улсын орлогод оруулах эрхтэй байдаг байна.

Албан үүргээ зөрчсөн албан хаагчийн хүлээх сахилгын хариуцлагын арга хэмжээнүүд үндсэндээ ижил боловч Ардын хяналт шалгалтын хууль, улсын хяналтын болон сахилгын тусгай дүрэм зэрэгт үндэслэл, журмын хувьд өвөрмөц байдлаар

тусгагдаж байжээ. Эдгээр нөхцөл байдалтай уялдан төрийн албан хаагчдад сахилгын хариуцлага хүлээлгэх журам нь өөрийн онцлогтой байсан байна. Тухайлбал:

а. Дотоод дүрэмд заасны дагуу

б. Сахилгын тусгай дүрэмд зааснаар арга хэмжээ авах гэж ангилагдаж байсан байна.

Доктор Д.Баярсайхан сахилгын хариуцлагыг- Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам зөрчсөн буюу хөдөлмөрийн сахилгын зөрчил гаргасан \тэрчлэн ёс зүйн зөрчил үйлдсэн нь байгууллагын хэвийн ажиллагааг алдагдуулсан\ буруутай этгээдэд \ажилтанд\ тухайн байгууллагын захиргаанаас оногдуулж буй хууль зүй хариуцлагын нэг төрөл мөн. Төрийн зарим албан тушаалтанд \шүүгч, прокурор, цагдаа, цэрэг, эмч, багш\ тухайн мэргэшлийн сахилгын болон ёс зүйн дүрмийг зөрчсөн тохиолдолд сахилгын хариуцлага хүлээлгэнэ. Сануулах, цалин хөлс бууруулах, хасах, албан тушаал бууруулах, ажлаас өөрчлөх, халах зэрэг төрөл хэлбэртэй байна^[20] гэж тайлбарласан бол Ч.Нямсүрэн Эрх зүйн онолын номондоо сахилгын хариуцлагыг- хөдөлмөрийн болон албаны сахилга зөрчсөн буруутай ажилтнуудад байгууллагын захиргаа, эсвэл тэдгээрийг удирдах дээд шатны эрх бүхий албан тушаалтнууд хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд хүлээлгэх албадлагын төрөл, хэлбэр юм гэж тайлбарлажээ.

2017 оны 2 сарын байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй 100 орчим хуулиар хөдөлмөрийн эрх зүйн шинжтэй харилцааг зохицуулж байгаагаас 60 орчим хууль, хуульчилсан актаар сахилгын шийтгэл ноогдуулахтай холбоотой харилцааг зохицуулж байна. Тодруулбал, хөдөлмөрийн дотоод дүрэм журам, ёс зүйн дүрэм болон холбогдох хууль тогтоомж зөрчсөн албан хаагчдад сахилгын шийтгэл ногдуулахдаа төрийн албан тушаалын ангилал, төрөл, зөрчлийн шинж чанар, хөнгөн хүнд зэрэг олон нөхцөл байдлаас шалтгаалан төрийн албаны болон хөдөлмөрийн хууль, бусад хууль тогтоомжинд заасан сахилгын шийтгэлүүдийг ногдуулахаар зохицуулсан байна.

¹⁶ БНМАУ-ын Хөдөлмөрийн хууль 1973 он

¹⁷ БНМАУ-ын Хөдөлмөрийн хууль 1973 он, 201 дугаар зүйл

¹⁸ БНМАУ-ын Хөдөлмөрийн хууль 1973 он, 119-р зүйл

¹⁹ БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1965 оны 7-р сарын 22-ны өдрийн 170 дугаар зарлиг

²⁰ Баярсайхан, Д. Эрх зүйн онол. 2010 он. УБ. ЭКИМПО хэвлэл



№	Сахилгын шийтгэл	Хуульд тусгагдсан байдал	Хэдэн хуулиар
1	Сануулах	Сануулах ¹	
		Нээлттэй ба хаалттай сануулах ²	2
2	Цалин бууруулах	Албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах ³	3
		Албан тушаалын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар, 20 хүртэл хувиар бууруулах ⁴	1
		Үндсэн цалинг гурван сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах ⁵	1
		Албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах ⁶	2
		Албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах ⁷	1
		Зургаан сар хүртэл хугацаагаар 30 хүртэл хувиар цалинг бууруулах ⁸	1
3	Цолны мөнгө хасах	Цолны мөнгийг 3 сар хүртэл хугацаагаар хасах ⁹	3
4	Албан тушаал, Цол, зэрэг дэв бууруулах	Албан тушаал бууруулах ¹⁰	6
		Албан тушаалыг 3 сар хүртэл хугацаагаар бууруулах ¹¹	1
		Зэрэг дэвийг 1 жил хүртэл хугацаагаар бууруулах ¹²	
5	Цол хасах, хураах	Цол бууруулах ¹³	5
		Цол хасах ¹⁴	1
6	Эрх хасах	Цол хураан авах ¹⁵	1
		Татварын улсын байцаагчийн эрхийг 12 сар хүртэл хугацаагаар, эсхүл бүр мөсөн хасах Эрх хасах ¹⁶	1 3
7	Халах, огцруулах	Халах талаарх эрхзүйн ерөнхий зохицуулалт ¹⁷	
		Огцруулах ¹⁸	31
		Төрийн албанд 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах ¹⁹	2
		Төрийн албанд хоёр жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр хална ²⁰	1
		Таван жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах ²¹	1
		Нэгээс арав хүртэл жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах ²²	1
		10 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах ²³	3

Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, доктор Б.Чимид хуулийг чанаржуулах явдлыг эрх зүйн шинэтгэлийн нэг бүрэлдэхүүн хэсэг гэж үзэн үүний тулд хуулиуд дахь зөрчил, давхардлыг арилгах, хийдлийг нөхөх зэрэг "...хуульд цэвэрлэгээ хийх"^[21] шаардлагатай болсныг тэмдэглэн бичжээ. Ер нь, боловсронгуй бус, доголдолтой хуулиуд амьдралд үйлчилснээр эрх зүйн шинжтэй янз бүрийн зөрчил, үл ойлголцол үүсч энэ нь маргаан болох даамжрах нь цөөнгүй тохиолддог. Шинжлэх ухааны доктор Л.Баасан "Хөдөлмөрийн хууль тогтоомжид иргэдийн хөдөлмөрлөх эрхийн зохицуулалтыг оновчтой зохицуулаагүй эсвэл хоёрдмол утгаар авч үзсэн зэргээс маргаан үл зохицох байдал үүсэх бөгөөд энэ бол хөдөлмөрийн маргаан үүсэхэд хүргэж буй эрх зүйн зохион байгуулалтын шинжтэй шалтгаан болно"^[22] гэж үзсэн. Ийм шалтгаан хөдөлмөрийн харилцаа, тэр дундаа төрийн албаны эрх зүйн харилцааны хүрээнд илрэх боллоо.

Төрийн албан дахь шийтгэлийг төрөлжүүлэн ангилсан эрх зүйн зохицуулалт болон нэг сэдэвт байхгүй байгаа явдал нь энэ судалгаагаар харагдаж байна.

Мөн дээрх сахилгын шийтгэлийг шийдвэрлэх процедурын асуудал ойлгомжгүй, нарийвчлан системчлэгдсэн зохицуулалт байхгүй байгаа бөгөөд судлаачийн зүгээс дараах байдлаар төрөлжүүлэн хүснэгтээр үзүүлэв.

№	Эрх зүйн актын нэр	Эрх хэм хэмжээнд тусгагдсан байдал
А. Сахилгын шийтгэл ноогдуулах хөөн хугацаа		
	Хөдөлмөрийн хууль	131.2.Сахилгын зөрчил гаргаснаас хойш зургаан сар, илрүүлснээс хойш нэг сарын дотор сахилгын шийтгэл ногдуулна. ²⁴

²¹Чимид.Б. Үндсэн хуулийн үзэл баримтлал: Нийтлэг асуудал. Нэгдүгээр дэвтэр, УБ., 2004 он, 278 дахь талд.

²²Баасан.Л. "Хөдөлмөрийн маргааны онол, практикийн асуудал". УБ., 2009 он, 11 дэх талд.



	Төрийн албаны тухай хууль	26.4. Сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш 1 сар, зөрчил гаргаснаас хойш 6 сараас илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулж болохгүй. ²⁵
	Гаалийн улсын байцаагчийн сахилгын дүрэм	6.6 Сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш 1 сар, зөрчил гаргаснаас хойш 6 сараас илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулахгүй. ²⁶
	Монгол Улсын татварын улсын байцаагчийн ёс зүйн дүрэм	4.4.Сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш 1 сар, зөрчил гаргаснаас хойш 6 сараас илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулахгүй.
	Прокурорын сахилгын дүрэм	5.1. Сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш 3 сарын дотор, сахилгын зөрчил гаргаснаас хойш 1 жилийн дотор сахилгын шийтгэл оногдуулж болно. ²⁷
	Монгол Улсын татварын улсын байцаагчийн ёс зүйн дүрэм	4.4.Сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш 1 сар, зөрчил гаргаснаас хойш 6 сараас илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулахгүй. ²⁸
	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны сахилгын дүрэм	4.1 Сахилгын зөрчил гаргаснаас хойш 6 сар, илрүүлснээс хойш 1 сарын дотор сахилгын шийтгэл оногдуулна. ²⁹
Б. Сахилгын шийтгэл ногдуулах хөөн хугацаа тасалдах		
	Гаалийн улсын байцаагчийн сахилгын дүрэм	6.6. ... Төрийн эрх бүхий байгууллагын хяналт шалгалт, гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалтаар илэрсэн зөрчилд сахилгын шийтгэл ногдуулахад энэ хугацааг баримтлахгүй.
	Прокурорын сахилгын дүрэм	5.2. Энэ дүрмийн 5.1-д заасан хугацаанд тухайн прокурорын хувьд дараахь хугацааг хамааруулахгүй. 5.2.1. Өвчтэй байсан хугацаа /энэ нь эмнэлгийн байгууллагын магадлагаа, дүгнэлтээр нотлогдсон бол/ 5.2.2. Ээлжийн амралт эдэлж байсан хугацаа 5.2.3. Жирэмсний амралттай байсан хугацаа 5.2.4. Захиргааны чөлөөтэй байсан хугацаа 5.2.5. Гадаад улсад албан томилолтоор ажилласан хугацаа 5.2.6. Ажлаасаа түр чөлөөлөгдөн гадаад, дотоодын сургалтанд хамрагдсан хугацаа 7.Сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш 1 сар / өвчтэй, ээлжийн амралт, чөлөөтэй байсан, түүнчлэн зөрчил гаргасан байдлыг шалгасан хугацааг энэ хугацаанд оруулахгүй/, зөрчил гаргаснаас хойш 6 сараас илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулахгүй. ³⁰
В. Сахилгын шийтгэлтэй байх хугацаа		
	Сараар тооцсон хугацаа	3-аас 6 сар хүртэл албан тушаалын цалин бууруулах, цол бууруулах, хасах, хураах гэх мэт 1 жил, 2 жил, 5 жил, 10 жил хүртэл халах сахилгын шийтгэл
	Жилээр тооцсон хугацаа	Цол бууруулах буюу хураан авах шийтгэлийг ногдуулсан өдрөөс хойш нэг жилийн хугацаанд тухайн ажилтан дахин зөрчил гаргаагүй, албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэсэн бол цолыг буцаан олгож болно ³¹
	Хугацаагүйгээр буюу бүр мөсөн ажиллах эрхийг хассан	Тухайн албан тушаал эрхлэх эрхийг сэргээгдэхгүйгээр хасах.
Г. Сахилгын шийтгэлтэй байх хугацаа тасалдах		
	Гаалийн улсын байцаагчийн сахилгын дүрэм	7.2. Сахилгын шийтгэлтэй байх хугацаанд чөлөө авсан тохиолдолд сахилгын шийтгэлийн хугацааг чөлөөний хугацаа дууссаны дараа үргэлжлүүлэн тооцно
В. Сахилгын шийтгэлийг хугацаанаас өмнө арилгах		



	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль	126.1.2.урьд оногдуулсан сахилгын шийтгэлийг хугацаанаас нь өмнө арилгах
	Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм	17. Цагдаагийн алба хаагчид энэ дүрмийн 11 дүгээр зүйлийн "а", "б", "в"-д заасан шийтгэл ногдуулснаас хойш 3 сар, "г"-д заасан шийтгэл ногдуулснаас хойш 6 сарын хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэлийг ногдуулсан албан тушаалтан хугацаанаас нь өмнө арилгаж болно. ³²
Д. Сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа		
	Төрийн албаны тухай хууль	26.6. Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш нэг жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно.
	Хөдөлмөрийн хууль	131.4.Сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно. ³³
	Монгол Улсын татварын улсын байцаагчийн ёс зүйн дүрэм	4.8.Сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш нэг жилийн хугацаа өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно. ³⁴
	Төрийн захиргааны албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, энэ талаар төрийн дээд шатны байгууллагад гомдол гаргах журам.	8.Сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жилийн хугацаа өнгөрч энэ хугацаанд дахин зөрчил гаргаагүй бол сахилгын шийтгэлгүйд тооцно. ³⁵
	Прокурорын сахилгын дүрэм	6.1. Сахилгын шийтгэл оногдуулснаас хойш 1 жилийн хугацаа өнгөрсөн бөгөөд энэ хугацаанд сахилгын шийтгэл гаргаагүй бол сахилгын шийтгэлгүйд тооцно. ³⁶
	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгуулагын ажилтны сахилгын дүрэм	4.2. Сахилгын шийтгэл оногдуулснаас хойш нэг жил өнгөрсөн бол сахилгын шийтгэлгүйд тооцно. ³⁷
	Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм	16. Энэ дүрмийн 11 дүгээр зүйлийн "а", "б", "в"-д заасан сахилгын шийтгэл ногдуулснаас хойш 6 сарын хугацаанд, мөн зүйлийн 2-д заасан сахилгын шийтгэл ногдуулснаас хойш 1 жилийн хугацаанд тус тус дахин зөрчил гаргаагүй бол сахилгын шийтгэлгүйд тооцно. ³⁸
	Монгол Улсын дээд шүүхийн тогтоол / Төрийн албаны тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай/	13. Энэ хэсэгт заасан "...зөрчил гаргаснаас хойш 6 сар өнгөрсөн..." гэдэгт зөрчил гаргасан өдрөөс хойш 6 сарын дотор уг зөрчил илрээгүй, мэдэгдээгүй өнгөрсөн байхыг ойлгоно. ³⁹
	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгуулагын ажилтны сахилгын дүрэм	4.3.Цол бууруулах буюу хураан авах шийтгэлийг ногдуулсан өдрөөс хойш нэг жилийн хугацаанд тухайн ажилтан дахин зөрчил гаргаагүй, албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэсэн бол цолыг буцаан олгож болно. ⁴⁰

Дээрх хүснэгтээс харахад зарим хуульчилсан актаар зохицуулагдаж буй хэмжээнүүд хуульд үл нийцэх явдал харагдаж байна. Тухайлбал, хуулиар бус хуульчилсан актаар эрхийг хязгаарласан байдал багагүй байна.

ДҮГНЭЛТ

Дүгнэн бичихээс өмнө нэгэн эрхэм хүний хэлсэн бас нэгэн үгийг дурдмаар байна.

... "10 жилд 300 шахам төрөлжсөн хууль гаргасан байдлыг судлаад энэ талаар бид зохих судалгаа хийж, ололт, дутагдлын тухай цөөнгүй ярилцсан тул энд давтахаа азная. Гагцхүү Монгол хуульд "дэлхийн эрх зүйн олон бүл" холилдсон, мэргэшлийн боловсруулалт дутсан, яам, газрын явцуу сонирхолд автсан зэргээс ерөнхийдөж, давхардаж, зөрчилдөж, бас нэгэн хууль олонтаа өөрчлөгдөж, тогтворгүй байдал

үүсгэж ирсэнд зөв дүгнэлт хийж, энэ мэт дутагдал, гажуудлыг арилгах цаг хэдийн болсныг дахин тэмдэглэж байна"^[23] гэжээ. Мөн тэрээр өөр нэг бүтээлдээ "захиргааны зохион байгуулалтын хэм хэмжээ зонхилох, нийгмийн эмзэг харилцааг зохицуулсан хуулийн заалт илт дутагдах, хуулийг хаа гуяар нь салгаж жижигрүүлэх, тоо хөөцөлдөн хуулийн зуд болох"^[24] сөрөг талтай гэдгийг анхаарах хэрэгтэй талаар хэлсэн байдаг.

Төрийн албан хаагчдад хүлээлгэх сахилгын шийтгэлтэй холбоотой эрх зүйн актуудад ч энэ "хуулийн зуд" нүүрлэсэн байгаа нь харагдаж байна.

Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцааг зохицуулсан хууль тогтоомжуудад

²³ Чимид.Б. "Үндсэн хуулийн институтчилсэн шинэчлэлийн тухайд". Төрийн захиргаа. сэтгүүл. 2003/3, 4. 12 дахь тал.

²⁴ Б.Чимид. "Үндсэн хуулийн үзэл баримтлал". УБ., 2002. 205 дахь тал.



тусгагдсан сахилгын шийтгэл болон түүний хууль зүйн хугацаа нь өөр хоорондоо агуулга хийгээд логикийн хувьд нийцэхгүй, практикт хэрэглэхэд хүндрэлтэй, өөр хоорондоо зөрчилдсөн нэршилтэй байгаа нь холбогдох зарим хууль, эрх зүйн актуудад хийсэн судалгаагаар илэрч байна. Энэхүү илтгэлийг бичиж судалсны хүрээнд дараах санал, дүгнэлтийг дэвшүүлж байна. Үүнд:

Санал

1. Сахилгын шийтгэл ногдуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг төрийн албаны болон хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулах зүйтэй байна.

Үндэслэл нь: Төрийн албаны тухай хуулийн 11.6. Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой, энэ хуулиар зохицуулаагүй бусад асуудлыг Хөдөлмөрийн хуулиар зохицуулна.

2. Хуулиас давсан, хүний эрх зүйн байдлыг дордуулсан, зөрчлөөс үл шалтгаалж хувь, хугацаа тогтоосон бууруулах, хасах шийтгэл болон хуульчилсан актуудыг хүчингүй болгох нь зүйтэй байна.

Үндэслэл нь: Захиргааны ерөнхий хууль 60.1.5.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог үндсэн болон нийтээр хүлээн зөвшөөрсөн утгаар хэрэглэх;

Мөн хуулийн 60.1.6.хуулиар хориглоогүй асуудлаар хориглосон зохицуулалт тогтоохгүй байх;

3. Хуулиар тогтоосон асуудлаар хуульчилсан актаар давхардуулан зохицуулахгүй байх шаардлагатай байна.

Үндэслэл нь: Захиргааны ерөнхий хууль 60.1.8.бусад хуулийн заалтыг давхардуулан заалгүйгээр шаардлагатай тохиолдолд эшлэл хийгдсэн байх;

4. Хуульчилсан актаар тогтоосон ойролцоо төрлийн сахилгын шийтгэлтэй холбоотой нэр томъёог үндсэн болон нийтээр зөвшөөрсөн утгаар эрх зүйн хэмжээнд тусгах шаардлагатай байна. Үндэслэл нь: Захиргааны ерөнхий хууль 60.1.5.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог үндсэн болон нийтээр хүлээн зөвшөөрсөн утгаар хэрэглэх;

1. Төрийн албаны тухай хууль 2002 он, 26.1.1-р зүйл; Хөдөлмөрийн хууль 1999 он, 131.1.1.-р зүйл; Тагнуулийн тухай хууль 1999 он, 21.1.1-р зүйл, гэх мэт хуулиуд

2. Захиргааны Ерөнхий хууль 2015 он, 105.2.1-р зүйл Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль

3. Гүйцэтгэх ажиллагааны тухай хууль 1997 он, 24.1.1-р зүйл; Шүүхийн шинжилгээний тухай хууль 2009 он, 44.1.2-р зүйл гэх мэт хуулиуд

4. Тагнуулийн тухай хууль 1999 он, 21.1.2-р зүйл

5. Хөдөлмөрийн хууль 1999 он, 131.1.2-р

зүйл

6. Төрийн албаны тухай хууль 2002 он, 26.1.2-р зүйл; Захиргааны Ерөнхий хууль 2015 он, 105.2.2-р зүйл

7. Авилгын эсрэг хууль 2006 он, 13.8.3-р зүйл

8. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль 2012 он, 37.1.2-р зүйл

9. Шүүхийн шинжилгээний тухай хууль 2009 он, 44.1.3-р зүйл; Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм 1994 он, 11.1-ийн б, гэх мэт хуулиуд

10. Тагнуулийн тухай хууль 1999 он, 21.1.4-р зүйл

11. Гаалийн тухай хууль 2008 он, 284.1.3-р зүйл

12. Гаалийн тухай хууль 2008 он, 284.1.2-р зүйл

13. Тагнуулийн тухай хууль 1999 он, 21.1.3-р зүйл; Шүүхийн шинжилгээний тухай хууль, 44.1.4-р зүйл

14. Тагнуулийн тухай хууль 1999 он, 21.1.3-р зүйл; Шүүхийн шинжилгээний тухай хууль, 44.1.4-р зүйл

15. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2002 он, 136.2.4-р зүйл

16. Гаалийн тухай хууль 2008 он, 284.1-р зүйл, Гаалийн улсын байцаагчийн сахилгын дүрэм, Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 90 дүгээр тогтоолын хавсралт, 6.5-р зүйл

17. Захиргааны Ерөнхий хууль 2015 он, 105.2.3-р зүйл; Ирээдүйн өв сангийн тухай хууль 2016 он, 32.1.3-32.1.4-р зүйл; Хөдөлмөрийн хууль 1999 он, 131.1.3-р зүйл гэх мэт 35 орчим хуулиудад

18. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль 2012 он, 37.1-р зүйл, Авлигын эсрэг хууль 2006 он, 13.8.4-р зүйл, Монгол улсын засгийн газрын тухай хууль 1993 он, 23.1.1-р зүйл гэх мэт хуулиудад

19. Төрийн албаны тухай хууль 2002 он, 26.1.3-р зүйл;

20. Сонгуулийн тухай хууль 2015 он, 4.7-р зүйл

21.Ирээдүйн өв сангийн тухай хууль 2016 он, 32.1.1-р зүйл

22. Захиргааны Ерөнхий хууль 2015 он, 105.2.4-р зүйл

23. 2Төсвийн тухай хууль 2013 он, 70.3 –р зүйл; Ирээдүйн өв сангийн тухай хууль 2016 он, 32.1.2-р зүйл; Өрийн удирдлагын тухай 2015 он, 45.1-р зүйл гэх мэт хуулиуд

24. Хөдөлмөрийн хууль 1999 он, 131.2-р зүйл

25. Төрийн албаны тухай хууль 2002 он, 26.4-р зүйл

26. Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 90 дүгээр тогтоолын хавсралт

27.Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 148 дугаар зарлигын хоёрдугаар хавсралт

28. ҮТЕГ-ын даргын 2002 оны 175



- дугаар тушаалын хавсралт
29. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2002 оны 205 тушаал
30. Засгийн газрын 1995 оны 97 дугаар тогтоолын хавсралт
- 31.Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2002 оны 205 тушаал
32. Засгийн газрын 1994 оны 85 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт
33. Хөдөлмөрийн хууль 1999 он, 131.4-р зүйл
34. ҮТЕГ-ын даргын 2002 оны 175 дугаар тушаалын хавсралт
35. Засгийн газрын 1995 оны 97 дугаар тогтоолын хавсралт
36. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 148 дугаар зарлигын хоёрдугаар хавсралт
- 37.Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2002 оны 205 тушаал
38. Засгийн газрын 1994 оны 85 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт
39. Монгол Улсын дээд шүүхийн тогтоол, 2010 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр , 8 дугаар тогтоол
40. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2002 оны 205 тушаал